



МОНГОЛ УЛСЫН ШИНЖИЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭЛЭН

# “ХҮЙТЭН ДАЙН”-ААС ХОЙШИХ МОНГОЛ, ОРОС, ХЯТАДЫН ГУРАМСАН ХАРИЛЦАА

СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН ТАЙЛАН  
2017-2019

Төслийн удирдагч:

Ж.БАЯСАХ доктор /Sc.D/,  
профессор. Олон улсын  
харилцааны хүрээлэн

Захиалагч байгууллага:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын яам

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх ухаан технологийн сан

УЛААНБААТАР 2020

**Улсын бүртгэлийн дугаар:**

Нууцын зэрэглэл: Б энгийн

**Аравтын бүрэн ангиллын код:**

Төсөл хэрэгжүүлэх гэрээний  
дугаар: ШУСс2017/45

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭЛЭН**

**“ХҮЙТЭН ДАЙН”-ААС ХОЙШИХ МОНГОЛ,  
ОРОС, ХЯТАДЫН ГУРАМСАН ХАРИЛЦАА**

**СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН ТАЙЛАН  
2017-2019**

**Төслийн удирдагч:**

Ж.БАЯСАХ доктор /Sc.D/, профессор  
Олон улсын харилцааны хүрээлэн

**Захиалагч байгууллага:**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын яам

**Санхүүжүүлэгч байгууллага:**

Шинжлэх ухаан технологийн сан

**Тайланг өмчлөгч:**

Олон улсын харилцааны хүрээлэн  
ШХ-187, Улаанбаатар-38,  
Монгол Улс 15141  
Утас: 318691, 88118885  
э-хаяг: bayasakhjk@gmail.com

**Улаанбаатар 2020**

## ТӨСЛИЙН КАРТ

<b>Сэдэвт ажлыг баталсан тушаал, огноо:</b>	2017.06.15
<b>Сэдвийн тайлангийн бүрэн нэр:</b>	“Хүйтэн дайн”-аас хойших Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа
<b>Сэдэвт ажлын төрөл:</b>	Суурь судалгааны сэдэвт ажил
<b>Захиалагч байгууллага:</b>	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
<b>Гүйцэтгэгч байгууллага: Хэрэгжүүлэх хугацаа:</b>	Олон улсын харилцааны хүрээлэн 2017-2019 он
<b>Гүйцэтгэгч байгууллагын</b>	
- Нэр:	ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн
- Регистрийн дугаар:	РД 9095837
- Дансны дугаар:	100900015270
- Банкны нэр:	Төрийн сан банк
- Хаяг:	Чингэлтэй дүүрэг, Баруун сэлбэ-15, ШУА-ийн Нэгдсэн II байр
- Вэб хуудас, И-мэйл:	<a href="http://www.ija.mas.ac.mn">www.ija.mas.ac.mn</a> <a href="mailto:ija@mas.ac.mn">ija@mas.ac.mn</a>
<b>Сэдвийн удирдагчийн</b>	
- Нэр:	Ж.Баясах. Доктор /Sc.D/, профессор Олон улсын харилцааны хүрээлэн
- Регистрийн дугаар:	ЧП56040813
- Утасны дугаар:	а: 318691, гар: 99116338
- И-мэйл:	<a href="mailto:bayasakhjk@gmail.com">bayasakhjk@gmail.com</a>
<b>Гэрээний дугаар:</b>	ШУСс2017/45
<b>Санхүүжүүлэгч байгууллага:</b>	Шинжлэх ухаан технологийн сан
<b>Сэдэвт ажлын код:</b>	17НН05СС366
<b>Тайлангийн төрөл:</b>	Эцсийн тайлан
<b>Нууцын зэрэглэл:</b>	Энгийн
<b>Тайланг өмчлөгч байгууллага:</b>	ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн
<b>Сэдэв гүйцэтгэсэн хот:</b>	Улаанбаатар
<b>Тайлан бичсэн он:</b>	2020 он

## РЕФЕРАТ

1990-ээд оны эхэнд социалист систем нуран унаж олон улсын нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдөхөд Монгол Улс тогтолцооны бүрэн шилжилт хийн нэг чиглэлтэй байсан гадаад харилцааны урьдын зарчмаасаа татгалзав. Хөрш хоёр улстайгаа бүх талаар тэнцвэртэй найрсаг харилцахыг эрхэмлэхийн зэрэгцээ гуравдагч хөршийн бодлогыг тунхаглаж, тууштай баримталснаар Монгол Улс тусгаар тогтнол, аюулгүй байдлаа дипломат шугамаар бататгах, үндэсний хөгжил дэвшилд нөлөөлөх их гүрнүүдийн нөлөөллийг тэнцвэржүүлэх олон тулгуурт гадаад бодлогыг идэвхитэй хэрэгжүүлэх боллоо.

Олон тулгуурт гадаад бодлогын хэрэгжилтийн явцад Монгол Улсын оролцоотой гурван талт харилцаа хөгжиж эхэлсний тод томруун илрэл бол Монгол-Орос-Хятадын харилцаа, хамтын ажиллагаа юм. Энэхүү гурван талт харилцаа, хамтын ажиллагаа хэдийгээр ойрын жилүүдээс эрчимжиж буй ч “Хүйтэн дайн”-аас хойш Монгол Улсаас ОХУ, БНХАУ-тай шинээр тогтоосон хоёр талт найрсаг харилцааны хөгжлийн уялдааны үр дүн болж, хөрш орнуудтай харилцах гадаад бодлогод нэгэн шинэ хуудсыг нээсэн юм. Хөрш орнуудтайгаа бүхэлдээ тэнцвэртэй найрсаг харилцах гэсэн Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл шинэ агуулгаар баяжин өргөжиж эхэлснийг энэхүү гурван талт харилцаа гэрчлэхийн зэрэгцээ Монгол Улсын хөгжилд боломж, сорилтыг ч хамтатгах болсон нь уг сэдвийн хүрээнд системтэй судалгаа хийхийн үндэслэл болж өгөв. Уг үндэслэлд тулгуурлан «“Хүйтэн дайн”-аас хойших Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа» хэмээх суурь судалгааны сэдэвт ажлыг 2017-2019 онд хийж гүйцэтгэлээ.

Суурь судалгааны сэдэвт ажлын үр дүнгээс харахад, “Хүйтэн дайн”-аас хойших энэ цаг хүртэл Монгол Улс хөрш хоёр улстайгаа хоёр талт харилцаагаар найрсаг, тэнцвэртэй харилцах бодлогоо амжилттай хэрэгжүүлж ирсэн байна. Тухайлбал, 1993 онд ОХУ-тай “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-г, хойтон жил нь ийм харилцааг БНХАУ-тай мөн байгуулав. Улмаар 2003 онд ОХУ-тай “Сайн хөршийн уламжлалт түншлэл” мөн онд БНХАУ-тай “Сайн хөршийн харилцан итгэсэн түншлэл”-ийг тогтоов. 2009 онд ОХУ-тай, хоёр жилийн дараа 2011 онд БНХАУ-тай тус тус “Стратегийн түншлэл”-ийн харилцаа тогтоож, 2014 онд БНХАУ-тай, 2019 онд ОХУ-тай “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа” байгуулж, бүхэлдээ хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах зарчмаа бодлогын түвшинд зэрэгцүүлэн шат ахиулан хангасаар иржээ.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхийн баталгаажилт, аюулгүй байдал, хөгжил цэцэглэлтэнд хоёр их хөрш эерэг сөрөг асар их нөлөө үзүүлсээр ирсэн, үзүүлсээр ч байгаагийн зэрэгцээ дэлхийн их гүрнүүдийн зөрчилдөөний явцад сүүлийн жилүүдэд Орос, Хятадын харилцаа улам бүр ойртон нягтарч, энэ байдал нь ойрын ирээдүйд хэвээр үргэлжлэх төлөвтэй байна. Манай улсаас үл шалтгаалах хөрш хоёр гүрний хоорондын харилцааны хүрсэн түвшин нь Монгол Улсыг бүс нутгийн хэмжээнд хөрш улсуудтайгаа өргөн хүрээнд зохицож, хамтрахыг шаардсан гадаад орчин болов. Үүнд зохицуулан Монгол улсаас санаачилсан Монгол, Орос, Хятадын гурван талт харилцаа алхам алхмаар урагшлан хэлбэржиж байна. Энэ бол Монгол Улсын хөгжил цэцэглэлтэд асар их боломж дагуулж болохыг үйл явдлын уялдаа холбоонд тулгуурлан сэдэвт ажлын хүрээнд манай судлаачид дүгнэн гаргажээ. Хэдийгээр Монгол, Орос, Хятадын гурван талт харилцаа урагшлан өрнөж байгаа ч Орос, Хятадын Монгол Улсын талаар баримталж бас сөргөөцөлдөж ирсэн “нөлөөний хүрээндээ байлгах, өөрсдийн улс төр, эдийн засгийн ашиг сонирхлоо бэхжүүлэх, Монгол дахь гадны оролцоог хязгаарлах” гэсэн уламжлалт геополитикийн чиг шугам, язгуур ашиг сонирхол нь өөрчлөгдөхгүй байгааг ч мөн онцлон тэмдэглэхийн зэрэгцээ энэ нь гурван талт харилцаагаар далдлагдан үндэсний аюулгүй байдалд шинэ сорилт, бэрхшээл учруулж болзошгүйг дэвшүүлэн гаргаж байна.

Сэдэвт ажлын хүрээнд ном, товхимол 9, эрдэм шинжилгээний өгүүлэл 32, илтгэл 45-г туурвиж судалгааны эргэлтэд оруулжээ. Мөн бодлогын зөвлөмж 3-ыг шийдвэр гаргах түвшний хэрэглэгдэхүүн болгон хүргүүлснээс гадна эрдэм шинжилгээний хурал 6-г зохион байгуулж, судалгааны үр дүнг олон нийтэд түгээн сурталчлах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр өгүүлэл, нийтлэл, ярилцлага өгөх, төрийн тусгай байгууллагын ажилтан албан хаагчдад лекц яриа хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**Судалгааны үр дүнгийн биелэлт:**

Төлөвлөсөн		Биелэлт	
Ном, бүтээл	1	Ном, бүтээл	9

Эрдэм шинжилгээний өгүүлэл	25	ЭШӨ, Гадаадад - Дотоодод -	32
	-	Эрдэм шинжилгээний илтгэл Гадаадад - Дотоодод -	45
Зөвлөмж	2	Зөвлөмж	3
	-	Мэдлэг түгээх, танин мэдэхүйн нийтлэл, ярилцлага	26
Эрдэм шинжилгээний хурал, семинар	3	Эрдэм шинжилгээний хурал, семинар	6
Нийт	20		121

**Түлхүүр үг:** Монгол-Орос-Хятад гурван талт харилцаа, стратегийн түншлэл, улс төр, соёл, боловсрол, эдийн засаг, геополитик

**Сэдэвт ажлын гүйцэтгэгчид:**

1. Ж.Баясах. Доктор (Sc.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн зөвлөх, сэдэвт ажлын удирдагч.

2. О.Батсайхан. Доктор (Sc.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрхлэгч, Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

3. А.Даваасүрэн. Доктор (Sc.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Бүс нутаг, олон улсын хамтын ажиллагааны салбарын эрхлэгч, Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

4. Д.Шүрхүү. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Хятад судлалын салбарын эрхлэгч, Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

5. Н.Ариунгуа. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

6. Ч.Батцэцэг. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

7. К.Дэмбэрэл. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

8. А.Нямдолжин. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

9. Н.Төмөр. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн гэрээт ажилтан.

10. Д.Алтай. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

11. А.Аюуш. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн гэрээт ажилтан

12. Д.Базардорж. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний дэд ажилтан

13. Д.Батжаргал. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний дэд ажилтан

14. Ж.Орхон. Магистр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан

15. Ж.Баярбаатар. Магистр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан

## ГАРЧИГ

1. Удиртгал .....	9
2. Сэдвийн судалгааны тойм .....	12
3. Дүгнэлт .....	32
4. Хавсралт	
Хавсралт 1. Бүтээлийн жагсаалт.....	34
Хавсралт 2. Бодлогын судалгаа, зөвлөмжүүд.....	48
Хавсралт 3. Эрдэм шинжилгээний зарим өгүүллүүд .....	62



## УДИРТГАЛ

“Хүйтэн дайн” төгсгөл болж Монгол, Орос, Хятад хөрш гурван улсын харилцаа олон улсын нөхцөл байдлын өөрчлөлтийн улмаас шинэ агуулгаар өрнөх болсон нь судлаачдад гурван улсын харилцааг шинээр авч үзэхийг шаардахын зэрэгцээ гурван улсын харилцааны цаашдын хөгжил, чиг хандлагыг тодорхойлон судлах боломжийг нээж өгсөн юм. «“Хүйтэн дайн”-аас хойших Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа» суурь судалгааны төслийн үндсэн зорилго нь Монгол, Орос, Хятад гурван улсын харилцааг улс төр, нийгэм эдийн засаг, хүмүүнлэгийн салбарт гурамсан байдлаар судлах, гурав дахь хөршийн нөлөөллийг харгалзан Монгол Улс дахь дэлхийн их гүрнүүдийн “хүчний тэнцвэрийн асуудалд” үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.

Монгол Улсын гадаад орчин сүүлийн жилүүдэд нэлээд эрчимтэйгээр хувьсан өөрчлөгдөхөд дэлхийн улс төр, зах зээл, шинжлэх ухаан-мэдээллийн технологи, байгаль экологид гарч буй эрс өөрчлөлт нөлөөлөхийн зэрэгцээ хамгийн гол хүчин зүйл бол яахын аргагүй Монгол Улсын мөнхийн хоёр хөрш болох Орос, Хятадын дотоод, гадаад бодлого, нийгэм, эдийн засагт нь гарч буй өөрчлөлт шинэчлэлт, тэдгээрийн өөр хоорондын харилцааны нягтрал болж байна.

Хоёр хөршийн гадаад бодлогод зарчмын шинжтэй өөрчлөлтүүд ч гарч эхэллээ. ОХУ нь АНУ, Өрнөдийн орнуудын шахалтыг хүчтэй сөрөхийн хамт “Евразийн эдийн засгийн холбоо”-г байгуулж, Ази-Номхон далайн бүс нутагт худалдаа-эдийн засаг, цэрэг-улс төрийн найдвартай түншүүдийг идэвхитэй эрэлхийлж, гадаад харилцаандаа тус бүс нутгийг ихэд чухалчлан үзэх боллоо.

БНХАУ дэлхийн улс төр, эдийн засагт шинэ дэг журам, шинэ харилцааг тогтоохын тулд өнөөгийн байгаа дэлхийн дэг журам, харилцааг АНУ тэргүүтэй өрнөдийнхний эрх ашигт суурилсан хэмээн шүүмжилж “Хятадын зам” хэмээх хөгжлийн шинэ замын боломж, давуу талыг даян дэлхийд тунхаглан зарлаж, ялангуяа хөгжиж байгаа улс орнуудад, тэр дундаа хөрш орнууддаа санал болгон дэлхий, бүс нутгийн хэмжээний “Бүс, зам” хөгжлийн стратегийг дэвшүүлж хамтран ажиллахыг идэвхийлэн уриалах боллоо.

Хоёр их хөршийн стратегийн шинжтэй дээрх алхамууд нь тус хоёр гүрний харилцааг улам нягтруулан БРИКС, ШХАБ зэрэг дэлхийн хэмжээний байгууллагыг тэргүүлэн чиглүүлж байгаа нь АНУ-ын хүчний харьцааг дахин тэнцвэржүүлэх, байр суурь, нөлөөллөө хадгалах гэсэн их гүрний гадаад бодлоготой мөргөлдөхөд хүрч, үүнээс үүдэлтэй зөрчил тэмцэл хаа сайгүй хурцдах хандлага нэмэгдэж байна.

Ийм нарийн төвөгтэй нөхцөлд Монгол Улс хөгжил, аюулгүй байдлын таатай орчин бүрдүүлэх үүднээс олон тулгуурт, идэвхитэй, нээлттэй, тэнцвэртэй гадаад бодлогыг явуулсаар ирсэн бөгөөд арга хэлбэрийн хувьд хөрш болон нөлөө бүхий орнуудтай янз бүрийн түвшинд стратегийн түншлэлийг хөгжүүлэхийг ихээхэн чухалчлан үзэж, гуравдагч хөршийн бодлогын хүрээнд ОХУ, БНХАУ-аас гадна Япон, АНУ, Энэтхэгтэй стратегийн түншлэлийн харилцаа тогтоон хөгжүүлж байна.

Энэхүү стратегийн түншлэл бүхий хоёр талт харилцаанаас гадна Монгол-Орос-Хятад, Монгол-АНУ-Япон гэсэн гурван талт харилцааны механизм хөгжих болсон нь Монгол Улсын гадаад бодлогын зарчимд тулгуурласан хөгжлийн зүй ёсны илрэл бөгөөд Монгол Улс дахь их гүрнүүдийн хүчний харьцааг тэнцвэржүүлэх бодлогын шинэ хэлбэр болж байгаа нь гадаад, дотоодын анхаарал сонирхолыг ихээр татаж байна.

Хүйтэн дайнаас хойш Монгол, Орос, Хятадын гурван талт харилцаа, түүний онцлог, хэлбэрүүд болон Монгол Улс дахь эерэг сөрөг нөлөөллүүдийг нээн харуулсан, ялангуяа хоёр хөршийн Монгол Улс руу чиглэсэн бодлогыг нэгтгэн авч үзсэн томоохон хэмжээний судалгааны ажил хийгдээгүй байна. Нөгөө талаас дэлхий дахины хүчний харьцаа түргэн хувьсан өөрчлөгдөж, Орос, Хятадын гадаад бодлого, хөрш орнууд, ойр зэргэлдээ орших бүс нутагт явуулах бодлогод нэлээд өөрчлөлт орж буйн тодорхой жишээ бол Хятадын “Бүс ба зам”, Оросын “Евразийн эдийн засгийн холбоо” зэрэг стратегийн санаачлагууд юм. Хоёр хөрш эдгээр санаачлагуудаа уялдуулах асуудалд ихээхэн анхаарч ахиулан хөгжүүлэхийг бүх талаар хичээх болсон нь хөрш зэргэлдээ орших Монгол Улсын хувьд зайлшгүй анхаарах ёстой гадаад хүчин зүйл болон хувирав. Иймд Монгол, Орос, Хятадын харилцааг шинэ нөхцөл, шинэ хүчин зүйлсийн холбоо шүтэлцээн дунд гурван талт харилцаагаар судалж, эхний үр дүнг олон нийтэд хүргэх нь олон улсын харилцаа, олон улс судлалын хүрээнд төдийгүй, бодлогын судалгаа, өргөн олон нийтийн танин мэдэхүйд ихээхэн тустай хэмээн үзэж байна.

Хүйтэн дайнаас хойш Монгол Улс ардчилал, зах зээлийн тогтолцоонд шилжих нарийн төвөгтэй, адармаатай шилжилтийн үеийг туулж байна. ХХ зууны Монгол Улсын гадаад харилцаа ЗХУ, социалист системийн цөөн орнуудын хүрээнд хязгаарлагдаж байснаа хоёр зууны заагаар ихээхэн тэлж, хоёр хөршийн харилцааг тэргүүлэх чиглэл болгож гуравдагч хөршийн бодлогын үзэл баримтлалын дагуу дэлхийн нөлөө бүхий их гүрнүүдтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж ирэв. Мөн асар баялаг эрдэс түүхий эдийн нөөцөө ашиглах, эргэлтэнд оруулах

идэвхитэй бодлогын үр дүнд зам тээвэр, эрчим хүчний хангамж, сүлжээ байгуулахыг ихээр шаардах болсоны дагуу гадаадын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хэрэгцээ өссөн нь Монголын геозэдийн засаг, геостратегийн ач холбогдолыг нэмэгдүүлэв. Монгол дахь бусад их гүрнүүдийн оролцоо, сонирхол нэмэгдэхийн хэрээр хоёр их хөршийн уламжлалт геополитикийн сонирхол ч дахин сэргэж ирсэн юм.

Ийм эгзэгтэй нөхцөл байдлын дунд бүрэлдэн төлөвшиж буй Монгол, Орос, Хятадын гурван талт харилцааны ашиг сонирхол, түүхэн уламжлал, туршлага, сургамж, үр өгөөж, нөөц бололцоо, тулгамдсан асуудлуудыг судлах нь зайлшгүй бөгөөд урт хугацаанд системтэй судалгаа явуулах зүй ёсны шаардага болж байна.

Энэхүү судалгааны ажил ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнд 2013-2015 онд хэрэгжиж дууссан “Монгол Улс дахь Орос, Хятадын ашиг сонирхолын тулгамдсан асуудлуудын судалгаа” сэдэвт төсөлтэй залгамж чанарын хувьд уялдан үргэлжилж байгаа болохоор хөрш орнуудын асуудлыг чухалчлан судлах тус хүрээлэнгийн судалгааны стратеги зорилтыг хангахад чухал хувь нэмэр оруулсан ажил боллоо.

Монгол, Орос, Хятадын гурван талт харилцаа, хамтын ажиллагааг үр өгөөжтэй, харилцан ашигтай байдлаар хөгжүүлэхэд оролцогч талуудын ашиг сонирхол, эрх ашгийн нийцэл, зөрүүтэй байдлыг ойлгон мэдэж, харилцан сонирхсон тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох нь чухал ач холбогдолтой хэмээн үзэж **«Хүйтэн дайн»-аас хойших Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа**» суурь судалгааны сэдэвт ажлыг 2017-2019 онуудад хийж гүйцэтгэлээ.

## **СЭДВИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ**

«Хүйтэн дайн»-аас хойших Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа» хэмээн суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд 1990 оноос хойших Монгол, Орос, Хятад гурван улсын харилцаа хамтын ажиллагааны хувьсал, өөрчлөлтийн Монгол Улс дахь эерэг сөрөг нөлөөллийг нээн харуулж, Монгол-Оросын харилцааны болон Монгол-Хятадын харилцаанд үнэлэлт өгөн, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлон улмаар Монгол, Орос, Хятадын гурван талт харилцааны хөгжлийн үүсэл, өрнөлд дүгнэлт хийн хөгжлийн чиг хандлагийн талаар санал дэвшүүлсэн өргөн цар хүрээтэй судалгаа явууллаа. Сэдвийн гүйцэтгэгчдийн ихэнх нь олон жил тухайн сэдвийн дагуу судалгааны ажил хийсэн туршлагатай, онол-аргазүй, мэдлэг мэдээллийн бааз суурь сайтай байсан нь судалгааны ажлыг үр дүнтэй, чанартай гүйцэтгэхэд зохих ёсоор нөлөөлсөн болно.

Төсөл гүйцэтгэгч судлаачид Монголын болон гадаадын архивуудын баримтууд, сурвалж бичиг, судалгааны бүтээлүүд, дотоод гадаадын хэвлэмэл болон цахим эх сурвалжууд, албан ёсны статистикийн дүн мэдээнүүдэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр судлаач бүр өөр өөрийн үнэлэлт дүгнэлтийг хийх замаар «Хүйтэн дайн»-аас хойших Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа» нэгэн сэдэвт хамтын бүтээл, «Монголын эрдэмтэдийн бичсэн Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорын тухай өгүүлүүдийн эмхэтгэл», «Монгол, Хятадын дурсамжууд» номын орчуулга зэрэг 9 ном бүтээл туурвижээ. Түүнээс гадна 6 удаа эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулав. Мөн манай судалгааны багийн эрдэмтэд гурван улсын эрдэмтэдийн “тинк танк” байгууллага болох жил тутам гурван улсад ээлжлэн зохион байгуулагддаг “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор”-ын асуудлаарх эрдэм шинжилгээний хурлуудад тасралтгүй оролцож, судалгааны үр дүнгээ танилцуулсаар ирлээ. Суурь судалгааны үр дүнг төр засгийн бодлого шийдвэрт тусгуулах, эрх баригчдын анхаарал, сонорт хүргэх хамгийн үр дүнтэй арга болох бодлогын судалгаа, зөвлөмж 3-ыг бэлтгэн бодлого боловсруулагчдад хүлээлгэн өгсөн байна. Сэдэвт ажлын хүрээнд гарсан дээрх ажлуудын талаар тоймлон танилцуулбал,

**1. “Хүйтэн дайн”-аас хойших Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа** хамтын бүтээл /361 хуудас, хэвлэлтэнд/

Энэхүү хамтын бүтээл нь «Хүйтэн дайн»-аас хойших Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа» суурь судалгааны төслийн ажлын хүрээнд гүйцэтгэсэн гол

бүтээл бөгөөд хүйтэн дайнаас хойших Монгол, Орос, Хятад гурван улсын харилцааг Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл хэрхэн хоёр талт харилцаанаас хальж гурван талт харилцаанд дэвшин хөгжиж байгааг геополитик, аюулгүй байдал, улс төр, нийгэм, эдийн засгийн өргөн хүрээг хамруулан судалсан байна. Номын зохиогчид судлан буй асуудлыг улс төр, эдийн засаг, нийгэм хүмүүнлэгийн салбараар ангилан авч үзжээ. Чингэхдээ Хүйтэн дайнаас хойших салбар бүр дэх Монгол-Орос, Монгол-Хятад, Орос-Хятадын хоёр талт харилцааны хүрсэн түвшин нь хэрхэн Монгол, Орос, Хятадын гурван талт харилцаа болон баяжин хөгжиж байгаагийн шалтгаан нөхцөл хийгээд өнөөгийн байдлыг тайлбарлан өгүүлж, хэтийн зураг төлөвийн талаар таамаглал санал дэвшүүлж, тухайн судлаачийн хувийн байр суурь, мэдлэг чадварт түшиглэн энэхүү гурван талт харилцааг аль болохоор өргөн хүрээнд судлан тодлохыг зорьсонд уг хамтын бүтээлийн онцлог оршиж байна.

Чингэхдээ гурван улс хүйтэн дайнаас хойш улс төрийн түвшинд амжилттай хамтарч, өндөр дээд түвшний харилцан айлчлалын давтамжийг нэмэгдүүлж, харилцааны зарчмаа тодорхойлсон гэрээ эрх зүйн шинэчлэлтүүдийг амжилттай хэрэгжүүлж, тус тусын хоёр талт улс төрийн харилцааг түүхэнд байгаагүй өндөр түвшинд гаргаж, гурван талт улс төрийн харилцааны төрийн тэргүүн нарын өндөр түвшний механизмыг үүсгэн байгуулж чадсан нь тус гурван улсын эдийн засаг, нийгэм хүмүүнлэгийн зэрэг бусад салбарын гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай суурийг тавьсан байна. Харин эдийн засгийн гурван талт харилцааг идэвхижүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд чингэхийн тулд юуны өмнө монголчууд өөрсдөөс шалтгаалах зүйлийг дотооддоо хөгжүүлэх нь чухал болохыг дурдаад дотоод асуудлаа цэгцэлж чадвал хөрш хоёр улсаас шалтгаалсан хүчин зүйлийн нөлөөлөлтэй уялдуулан өргөжүүлэхэд суурь түшиг болохыг дурдан гаргажээ. Нийгэм хүмүүнлэгийн хамтын ажиллагаа нь иргэд хоорондын харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх, ялангуяа монголчуудын зүгээс муйхарлан Орос, Хятадыг хэт сэрэмжлэн харах, хардах туйлширсан байдлыг бодит нөхцөлтэй нийцүүлэн эерүүлэхэд чухал нөлөөтэй болох тул улс төр, эдийн засгийн харилцааны хөгжлийг дэмжих тулгуур болох ач холбогдолтойг дурдсан байна. Иймээс гурван талт харилцааны өнөөгийн хүрсэн түвшинг улс төрийн хувьд хүрсэн түвшингээ хадгалж үлдэх, эдийн засгийн салбарын харилцааг бодитоор эхлүүлэх, нийгэм хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай ба эдгээрийн өөр хоорондын уялдаа холбоог хөрш хоёр гүрний гадаад дотоод

байдалтай уялдуулан өөрийн орны нөхцөл байдалд нийцүүлэх нь юуны өмнө чухал ач холбогдолтой болохыг дурдан гаргасан байна.

Уг номын “Монгол, Орос, Хятадын улс төрийн харилцаа” хэмээх нэгдүгээр бүлэг нь дотроо 5 зүйлтэй. “Монгол, Орос, Хятадын хоёр талт болон гурван талт харилцааны түүхэн тойм” хэмээх нэгдүгээр зүйлийг Ж.Баясах, “Хүйтэн дайнаас хойших Монгол, Орос, Хятадын харилцааны үечлэл, онцлог” хэмээх хоёрдугаар зүйлийг Н.Ариунгуа, “Монгол, Орос, Хятадын төрийн тэргүүн нарын уулзалт” хэмээх гуравдугаар зүйлийг О.Батсайхан, “Монгол, Орос, Хятадын хамтын ажиллагааны гурван талт механизм ба гэрээ эрх зүйн үндэс” хэмээх дөрөвдүгээр зүйлийг Ж.Баясах, Д.Базардорж нар, “Орос, Хятадын гадаад бодлогын үзэл баримтлалын хувьсал, өөрчлөлт, тэдгээрийн Монгол дахь тусгал” хэмээх тавдугаар зүйлийг К.Дэмбэрэл, Ж.Баярбаатар нар тус тус бичсэн болно.

Доктор Ж.Баясахын бичсэн “Монгол, Орос, Хятадын хоёр талт болон гурван талт харилцааны түүхэн тойм” хэмээх нэгдүгээр зүйлд хөрш гурван улсын харилцааг Монгол-Орос, Монгол-Хятадын хоёр талт улмаар Монгол, Орос, Хятад гурван талт харилцаа хэмээн авч үзэн, хүйтэн дайнаас өмнөх ба хойших цаг үед ангилан өгүүлэхдээ гурван улсын гурван талт харилцаа бол түүхэн туршлага сургамжаар шүүгдэгдсэн үзэгдэл бөгөөд шинэ эринд шинэ агуулгаар улам баяжин цаашид өргөжин хөгжих асар их боломжтой бөгөөд гурван талын хүлээлттэй хэмээн дүгнэсэн байна.

Доктор Н.Ариунгуа “Хүйтэн дайнаас хойших Монгол, Орос, Хятадын харилцааны үечлэл, онцлог” хэмээх хоёрдугаар зүйлийг дараах байдлаар дүгнэжээ. Хүйтэн дайны үе дуусгавар болсноор Монгол, Орос, Хятад гурван улсын хоорондын харилцаанд тэдгээрийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдал, дотоод, гадаад хөгжлийн зорилт, олон улсын харилцааны өрнөл, чиг хандлага зэргээс хамааран багагүй өөрчлөлт гарсан бөгөөд энэхүү харилцааг үечлэн авч үзэх нь гурван орны хамтын ажиллагааны хөгжил, үр өгөөж, нөөц бололцоо, тулгамдсан асуудлуудыг олж харахад ач холбогдолтой. Хүйтэн дайны дараах гурван улсын харилцаа хоёр талт харилцаагаар тодорхойлогдож байсан ч хоорондын харилцаанд нь тус бүрийн хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэсээр байгаа нь гурван улс геополитикийн нэг орон зайд багтдагтай шууд хамааралтай хэмээжээ. Зохиогч гурван орны геополитикийн харилцан хамаарал эдгээр орнуудын хоорондын хоёр талт харилцаанд хэрхэн нөлөөлж буй асуудлыг хөндөн гурван талт харилцааны хэлбэр бий болоход ямар учир холбогдолтойг харуулахыг зорьжээ. Зохиогч энэхүү

харилцааг үечлэхдээ юуны түрүүнд олон улсын харилцаанд гарсан болон гарч буй үндсэн өөрчлөлт, хоёр хөршийн дотоод, гадаад бодлогоос улбаатай зарчмын өөрчлөлтүүд манай гурван орны харилцаанд хэрхэн нөлөөлсөн болон нөлөөлж байгааг эш үндэс болгон харилцааны үе шатыг тодорхойлохыг оролдсон байна. Мөн Монгол Улс хөгжлийн чиг хандлагаа тодорхойлох, хөгжлийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ гадаад бодлогодоо хоёр хөршийн улс төр, эдийн засгийн хүчин зүйлийг хэрхэн харгалзан үзэж, ашиглаж ирснийг эш үндэс болгож, Хүйтэн дайны дараах гурван улсын харилцааг барагцаалан хоёр үед хуваан тэдгээр харилцаанд гарсан өөрчлөлт, онцлогийг тодорхойлохыг оролджээ.

Доктор О.Батсайхан “Монгол, Орос, Хятадын төрийн тэргүүн нарын уулзалт” хэмээх гуравдугаар зүйлдээ “Хүйтэн дайн”-аас хойш гурван улсын харилцаанд гарсан хамгийн том амжилтуудын нэг бол Монголын Улсын төрийн тэргүүний санаачилга зүтгэлээр гурван талт төрийн тэргүүн нарын дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулж чадсанаар үл барам энэ нь механизм болон тогтворжин хөгжиж байгаа хэрэг хэмээн үзжээ. Хэдийгээр гурван улсын төрийн тэргүүн нарын уулзалт ШХАБ-ын хүрээнд хайрцаглагдан хэрэгжиж байгаа нь хөрш орнуудын зүгээс Монгол Улсад тулгасан цаг үеийн тодорхой шаардлагын илрэл ч, ойрын ирээдүйд зөвхөн гурван талт хэлбэрээр хэрэгжүүлж чадвал хөрш гурван улсын гурван талт харилцааг улам ахиулж биежүүлэн Монгол Улсын ашиг сонирхолд бүрнээ нийцүүлэх боломжтой байгааг үйл явдлын өрнөлд тулгуурлан дүгнэжээ. Чингэхийн тулд зохиогч гурван талт дээд хэмжээний уулзалтуудаар яригдсан зүйлс болон тэдгээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн байна.

Доктор Д.Базардорж “Монгол, Орос, Хятадын хамтын ажиллагааны гурван талт механизм ба гэрээ эрх зүйн үндэс” хэмээх дөрөвдүгээр зүйлд өнөөдөр өрнөж буй Монгол, Орос, Хятад гурван талт харилцаа Монгол Улсаас хөрш улсуудтайгаа байгуулсан хоёр талт харилцааны үр дүн болж, стратегийн иж бүрэн түншлэлүүдээр баталгаажсан хэмээгээд зөвхөн төрийн байгууллагуудын хүрээнд бус төрийн бус байгууллага иргэд хоорондын хүрээнд ч өргөжин тэлж байгааг онцлон тэмдэглэжээ. Төрийн байгууллагуудын гурван талт харилцаа нь төрийн тэргүүн нарын уулзалтын механизм, сайд нарын түвшний уулзалтын механизм, тодорхой чиг үүргийн байгууллагуудын уулзалтын механизмаар тодорхойлогдож, зам тээвэр, дэд бүтэц, аялал жуулчлалын чиглэлд тэргүүлэх байртайгаар өрнөж байгааг өгүүлжээ. Төрийн бус байгууллагуудын гурван талт механизм нь гурван улсын эрдэмтдийн “тинк танк” форум, сэтгүүлчдийн форум, худалдаа аж

Үйлдвэрийн танхимуудын уулзалтуудаар голлон “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорын хүрээнд” хэрэгжиж гурван талт хамтын ажиллагааны хүрээ царгаг өргөтгөх ач холбогдолыг таниулахад харилцан биенээ сонсох чиглэлд идэвхийлэн ажиллаж байгааг нэгбүрчлэн өгүүлжээ. Чингэхдээ гурван талт механизм нь төрийн тэргүүдийн түвшнээс иргэдийн түвшинд хүртэл өргөжин биежиж, цаашдын гурван талт харилцааны хөгжилд суурь болж, харилцан уялдаа бүхийгээр бэхжиж байгааг онцлон тэмдэглээд, гурван талт харилцаа яахын аргагүй гурван улсын харилцаанд шинэ хуудас нээж чадсаныг дүгнэн хэлсэн байна.

Доктор К.Дэмбэрэл, магистр Ж.Баярбаатар нар “Орос, Хятадын гадаад бодлогын үзэл баримтлалын хувьсал, өөрчлөлт тэдгээрийн Монгол дахь тусгал” хэмээх тавдугаар хэсэгт хүйтэн дайнаас хойш Орос, Хятадын гадаад бодлогын өөрчлөлт хөдөлгөөнийг тэдгээр улсуудын гадаад бодлогын үзэл баримтлал ба түүнтэй дүйцэхүйц баримт бичгүүдэд тусгагдсан байдлаар томъёолон илэрхийлэхдээ Монгол Улс тэдгээр улсуудын гадаад бодлогод өндөр байр суурь эзлэх болсныг дурдсан байна. Ялангуяа Украины хямралаар Оросын гадаад бодлого Ази руу чиглэн эрчимжсэн бол Хятадын хөрш орны бодлого нь хөрш улсуудаа тэргүүн чиглэлд гаргаж тавьснаар нь Монголын ач холбогдолыг өргөсөн хэмээн дүгнэсэн байна. Орос, Хятад хоёрын хүйтэн дайнаас хойших стратегийн түншлэл тогтоосон өнөөг хүртэлх харилцааг гурван үед хуваан авч, хэдийгээр өөр хоорондоо ойртон нягтарч буй ч тэдний хооронд стратегийн сонирхол бий болоогүй хэмээн үзжээ. Энэ нь харилцан хамтын ажиллагааг стратегийн түншлэлийн хэмжээнээс илүү гаргах, буюу холбоотны хэмжээнд хүргэх сонирхол багатай гээд гурван талт харилцааг хөгжүүлэхэд Монгол Улсын хувьд энэ нь аюулгүй байдлаас үүдэлтэй хөрш улсуудаас ирэх дарамтыг бууруулж байна хэмээн дүгнэн үзсэн байна.

“Эдийн засаг, худалдааны харилцаа” хэмээх хоёрдугаар бүлэг нь таван зүйлтэй. “Монгол Улс дахь Орос, Хятадын хөрөнгө оруулалт” хэмээх нэгдүгээр зүйлийг А.Даваасүрэн, “Монгол Улсын гадаад худалдаанд Орос, Хятадын эзлэх байр суурь” хэмээх хоёрдугаар зүйлийг Д.Аюуш, Ж.Орхон нар, “Монгол, Орос, Хятад гурван улс дамнасан зам тээврийн (төмөр зам, авто зам) дэд бүтцийн сүлжээ” хэмээх гуравдугаар зүйлийг Д.Шүрхүү, “Монгол, Орос, Хятадын эрчим хүчний хамтын ажиллагаа (цахилгаан эрчим хүч, газрын тос ба хийн хоолой, Азийн супер сүлжээ)” хэмээх дөрөвдүгээр зүйлийг Н.Төмөр, “Хилийн боомтуудын хөгжил, хамтын ажиллагаа” хэмээх тавдугаар зүйлийг Д.Шүрхүү, А.Нямдолжин нар бичжээ.



Доктор А.Даваасүрэн “Монгол дахь Орос, Хятадын хөрөнгө оруулалт” хэмээх нэгдүгээр зүйлд Монгол Улс дахь Орос, Хятадын хөрөнгө оруулалтыг хоёр үе шатанд эдийн засгийн салбар тус бүрээр нь нарийвчлан үзжээ. Хоёр хөршийн хөрөнгө оруулалтын хэмжээ, оруулсан салбар зэрэгт гурван улсын албан ёсны статистик мэдээ баримтуудад тулгуурлан харьцуулалт хийжээ. Чингэхдээ Хятадын хөрөнгө оруулалт давамгайлж байгаагийн шалтгаан нөхцөлийг тоочин гаргаж, энэ нь гурван талт харилцааг хөгжүүлэхэд ямар нөлөө үзүүлж байгааг дэлгэрэнгүй дурдахын зэрэгцээ цаашид анхаарах ёстой саналыг дэвшүүлэн гаргасан байна. Түүнчлэн Орос дахь, Монгол, Хятадын хөрөнгө оруулалт, тэдгээрийн хэмжээ, Хятад дахь Монгол, Оросын хөрөнгө оруулалт тэдгээрийн хэмжээ, хувьсалт өөрчлөлтийн талаар нарийн тодорхой өгүүлэхдээ гурван талт харилцааны тэнцвэртэй хөгжлийг хангахын тулд ялангуяа Монгол дахь хоёр хөрш гүрний хөрөнгө оруулалтыг балансжуулах нь туйлын чухал болохыг онцлон тэмдэглэсэн байна.

Доктор А.Аюуш “Монгол Улсын гадаад худалдаанд Орос, Хятадын эзлэх байр суурь” хэмээх хоёрдугаар зүйлд “Хүйтэн дайн” дууссанаас хойш Монгол, Орос, Хятадын хоорондын худалдаанд нэлээд их өөрчлөлт гарсныг дурдаад, Монгол Улсаас ОХУ-тай хийж буй худалдааны хэмжээ багасч, маш их алдагдалтай байхад БНХАУ-тай хийж буй худалдаа нэмэгдсэн боловч уул, уурхай, мал аж ахуйн түүхий эдийн бараа зонхилсон байдалтай байгааг хүснэгтлэн харуулжээ. Иймд Монголын талаас ОХУ болон БНХАУ-тай хийж буй худалдааг тэнцвэржүүлэх арга замыг хайх, экспортын барааны нэр төрлийг нэмэгдүүлэх, экспортын түүхий эдийг дотооддоо боловсруулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, экспортлох чиглэлээр ажиллах шаардлагатайг чухалчилжээ.

Доктор Д.Шүрхүү “Монгол, Орос, Хятадын улс дамнасан зам тээврийн дэд бүтцийн сүлжээ” хэмээх гуравдугаар зүйлийг туурвив. Тэрбээр энэхүү зүйлдээ Монгол, Хятад, Оросын зам тээврийн дэд бүтцийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх үндэслэл, шаардлага ба сүүлийн жилүүдэд энэ чиглэлээр хоёр болон гурван талт хэлбэрээр хийж гүйцэтгэсэн ажлууд, ололт амжилтуудыг тодорхой жишээ, статистикийн тоо баримтуудад түшиглэн харуулав. Монгол Улс хоёр хөрштэйгээ зам, тээврийн дэд бүтцийн салбар дахь хамтын ажиллагааг эрчимжүүлэх гурван том үндэслэл шалтгаан байна гээд нэгдүгээрт, Монголын хөгжлийг хөтөлж буй эрдэс баялгийн салбарын эрэлт хэрэгцээг хангах, хоёрдугаарт, экспортын бүтэц, гадаад зах зээлийг төрөлжүүлэх замаар эдийн

засгийн аюулгүй байдлыг хангах, гуравдугаарт, бүс нутгийн нөхцөл байдал, хөрш орнуудын гадаад бодлогод гарч буй өөрчлөлтүүд хэмээжээ.

Монгол, Хятад, Оросын зам тээврийн дэд бүтцийн хамтын ажиллагааны явц байдлыг юуны өмнө улс төр, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах болон төмөр зам, авто, агаар, хоолойн тээвэр, боомт, логистикийн төвүүд гэх мэт бодит салбарууд дахь бүтээн байгуулалтын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хоёр чиглэлээр харуулахыг хичээжээ. Өнгөрсөн 5-6 жилд хөрш гурван орны хамтын ажиллагааны улс төр, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, хөхиүлэн дэмжих чиглэлд гарсан том амжилт бол Монголын талын санаачлагаар 2014 оноос эхэлсэн Монгол, Орос, Хятад гурван орны дээд хэмжээний уулзалтын механизм бөгөөд түүний эхний том үр дүн бол 2016 онд баталсан Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс дэд сайд нарын, шинжээчдийн, зам тээврийн салбар хоорондын гэх мэт гурван талт механизмууд төлөвшиж байна. Үүний үр дүнд зам тээврийн салбар дахь хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлж, хөрөнгө хүчийг төвлөрүүлэхээр тохиролцож, “Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх тухай Монгол, Орос, Хятад гурван улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2016 оны 12 дугаар сард байгуулж, 2019 оноос хэрэгжиж эхлээд байна.

Хэдийгээр гурван тал оролцсон том төслүүд хараахан эхлээгүй байгаа ч талууд өөр өөрийн бүтээн байгуулалтуудаа урагшлуулсаар байна. Тухайлбал, Монгол Улс олон улсын шинэ нисэх буудлын бүтээн байгуулалтаа дуусган, ашиглаж эхлэх бэлтгэлээ хангаж байна. Азийн авто замын сүлжээний АН 4 чиглэлд хамаарах Улаанбайшинт-Ховд-Ярантай баруун босоо коридорын бүтээн байгуулалт дуусах шатандаа орсон, мөн АН3 чиглэлд багтсан Дархан-Улаанбаатарын замыг шинэчлэн өргөтгөх ажил 2019-2020 онд хэрэгжиж байгаа болон Тавантолгойн ордыг төмөр замаар Гашуунсухайт боомт, Зүүнбаян өртөөтэй холбох, Замын-Үүд, Гашуунсухайт, Алтанбулаг, Боршоо хилийн боомтуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалт амжилттай хэрэгжиж байна. Монголын нутгаар дайруулан байгалийн хийн хоолой тавих манай хүсэлтийг ОХУ 2019 оноос нааштайгаар хүлээн авч, хамтарсан судалгааны ажлыг эхлүүлээд байна. Зөвхөн дээр дурдсан Монгол Улсад эхэлсэн дэд бүтцийн төслүүд амжилттай хэрэгжвэл түүний үр өгөөж Монголд төдийгүй хөрш орнууд, цаашлаад бүс нутгийн эдийн засгийн интеграцид жинтэй нөлөө үзүүлэх боломжтой хэмээн дурджээ.

Доктор Н.Төмөр “Монгол, Орос, Хятадын эрчим хүчний хамтын ажиллагаа” хэмээх дөрөвдүгээр зүйлд гурван улсын эрчим хүчний салбарын хөгжлийн хандлага уялдаа болон хамтын ажиллагааг цаашид эрчимжүүлэхийн үндэслэл шаардлагийг гаргаж, эрчим хүчний салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь Монгол, Орос, Хятад гурван талт харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг онцлон дурдсан байна. Монгол Улсын төрөөс эрчим хүчний талаар баримталж байгаа бодлого, эрх зүйн зохицуулалтыг эрчим хүч, экологи, эдийн засгийн тэнцүү хүчинд хуваарилж хөгжүүлэхийн чухлыг дурдаж, гурван улсын хамтарсан эрчим хүчний салбарын Монгол дахь үлгэр жишээ бүтээн байгуулалтыг өгүүлж, цаашид илүү нягт өргөн хүрээнд эрчим хүч үйлдвэрлэлийн төслийг бодитоор хэрэгжүүлэх нь зүйтэй болохыг чухалчилжээ. Чингэхдээ энэхүү гурван талт харилцаа нь юуны өмнө Монгол Улсын эрчим хүчний хараат байдлыг бууруулж, дотоодынхоо хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангаж, улмаар “Азийн супер сүлжээ” зэрэгт идэвхийлэн оролцож бүс нутгийн эрчим хүч үйлдвэрлэлийн цөм болох том зорилтыг хангахад чухал ач холбогдолтой хэмээн дүгнэжээ.

Доктор Д.Шүрхүү, А.Нямдолжин нар “Хилийн боомтуудын хөгжил, хамтын ажиллагаа” хэмээх тавдугаар зүйлд Монгол Улс Ази, Европыг холбосон хамгийн дөт, найдвартай зам бүхий газарзүйн байршлын давуу талаа ашиглан олон улсын худалдаа, тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг өргөжүүлж, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлснээр дэлхийн худалдаа, эдийн засгийн сүлжээнд идэвхтэй оролцох, эдийн засгийн өрсөлдөх чадвараа сайжруулах, зам, тээвэр, дэд бүтцийн зангилаа орон болж, бүс нутгийн худалдаан дахь байр сууриа нэмэгдүүлэх боломж байгаа талаар гурван талт хамтын ажиллагааны хүрээнд судлан шинжилжээ. Чингэхдээ судлаачид Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын гол дамжин өнгөрөх суваг болохын тулд дотооддоо төмөр зам, авто замын дэд бүтцийн сүлжээ байгуулж, уул уурхайн том төслүүдээ хилийн боомтууд, магистрал шугамуудтай холбон, тээвэр логистикийн нэгдсэн төвүүдийг яаралтай байгуулж, хилийн гол гол боомтуудаа олон улсын стандартын түвшинд шинэчлэн сайжруулах, дамжин өнгөрөх, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаагаас үүдэн гааль, хилийн боомтуудын шинэчлэл, бүтээн байгуулалтын хэрэгжиж буй төслүүдэд тулгуурлан дэлгэрэнгүй судалсан байна. Түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх ачаа тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, холимог тээврийн системийг хөгжүүлэхэд “Бүс нутгийн логистикийн төв” байгуулах ажил чухал ач холбогдолтой болон олон улсын бараа эргэлтийн идэвхжил, эдийн

засгийн интеграцийн үйл явцыг өргөтгөх бодит үйл ажиллагааны үр дүнд эдийн засгийн түвшинг хурдасгах гол үзүүлэлт болох эдийн засгийн чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааны өнөөгийн байдлын талаар өгүүлсэн байна.

Уг номын “Соёл, боловсрол, хүмүүнлэгийн харилцаа” хэмээх гуравдугаар бүлэг нь дөрвөн зүйлээс бүрджээ. “Монгол, Орос, Хятадын соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа” хэмээх нэгдүгээр зүйлийг Ч.Батцэцэг, “Монгол, Орос, Хятадын боловсролын салбарын хамтын ажиллагаа” хэмээх хоёрдугаар зүйлийг Н.Ариунгуа, А.Нямдолжин, Д.Батжаргал нар, “Монгол, Орос, Хятадын шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа” хэмээх гуравдугаар зүйлийг Д.Алтай, Д.Батжаргал нар, “Монгол, Орос, Хятадын аялал жуулчлалын үйлдвэрлэл, хамтын ажиллагаа” хэмээх дөрөвдүгээр зүйлийг Ч.Батцэцэг, Д.Базардорж нар бичсэн болно.

Доктор Ч.Батцэцэг “Монгол, Орос, Хятадын соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа” хэмээх нэгдүгээр зүйлдээ хүйтэн дайнаас хойш эдүгээ хүртэлх хугацаанд Монгол, Орос, Хятад хөрш гурван орны соёл, хүмүүнлэгийн салбарын харилцаа, хамтын ажиллагаанд холбогдох гэрээ хэлэлцээр, хоёр хөршөөс Монгол Улсад явуулж буй “зөөлөн хүч”-ний бодлогын хэрэгжилтийн онцлог, нөхцөл байдлыг тус бүрд нь судалж, гурван талын харилцааг хөгжүүлэх боломжийг гаргахыг зорьжээ. 1990-ээд оноос хойших Монгол-Орос, Монгол-Хятадын соёлын харилцаа хамтын ажиллагааг хоёр талт байдлаар судлаж ирсэн бол энэ хэсэгт зохиогч Орос-Хятадын соёл боловсролын харилцааг үечлэн авч, хөгжлийн онцлогийг нь дурдан гаргасан төдийгүй Монгол, Орос, Хятадын гурван талт хүмүүнлэгийн салбарын харилцаа хамтын ажиллагааны эхлэл, өнөөгийн байдал ба хэтийн төлөвийн талаар өгүүлсэн нь шинэлэг болсон байна.

Доктор Н.Ариунгуа, А.Нямдолжин, Д.Батжаргал нар “Монгол, Орос, Хятадын боловсролын салбарын хамтын ажиллагаа” хэмээх зүйлд боловсролын систем дахь харилцаа, хамтын ажиллагаа нь харилцан итгэлцэлийг нэмэгдүүлж, ойлголцолыг буй болгох чухал хүчин зүйл гээд гурван талт харилцааг урагшлуулан хөгжүүлэх чухал ач холбогдолтой дурдаж, энэ талаар гурван улс идэвхитэй шат дараатай ажил өрнүүлж байгааг Монгол-Орос, Монгол-Хятадын хоёр талт болон Монгол, Орос, Хятад гурван талт харилцаагаар тодорхой өгүүлжээ. Чингэхдээ боловсролын салбар бол зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх чухал арга зам байдаг тул хоёр хөрш боловсролын систем, тухайлбал манай улсын боловсон хүчнийг бэлтгэхдээ “зөөлөн хүчний бодлогыг” геополитикийн үүднээс хэрэгжүүлж буйг үгүйсгэх аргагүй гээд үндэсний аюулгүй байдлын үүднээс энэхүү асуудалд

хянамгай анхаарч зохих түвшинд нь барьж тэнцвэржүүлэн хөгжүүлэхийн чухлыг онцолсон байна. Цаашид боловсролын салбар дахь хамтын ажиллагааг нарийвчлан судлах нь маш чухал бөгөөд орчин үед боловсролын утга учир, түүний ач холбогдол боловсролын хүчин зүйлээс улс төрийн хүчин зүйл болон хувирч байгааг анхаарах хэрэгтэйг сануулжээ. Боловсролын салбар дахь хамтын ажиллагаа нь гурвалсан харилцааг хөгжүүлэх чухал хүчин зүйл тул боловсрол хэмээх ойлголтонд оршиж буй утга санаа, түүний улс төр, геополитикийн агуулгыг нээн харуулж эдгээр нь манай гурван улсын хоорондын харилцаанд эерэг нөлөө үзүүлэх боломж байгааг мөн дурдан гаргасан байна.

Д.Алтай, Д.Батжаргал нар “Хүйтэн дайнаас хойших Монгол, Орос, Хятадын шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа” хэмээх гуравдугаар зүйлд Монгол-Оросын, Монгол-Хятадын, Орос-Хятадын шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа ба Монгол-Орос-Хятадын шинжлэх ухааны хүрээн дэх гурван талт хамтын ажиллагааг ангилан авч үзжээ.

Монгол-Оросын шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны тухайд өгүүлэхдээ хүйтэн дайнаас хойш харилцааны сорилтоос улбаатай бэрхшээлийг даван туулж 2000 оноос шинэ агуулга хэлбэрээр хөгжиж, хоёр орны ШУА-ийн харилцааны эрх зүйн үндэс шинэчлэгдэж, хамтын ажиллагааны шинэ механизм хэрэгжиж эхэлсэн ба тэдгээрийн тоо, чанарын үзүүлэлтэд ахиц гарах болсон хэмээн дурдаж, ялангуяа байгалийн шинжлэх ухааны суурь судалгааны сэдэвт ажил, хамтарсан грант төслүүд тооны хувьд нийгмийн ухааны салбараас давуу байгааг онцолжээ.

Харин Монгол-Хятадын шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны тухайд өгүүлэхдээ хүйтэн дайны жилүүдэд хорь гаруй жил тасалдсаны дараа сэргэж, өдгөө иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээнд хөгжих болсныг дурджээ. 2005 оноос Монгол Улс БНХАУ-ын ӨМӨЗО-ы хооронд шинжлэх ухаан техникийн харилцаа, хамтын ажиллагаа эрчимжиж, улмаар Монголын ШУА-ийн Хүрээлэнгүүд болон Хятадын ижил төстэй хүрээлэн, судалгааны байгууллагуудтай хамтарсан грант төсөл хэрэгжүүлж эхэлсэн байна. Хэдийгээр Монгол-Хятадын шинжлэх ухааны салбарын харилцаа, хамтын ажиллагаа хожуу хөгжиж буй ч зөвхөн нийгмийн ухааны салбараар хязгаарлахгүй, мал аж ахуй, сэргээгдэх эрчим хүч, харилцаа холбооны нанотехнологи, эмийн ургамлын фитохимийн судалгаа зэрэг байгалийн шинжлэх ухааны салбарт өргөжин гүнзгийрч байна хэмээн өгүүлжээ.

Орос, Хятадын шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны тухайд өгүүлэхдээ Хятад өөрийн оронд Оросын өндөр технологийг нэвтрүүлэх зорилтыг чухалчилдаг бөгөөд үүний үр дүнд техник технологийн бэрхшээлтэй олон асуудлыг шийдэж, судалгаа, хөгжлийн мөчлөгийг богиносгож, барууны орнуудаас техник технологийн хувьд хоцрогдсон байдлыг даван туулжээ хэмээгээд Орос, Хятадын олон хотод шинжлэх ухааны хамтын ажиллагааны технологийн парк, шинэчилсэн төвүүдийг байгуулсан нь хоёр орны шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны нэг хэлбэр болсныг онцолжээ.

Монгол-Орос-Хятадын шинжлэх ухааны салбарын гурамсан харилцааны тухайд өгүүлэхдээ шинжлэх ухаан технологийн салбарт хоёр болон гурван талт эрдэм шинжилгээний хурал, чуулган зохион байгуулагдаж байгаа нь хөрш орнуудын судлаачид харилцан туршлага, мэдлэгээс хуваалцах боломжийг өргөжүүлж энэ нь цаашид бодлогын зорилтот хамтарсан гурван талт судалгааны төсөл зэрэг гурамсан харилцааны шинэ хэлбэр бий болох хандлагатай байна хэмээжээ. “Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах” хөтөлбөрт шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны тодорхой зорилтууд тусгагдсан ч түүнийг хамтран хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл дутмаг, бодит ажил удаашралтай байгааг шүүмжилжээ. Түүнчлэн Монгол-Оросын, Монгол-Хятадын судлаачдын хамтарсан судалгаанд оролцож буй монголын залуу судлаачид нэмэгдэж, тэдний чадавхи, туршлага арвижиж байгаа нь Монголын шинжлэх ухааны салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд ач холбогдолтой хэмээгээд Монгол-Орос-Хятадын шинжлэх ухааны салбарын эрчимтэй харилцаа, хамтын ажиллагаа нь хөрш гурван орны дотоодын нийгэм-эдийн засгийн хөгжилд ахицтай байхын сацуу, Евразийн бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийн хөгжилд бодитой хувь нэмэр болох юм хэмээн дүгнэсэн байна.

Ч.Батцэцэг, Д.Базардорж нар “Монгол, Орос, Хятадын аялал жуулчлалын үйлдвэрлэл, хамтын ажиллагаа” хэмээх дөрөвдүгээр зүйлд хүйтэн дайнаас хойш аялал жуулчлал нь дэлхийн улс орнуудад эдийн засгийн чухал салбар, олон улсын тавцанд нэр хүндээ өсгөх чухал хүчин зүйл болж, орчин үеийн шинжлэх ухааны салбар болтлоо хурдацтай хөгжиж байгааг дурдаад хйтэн дайнаас хойш, ялангуяа шинэ зууны гараанаас Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа, хамтын ажиллагаанд аялал жуулчлалын үйл ажиллагаа харьцангуй идэвхжих болсон хэмээжээ. Монгол, Орос, Хятадын гурамсан харилцааны аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаанд хил орчмын бүс нутгийн харилцаа чухал байр

суурь эзэлж байна хэмээгээд үүнийг өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд эхлээд Монгол Улсын аялал жуулчлалын салбарыг эрчимжүүлж улмаар Орос, Хятадын аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаатай хэрхэн уялдуулах талаар бичсэн байна. Чингэхдээ Монгол, Орос, Хятадын аялал жуулчлалын гурамсан хамтын ажиллагаанд “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор”, “Торгоны замын аялал жуулчлал”, “Цайны замын аялал жуулчлал” зэрэг санаачилга, төсөл чухал байр суурь эзэлж байгааг дурдаад эгээр санаачилга, төслийн хүрээнд Монгол, Орос, Хятадын гурван талын аялал жуулчлалын хамтын ажиллагааны нөхцөл байдлыг тодруулан бичиж, гурван улсын хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх тухайд санал дэвшүүлэн гаргажээ.

**2. Ж.Баясах. “Монгол Улс ба хөрш орны гадаад бодлого”** УБ., Соёмбо принтинг, 2015, 37.5 хх.

Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдал, түүх соёл иргэншлийн асуудлыг тусгайлан авч үзсэн энэхүү бүтээл нь зохиогчийн эрдэм шинжилгээний өгүүлэл, гадаад дотоодод уншсан лекц, мөн сэдвийн хүрээнд сонин хэвлэлүүдэд өгсөн ярилцлага нийтлэлүүдээс бүрдсэн дөрвөн бүлэгт зохиол болно. Бүхэлдээ уг бүтээл нь Монгол Улсын хийгээд Орос, Хятад, Солонгос, АНУ болон Өрнөдийн орнуудын гадаад харилцааны асуудлыг хөндөн өгүүлсэн бөгөөд олон улсын харилцааг сонирхон судлагч хэн бүхэнд зориулагдсан байна. Өгүүлэл лекцүүдийн ихэнх нь монгол-англи, монгол-хятад, монгол-солонгос хос хэлээр бичигдсэн тул гадаадын хүмүүс хийгээд тэдгээр хэлийг сонирхон суралцагч хүмүүст харьцуулсан орчуулгын гарын авлага болон хэрэглэгдэх давхар ач холбогдолтой болжээ.

**3. Л.Бэгзжав. “Монгол-Хятадын харилцаа (1949-1999)”**, нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., ТЭПЭ, 2018, 10.8 хх.

Монгол, Хятадын харилцааг сонирхон судалдаг судлаач, оюутан сурагчдын гарын авлага болон хэрэглэгдсээр байгаа ч өдгөө олдоц ховордсон тул уг бүтээлийг тус хүрээлэнгээс эрхлэн хүрээлэн байгуулагдсаны 50 жил, Монгол-Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд дахин хэвлэн гаргасан байна. Чингэхдээ анхны хэвлэлтэд тухайн үеийн техник, хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан орхигдсон зарим зүйлийг засч сайжруулахыг зорьжээ. Хятад галигаар бичсэн ном болон хүний нэрийг ханз үсгээр буулгаж, товчилсон үгс, хүний нэрийн заагуурыг шинээр оруулж, зохиогчийн Хятад

судлал, орон судлалын чиглэлээр туурвисан голлох бүтээлийн жагсаалт, гэрэл зургийн цомогийг хамтатгасан байна.

4. К.Дэмбэрэл. **“Олон улсын харилцааны онол, үйл ажиллагааны үндэс”** УБ., 2018, 35.5 хх

Зохиогч тус бүтээлээ Олон улсын харилцааг бие даасан шинжлэх ухаан хэмээн үзэх үзэлд нэмэр оруулахыг хичээж, Монгол Улсаас гадаад улс орнуудад ажиллаж буй ДТГ-ын ажилтнуудад гарын авлага, үйл ажиллагааны чиглэлд нь дэм болох зорилгоор олон улсын харилцааны мэдлэгийг уг язгуураас эхлэн цэгцтэй, товч, энгийн хэлбэрээр бичжээ. Тиймээс олон улсын харилцааны талаархи ойлголтоос эхлэн түүнийг шинжлэх ухааны нэгэн салбар, өөрийнх нь суурь ойлголтуудтай нь авч үзсэн. Олон улсын харилцааны онол, үйл ажиллагааг тайлбарлахад энэхүү бүтээлийн 1-4-р бүлэг нь чиглэгдсэн бол 5-р бүлэгт гадаад бодлогын дүн шинжилгээ, шийдвэр гаргах үйл явцын талаар өгүүлжээ. Манай дипломатчуудын үйл ажиллагааны нэг хэсэг бол суугаа улсынхаа нийгэм, эдийн засаг, улс төрийн талаар “товч танилцуулах мэдээ” бичих ажил байдаг. Тэрхүү ажлыг гүйцэтгэхэд энэхүү судалгаанд тусгагдсан аргазүй зохих дэмжлэг үзүүлэх учиртай. Түүнчлэн хавсралт 6-р бүлэгт гадаад бодлогын дүн шинжилгээний 333 өгөгдөхүүний томъёолол, олон улсын харилцаа болон гадаад бодлого, дипломатчуудын үйл ажиллагаанд даруй хэрэг болохуйц нэр томъёо, нэршлийн тайлбар, нэрсийн товчлол, эх сурвалжийг ашиглах аргазүй, зураг схем, өнөөгийн судалгааны талаар, Монгол Улсын гадаад үйл ажиллагаа зэрэг асуудлыг оруулсан буй. Олон улсын харилцааны үндсэн, суурь ойлголтуудыг нэгтгэн багцлаад тус бүрт нь зохих тайлбарыг хийх замаар, эмх цэгцгүй, дураараар хэрэглэж буйг буруушаан, түүнийг цэгцлэхэд нэгэн алхам хийсэн. Олон улсын харилцааны суурь ойлголт хэмээх томъёоллыг гаргаж тусад нь бүлэг болгон судалгааны объектод оруулснаар тэдгээр ойлголтыг хаана, хэдийд хэрхэн хэрэглэх үндэслэлийг нь гаргаж өгснөөрөө практик ач холбогдолтой болжээ.

5. **“Монгол, Хятадын харилцааны шинэ эрин: Боломж, сорилт”** 《中蒙关系新时代：机遇，挑战》 олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2019 “Бэмби сан” хэвлэлийн газар

Монгол, хятад хэлээр гарсан энэхүү эмхэтгэл нь Монгол Улс БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд Олон улсын харилцааны хүрээлэнгээс голлон зохион байгуулсан олон улсын эрдэм



шинжилгээний хурлын үр дүн юм. Монголын талаас ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, ҮАБЗ-ийн дэргэдэх Стратегийн судалгааны хүрээлэн, МУИС, ШУТИС, “Эрдэнэс Тавантолгой” ХК зэрэг шинжлэх ухаан, их сургууль, биенесийн байгуулагын төлөөлөл болсон эрдэмтэд, шинжээчид, БНХАУ-ын талаас БНХАУ-ын Нийгмийн ШУА-ийн Ази, Номхон далайн судлалын хүрээлэн, БНХАУ-ын Орчин үеийн олон улсын харилцааны хүрээлэн, Зүүн хойд Ази судлалын хүрээлэн, ӨМӨЗО-ны Нийгмийн ШУА-ийн Орос ба Монгол судлалын хүрээлэн, Бээжингийн их сургууль, Өвөр Монголын их сургуулийн эрдэмтэн, багш, судлаачдын нийт хоёр улсын эрдэмтэдийн 12 илтгэл багтжээ. Зохиогчийн эрхийг хүндэтгэх үүднээс хятадын судлаачдын илтгэлүүдийг эх хэлээр нь болон тус хүрээлэнгийн судлаачдын хийсэн монгол орчуулгын хамт оруулсан байна.

Агуулга нь хоёр улсын дипломат харилцааны 70 жилийн түүхийн асуудал гэхээсээ голчлон улс төр, эдийн засаг, соёл хүмүүнлэгийн харилцааг цаашид хэрхэн үр ашигтай хөгжүүлэх шаардлага, боломжийг бүс нутгийн хөгжлийн үйл явц хийгээд Монгол, Орос, Хятад гурван талт харилцааны төлөв байдалд уялдуулан авч үзэхэд төвлөрсөн байна. Эрдэмтдийн энэхүү санал бодлыг бодлого боловсруулагч нарт хүргэх нь хурлын үндсэн зорилго байсан бөгөөд дэвшүүлсэн зорилгоо бүрэн биелүүлсэн хэмээн үзэж байна.

Уг эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд доктор Д.Шүрхүү *Монгол-Хятадын харилцааны шинэ үе шат: харилцан ашиг, хүртээмжтэй хөгжил*, доктор Фань Сяожу *Зүүн хойд Азийн шинэ байдал ба Хятад-Монголын харилцааны ирээдүй*, доктор Б.Отгонсүрэн *Монгол-Хятадын дэд бүтцийн хамтын ажиллагаа: тэргүүлэх чиглэл*, доктор Ду Шивэй *Хятад-Монголын харилцааны стратегийн гурван дэвшил ба боломж, сорилт*, профессор Д.Баярхүү *Хятадын стратегийн түншлэл*, доктор Ван Хао *Түүхийн урсгалыг дагаж, Хятад-Монголын харилцааны шинэ үеийг нээх нь*, доктор Наран (БНХАУ) *“Бүс ба зам”, “Хөгжлийн зам”-ын хүрээнд ӨМӨЗО-ны Монгол Улс дахь хөрөнгө оруулалт, худалдааны талаарх дүгнэлт ба зөвлөмж*, Д.Базардорж *Монгол-Хятадын хил дамнасан аялал жуулчлалын жишиг бүсийг хөгжүүлэх боломж*, Гуо Жигуан *Их өөрчлөлт дэх Хятад улс ба хөрш орнуудын харилцаа: өнөөгийн байдал ирээдүйн хөгжил*, Р.Давааням, Ж.Мөнхбаяр *Монгол-Хятадын нүүрсний зах зээлийн хөгжил, боломж, эрсдэл*, Б.Анхбаяр *Ши Жиньпиний хөрш орнуудын бодлогын өөрчлөлт, чиг хандлага*, Ли Чао *Хүн төрөлхтний хувь заяаны цогц нийтлэг болон Хятад-Монголын харилцааны ирээдүйн хөгжил* гэсэн илтгэлүүд нийтлэгджээ.

**6. Монголын эрдэмтдийн “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор”-ын талаарх өгүүллийн эмхэтгэл.** Улаанбаатар 2018, Эмхэтгэсэн Ш.Амангүл, Мөнхийн үсэг, 18.5 хх.

Тус өгүүллийн эмхэтгэл нь Монгол, Орос, Хятадын хооронд байгуулахаар тогтсон эдийн засгийн коридорын байгуулалтын асуудлаар Монголын эрдэмтэд улс төр, эдийн засаг, уул уурхай, дэд бүтэц, аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын харилцааны чиг хандлага, тулгамдсан асуудлуудын талаар бичсэн өгүүллүүдийн зэрэгцээ Хятадын төрийн тэргүүнээс ХКН-ын 19 дүгээр их хуралд тавьсан илтгээлтийг бүрэн эхээр нь орчуулсан нь БНХАУ-ын төр засгийн бодлогыг судлах судлаачдад эх хэлээрээ ашиглах чухал хэрэглэгдэхүүн болсон юм.

Өгүүллийн эмхэтгэлд доктор (Sc.D) Ц.Баатар *Монгол-Хятад-Орос гурван улсын эдийн засгийн зурвас бүс: баруун босоо тэнхлэг*, доктор (Sc.D) Ж.Баясах *Монгол улсын тусгаар тогтнол ба гадаад бодлогын тулгын гурван чулуу*, магистр Ж.Баярбаатар *Нөхөр Ши Жиньпингээс Хятадын коммунист намын 18 дугаар их хурлын төв хорооны байнгын хороог төлөөлөн 19 дүгээр их хуралд тавьсан илтгэл (монгол, хятад хэлээр)*, доктор (Sc.D) А.Даваасүрэн *Монгол, Хятад, Оросын хооронд эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтын ач холбогдол*, доктор (Ph.D) С.Отгонбаатар *Монгол-Орос-Хятадыг холбосон эдийн засгийн баруун коридор ба аялал жуулчлалд түшиглэсэн хөгжил*, доктор (Ph.D) Н.Төмөр *Гурван улсын эдийн засгийн коридорт дэд бүтцийн салбар дахь хамтын ажиллагааы гүйцэтгэх үүрэг (монгол, хятад хэлээр)*, мөн доктор (Ph.D) Н.Төмөр *Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридорын бүрэлдэхүүн хэсэг – экологийн орчныг хамгаалах болон сэргээгдэх эрчим хүчийг ашиглах салбар дахь хамтын ажиллагаа (монгол, хятад хэлээр)* гэсэн өгүүллүүд нийтлэгдэв.

**7. Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдэмтэдийн гадаад хэл дээрх өгүүллийн эмхэтгэлүүд.** 5 дэвтэр. (Орос, хятад, англи, япон, солонгос хэлээр тус бүр нэг дэвтэр) УБ., 2016

Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын сүүлийн жилүүдэд бичиж хэвлүүлсэн орос, хятад, англи, солонгос, япон хэлээрх өгүүлэл, эрдэм шинжилгээний илтгэлүүдийг эмхэтгэн нийтэлжээ. Чингэхдээ дэвтэр болгонд нийтлүүлсэн өгүүлэл, илтгэлүүд агуулгын хувьд давхцаагүй ба зохиогчдын товч танилцуулгийг хавсралтад тухайн хэлээр нь мөн бичиж оруулжээ. Хүрээлэнгийн хамт олны бүтээлийг гадаадын эрдэмтэдэд олон хэлээр дамжуулан сурталчилах

зорилгоор эмхэтгэн хэвлүүлсэн эдгээр бүтээл урьд өмнө манай улсад хийгдэж байгаагүй шинэлэг ажил байж, тус хүрээлэнгийн гадаад харилцааны ажилд түлхэц үзүүлсэн ач холбогдолтой болжээ. Хятад хэлээрх ботийг Д.Базардорж, П.Бямбахорол нар, орос хэлээрх ботийг Д.Аюуш, К.Дэмбэрэл нар, англи хэлээрх ботийг Т.Бат-Амгалан, япон хэлээрх ботийг Б.Сэржав, У.Загдзэсэм нар, солонгос хэлээрх ботийг Э.Энхболд нар тус тус хариуцан эрхлэн хэвлүүлсэн байна.

**8. “Монгол, Хятадын дурсамжууд”** Хятад хэлнээс монгол хэлнээ орчуулсан Д.Базардорж, Н.Ариунгуа нар Бээжин 2019,

Монгол, Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулан Хятадын ахмад дипломатчдын клубээс санаачлан дипломат харилцаа бүхий улс орнуудтайгаа хамтран гаргадаг “Тэд нар ба бид нар” цувралын хүрээнд энэхүү дөрвөн бүлэгт дурсамжийн номыг монгол, хятад хэлээр эрхлэн гаргажээ. Хятад хэлний хэвлэлийн нэр нь “中国和蒙古国的故事”. Монгол хэлний хэвлэл нь 348 хуудастай. Ерөнхий редактораар БНХАУ-аас Монгол Улсад суух Элчин сайд асан Гао Шүмао ажилласан бол монгол хэлнээ орчуулах ажлыг тус хүрээлэнгийн Хятад судлалын салбарын судлаачид хариуцсан байна. Энэхүү ном хоёр улсын харилцааны сайнтай саартай хөгжлийн үйл явцад оролцож, хоёр орны харилцааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, өөр өөр цаг хугацаанд ажиллаж амьдарч байсан, мөн өдгөө ч үйл хэргээ үргэлжлүүлсээр буй дипломатчид, зохиолчид, орчуулагчид, эрдэмтэд, бизнесмэнүүд зэрэг адил бус мэргэжлийн 24 хүний дурсамж, дуртгалаар бүтжээ. Тэд хоёр улсын харилцааны зам дахь анхдагчид, гэрчүүд тул тус тусынхаа туулсан амьдрал дахь хоёр улсын харилцааны түүхийг олон өнцгөөс өргөн хүрээг хамарч дүрсэлсний нийтлэг агуулга нь Монгол, Хятадын харилцаа өнөөгийн өндөрлөгт хүрч хөгжсөн амжилт амар хялбараар олдоогүй гэдгийг дор бүрнээ илэрхийлжээ. Энэхүү дурсамжийн номоос холбогдох сэдвээр бүтээгдсэн судалгааны бүтээлүүдэд тэр болгон тусгагдаж чаддаггүй үйл явдалд оролцогч хувь хүмүүсийн торгон мэдрэмж, сэтгэл зүрхнээс урган гарсан сонин содон үг өгүүлбэрийг олж уншин, Монгол, Хятадын харилцааны өнгөрсөн өнөөгийн асуудлаарх мэдлэгийн хүрээгээ өргөжүүлэн тэлэх боломжтой.

**9. Лань Мэйхуа. “Цэдэнбалын үеийн Монгол, Хятадын харилцаа”** Улаанбаатар, 2019. Орчуулсан Д.Батжаргал нар.

Монгол судлал тэр дундаа Монголын түүх судлалын олон арван жилийн уламжлалтай Тайваний монголч эрдэмтдийн өнөө цагийн томоохон төлөөллийн нэг Үндэсний Чэнчи их сургуулийн профессор, доктор Лань Мэйхуан энэхүү бүтээлийг албан ёсны эрхтэйгээр эх хэлээрээ орчуулан гаргасан юм. Олон мянганы турш айл зэргэлдээ хөршлөн оршсон Монгол, Хятадын ард түмний харилцааны түүх өнө эртний уламжлалтай бөгөөд Монгол Улсын шинэ үеийн гадаад харилцааны түүхэнд ч Монгол, Хятадын харилцаа онцгой байр эзэлсээр байна. Тэр дундаа хүйтэн дайны хямралын эгзэгтэй үед Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн болж чадсан шинэ Монголын түүхийн нэн сонирхолтой үе болох социалист бүтээн байгуулалт, нийгэм, соёлын үсрэнгүй өөрчлөлт дэвшлийн түүхийг монголч эрдэмтний өнцгөөс тодорхойлон бичсэнд энэхүү бүтээлийн үнэ цэнэ, онцлог тал оршиж байна. Тус бүтээлд ХХ зууны Монголын түүхэнд холбогдох өрнөдийн эрдэмтдийн бүтээл, архивын баримтыг голлон ашиглаж, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсан нь үүний бодит нотолгоо хэмээн үзэж болно. Энэхүү бүтээл ХХ зууны Монголын гадаад харилцаа, Монгол-Хятадын харилцааны түүхийг шимтэн сонирхдог хэн бүхний ширээний ном болно гэдэгт итгэлтэй байна. Энэхүү бүтээлдээ Ю.Цэдэнбалын засаглалын үеийн Гадаад Монгол, коммунист Хятадын харилцаанд анализ хийж, Гадаад Монголын тухайн үеийн түүхэн хөгжлийн талаар илүү гүнзгий ойлгохыг оролдож, Гадаад Монгол нь коммунист Хятад, ЗХУ гэсэн эсрэгцсэн хоёр хүчний хооронд хэрхэн оршин тогтнож байв? Коммунист Хятад, ЗХУ-ын харилцаа Гадаад Монгол, коммунист Хятадын харилцааны хөгжилд хэрхэн нөлөөлөв? Гадаад Монголын хувьд идэвхгүй гадаад бодлого явуулахаас өөр сонголт байсан уу? зэрэг асуултад хэсэгчлэн хариулт өгөхийг оролдов. Энэхүү бүтээл бол Хятадын хилийн бүс нутгийн судалгааны хүрээлэнд хамгаалсан миний магистрын дипломын ажлыг бага зэрэг нэмж засварласан хувилбар юм.

**10.** Судалгааны үр дүнг эргэлтэд оруулах, шинжлэх ухааны мэдлэгийг нийтэд түгээн сурталчлах хамгийн сайн аргуудын нэг болох эрдэм шинжилгээний хурал, симпозиумыг нэлээд идэвхитэй зохион байгуулсны дотор үндэсний болон олон улсын өндөр түвшинд хийгдсэн зарим хурлуудын талаар тоймолвол:

- **“Монгол, Хятадын харилцааны шинэ эрин: Боломж, сорилт”** сэдэвт Монгол-Хятадын эрдэмтдийн хамтарсан эрдэм шинжилгээний хурал Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг

тэмдэглэн өнгөрүүлэх хоёр талын нэгдсэн төлөвлөгөөнд орсон "Монгол, Хятадын харилцааны шинэ эрин: Боломж, сорилт" сэдэвт Монгол-Хятадын эрдэмтдийн хамтарсан эрдэм шинжилгээний хурлыг 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Гадаад харилцааны яамны "Зөвшилцөл" их танхимд зохион байгуулахад тус хүрээлэнгийн Хятад судлалын салбар голлох үүрэгтэй оролцлоо. Энэхүү эрдэм шинжилгээний хурлыг Монгол, Хятад хоёр орны Гадаад харилцааны сайд нар санаачлан идэвхитэй дэмжлэг үзүүлсэн нь хурал үр дүнтэй, ажил хэрэгч болоход чухал түлхэц үзүүлснийг энд онцлон дурдмаар байна. Энэхүү хуралд Монголын талаас ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Стратегийн судалгааны хүрээлэн, МУИС, ШУТИС, Дипломатын академи /ТББ/, Эрдэнэс тавантолгой ХК зэрэг төр засаг, судалгаа, сургалт, бизнесийн байгууллагуудыг төлөөлсөн 9 эрдэмтэн, мэргэжилтэн оролцсон бол БНХАУ-ын талаас Орчин үеийн олон улсын харилцааны хүрээлэн, БНХАУ-ын Нийгмийн ШУА-ийн Ази, Номхон далайн болон Дэлхийн стратеги судлалын хүрээлэн, Угсаатан, Антропологийн хүрээлэн, ӨМӨЗО-ны Нийгмийн ШУА-ийн ОХУ, Монгол Улс судлалын хүрээлэн, Бээжин их сургууль, Өвөр Монголын Их Сургууль зэрэг сургалт судалгааны байгууллагуудаас 6 эрдэмтэн тус тус илтгэл бэлтгэж оролцсон болно. Монгол-Хятадын эрдэмтдийн хамтарсан энэ удаагийн хурлын хэлэлцсэн илтгэлүүд гол төлөв хоёр талын харилцааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг тодорхойлсон, улс төр, эдийн засаг, худалдаа, уул уурхай, аялал жуулчлал гэх мэт өргөн хүрээг хамарсан, чиглэл бүрийн салбарын залуу эрдэмтэд түлхүү оролцсоноороо онцлог бөгөөд хоёр талын харилцааг хөгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулсныг талууд онцлон тэмдэглэсэн билээ.

- **“Монгол Улс судлалын өнгөрсөн ба ирээдүй”** олон улсын эрдэм шинжилгээний хурал, ӨМӨЗО-ны Баарин зүүн хошуу. 2019.09.21-23.

Монгол, Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг тохиолдуулан ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн БНХАУ-ын Монгол Улсыг судлах нийгэмлэг, ӨМИС-ийн Монгол Улсыг судлах хүрээлэн, Улаанхад хотын захиргаатай хамтран зохион байгуулав. Монгол Улсаас ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, МУИС-ийн ОУХНУС, МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэн, СУИС-ийн Соёл урлаг судлалын хүрээлэн, БНХАУ-ын талаас Монгол Улс судлах нийгэмлэг, ӨМИС-ийн Монгол Улс судлах хүрээлэн, ӨМӨЗО-ны НШУА-ийн Орос, Монгол судлалын хүрээлэн зэрэг судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагын 60 гаруй судлаач оролцжээ. Монгол-Хятадын улс төр, худалдаа

эдийн засаг, соёл боловсрол, аялал жуулчлалын харилцаа, Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор, Монгол Улсын худалдаа эдийн засаг, соёл боловсрол, нийгмийн асуудал зэрэг өргөн хүрээг хамарсан илтгэл хэлэлцүүлжээ.

- ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс МУИС-ийн ОУХНУС, Засгийн газрын дэргэдэх Удирдлагын Академи, Монголын Дипломатын Академи, Аюулгүй байдлын судалгааны төв зэрэг байгууллагатай хамтран 2 дахь удаагийн **“Монголын геополитик”** Академик мэтгэлцээнийг **“Буддын шашны дипломат үйл ажиллагаа”** дэд сэдвийн хүрээнд 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав.

Энэхүү Академик мэтгэлцээний зорилго нь улс төр, аюулгүй байдал, геополитик, олон улсын харилцааны чиглэлээр судалгаа хийдэг мэргэжлийн байгууллагууд болон улс төрч, эрдэмтэн судлаачид хамтран Монгол улсын хувьд тулгамдаж буй асуудлыг тодруулах, онол практикийн мэдлэгээ цэгцлэх, судалгааны аргазүйг нээх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, залуу улс төрч, судлаачдыг дэмжих, академик мэтгэлцээний соёлыг төлөвшүүлэх, Монголд геополитик судлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах явдал бөгөөд мэтгэлцээний үр дүнд Монгол дахь буддын шашны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шийдвэр гаргагчдад хэрэглэгдэхүйц зөвлөмж боловсруулан хүргүүлсэн юм.

Уг арга хэмжээнд ҮАБЗ, Ерөнхийлөгчийн Тамгын Газар, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, УИХ-ийн АБГББХ, ГХЯ, ТЕГ, Үндэсний хөгжлийн газар, ШУА, МУИС, ҮБХИС-ийн БХЭШХ, ХСИС-ийн ЭШХ, ЗГХГ-ын дэргэдэх Удирдлагын Академи, Монголын Дипломатын Академи, Хууль сахиулахын Удирдлагын Академи, Тагнуулын Академи, Геополитик судлалын хүрээлэн, Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төв, Энхтайван АБС-ын хүрээлэн, Цэнхэр сүлд ТББ, ХИС-ийн ОУХНСС, Улаанбаатар судалгааны хүрээлэн, Зүүн Хойт Азийн АБСХ зэрэг мэргэжлийн байгууллагын төлөөллөөс гадна Монгол улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, ҮАБЗ гэх мэт төрийн өндөр албанд ажиллаж байсан хүмүүс, Ерөнхийлөгч болон УИХ-ын дарга, Ерөнхий сайдын Гадаад бодлогын зөвлөхүүд, Элчин Сайдууд, Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайдууд, улс төрч, ахмад дипломатч, эрдэмтэн судлаачид өргөнөөр оролцсон юм. ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Хятад судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Д.Базардорж *“Богдын дараагийн дүрийг тодруулах асуудалд (Түүхэн нөхцөл ба боломж, сорилт)”* сэдвээр үндсэн мэтгэлцэгчээр, захирал, доктор Д.Золбоо мэтгэлцээний модератороор оролцсон болно.

- ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс ШУТСантай хамтран **“Ази дахь геополитикийн өөрчлөлт, хэтийн төлөв ойрын 10 жилд”** эрдэм шинжилгээний бага хурлыг 2017 оны 7-р сарын 3-ны өдөр ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын Хурлын танхимд зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний бага хуралд гадаадын Монгол, Орос, Хятадаас гадна Австрали, Франц, Нидерландын эрдэмтэн судлаачид оролцож, Орос, Монгол, Хятад гурван улсын эдийн засгийн коридор, Ойрхи Дорнод руу чиглэсэн Оросын гадаад бодлого, цэргийн ажиллагаа, Орос-Америкийн харилцаа, Ази дахь газар нутгийн маргаан, Солонгосын хойгийн аюулгүй байдал сэдвүүдээр илтгэл хэлэлцүүлжээ. Хурлын үеэр манай улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх, гурав дахь хөрш орнуудтай түншлэлийн харилцаа хамтын ажиллагаа хөгжүүлж тэдний ашиг сонирхлыг Монголд бий болгох арга замын талаарх сонирхолтой шинэ санаа, дүгнэлтүүдийг дэвшүүлсэн байна.

## ДҮГНЭЛТ

1. Сэдэвт ажлын хүрээнд дэвшүүлсэн зорилго хийгээд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг амжилттай биелүүлж, гэрээнд тусгагдсан бүтээлүүдийг тоо чанарын хувьд давууллаа.

2. Тус хүрээлэнд 2013-2015 онд хэрэгжиж дууссан “Монгол Улс дахь Орос, Хятадын ашиг сонирхолын тулгамдсан асуудлуудын судалгаа” сэдэвт төсөлтэй залгамж чанарын хувьд уялдан үргэлжилжсэн болохоор хөрш орнуудын асуудал хийгээд Монгол Улсаас тэдгээртэй харилцахыг чухалчлан судлах тус хүрээлэнгийн судалгааны стратеги зорилтыг хангахад чухал хувь нэмэр оруулсан ажил боллоо.

3. Сэдэвт ажлын хүрээнд бичигдсэн хамгийн гол ажил болох «“Хүйтэн дайн”-аас хойших Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа» нэгэн сэдэвт хамтын бүтээл нь хүйтэн дайнаас хойших Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд илэрч гарсан ч “гуравдагч хөршийн бодлого”-той нягт уялдаатай өрнөж буй Монгол, Орос, Хятадын гурван талт харилцааны үүсэл, өрнөл, онцлогийг бүс нутгийнхаа нөхцөл байдлын өөрчлөлт хөдөлгөөнд суурилан нягталж, тэрхүү гурван талт харилцааны Монгол Улсад үзүүлж буй эерэг сөрөг нөлөөг үнэлэн цаашдын хөгжлийн чиг хандлага, боломж, сорилтыг тодорхойлон суурь судалгааны сэдэвт ажлын түвшинд боловсруулахдаа судлаачдынхаа байр суурийг нэгтгэн дүгнэлт санал дэвшүүлсэнээрээ шинэлэг ажил болж байна.

4. Энэхүү суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд бодлогын судалгаа, зөвлөмжүүд хийгээд санал бэлтгэн төр засагт үйлчлэх үүргээ тодорхой хэмжээнд биелүүллээ. Бодлого боловсруулах төрийн байгууллагууд, шийдвэр гаргах эрх мэдэл бүхий хүмүүст хүргэсэн зарим зөвлөмж харьцангуй богино хугацаанд төрийн бодлого шийдвэрт тусан хэрэгжиж эхэлсэн нь уг ажлын ач холбогдолыг тодорхойлох үзүүлэлт боллоо хэмээн үзэж байна. Мөн төрийн зарим тусгай байгууллагуудын захиалгаар хөрш орнуудын нөхцөл байдал хийгээд тэдгээрийн Монгол дахь нөлөө тусгалын талаар сэдэвт ажлын гүйцэтгэгчид жил дараалан уригдан тусгайлан яриа лекц тавьсан нь тэдгээр байгууллагуудын ажилчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх практик ач холбогдолтой чухал ажил болсон хэмээн үзэж байна.

5. Сэдэвт ажлын үр дүнг нийгэм, олон нийтэд хүргэх талаар идэвхитэй ажиллаж, шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, ард иргэдийг соён гэрээрүүлэх үүргээ сайн биелүүллээ. Олон нийтэд зориулсан хамтын бүтээл,



товхимол, орчуулгын ном 9-ийг хэвлэж түгээлээ. Эрдэм шинжилгээний 6 хурал зохион байгуулж, төслийн гүйцэтгэгчид олон өгүүлэл, илтгэл нийтлүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэл ярилцлага, мэдээлэл, үйл явдлын тайлбар өгөх зэргээр судалгааны үр дүнг олон нийтэд сурталчилсан нь эрдэм шинжилгээ, практикийн зохих үр дүнтэй ажил болсон гэж үзэж байна.

Тайлан бичсэн:

Ж.Баясах. Доктор (Sc.D), профессор  
Сэдэвт ажлын удирдагч, ОУХХ-гийн зөвлөх

«ХҮЙТЭН ДАЙН»-ААС ХОЙШИХ МОНГОЛ, ОРОС, ХЯТАДЫН  
ГУРАМСАН ХАРИЛЦАА» СЭДЭВТ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН  
БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ /2017-2019/

НЭГ. НОМ, БҮТЭЭЛ

Нэгэн сэдэвт бүтээл

1. “Хүйтэн дайнаас хойших Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа” хамтын бүтээл, хэвлэлтэд. 30 хх
2. Ж.Баясах. “Монгол Улс ба хөрш орны гадаад бодлого” УБ., Соёмбо принтинг, 2015, 37.5 хх.
3. Л.Бэгзжав, “Хятад, Монголын харилцаа (1949-1999)”, Нэмж засварласан 2 дахь хэвлэл, УБ, ТЭПЭ, 2018, 10.8 хх
4. К.Дэмбэрэл. “Олон улсын харилцааны онол, үйл ажиллагааны үндэс” УБ., 2018, 35.5 хх.

Эмхэтгэл

5. Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдэмтэдийн гадаад хэл дээрх өгүүллийн эмхэтгэлүүд. (Орос, Хятад, Англи, Япон, Солонгос хэлээр тус бүр нэг дэвтэр) УБ., 2016
6. “Монголын эрдэмтэдийн Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын талаарх өгүүллийн эмхэтгэл” Ж.Баясах нар УБ., 2018, 18.5хх
7. “Монгол, Хятадын харилцааны шинэ эрин: Боломж, сорилт” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2019 “Бэмби сан” хэвлэлийн газар.

Орчуулгын ном

8. “Монгол, Хятадын дурсамжууд” Хятад хэлнээс монгол хэлнээ орчуулсан Д.Базардорж нар Бээжин 2019, 22.5хх
9. Лань Мэйхуа. “Цэдэнбалын үеийн Монгол, Хятадын харилцаа” Хятад хэлнээс монгол хэлнээ орчуулсан Д.Батжаргал нар. УБ., 2019, 12.16хх.

**ХОЁР. БОДЛОГЫН СУДАЛГАА, ЗӨВЛӨМЖ**

1. О.Батсайхан “Шашны хуулийн төсөлд зориулсан бодлогын зөвлөмж”, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүлээлгэн өгөв. Улаанбаатар, 2018.10.30.

2. К.Дэмбэрэл. *“ШХАБ ба Монголын оролцоо”* ШХАБ-ын хэтийн төлөв, Монгол Улсын баримтлах бодлого сэдэвт хэлэлцүүлэгт дэвшүүлсэн санал. ГХЯ-ны Дипломатын Академи, Улаанбаатар, 2019.04.24.

3. Д.Базардорж. *“Монголын бурхны шашны нөхцөл байдал ба хөрш орнуудын нөлөө”* сэдвээр бодлогын зөвлөмж бичиж Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн Ажлын албанд шилжүүлэн өгөв. 2019.03.07.

## ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

### Д. Алтай

1. *“Горбачёвын” перестройка: Монголын талаархи ЗХУ-ын ашиг сонирхолын өөрчлөлт*”, Монгол Улсын гадаад харилцаа: түүх, орчин үе өгүүллийн эмхэтгэл, УБ, Соёмбо принтинг, 2018, 301-314-р тал.

2. *“Взаимодействие на Евразийском континенте: участие Монголии в ШОС (Шанхайская Организация Сотрудничества)”*, Globalization and Modern Eurasia: History, Trends, Challenges for Change, The Ninth East Asian conference on Slavic Eurasian studies, Ulaanbaatar, 2018, Udam soyol Printing company, pp.69-74.

3. *“Trilateral cooperation of Mongolia, Russia and China in the field of environmental protection: Current state and tasks”*, Proceedings of China-Mongolia-Russia Think Tank Forum, Ulaanbaatar, Mongolia, 2018.09.18-19, 318, pp.171-178.

### Н.Ариунгуа

4. *Трехстороннее сотрудничество с Россией и Китаем как залог сбалансированного и эффективного экономического развития Монголии /середина XX- начало XXIв./*, Вестник Бурятского научного центра Сибирского отделения Российской Академии наук, 2017№1/25/, стр.138-144.

5. *Политические и экономические взаимосвязи МНР, СССР и КНР в 1953-1985 гг. // Монгольский мир в условиях взаимодействия России и Восточной Азии в XX-XXI вв.* Улан-Удэ. Издательство. БНЦ СО РАН. 2017, стр. 98-108.

6. *“Нэг зам, нэг бүс” төсөл бол Монгол, Орос, Хятадын хоорондын уламжлалт харилцааны үргэлжлэл мөн*”, “Шинжлэх ухаан”/ Шинжлэх ухаан технологийн сангийн сэтгүүл 5 х. 2018. 11 сар

7. *“Хүйтэн дайнаас дараах Монгол, Орос, Хятадын гурамсан харилцааны үе шат, онцлог”*, Олон улс судлал, №1(2019).

## **Д.Аюуш**

8. *Актуальные проблемы торгово-экономического сотрудничества между Монголией и Россией.*// “Олон улсын харилцаа” сэтгүүлийн тусгай дугаар. 2018. 20-33-р тал.

9. *“Гадаад өр зээлийг зохицуулах олон улсын туршлага ба хуучин ЗХУ-д төлөх “ИХ ӨР”-ийг шийдвэрлэсэн нь”*, Монгол Улсын гадаад харилцаа: түүх, орчин үе. Эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл. Эмхэтгэсэн: Б.Сэржав, К.Дэмбэрэл. УБ. “Соёмбо Принтинг”, 2018, 323-331-р тал.

10. Д.Аюуш, В.А.Родионов, Б.Санжмятав, “Роль “третьего соседа” в политической стратегии Монголии”, Вестник БНЦ СО РАН, 2018, №4, С. 60-68.

11. *“Russian influence in trade-economical cooperation between Russia and Mongolia”*, World Affairs, 2019, №4.

## **Ц.Баатар**

12. *“Монгол-Хятад-Орос гурван улсын эдийн засгийн зурвас бүс: Баруун босоо тэнхлэг”*, Монголын эрдэмтдийн Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор өгүүллийн эмхэтгэл, УБ, 2018, 3-22-р тал.

## **Д. Базардорж**

13. *“Цөлжилттэй тэмцэж буй Хятад улсын арга туршлага: Хөвчийн элс болон Муу-Ус, Хуландаагийн элсэрхэг газрын жишээн дээр”* (Монгол, хятад хэлээр) Ши Жиньпингийн шинэ эрин үеийн Хятадын онцлогтой социализмын үзэл санаа хэмээх Монгол, Хятадын хамтарсан судалгааны өгүүллийн эмхэтгэл, УБ., 2019, 6-14, 113-122 дугаар тал.

## **Ч. Батцэцэг**

14. *“Монгол Улс, БНХАУ-ын соёлын харилцаа, хамтын ажиллагаа XXI зуунд”*, “Монгол Улсын гадаад харилцаа түүх, орчин үе” УБ., 2018 331-341-р тал.

15. *“Орос, Хятадын соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбарын харилцаа, хамтын ажиллагааны төлөв байдал”*, Олон улс судлал сэтгүүл, Улаанбаатар, 1(2019).

## **Ж.Баясах**

16. *“Mongolia has an important part to play in the Road and Belt project”*, The Mongolian Observer №5 (057), May 31, 2017, p.66-69.

17. *The Three Cornerstones of Mongolia's Independence and Foreign Policy*, ISPSW Strategy Series: Focus on Defense and International Security, Issue No. 579, Berlin, Sep 2018,

18. Р.Төрдалайн хамт. “Монгол Улсын тусгаар тогтнол ба гадаад бодлогын тулгын гурван чулуу”, *Рах Mongolica*, 2018, №1, 3-19-р тал.

#### **К. Дэмбэрэл**

19. “Нийгмийн салбар, хүн ам зүйн нөхцөл байдал”, *Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс-2018*, Судалгааны өгүүллүүд, Улаанбаатар, Аюулгүй Байдал судлалын хүрээлэн, 2019, 45-54 дүгээр тал.

#### **А. Нямдолжин**

20. *Культурно-гуманитарные взаимоотношения как главные факторы экономического коридора Монголии, России и Китая.*//Вестник Бурятского научного центра Сибирского отделения Российской Академии наук. №4, 2017. Изд-во БНЦ СО РАН.

21. *Mongolia and Russia have a long way to go in boosting relations.*//The Mongolian Observer. №6 (060), 30.6.2017. P.51-56.

22. А.Нямдолжин, Б.В.Базаров, В.Б.Базаров. *Внешиполитическое сотрудничество России, Монголии и Китая.* //Монгольский мир в условиях взаимодействия России и Восточной Азии в XX-XXI вв. Улан-Удэ. Издательство. БНЦ СО РАН.2017, стр. 137--174.

23. *Роль образования в вопросе взаимодействия между Монголией и Россией.* //Eurasia: Statum et Legem (Евразия: Государство и Право). Международный научный журнал. 10/2018. стр.71-78.

24. “*Mongolia's view on Sino-Russian relations*”, Near, Far, Wherever You Are: Views on Sino-Russian Relations, Northeast Asia Today, Vol.5, April 25, 2018; *The Journal of the Mongolian Society*, Bloomington, Indiana, 2019

25. “Монгол-Оросын боловсролын салбарын хамтын ажиллагаа, хэтийн төлөв”, Олон улс судлал сэтгүүл, Улаанбаатар, 1(2018).

26. “Монгол Улс, ОХУ-ын харилцаанд хийсэн дүн шинжилгээ”, “Монгол Улсын гадаад бодлогын өнөөгийн байдал ба цаашдын чиг хандлага” сэдэвт төслийн эмхэтгэл, Хөгжлийн бодлогын судалгааны хүрээлэн, Улаанбаатар, 2019.

## **Н.Төмөр**

27. *“Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа-Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг: Өнгөрсөн ба ирээдүй”* Хармөрөн муж болон Зүүн хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны талаар өргөн хэлэлцүүлэх нь, Хар мөрөн мужийн хэвлэлийн газар, 2018.

28. *“Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг-ногоон хөгжил”*, МУИС-ийн “Олон улсын харилцаа” сэтгүүл, УБ., 2019.

## **Д. Шүрхүү**

29. *“БНХАУ-ын улс төр, эдийн засгийн өнөөгийн байдал ба Монгол Улс”* “Монгол Улсын аюулгүй байдлын орчин-батлан хамгаалах бодлого” УБ 2017, тал 79-90

30. Д.Шүрхүү, В.Б.Базаров, *“Формирование нового курса внешней политики Монголии”*, Монгольский мир в условиях взаимодействия России и Восточной Азии в XX-XXI вв, Улан-Удэ. Издательство. БНЦ СО РАН, 2017, стр.129-137.

31. *АНУ-БНХАУ-ын стратегийн сөргөлдөөн ба Монгол Улсын хөгжил, аюулгүй байдалд үзүүлэх нөлөө*, “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүл 2018, №26(36)

32. *“Цэнгэг ус, ногоон уул бол алтнаас ч үнэтэй” үзэл онол ба Сайхан давааг дахин ойжуулсан түүхэн туршлага* (Монгол, хятад хэлээр) Ши Жиньпингийн шинэ эрин үеийн Хятадын онцлогтой социализмын үзэл санаа хэмээх Монгол, Хятадын хамтарсан судалгааны өгүүллийн эмхэтгэл, УБ., 2019, 1-5, 107-112 дугаар тал.

ДӨРӨВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ:

## **Д.Алтай**

1. *Отношения между ШОС и Монголией*// ШХАБ-ын асуудлаархи Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. БНХАУ, Бээжин хот, Нийгмийн ШУА. 2018.03.26.

2. *“Interconnectivity in the region of Eurasia: Mongolia s presence in Shanghai Cooperation Organization”*.// “Globalization and Modern Eurasia: History, Trends, Challenges for Change”. Ulaanbaatar. 2018.06.30.

3. *“Взаимодействие на Евразийском континенте: участие Монголии в ШОС (Шанхайская Организация Сотрудничества)”*, Слав-Еврази судлалын Зүүн Азийн олон улсын есдүгээр бага хурал, Улаанбаатар, 2018.07.01.

4. *“Монгол, Орос, Хятад Улсын хүмүүнлэгийн солилцооны салбарын хамтын ажиллагаа: Зорилт ба өнөөгийн байдал”*, Слав-Еврази судлалын Зүүн Азийн олон улсын Х бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, Токио Их сургууль, 2019.06.29-30.

5. *“Хүрээлэн буй орчныг хамгаалах салбар дахь Монгол, Орос, Хятадын гурван талт хамтын ажиллагаа: Өнөөгийн байдал ба цаашдын зорилт”*, Хятад, Монгол, Оросын Тинк Танкын олон улсын форумын илтгэлүүдийн эмхэтгэл, Улаанбаатар, 2019.

#### **Н.Ариунгуа**

6. *“Хятадын гадаад бодлого: Хятад-Монголын харилцаа”*, Тагнуулын академи дээр болсон эрдэм шинжилгээний бага хурал. 2017 оны 5 дугаар сар.

7. *“Боловсролын салбар дахь хамтын ажиллагаа нь гурвалсан харилцааг хөгжүүлэх чухал хөшүүрэг мөн”*, Ази судлалын олон улсын эрдэм шинжилгээний хурал, Vol. 5, Улаанбаатар, 2019.05.10.

8. *“Монголын хятад судлалын хөгжлийн онцлог”*, МУИС-ийн ОУХНУС болон БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн Монгол Улсыг судлах хүрээлэн хамтран зохион байгуулсан “Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой: Өнгөрсөн, одоо, ирээдүй” сэдэвт эрдэм-шинжилгээний хурал, Улаанбаатар, 2019.06.14.

#### **Д.Аюуш**

9. *“Монгол-Оросын худалдаа эдийн засгийн харилцаан дахь Монголын экспортыг нэмэгдүүлэх асуудалд”*, Монгол-Оросын худалдаа эдийн засгийн харилцааны тулгамдсан асуудал эрдэм шинжилгээний хурал, МУИС-ОУХНУС 2017.12.15

10. *Торгово-экономические отношения между Монголией и Россией: прошлое, настоящее и перспективы. //Монголия и её соседи: политика и экономика в изменяющемся мире. Олон улсын эрдэм шинжилгээний дугуй ширээний уулзалт. Улаан-Үд.2018.05.18.*

11. *“Монгол-Хятадын худалдааны зарим асуудал”*. БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хотод болсон ЭШХ. 2018.06.21-22.

12. *“Монгол, Орос, Хятадын худалдааны хамтын ажиллагаа”*, МУИС-ийн ОУХНУС зохион байгуулсан Эрдэм шинжилгээний хурал, Улаанбаатар, 2019.12.05.

#### **Ч. Батцэцэг**

13. *“Монгол, Хятадын соёлын солилцооны өнөөгийн байдал”* илтгэл, БНХАУ-ын Өвөр Монголын Хэвлэл мэдээллийн алба, Монгол Улсын “Монгол, хятад хэлний орчуулагчдын холбоо”-ны нэгдсэн эрдэм шинжилгээний хурал, Хөх хот, 2019.11.25-30.

14. *“Шинэ зууны Монгол, Хятадын соёлын харилцаа”*, МУИС-ийн ОУХНУС болон БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн Монгол Улсыг судлах хүрээлэн хамтран зохион байгуулсан “Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой: Өнгөрсөн, одоо, ирээдүй” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, Улаанбаатар, 2019.06.14.

#### **Д.Батжаргал**

15. *“Монгол, Хятадын боловсролын харилцаа, хамтын ажиллагааны түүх ба орчин үе”*, МУИС-ийн ОУХНУС болон БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн Монгол Улсыг судлах хүрээлэн хамтран зохион байгуулсан “Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой: өнгөрсөн, одоо, ирээдүй” сэдэвт эрдэм-шинжилгээний хурал, Улаанбаатар, 2019.06.14.

#### **Д.Базардорж**

16. *“Халх голын сав нутагт хил дамнуулсан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж”*. “Судлаачид XXI зуунд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, Их Засаг их сургууль. 2018.04.07

17. *“Монгол, Хятадын боловсролын салбарын харилцаанд тулгамдаж буй зарим асуудал”*. Монгол, Хятадын соёлын харилцаа ба хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал. ХААИС. 2018.04.25.

18. *“Монгол дахь бурхны шашны нөхцөл байдал”*, Монголын геополитик хэмээх цуврал академик мэтгэлцээн, Улаанбаатар, МУИС, ОУХНУС, 2019.05.30.

19. *“Монгол, Хятадын хил дамнасан аялал жуулчлалын загвар бүсийг байгуулах боломж”* ГХЯ, Олон улсын харилцааны хүрээлэнгийн хамтран зохион байгуулсан “Монгол, Хятадын харилцааны шинэ эрин: Боломж, сорилт” олон улсын эрдэм шинжилгээний хурал, УБ., ГХЯ, 2019.09.30.

#### **Ж.Баясах**



20. *“Монгол, Орос, Хятад гурван улсын харилцааны шинэ өрнөл”*, “Евроазийн хамтын ажиллагаа: Хүмүүнлэгийн асуудлууд”- эрдэм шинжилгээний бага хурал, Эрхүү хот 2017.09.14-15:, Монгол, Орос, Хятад гурван улсын тинк-танкын III чуулган, Улаан Үд 2017.09.18/22:, Хятад улс Тяньжин хотын Мэй- Жян үзэсгэлэнгийн төвд зохион байгуулагдсан 2017 оны (19 дэх удаагийн) Хятадын олон улсын уул уурхайн дээд хэмжээний чуулга уулзалт болон бүх дэлхийн уул уурхайн Монгол, Хятадын хүмүүнлэгийн солилцоо худалдааны урсгалыг нэмэгдүүлэх оргил хэлэлцүүлэг, Тяньжин 2017.09.24/27.

21. *“Монгол, Орос, Хятад гурван улсын харилцаа”* ГХЯ-ны хөрш орнуудын газар, 2017.02.18.

### **Ж.Баярбаатар**

22. *“Монгол, Хятадын харилцаан дахь Хятад дахь Монгол үндэстний хүчин зүйл”*, МУИС-ийн ОУХНУС-аас зохион байгуулсан “Монгол Улсын гадаад бодлого” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, Улаанбаатар, 2018.12.07.

### **К.Дэмбэрэл**

23. *“Какой концепции будет придерживаться ШОС: “Pan” или “Pax”?*, “ШХАБ-ыг бэхжүүлж, хөгжүүлэх асуудал, хэтийн төлөв” сэдэвт Евразийн интеграцийн Сочигийн олон улсын II форумын хүрээн дэх олон улсын эрдэм шинжилгээний хурал, ОХУ-ын ШУА-ийн ТУХН-ийн орнуудын судалгааны хүрээлэн, Москва, 2018.04.17-19.

24. *“Орчин үеийн Оросын геополитик”*, “Монголын геополитик: Академик мэтгэлцээн” цуврал, МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль, Улаанбаатар, 2019.01.30, №1, 19-25, 72-73 дугаар тал.

25. *“Бүс ба Зам” санаачилгын санхүүжилтийн талаархи олон улсын хамтын ажиллагааны тойм (Монгол Улсын жишээн дээр)*. Монгол, Орос, Хятад гурван улсын эрдэмтэдийн "Тинк-танк" форум. 2019 оны 7 сар. Хөх хот

### **Х.Мандхай**

26. *“Монгол-Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа, тулгамдаж буй асуудлууд”*, "The Belt and Road" international technology transfer forum, Beijing, 2019.09.16-18.

### **А.Нямдолжин**

27. *Культурно-гуманитарные взаимодействия между Монголией, Россией и Китаем как залог успешного всеобъемлющего развития трёхсторонних отношений.* // Актуальные проблемы современного монголоведения. Москва. 11-12.10.2017.

28. *Монгол-Оросын боловсролын салбар дахь хамтын ажиллагааны асуудлууд, хэтийн төлөв.* // “Монгол-Оросын боловсролын салбар дахь хамтын ажиллагааны асуудлууд, хэтийн төлөв” сэдэвт онол, практикийн бага хурал. Төрийн ордон. 2017.02.17

29. *“Культурно-гуманитарное сотрудничество Монголии, России и Китая: взаимосвязанности в Евразии”.* // “Перспективы развития и укрепления ШОС”, Второй Сочинский форум. Сочи. 17-19.04.2018.

30. *Роль образования в вопросе взаимодействия между Монголией и Россией.* // “Международный научный форум экспертов в области права стран Восточной Азии”. Улан-Удэ. 01-04.07.2018.

31. *Монгол-Оросын харилцаанд гарч буй өөрчлөлтүүд Монгол Улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлөх нь.* // “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2018.10.11.

32. *“Роль образования в вопросе взаимодействия между Монголией и Россией”, “Россия-Монголия: Опыт и перспективы международной интеграции в образовании и науке”,* Улаанбаатарский филиал Российского Экономического Университета им. Г.В.Плеханова. 2019.11.07.

## **Ж.Орхон**

33. *“Монгол-Оросын стратегийн түншлэл дэх хил орчим, бүс нутгийн харилцаа”* илтгэл, 2017-05-17, “Монгол-Оросын харилцааны өнөөгийн байдал, хэтийн төлөв” сэдэвт онол, практикийн бага хурал, МОКС-МЗНН-ННМЭ-ийн 70 жил, ГХЯ, “Зөвшилцөл” танхим.

## **Н.Төмөр**

34. *“Гурван улсын эдийн засгийн коридорт дэд бүтцийн салбар дахь хамтын ажиллагааны гүйцэтгэх үүрэг”, “Экономический коридор Китай-Монголия-Россия: Дорожная карта”* олон улсын форум, г. Улан-Удэ, 2017.09.18-22.

35. *“Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридорын бүрэлдэхүүн хэсэг-экологийн орчныг хамгаалах болон сэргээгдэх эрчим хүчийг ашиглах салбар дахь*

хамтын ажиллагаа”, “Монгол, Хятад-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгууллат” олон улсын форум, Хөх хот, 2017.09.26-27.

36. “Нэг бүс нэг зам” болон Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны шинэ хандлага: Ногоон хөгжил”, “Нэг бүс нэг зам” олон улсын хамтын ажиллагаа нь Хармөрөн мужийг цэцэглүүлэн хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх нь” олон улсын форум, Харбин, 2018.06.14-16.

37. “Нэг бүс нэг зам” болон Зүүн хойд Азийн улс орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа”, “The 5<sup>th</sup> Forum of Northeast Asian Peace and Development”, International Forum, Шанхай, 2018.12.01-02.

38. “Нэг бүс нэг зам” болон Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа”, “The Belt and Road Initiative and Northeast Asia Energy Security System”, International Conference, Changchun, 2018.12.06-08.

39. “Гурван улсын эдийн засгийн хамтын ажиллагаа ба Ногоон хөгжил”, Алтанбулаг-290: Өнгөрсөн, одоо, ирээдүй” олон улсын эрдэм шинжилгээний хурал, Алтанбулаг, 2019.05.27.

40. “Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа ба Ногоон хөгжил” “Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой: Өнгөрсөн, одоо, ирээдүй” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, Улаанбаатар, МУИС, 2019.06.14.

#### **Д.Шүрхүү**

41. “Монголын транзит тээврийн төв шугамыг шинэчлэх үйл явц ба Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор байгуулахад үзүүлэх нөлөө” илтгэл, “Монгол-Хятадын хоёр дахь удаагийн ЭКСПО-2017”-гийн хүрээнд зохион байгуулсан “Нээлттэй, хүртээмжтэй байдал: Соёл иргэншлийн харилцаа болон “Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор”-ын бүтээн байгуулалт сэдэвт форум, Хөх хот, 2017.09.27.

42. БНХАУ-ын өнөөгийн нөхцөл байдал, төрийн бодлогын чиг хандлага.// “БНХАУ-ын гадаад бодлогын өөрчлөлт ба Монгол-Хятадын харилцаа” сэдэвт сургалт хэлэлцүүлэг, Монгол Улсын Үндэсний тагнуулын академи, 2018.01.26

43. Монгол-Хятадын хилийн орон зайд гарч буй өөрчлөлт ба Монгол Улсын өмнөд хилийн аюулгүй байдал, “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, Хууль сахиулахын их сургууль, Улаанбаатар, 2018.10.11.

44. *“Орчин цагийн Монгол-Хятадын харилцааны түүх судлал дахь шинэ хандлагууд”*, Олон улсын харилцааны хүрээлэн, ӨМИС-ийн Монгол Улс судлах хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан олон улсын хурал, ӨМӨЗО-ны Баарин зүүн хошуу, 2019.09.21.

45. *“Монгол-Хятадын харилцааны шинэ үе шат: Харилцан ашигтай, хүртээмжтэй хөгжил”*, Гадаад харилцааны яам, Олон улсын харилцааны хүрээлэнгийн хамтран зохион байгуулсан “Монгол, Хятадын харилцааны шинэ эрин: Боломж, сорилт” олон улсын эрдэм шинжилгээний хурал, Улаанбаатар, ГХЯ, 2019.09.30.

#### ТАВ. ТАНИН МЭДЭХҮЙН НИЙТЛЭЛ, ЯРИЛЦЛАГА, ЛЕКЦ

1. Д.Базардорж. *“Цагаан дэл уул – Өлзий боомтыг ашиглах талаарх өнөөгийн нөхцөл байдал”* сэдвээр илтгэл танилцуулга бэлтгэж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алашаа аймгаас ирсэн зочид, судлаачидтай хийсэн “Дугуй ширээ”-ний ярилцлагад оролцов. 2017 оны 5 дугаар сар.

2. Д.Батжаргал, *“Хятадын боловсрол бол Хятадын онцлогтой социализмыг түгээн дэлгэрүүлэх хэрэгсэл”* сэдэвт ярилцлага, Unuudur.mn, 2019.08.21, “UB Post” сонины 2019.08.26, № 1, 5 дугаар нүүрэнд англи хэл дээр хэвлэгдэв.

3. Ч.Батцэцэг. *“Өнөөгийн Монгол Улс, БНХАУ-ын харилцаанд ӨМӨЗО-ы гүйцэтгэж буй үүрэг”* сэдвээр илтгэл бичиж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алашаа аймгаас ирсэн зочид, судлаачидтай хийсэн “Дугуй ширээ”-ний ярилцлагад оролцов. 2017 оны 5 дугаар сар.

4. Ч.Батцэцэг. *“Хятад улс 2035 он гэхэд чинээлэг нийгмийг бүх талаар бүтээн байгуулах зорилт тавилаа”* ярилцлага. Өдрийн сонин 2017.10.25 №230(5797).

5. Ч.Батцэцэг, докторант Ц.Ариунаагийн хамт *“Монгол, Хятад хоёр улсын аялал жуулчлалын үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал ба цаашдын чиг хандлага”* нийтлэл. Монцамэ агентлагийн хятад хэлээрх “Монголын мэдээ сонин” №45,46,47,48 (4843), (4844), (4845), (4846) 2017.11.16-30

6. Ж.Баярбаатар. *“Хятадын улс төр, удирдлагын тогтолцоо”* “Замбуулин” сэтгүүл, 2018, №1

7. Ж.Баясах, З.Мэндийн хамт. *Өмнөх дөрвөн ерөнхийлөгчийн гадаад бодлого*. “Mongolian News” in Chinese, 2017.05.25, 21(4819) 2017.05.18 № 20 (4818), 2017.05.25 №21 (4819), 2017.06.01 №22 (4820).

8. Ж.Баясах. *“Дундаа байгаа хөршөө үл тоож болдоггүйг Орос, Хятад ойлгосон”*, Өнөөдөр сонин №106(6099), 2017.05.08

9. Ж.Баясах. *“Монгол Улс хийгээд хөрш орнуудын харилцаан дахь шинэ өрнөл”*. Олон улсын харилцааны хүрээлэнгийн нээлттэй хаалганы өдөр. 2017.11.29

10. Ж.Баясах. 蒙古国独立与外交政策的“三个基石”连接过去、现状和未来发展情况 Монцамэ агентлагийн Монголын мэдээ сонин, хятад хэлээр. 2018.03.15

11. Ж.Баясах. *“The three cornerstones of Mongolia’s independence and foreign policy”* Монцамэ агентлагийн Монгол мессенжер сонин, англи хэлээр. 2018.03.16

12. Монгол-Хятадын дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд Монголын Үндэсний радиотой хамтран “Монгол-Хятадын харилцаа 70 жилд” 35 цуврал нэвтрүүлгийг тус хүрээлэнгийн Хятад судлалын салбарын хамт олон бэлтгэн хэрэгжүүлэхээр тохиролцож, одоогоор 20 гаруй цуврал нэвтрүүлгийг хамтран бэлтгэж, 2019 оны 5 дугаар сараас эхлэн нэвтрүүлж буй бөгөөд уг нэвтрүүлгүүдэд Хятад судлалын салбарын Д.Шүрхүү, Д.Базардорж тэргүүтэй эрдэмтэд идэвхитэй оролцсон байна.

13. А.Нямдолжин. *“Орос, Монголын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд төмөр замын асуудал чухал”*. Өдрийн сонин. 2017.02.24. №048,049 (5615, 5616)

14. А.Нямдолжин. *“Оросын гадаад бодлого-2016”* лекц. Тагнуулын Ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн хэлтэс. 2017.01.31

15. А.Нямдолжин. *ОХУ-ын улс төр, нийгмийн өнөөгийн байдал*. //ОХУ-ын өнөөгийн нөхцөл байдал, төрийн бодлогын чиг хандлага. сэдэвт сургалт хэлэлцүүлэг. Монгол Улсын Үндэсний тагнуулын академи. 2018.01.29

16. А.Нямдолжин, *“Хоёр хөршийн харилцаа дотносч байгаа ийм үед манай улс “Гуравдагч хөрш”-ийн бодлогодоо анхаарах ёстой”* ярилцлага, Улаанбаатар, 2019.06.10. №120, Өдрийн сонин.

17. Д.Шүрхүү. *Монголын баялагт өрсөлдөөн үүсгэх хэрэгтэй* - Улс төрийн тойм сонины 2017.03.19-ны дугаарт Монгол-Хятадын харилцаа, эдийн засгийн коридорын асуудлаар ярилцлага өгөв

18. Д.Шүрхүү. *"Монголын улс төр, эдийн засгийн өнөөгийн байдал ба Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын үйл явц"* сэдэвт лекц. Өвөр Монголын их сургуулийн Монгол Улсыг судлах хүрээлэнд. 2017.05.16-19

19. Д.Шүрхүү. *"Эдийн засгийн коридор хөтөлбөрөөс даруй хэрэгжих 3 том төсөл л харагддаг"* ярилцлага "Mongolian Mining Journal" сэтгүүлийн 2017 оны 9 дүгээр сарын дугаар. №009 (106) хуудас: 41-47

20. Д.Шүрхүү, *"Тавантолгой-Зүүнбаянгийн төмөр замын бүтээн байгуулалтын геостратегийн ач холбогдол"*, Mongolian Mining Journal сэтгүүл, Улаанбаатар, 2019.

21. Д.Шүрхүү. *"Хоёр орны харилцаанд эрдэмтэн судлаачдын шаардлага их байна"*, Өвөр Монголын өдрийн сонин-оос монгол хэл дээр сар тутам эрхлэн гаргадаг Солонго сэтгүүлийн 2018 оны 1-р сарын дугаар

22. Д.Шүрхүү. *"БНХАУ эртнээс манай орны баруун бүс нутгийг ихээхэн сонирхож ирсэн"* ярилцлага "Өдрийн сонин" 2018.09.04 №175/6018

23. Д.Шүрхүү. *"Хөрөнгө оруулалтын орчинд эрх ашгийн эрэмбэ, үндэслэлтэй тооцоо, судалгаа алдагдсан"* ярилцлага, Өнөөдөр сонин, 2018.10.01, №188

24. Д.Шүрхүү. *Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор ба төмөр замын бүтээн байгуулалт*" ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн дээр болсон "Нээлттэй хаалганы өдөрлөг", 2018.11.15

25. Д.Шүрхүү. Цагдаагийн ерөнхий газрын албан хаагчдад Олон улсын харилцааны тулгамдсан асуудлаар яриа хийв. 2018.11.21

26. Д.Шүрхүү. *"Бүс нутаг, дэлхийд эерэг нөлөө үзүүлсэн Хятадын шинэтгэл, нээлттэй бодлого"* тус орны төв хэвлэл "Ардын өдрийн сонин"-д өгсөн ярилцлага, 2018.11.22

## ЗУРГАА. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

1. *"Монгол-Оросын боловсролын салбар дахь хамтын ажиллагааны асуудлууд, хэтийн төлөв"* сэдэвт онол, практикийн бага хурлыг ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс БСШУСЯ, МАВСУЗ холбоотой хамтран Төрийн ордонд зохион байгуулав. 2017.02.17.

2. *“Монгол-Оросын харилцааны өнөөгийн байдал, хэтийн төлөв”* сэдэвт онол, практикийн бага хурлыг ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс ГХЯ, ОХУ-ын ЭСЯ, Найрамдлын нийгэмлэгүүдийн Монголын эвлэлтэй хамтран ГХЯ-ны хурлын танхимд зохион байгуулав. 2017.05.17

3. *“Ази дахь геополитикийн өөрчлөлт, хэтийн төлөв ойрын 10 жилд”* олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс ШУТСантай хамтран ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын Хурлын танхим зохион байгуулав. 2017.07.03.

4. *“Монгол дахь бурхны шашны нөхцөл байдал”*, Монголын геополитик хэмээх цуврал академик мэтгэлцээн, Олон улсын харилцааны хүрээлэн, Монгол улсын их сургуулийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуультай хамтран зохион байгуулав. Улаанбаатар, 2019.05.30.

5. *“Монгол Улс судлалын өнгөрсөн ба ирээдүй”* Олон улсын харилцааны хүрээлэнгээс ӨМИС-ийн Монгол Улс судлах хүрээлэн хамтран ӨМӨЗО-ны Баарин зүүн хошуунд зохион байгуулав. 2019.09.21-23.

6. *“Монгол, Хятадын харилцааны шинэ эрин: Боломж, сорилт”* олон улсын эрдэм шинжилгээний хурлыг ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс Гадаад харилцааны яамтай хамтран зохион байгуулав. Улаанбаатар, ГХЯ, 2019.09.30.

## ШХАБ БА МОНГОЛ УЛСЫН ОРОЛЦОО\*

К.Дэмбэрэл

ШУА-ийн ОУХХ-гийн ЭШАА, доктор (Ph.D)

2018 онд Чиндао-д Монголын төрийн тэргүүн “бид шат ахиулах боломжийг судалж байгаа, хэлэлцүүлгийг зохих шатанд хийж байна” хэмээн мэдэгдсэн. Түүний өмнөх нь ЕТГ-аас Монгол Улс “ШХАБ-д элсэх тухай” хэлэлцүүлгийг ГХЯ-н дээр зохион байгуулсан. Тэр хэлэлцүүлэг 8 асуудал дээр төвлөрсөн байсан. Түүнд судлаачийн хувьд оролцож Монголын “эрх ашиг бүдгэрч” болох тул элсэх шаардлага одоогоор алга гэсэн өөрийн саналаа илэрхийлсэн.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан “хоёр хөрштэйгээ эн тэнцүү харилцааг эрхэмлэнэ”, “өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцааг хөгжүүлнэ”, “бүх улс оронтой найрсаг байна” зэрэг олон заалтууд нь манай улс гишүүнчлэгдснээр “бүдгэрэх” тул энэхүү илтгэлийг хийхэд хүргэсэн болой.

- Бид шашны болон угсаатны зөрчил ихтэй, тэдгээрийгээ шийдэхийн тулд бусад асуудлыг “түй чөрт” гэх байгууллагад орох уу?
- Хилийн болон газар нутгийн хоорондын зөрчлийг арилгахын тулд олон тооны “манипулаци” хийж чадах бүлэг улсуудын нэгдэлд нэгдэх ёстой юу?
- ШХАБ-ын хэмжээнд дунджаар нэг хүнд ногдох ДНБ 5210\$ ба үүний Хятад, Орос, Казахстан 3 улсыг хасвал бусад нь ядуу, нэн ядуу ангилалд орох үзүүлэлттэй улсууд бөгөөд нийтлэг тодорхойлолт нь хөгжиж байгаа улсууд, тэдэнтэй нэгдэж хөгжинө гэдэг нь хэр оновчтой бол?

ШХАБ-ын асуудал манайд “босч” ирснээр олон хүн байр сууриа илэрхийлсэн. ШОС гэж цөөн хүн ярьдаг байсан бол ШХАБ гэж олон хүн ярьдаг болсон нь сайн хэрэг. Ингэхдээ 1-2 статья уншихаад ярьсан нэгэн ч бий, бүр “сургаар ярьж байгаа” нэгэн ч бий. Миний хувьд 18 жил бичиж, ярьж ирсэн.

Олон улсын харилцааны асуудалд онолын үүднээс хандаж тайлбар хийх нь гарцаагүй зүйл. Ер нь ОУХ өөрөө бие даасан шинжлэх ухаан. Өнгөрсөн 10 сард

---

\* ШХАБ-ын хэтийн төлөв, Монгол Улсын баримтлах бодлого сэдэвт хэлэлцүүлэгт дэвшүүлсэн санал. ГХЯ-ны Дипломатын Академи, Улаанбаатар, 2019.04.24.



гаргасан “Олон улсын харилцааны онол, үйл ажиллагааны үндэс” бүтээлийн 122-137 талд “Үндэсний эрх ашиг олон улсын харилцааны язгуур ойлголт болох нь” хэмээх дэд сэдэвт өгүүлснээс ишлэе. Үүнд, уламжлал ёсоор бид газар нутгийн болон хил хязгаарын бүрэн бүтэн байдал, улс төрийн хувьд тусгаар байх, эдийн засгийн хувьд бие даан оршин тогтнох зэргээр тухайн улсад амин чухал гэсэн асуудлыг ерөнхийлөн оруулдаг. Бид хоёр хөрштэйгээ хил хязгаар, газар нутгийн хувьд ямар нэгэн асуудалгүй. Харин ШХАБ бий болох анхны үндэслэл нь хил хязгаарын асуудлаа зохицуулах зорилго байв.

Өнөөдөр ШХАБ бол улс төр, аюулгүй байдал, эдийн засаг, хүмүүнлэнгийн чиглэлээр хамтран ажилладаг олон улсын байгууллага болж өргөжсөн. Олон улсын байгууллага гэдэг талаас нь онолын хувьд бол идеализмын үзэл баримтлалд хамрагдана. Тэгэхээр олон улсын харилцаанд реалист үзэл баримтлал бүхий хүчин голлоод эхэлбэл үйл ажиллагаа нь саараад, идеалист үзэл баримтлал бүхий хүчин идэвхижээд эхэлбэл үйл ажиллагаа нь идэвхижинэ гээд ойлгох нь зүйтэй. НҮБ-ын жишээг харахад л ойлгомжтой зүйл. Монгол улсын хувьд ШХАБ-ын гишүүнчлэлийн ямар статустай байхаас үл хамаараад түүний үйл ажиллагаанд анхааралтай хандаж байх учиртай, учир нь манай хоёр хөрш маань уг байгууллагыг бүрдүүлэгч цөм нь буюу ШХАБ-ын төсвийн 70%-г (6 гишүүнтэй үе буюу 35:35, 10:10, 5:5) бүрдүүлж байгаа билээ. Өнөөгийн өнцгөөс харвал энэ байгууллагын хувьд Монголд сайн нөлөөтэй байхыг үгүйсгэхгүй. Бид өнөө, маргаашаар юмыг төсөөлж болохгүй л дээ.

ШХАБ нь ойрын 10-20 жилд дэлхийн хэмжээний бодлогод шийдвэрлэх нөлөө үзүүлж чадахуйц хэмжээнд өсөж дэвжих ирээдүй харагдахгүй байгаа. Энэ нь түүний хувьд эдийн засгийн чадавхи, улс төрийн зөрчилтэй нь шууд холбоотой хэмээн үзэж байна. Ши Жиньпин “худалдааг” түлхүү ярьдаг бол В.Путин “аюулгүй байдлыг” ярьдаг. Энэ нь өөрөө Орос, Хятадын зөрчилтэй байр суурийн илэрхийлэл. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд дорвитой томоохон нэг ч төсөл хэрэгжүүлээгүй нь мөн л дээрхи шалтгаантай холбоотой байж уг байгууллагыг зохих хэмжээнд хумигдмал байдалд ч оруулсан хэмээн үзэж болно. Бүр тодруулбал, гишүүнчлэлийн асуудлыг “царцааж ч” байсан ба өрнөдөөс орос тавьсан хориг хэрэгжээд эхлэхтэй зэрэгцээд шинээр “гишүүнчлэх асуудал” сэргээгдсэн.

Тиймээс манай улсын хувьд 2025 оныг хүлээх нь зүйтэй. Учир тэр үед ШХАБ-ын шинэчлэгдсэн харти гарч, үзэл баримтлал, бодлого үйл ажиллагаа нь тодорхой

болж магад. Тэдний хувьд өнгөрсөн 20 жилийн “ажлын туршлага” дээр тулгуурлан улс төр, аюулгүй байдал, эдийн засаг, соёл хүмүүнлэнгийн чиглэлд шинэ арга механизм бүхий хөгжлийн шинэ стратеги гаргаж тавих ба Хятадын үйл ажиллагаанаас шууд хамааралтай хэмээн дүгнэж болох юм.

ШХАБ нь 2025 он хүртэлх стратегийн төлөвлөгөөгөө баталсантай холбогдуулан тус байгууллага, түүний үйл ажиллагаанд хийж буй судлаачийн ерөнхий дүгнэлтээс 5 зүйлийг танилцуулбал. Үүнд:

1. НАТО нь цэргийн эвсэл, Евро-Атлантын аюулгүй байдлын механизм. Харин ШХАБ-ыг түүнтэй өрсөлдөхүйц Евро-Азийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны механизм хэмээн харж болно. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин нэгэн мэдэгдэлдээ «Европ, АНУ-ыг бүхэлд нь хамарсан орон зайн аюулгүй байдлыг НАТО-д түшиглэн хангадаг бол Азид тогтвортой байдлын тулгуур нь ШХАБ болох ёстой» хэлсэн нь уг байгууллагыг НАТО маягийн гэдгийг баталж буй хэрэг. АНУ-ын дангаар ноёрхсон «ганц туйлт дэг журмаас», «олон туйлт дэгэнд» шилжихэд тодорхой бүлэглэлээр дамжин бий болох ба тийм үүргийг ШХАБ гүйцэтгэнэ.

2. НАТО-д АНУ гол санхүүжүүлэгч, удирдан зохион байгуулагч, эрх ашгаа хэрэгжүүлэгч бол ШХАБ-д тийм функцыг ойрын ирээдүйд БНХАУ гүйцэтгэнэ. ШХАБ-ын ДНБ нь 16 орчим их наяд ам.доллар байгаагаас 2017 онд БНХАУ-ын ДНБ нь 11,9 их наяд, Энэтхэг 2,4 их наяд, ОХУ 1,4 их наяд, бусад бараг л “0” гарч байна. Энэ мөн л Монголын тэнцвэртэй харилцааны үзэл баримтлалыг гажуудуулж байна. 2018 оны хурлаар ШХАБ-ын банк хоорондын консорциумд 5 тэрбум орчим ам.долларын зээлийн шугамыг Хятад дангаараа нээхээр болсон. ШХАБ-ын ДНБ-ийн 70 гаруй хувийг дангаараа эзэлж БНХАУ нь онолын хувьд уг байгууллагад “гегемони”-оо тогтоочихоод байгаа хэрэг.

3. НАТО ч бай, ЕХ бай Туркийг эс тооцвол Европын соёлд түшиглэсэн улс орнуудын нэгдэл. Харин ШХАБ нь маш олон соёлын “цуглуулга” тул урт хугацаанд оршин тогтнох үндэслэл муутай. С.Хантингтоны “иргэншлийн мөргөлдөөн” чухам л гарах бол эндээс эхэлнэ. Өөрөөр хэлбэл, ШХАБ нь эдийн засаг, улс төрийн байгууламж, нийгмийн янз бүрийн харилцаатай, олон соёлын нэгдэл тул урьдчилан таамаглах, хамтран ажиллахад төвөгтэй механизм.

4. ШХАБ-ын хүрээнд гишүүн орнуудын эдийн засгийн бус хүчний байгууллагын хамтын ажиллагаа тогтмолжсон байгаа нь түүний үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж буй хэрэг. Энэ байгууллагын дараагийн нэг чухал хамтын

ажиллагааны чиглэл нь “терроризм, салан тусгаарлах үзэл санааг эсэргүүцэх” явдал, үүндээ ч 2018 онд түлхүү анхаарал хандуулсан.

5. ШХАБ-ыг тодорхойлохдоо зарим нэгэн алдаатай зүйл байгааг судлаачид засах учиртай. Тухайлбал, “эдийн засгийн үзүүлэлтээрээ ЕХ-г гүйцэж түрүүлэх төлөвтэй, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг тодорхойлох хэмжээний, бизнес төсөл, бизнес санааг хэрэгжүүлэх ирээдүйтэй орон зай” гэх зэргээр бичиж байна. АНД-н бүс нутагт өрнөж буй улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны үйл явцад идэвхитэй оролцох “чухал суваг” нь ШХАБ мөн гэх маягтай.

Өнөөгийн ШХАБ-ын талаар дараахи 5 зүйлийг онцолж хэлье. Үүнд:

1. Ээлжит уулзалтын дараагаар “инфор.сообщение” хийдэг нь олон нийтэд хараахан хүрдэггүй, зохистой тайлбар байдаггүй, графикт төсөл хөтөлбөргүй, түүнчлэн ШХАБ-ын бүтцийн байгууллагын хүрээнд жил тутам 10-20 орчим уулзалт, яриа хэлцэл хурал, зөвөлгөөн болдог ч тэр нь гишүүн орнуудын олон нийтэд бараг мэдрэгдэхгүй өнгөрдөг. Энэ нь тухайн байгууллагын хэр “хаалттай үйл ажиллагаа” явуулдгийн шинж.

2. Ерөнхийдөө ШХАБ-ын бүтцийн байгууллагууд үйл ажиллагаагаа “положительно” хэмээн байнга дүгнэж ирсэн нь бас зохистой зүйл бус. Тогтсон нэг л схемээр явж ирсэн нь буруу зүйл хэмээн үзэх үндэстэй. Жил бүрийн дүгнэлтүүд нь дэлхий дахины асуудлыг “сложный переходный период”, бүс нутгийн, олон улсын аюулгүй байдал, гэх мэтийн хэвшмэл нэр томъёонууд буюу “жижүүрийн хэдэн үг” байнга хэрэглэж буй нь ажил хэрэгч бус зүйл.

3. “2013-2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” гэж байгаа ч нийтэд тодорхой бус зөвхөн гишүүн орнуудын хариуцсан төлөөлөл өөрөө өөрсдөдөө гаргаад, өөрөө өөрсдөө дүгнэдэг сул талтай байгааг анхаарах.

4. Гишүүн орнуудын хүрээнд явагдаж байгаа терроризм, экстремизм, сепаратизмийн эсрэг явуулж байгаа тэмцлийн чухам хэдэн хувь нь ШХАБ-ын хүрээнд хийгдснийг одоо хэр тодорхойлоогүй байгаа. Өөрөөр хэлбэл, ялгаж салгаж мэдээлэх “дургүй” байгаа. Чухам ямар тэмцлийг нь эдгээрт хамруулах гэдгээсээ асуудалтай зүйл.

5. ШХАБ-ын гол зорилт болсон хил, хязгаарын зохицуулалт нь хэдийгээр “нууц” ч энэ асуудлаар аль улс, ямар үр дүнд хүрсэн нь тодорхой бус байгаа. Өөрөөр хэлбэл, 20 жилд энэ асуудал шийдэгдээгүй, зөвхөн тохиролцоод орхисон гэсэн үг.

Монголын хувьд ШХАБ-д оролцох, гишүүнчлэгдэхээс өмнө “ОХУ, БНХАУ-ын тухайн байгууллага дахь эрх ашиг, түүний мөн чанар”-ыг углуургаар нь ойлгож байж шийдвэрээ гаргах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, ШХАБ-аар дамжуулан тэд ямар зорилгод хүрэх, ямар зорилт тавьж буйг нь тодорхойлоод тэр зорилт нь Монголын эрх ашигт хэр нөлөөтэйг нь харцгаах учиртай. Үүнийг судлаачийн байр сууринаас авч үзвэл.

### **ОХУ-ын хувьд**

ЗХУ задарснаар Төв Азид З.Безежинскийн томъёолсноор “хар нүх” буюу хоосон орон зай бий болсноор тэнд өөрсдийн нөлөөг тогтоохын тулд АНУ, БНХАУ, Япон, Энэтхэг, Турк зэрэг улсууд “өөрсдийн менежмент” хийсэн бол ОХУ-ын хувьд хуучин эрх мэдлээ хадгалж үлдэхийн төлөө “арга саам” хайсан нь “ШХАБ”-ыг төрүүлж, бэхжүүлэхэд хүргэсэн. Төв Азийн таван улсыг нэгдсэн байдлаар ОХУ-тай хорших нь оросуудын сонирхолд нийцэж байгаа, тэдгээрээс салгаж харилцах нь стратегийн хувьд оросуудад сонин биш. Тиймээс тэдгээр улсууд ТУХН, ЕАЭЗХолбоо, ШХАБ гэсэн бүтцэд байх нь ашигтай хэмээн үзнэ.

Төв Азийн улсуудын экспортыг Оросоор дамжуулан гаргаж байх эдийн засгийн сонирхол түүнд байгаа. Ингэхийн тулд мөн тодорхой бүтцээр дамжуулах хувилбар нь зохистой байгаа. Төв Ази нь аюулгүй байдлын хувьд “бамбай” байх түүхэн үүрэгтэй. ОХУ-ын Засгийн газар, тухайлбал, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам нь ШХАБ-ын гол зорилго нь аюулгүй байдлын хамтын ажиллагаа болохоос биш эдийн засгийн хамтын ажиллагаа биш гэж шууд хэлдэг. Харин эдгээр яамдын зүгээс Төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагааг Евразийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд явуулахыг л хатуу тулгадаг.

ОХУ-ын хувьд Төв Азийг өөрийн онцгой сонирхлын бүс гэсэн сэтгэлгээнээсээ салахгүй байгаа. ШХАБ нь ОХУ-ын хувьд Төв Азийн бүсэд зохих нөлөөтэй байх “нэмэлт суваг” болж байгаа ба аюулгүй байдлыг хангах механизмын хэмжээнд ОДКБ/Туркменээс бусад түүний шүхэр дор байгаа/, эдийн засгийн интеграцийг хангах механизмын хэмжээнд (ЕврАзЭСоюз) ЕАЭЗХ ажиллаж байгаа тул ШХАБ-ын хувьд энэ хэмжээнд хүрч ажиллахад нэлээн төвөгтэй. Эдгээр нь ОХУ-ыг бүс нутагт тэргүүлэх үүрэг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлж байна.

ОХУ-ын хувьд АНУ, ЕХ-той ямар нэг хэлбэрээр нэгдэх, холбогдож байх “мөнхийн сонирхолтой” улс. Тийм нөхцөл бий болоход ШХАБ-ын чиглэлд үйл ажиллагаа нь шууд саарах юм. Энэ талаар АНУ-тай зохих бэлтгэлтэйгээр яриа хэлэлцээр эхлүүлэхийг ОХУ хүсэж байгаа. Европчууд аюулгүй байдлаа АНУ-д, эдийн засгаа Хятадуудад даатгасан байдалтай байгаа нь оросуудын “санаа зовоосон асуудал” болоод байгаа, учир нь ОХУ тэнд өөрийн оролцоог байх ёстой гэж үздэг.

ОХУ-ын хувьд ШХАБ-ын цаашдын хөгжлийг аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагаа, соёл, боловсрол, спортын хамтын ажиллагаа гэсэн 3 чиглэлд хөгжүүлэх нь илүү шаардлагатай хэмээн Оросын судлаачид бичдэг. Энэ байгууллага аюулгүй байдлын салбарт хамтын ажиллагааг хүчтэй явуулж байгаа төдийгүй цэрэг, батлан хамгаалахын салбарт илүү ойр дотно харилцаатай байгаа нь уг байгууллагын Хартийг зөрчсөн хэрэг болж байгаа талаар судлаачид тэмдэглэсэн.

### **БНХАУ-ын хувьд**

БНХАУ-ын хувьд Шинжан-Уйгурын автономит район нь Төв Азийн улсуудтай шууд хиллэдэг, үндэсний цөөнх аж төрдөг, исламын шашинтай, салан тусгаарлах “үзэл газар авчихсан” хэсэг. Тиймээс Төв Азийн улсуудын тогтвортой хөгжил БНХАУ-ын хувьд нэн чухал зүйл. Дараагийн нэг зүйл бол бүс нутгийн эрчим хүчний эх үүсвэрт өөрийн гэсэн сегмент бий болгож, хяналтыг тогтоох нь юу юунаас илүү чухал болоод байгаа. Хуучин ЗХУ-ын нөлөөнд байсан бүс нутагт Хятадын зүгээс “яаралтай” довтлох нь тийм ч хүсэх зүйл биш учраас “алгуур нэвчих” буюу эдийн засгийн нээлттэй хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар орох сонирхолтой, тэгж ч ажиллаж байгаа. Түүнийгээ гэрээндээ “урт хугацааны сайн хөрш, хамтын ажиллагааны тухай, гишүүн орнууд бие биеэ хүндэтгэж, эдийн засгийн, улс төр, соёлын хөгжлийн замыг сонгох чөлөөт эрхтэй” хэмээн тусгасан.

Хятадын хувьд нэгэнт эдийн засгийн салбарт орж чадвал цаашлаад цэрэг, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг идэвхижүүлэх гарц нээгдэж байгаа. ШХАБ-ыг хамтын ажиллагааны механизм гэдэг ойлголт нь ОХУ-аас илүүтэйгээр БНХАУ-д хүртээмжтэй асуудал. Төв Азид АНУ, ОХУ-ын зөрчлийн дундаас БНХАУ-ын байр суурь бэхжсэн.

Хятад нь ШХАБ-ыг Төв Ази, АНД-н бүсийг холбосон тийм механизм болгож өөрийн байр суурийг энэ орон зайд бэхжүүлэх туйлын зорилго байгаа. ШХАБ бол

“хүйтэн дайны” дараа бий болсон бүс нутгийн болон “олон улсын хамтын ажиллагааны тухай сэтгэлгээнд бий болсон үйл ажиллагааны шинэ хэлбэр” хэмээн хятадууд бичиж байгаа. Тэдний үзэж буйгаар бол ТУХН-ийн хүрээнд улс орнуудын нэгдсэн байдлыг “эмгэнэлт үйл явдал” аж. Төв Азийн аюулгүй байдлыг хангахад ШХАБ ямар үүрэгтэй байхыг илүү тодруулахыг хятадын тал хүсээд байгаа. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлыг хангахад хэдийгээр ШХАБ, ОДКБ хоёрын хооронд хэлэлцээр бий ч үүрэг ролийг зааглах буюу хаана, нэгдэж байгаа, хаана хуваагдаж буйг ялгаж салгахыг хятадын тал хүсээд байгаа.

ШХАБ нь тодорхой чиглэлд бүс нутгийн бус улс орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэхийг хятадын тал дэмждэг. Түүнчлэн ШХАБ-ын орнууд бие даан 2 талын хамтын ажиллагааг өргөжүүлэхийг ч дэмждэг ба энэ нь орос, хятадаас хамааралтай гэсэн хардлагыг арилгах ач холбогдолтой хэмээн хятадууд үздэг. ШХАБ-ыг илүү нэгдмэл, хүчирхэг болгох хамтын ажиллагааны тийм хэлбэрийн төлөө байгаа гэдгээ ч хятадууд илэрхий гаргаж байгаа. Эцэст нь хэлэхэд, ШХАБ-ыг нэр хүнтэй, үүрэг рольтой байлгахыг хятадууд л хүсч байна.

### **Монгол Улсын хувьд**

ШХАБ-ын гол зохицуулах асуудал бол хилийн шугамыг “тохиролцох”, гэтэл энэ байгууллагад газар нутгийн маргаанаа шийдээгүй Энэтхэг-Пакистан, Орос-Хятад, Энэтхэг-Хятад, Хятад-Төв Азийн шинээр тусгаар тогтносон улсууд, Азербайжан-Армян гишүүн буюу түншлэгчид. Монголын хувьд хэнтэй нь ч газар нутаг болон хилийн ямар нэг маргаангүй мөртлөө энэ “асуудалтай” байгууллагад гишүүнчлэгдэх нь “түүгээр явсан гайг, өөртөө дуудаж” буй хэрэг. Си Жинпиний “худалдааны протекционизмын аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй” гэсэн үг нь Монгол Улсын зүгээс ЕХ-нд экспорт хийх нөхцөл, Японтой байгуулсан худалдааны түншлэлийн гэрээнд хэрхэн тусах билээ? Монголын эдийн засгийн эрх ашиг “бүдгэрнэ”.

Монгол Улс нь ШХАБ-ын хүрээнд транзит тээврийн асуудлыг шийдэх талаар “горьдож” ирсэн. Эдийн засгаа “солонгоруулах” бодлогын хувьд хэрэгтэй ч, эдийн засагт “жин дарахгүй”. Энэ чиглэлээр 3-уулаа хамтрах гэхээр Орос, Хятад хоёр “хамтдаа байя”, түрүүлж хөгжинө гэсэн ойлголт байхгүй шүү гэсэн уриалга бүхий “төсөлд” нэгдэхийг шаарддаг. В.Путины “транзит тээврийг дэмжих боломжтой” гэсэн хариу хэлснийг шууд дэмжих маягаар буруу ойлгоод байгаа. Хэн ч байсан дэмжихгүй хэмээн хэлэхгүй шүү дээ. Оросоор дамжих Монголын транзит тээвэрт

хөнгөлөлт үзүүлнэ гэсэн. Энэ нь манай эдийн засгийн засагт чухал дэм болох талаар оросууд ярьж байгаа. 2018 онд УБТЗ нь 25.7 сая тн ачаа тээвэр, үүнээс 3.3 сая тн нь транзит тээврийн ачаа байлаа. Энэ нь мөнгөн дүнгээр бол 530 тэрбум төгрөг, үүнээс транзит тээвэр нь 82,3 тэрбум төгрөг болж байгаа. Хятадууд бол бид хамтдаа дэлхийн ноолуурын 95%-г “атгаж байна” тиймээс хамтдаа хөгжих ёстой гэдэг. АНУ, Япон, ЕХ-нд зарагдаж байгаа “Говийн бүтээгдэхүүнийг” хятадын лангуун дээрээс зарна шүү гэдэгтэй агаар нэг юм.

Монголоор дайрсан хурдны зам, төмөр замын асуудлыг манайх 2 талтай тусад нь яриад шийдэж болох зүйл. 2014,15,16,18 онуудад ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр Орос-Монгол-Хятадын гурван талт уулзалт зохион байгуулагдсан. Дэд бүтцийн ШИНЭЧЛЭЛ байхаас, шинээр байгуулагдах ажил хараахан ашигтай бус. Манай тээврийн дэд бүтэц 100% хоёр хөршийн хяналтад байгаа тул хэдийгээр боломжгүй ч түүнийг бид хэрхэн саармагжуулах талаар гаргалгаа хайх хэрэгтэй.

Хоёр хөршийн өрсөлдөөний дүр зураг сүүлийн 27 жилд дараахи үйлдлээр тодорч байна. Үүнд:

ОХУ - “ТУХН”, Хятад - “ШХАБ”, Орос - “ЕАЭХ”, “ОДКБ”, Хятад - “Шинэ Торгон зам”, “Зам-Бүс”, Орос - “Большая Евразия”

Энэхүү Орос, Хятадын өрсөлдөөний мөн чанарт зөв дүгнэлт эс хийвээс бид юунд хэрхэн хамрагдахаа эс ойлгоход хүрнэ.

### **ШХАБ-ын хувьд**

ШХАБ-ын зорилго, үйл ажиллагааны тодорхойгүй байдал нь түүнийг “Дорно дахины НАТО”, “Цөмийн зэвсэгтэй ОПЕК”, “Америкийн эсрэг Орос-Хятадын альянс”, “ШХАБ-ын тусламжтайгаар Төв Азид ОХУ, БНХАУ-ын хяналт тогтоох механизм” гэсэн нэр хаяг зүүлгэсэн.

Хятад эдийн засгийн хүчээр түрүү бариад, Оросууд цэрэг-техникээр түрүү бариад зөрчлөө шийдэхгүй тул орос, хятадын “тохироо” юу юунаас илүү чухал хэмээн судлаачид бичиж байгаа. Тэгвэл тэдний “тохироо” нь Монголд ямар үр дагавартай болох талаар бид тандаж байх учиртай. Гишүүнчлэгдсэн нөхцөлд тэрхүү “тохирооны” сөрөг үр дагавар нь илүү байх магадлалтай.

Хятадуудын хувьд АНУ-г ШХАБ-д орж ирэхийг дэмжихгүй байгаа бол, оросууд хэдийгээр америкчуудад сайнгүй ч энэ байгууллагад хятадтай хоёулаа

байхыг ч хүсэхгүй байгаа. Өөрөөр хэлбэл, ШХАБ-д гуравдахь ч гүрний оролцооны талаар нэгдсэн ойлголт хоёр улсад алга байгаа. Энэ утгаараа ШХАБ тийм ч үр ашигтай механизм болж өгөхгүй байгаа. Цэрэг, батлан хамгаалах болон эрчим хүчний салбарт ШХАБ нь хамгийн нэр нөлөө бүхий олон улсын хамтын нийгэмлэг болох боломжтой нь зарим улсын сонирхолд сөрөг нөлөө үзүүлж байгаа .

АНУ-ын хувьд Төв Азийг геостратегийн хувьд ашигтай хэмээн тодорхойлоод , “Том Төв Ази” гэсэн томъёололдоо Дундад Азийн таван улс дээр Пакистан, Энэтхэг, Афганистаныг оруулж авч үздэг.

Япон улс ШХАБ-д орох хамгийн боломжийн улс гэдгээр “өөрийгөө тодруулсан” ба 2004 оноос “Төв Ази+Япон” форумыг зохион байгуулсаар ирсэн бөгөөд Орос, Хятадын зүгээс л саад хийхгүй тохиолдолд тэрээр элсэх боломжтой улс . Япон ажиглагчийн статустай болох тохиолдолд Монгол Улсын гишүүнчлэлийн асуудал ярихад боломжтой.

Өнөөгийн олон улсын хэв маяг буюу дэлхийн өнөөгийн дэг журамд ОХУ, БНХАУ хоёр сэтгэл хангалуун байж чадахгүй байгаа нь тэднийг “шинэ дэг журмын төлөө” гэсэн бодлогыг шаргуу тавихад хүргэсэн. Өнөөгийн тоглоомын дүрмийг гаргахад хятад, оросын оролцоо байгаагүй учраас өөрчлөхийн төлөө байгаа. “Орос, Хятад нь өөрсдөдөө тохирсон шинэ дэг журам боловсруулахад голлон оролцох ёстой” тэр нь магад ШХАБ-аар дамжин илэрч болох талаар хятадын элчин сайд асан Ли Фэнлинь өгүүлсэн. Академич Ли Цзинцзе (Ли Жинжэ) “Орос, Хятадын аль алины сонирхол энэхүү шинэ маягийн бүтцийг илүүд үзэж байгаа. Чухамхүү, ШХАБ нь энэ үзэл санааны анхны илрэл” хэмээн тэмдэглэсэн ч байдаг.

ШХАБ-ын эгнээг АНУ-тай “хэт ойртдоггүй” улсуудыг элсүүлэх замаар өргөжүүлэх бодлого барьж байна. ШХАБ-д шинэ гишүүн элсүүлэхэд Орос, Хятадын байр суурь шууд нөлөөлж байгаа. Төв Азийн шинэ улсууд нь хэдийгээр Өрнөд, АНУ-тай ойртох хүсэл эрмэлзэл байсан ч өнөөгийн нөхцөл байдал нь тэднийг тийм зүйлд хүрэх боломжийг нь хаасаар байна. ШХАБ-ын Хартид Орос, Хятадын эрх ашиг л зонхилсон.

ОХУ, БНХАУ-ын хувьд ШХАБ-аар хамгийн ихээр эрх ашиг нь нийлдэг зүйл бол салан тусгаарлах үзэл санааны эсрэг хамтран тэмцэх үйл ажиллагаа юм. Эндээс ШХАБ дотор Орос, Хятадын эрх ашиг ба бусад улсуудын эрх ашиг гэсэн далд хэлбэрийн үндсэн 2 бүлэг зөрчлийг үүсгэсэн байгаа. Бусад гишүүд нь дотроо ч бас өөр өөрийн эрх ашгийн төлөө ШХАБ-ыг ашиглах зорилготой байгаа.



ШХАБ-ын үндсэн талбар болох Төв Азид дэд бүтцийн нэн ялангуяа, тээврийн сүлжээг хэн өөрийн эрх ашигт нийцүүлж байгуулах талаар тун удахгүй нэлээн том зөрчил гарч, тэр нь хоёр болон олон талын харилцааг хөндөж эхэлнэ.

Дүгнэлт хийхэд, «ШХАБ дахь Монголын оролцоо нь гэдэг нь түүнд «бүдгэрэх» Монголын эрх ашиг ажгуу.

## ШАШИН ШҮТЭХ, ЭС ШҮТЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ

### ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ӨГӨХ САНАЛ\*

2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Пума зочид буудлын хоёрдугаар давхрын хурлын танхимд Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн” талаарх хэлэлцүүлгийг албан ёсоор зохион байгуулав. Хачирхалтай нь уг хуулийн төслийг “ЭНЭ ТӨСӨЛ БОЛ НООРОГ ГЭДГИЙГ ОЙЛГООРОЙ” хэмээн Хууль зүйн дэд сайд хэмээх эрхэм удаа айлдаж, тэрхүү ноорогийг хэн санаачилсан, хэн хийснийг огт хэлэхийг хүссэнгүй, Монголын төр санаачилсан хэмээн хэлж байв.

1993 онд батлагдсан Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг шинэчлэх, Монгол дахь шашны байгууллагуудыг хийгээд шашны асуудлыг хуулиар зохицуулах шаардлага байгаа гэдэгтэй бол санал нэг байгаа юм. Харин хийдэл гарсаныг далимдуулан хэлэлцүүлсэн энэхүү хуулийн төсөл хэмээх ноорог нь Монгол Улсын үндэсний эрх ашигт харшилсан зүйл төдийгүй, үр дагавар нь үндэсний аюулгүй байдалд хор хохирол дагуулах эрсэлтэй болохыг юуны өмнө хэлэхийг хүсч байна. Тиймээс Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан уг хуулийн төслийг хэлэлцэхгүй байх нь улс, үндэсний эрх ашигт тустай хэмээн үзэж байна. Учир нь уг хуулийн төсөл хэмээн хэлж буй ноорогийн үзэл баримтлал – концепци нь бурханы шашин, үндэсний уламжлал, эх түүх, соёл, зан заншлыг үгүй хийх далд санаа агуулсан төдийгүй Азийн, дорнодахины уламжлал, түүхийн дэлхийд үлдээсэн өвтэй Монгол орныг шинээр зохион байгуулах санаа агуулсан байж болох хэмээн хардаж болохоор санагдсаныг нуух юун.

Энэхүү хуулийн төслөөр Монголын төр анх удаа Монголд бурханы шашин, христос, лалын шашин, бөө мөргөл зэрэг бусад олон шашин зэрэгцэн оршиж байгааг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн алхам хийсэн болно. Энэхүү хэлэлцүүлгийг хийсэн явдал уг агуулгаараа тэдгээр шашны төлөөлөлд ийм ойлголт өгсөнөөр барахгүй, цаашид улам дур зоригоор авирлах боломжийг олгосон хэмээн үзэхэд болно. Энэ бол маш алдаатай алхам болсон хэмээн үзэж байна. Монгол улсад олон шашиныг зэрэгцэн адил тэнцүү эрхтэйгээр орших хуулийн орчиныг

---

\* Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Гансүхэд хүргүүлжээ.

тавих нь шашны мөргөлдөөний үүр болох магадлал өндөр болно. Энэхүү хуулийн төслийн үзэл санаа, концепцийг цаашид дэмжиж болохгүй хэмээн хэлж буйгаа тодорхой үндэслэлээр тайлбарлахыг хүсч байна. Үүнд:

Нэгдмэл улсын үүднээс хандах аваас туулж ирсэн багаар бодоход сүүлчийн дөрвөн зуун жилийн түүхэн уламжлал, бурханы шашин, үндэсний түүх, уламжлал, соёл тэргүүтнээ хөсөр хаяж хэрэггүй хэмээн гээж хаяад Монголд лав удаан ээнэгшин дасаагүй бусдын шашин, соёлыг дэлгэрүүлэхийг зорьж байгааг хуулийн агуулгаас харж болно. Уг хуулийн төслийн 3.1. Шашны бүлэг, Шашны байгууллага, шашны номлол түгээгч, 4.9., 4.10.д буй гадаад улсын иргэн ... эрхтэй гэсэн заалт. 6.22 буддын шашин /уламжлалт шашин/ хэмээсэн заалт, 7.1-ийн Сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан хуулийн этгээдийн эрхгүй этгээдийн байгууллагыг шашны бүлэг гэнэ гэсэн заалтуудаас дээр хэлсэн утга, агуулгыг тодорхой харж болно.

2. Буддын шашин - уламжлалт шашин хэмээн тэмдэглэсэн нь Христос шашинтай Орос зэрэг улсад Буддын болон бусад зарим шашныг уламжлалт хэмээн бичсэн байдаг түвшинд хүлээн зөвшөөрөх хэмээсэн санаа нэвт шингэсэн байна.

3. Буддын шашин лав сүүлийн зуу гаруй жилийн бие даан тусгаар оршиж буй Монгол Улсын хувьд үндэсний шашин байсан, өнөөдөр ч зонхилох, үндэсний шашин хэмээн үзэх бүрэн түүхэн үндэслэлтэй. Эс тэгвээс Ерөнхийлөгч маань Библи судар дээр баруун гараа тавин тангараг өргөх хувь зохиол цаг хугацааны асуудал болсон хэмээн үзэж болно.

4. Уг хуулийн төслийн 40.1-д Шашны асуудал эрхэлсэн Зөвлөлийн тэргүүнээр Хууль зүй, дотоод хэргийн яамны сайд байхаар тусгасаныг шашны асуудал ямагт Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тэргүүний мэдэлд байснаас гаргах гэсэн санаа хэмээн хардаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх мэдэлд халдсан төдийгүй, аюулгүй байдалд шууд хамаарах асуудлыг ийнхүү хөнгөн гоомой мөчидөөр авч үзэхийг оролдсон явдал бол улсын үндэсний аюулгүй байдалд хор уршиг дагуулах эрсдэлтэй хэмээн үзэх байна.

Уг хуулийн төслийн 42 дугаар зүйлд Шашны байгууллагад үл харьяалагдах шашны номлол түгээгч байж болохоор заасан нь Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичигт буй харьяалалгүй лам байж болохгүй хэмээсэн

заалтыг ч олж үзээгүй төдийгүй дур зоригоор авирлахыг хүлээн зөвшөөрсөн агуулгатай болсон мэт байв.

Санал:

Нэг. Монгол бол бурханы шашинтай орон. Бурханы шашин монголчуудыг нэгтгэсэний хүчинд Монголчууд Богд гэгээнтэний үгийг хууль мэт даган тусгаар тогтнол, төр улсаа олж авсан билээ. Энэ бол ердөө зуун жилийн өмнөх түүх. Харамсалтай нь үе үеийн Ерөнхийлөгч нарт, одоогийн төрийн тэргүүн Х.Баттулга танд ч Богд хаанд хөшөө босгохыг уриалсан зарлиг буулгахыг гуйж, олонтоо захидал, хүсэлт илэрхийлсэн боловч нэгээхэн бээр бүтээгүй байгаа юм. Улаанбаатар хэмээх нэртэй Богдын Хүрээнд сууж буй монголчуудад Богд хаандаа хөшөө босгож, түүхэнд оруулсан үнэт хувь нэмэрийг хүлээн зөвшөөрсөн бол ядаж монгол түмэн түүхээ ойлгож, өөрийгээ таних наад захын мэдлэгтэй болохоос гадна элдэв гадны шашны урсгалуудын нөлөөлөлд бага ч болов хязгаарлалт болох байсан боловч хэмээн бодох юм. Тиймээс нэгдсэн Монгол Улсын үүднээс бурханы шашныг үндэсний зонхилох шашин хэмээн хүлээн зөвшөөрч, одоогоор тодорхой хувь эзэлсэн бусад шашныг хүндэтгэх үзэл баримтлалтай шашны хуулийн төслийг шинээр боловсруулан УИХ-д хэлэлцүүлэн батлуулах аваас Монгол Улсын эрх ашигт нийцнэ хэмээн бодож байна.

Хоёр. Ийнхүү үзэл баримтлалаар шашны хуулийн төсөл боловсруулахдаа бурханы шашны Монголын түүхэнд оруулсан хувь нэмрийг тодорхой тусгах шаардлагатай. Учир нь социализмын жилүүдэд шашингүй үзлийн үүднээс бурханы шашныг устгаж, оюун санааны хоосролд оруулсаны хор уршгаар бид аливааг бодитойгоор харах мэлмий үгүй болж, зөвөөр цэгнэх чадваргүй болтлоо доройтсон байна.

Гурав. Шашны хуулийн төслийг боловсруулахын өмнө Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс эрхлэн, Монгол Улсад буй шашин, шашины байгууллагуудын талаар бодитой үнэн зөв судалгааг мөнгө хөрөнгө гарган бие даан хийх, эсвэл хөндлөнгийн байгууллагаар хийлгэх шаардлагатай байна. Ийнхүү бодитой гаргасан социологийн судалгааны үндсэн дээр Монгол Улс дахь шашны байгууллагуудын талаарх зохицуулалтыг өнгөрсөн, одоогоо эргэцүүлж ирээдүйгээ бодсон байдлаар хийх нь зүйтэй болов уу хэмээн үзэж байна.

Санал бичсэн: ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдэмтэн, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Оохнойн Батсайхан

“МОНГОЛЫН БУРХНЫ ШАШНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ БА  
ХӨРШ ОРНУУДЫН НӨЛӨӨ”\*

**Товч агуулга:** 1990 оноос Монгол Улс нийгмийн шилжилт хийснээр урьдын захиргаадалтын тогтолцоог халж, хүний эрх, эрх чөлөөг бүх талаар дээдэлсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлж эхэлсэн билээ. Тэр цагаас хойш урьд хаагдмал байсан шашин шүтлэг нээлттэй болж, хурдацтай хөгжсөнөөр үл барам тэрхүү хурдацтай хөгжил нь эдүгээ нэгэнт төрийн хяналтаас алдуурч, гадаад дотоодоос үүдэлтэй олон сөрөг үр дагаварыг нийгэмд үзүүлэх болов. Хэдийгээр шашны асуудал нь хүний эрхийн салшгүй нөхцөлдүүлэгч байдаг ч түүний эрх зүйн орчныг цаг үетэйгээ нийцүүлэн боловсронгуй эс болговол хүний эрхийг ноцтой зөрчих үндэс, үндэсний хэмжээний эрх ашгийг боогдуулах хүчин зүйл болдог нь Монголын өнөөгийн нөхцөл байдлаар илэрч гарав. Сүүлийн үед төр засгаас энэ байдалд анхаарал хандуулж, тодорхой ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байгаагийн тод илрэл нь “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль”-ийн төслийг боловсруулан, хэлэлцүүлэг өрнүүлсэнд оршино.

Бид энэхүү зөвлөмжид цаг үеийн шаардлагаар урган гарсан уг хуулийн төсөл ба түүний агуулга, үзэл санаа нь Монголын шашныханд тэр дундаа бурханы шашныхны нөхцөл байдалд хэрхэн нөлөөлж болохыг тусгайлан авч үзэв. Чингэхдээ үндэснийхээ уламжлалт соёл, эв нэгдлийг хангах нэг хүчин зүйл бол төрийн хяналтын дор хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах аливаа шашин ба шашны байгууллага хэмээн үзэж тэр дундаа Бурханы шашныг онцгойлж, түүний албан ёсны тэргүүнийг тодруулах, байр суурийг нь бэхжүүлэх эрх зүйн орчныг буй болгох хийгээд Монголын бурханы шашны өнөөгийн байдал ба хэтийн төлөв, түүнд нөлөөлөх хөрш орнуудын нөлөө, оролцоо, ашиг сонирхолын талаар тусгайлан өгүүлжээ.

Боловсруулсан Д.Базардорж.

---

\* Үндэсний Аюулгүй Байдлын Ажлын албаны захиалгаар 15 хуудас өгүүлэл бичиж, 2019.03.07-д хүргүүлэв. Нээлттэй нийтлэхийг хориглосон.

ХҮЙТЭН ДАЙНЫ ДАРААХ МОНГОЛ, ХЯТАД, ОРОСЫН  
ГУРВАН ТАЛТ ХАРИЛЦААНЫ ҮЕ ШАТ БА ОНЦЛОГ\*

*Нацагдоржийн Ариунгуа*

*ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн*

*Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Ph.D*

*E-mail хаяг: [ariunguan@mas.ac.mn](mailto:ariunguan@mas.ac.mn)*

**Хураангуй:** Хүйтэн дайны үе дуусгавар болсноор Монгол, Орос, Хятад гурван улс хоорондын харилцаанд тэдгээрийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдал, дотоод, гадаад хөгжлийн зорилт, олон улсын харилцааны өрнөл, чиг хандлага зэргээс хамааран багагүй өөрчлөлт гарсан бөгөөд энэхүү харилцааг тодорхой хэмжээгээр үечилж болох юм. Чингэх нь гурван орны хамтын ажиллагааны хөгжил, энэхүү харилцааны үр өгөөж, нөөц бололцоо, тулгамдсан асуудлуудыг олж харахад ач холбодолтой. Хүйтэн дайны дараах гурван улсын харилцаа хоёр талт харилцаагаар тодорхойлогдож байсан ч хоорондын харилцаанд нь тус бүрийн хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэсээр байгаа нь энэ гурван улс геополитикийн нэг орон зайд багтдагтай шууд хамааралтай. Зохиогч гурван орны геополитикийн харилцан хамаарал эдгээр орнууд хоорондын хоёр талт харилцаанд хэрхэн нөлөөлж буй асуудлыг хөндөн гурван талт харилцааны хэлбэр бий болоход ямар учир холбогдолтойг харуулахыг зорьжээ.

**Түлхүүр үг:** *Хүйтэн дайны дараах Монгол, Орос, Хятад гурван улсын харилцаа, ашиг сонирхолын нэгдэл, хүлээлт*

1990-ээд оны эхэнд социалист систем нуран унаж, ЗХУ задарснаар олон улсын харилцаа хоёр туйлаас олон туйлд шилжиж, дэлхийн хэмжээний хүчний харьцаанд чанарын өөрчлөлт гарав. Тухайн үед олон улсын харилцааны дэг журам шинээр бүрэлдэн бий болж Монгол Улс, БНХАУ, ОХУ нь гадаад улс төрийн бодлогоо шинээр тодорхойлсон нь гурван орны хоорондын харилцаанд ч шууд тусгалаа олсон юм. Нөгөөтэйгүүр хүйтэн дайны дараах гурван улсын харилцаа

---

\* Олон улс судлал сэтгүүл, 2019№1(109), тал 40-63 DOI: <https://doi.org/10.5564/jis.v0i1.1253>

хоёр талт харилцаагаар тодорхойлогдож байсан боловч тэдгээрийн хоорондын харилцаанд тус бүрийн хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэсээр байсан хийгээд байгаа нь ерөөс энэ гурван орон нь геополитикийн нэг орон зайд багтдагтай шууд хамааралтай.

ЗХУ задарч Монголын гадаад орчинд шинэ нөхцөл байдал үүссэнээр ЗХУ-ын улс төр, эдийн засаг болон үзэл суртлын нөлөөнөөс гарч, Монгол өөрийн сонгосон зах зээлийн замаар хөгжих нөхцөл бүрэлдэн бий болов. Монгол Улс нь газар зүйн хувьд Орос, Хятад хоёрхон хөрштэй нь түүхээсээ аваад Монголын гадаад бодлогод маш чухал хүчин зүйл болсоор ирсэн. Иймээс ч Монгол Улс гадаад бодлогоо шинээр тодорхойлохдоо газар зүйн онцлог, түүхийн уламжлалынхаа дагуу хоёр хөршөө гадаад бодлогынхоо чухал хүчин зүйл гэж үзэж эдгээр орнуудтай харилцах харилцаагаа тэргүүлэх чиглэл хэмээн тунхаглан зарлав. Манай улс шинэ нийгэм байгуулахдаа ямартай ч хоёр хөрштэйгээ эрх тэгш үндсэн дээр харилцан ашигтай харилцаа тогтоохыг эрмэлзэн ийнхүү тунхагласан юм. Чингэхдээ энэ хоёр улстай адил зайнаас харилцах зарчмыг баримтлахаа<sup>1</sup> мөн онцолсон билээ.

Нөгөөтэйгүүр Монгол Улс нь гуравдагч хөршийн бодлого баримтлахаа зарласан бөгөөд түүхээсээ аваад хоёрхон хөрштэй, хоёр хөршөө ихэнхдээ дулдуйдан оршин тогтнон байсан Монгол орны гадаад орчинд тусгаар тогтнолоо бэхжүүлэн хамгаалах, эдийн засгаа хөгжүүлэх таатай нөхцөл байдал үүсч байсны тод илрэл юм. Хоёр хөрш маань ч Монголтой харилцахдаа гадаад орчинд нь шинээр үүссэн нөхцөл байдлыг харгалзах болов.

1990-ээд оноос хойш өнөөг хүртэл манай орон хөршүүдтэйгээ харилцсан харилцааг ерөнхийд нь авч үзэхэд, хоёр хөрш орон маань Монгол Улсын тодорхойлсон гадаад бодлогын чиглэлийн дагуу харилцаагаа тогтоож, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг ямагт хүндлэн харьцаж ирснийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Энэ 20 гаруй жилийн хугацаанд гурван орны улс төр, эдийн засгийн дотоод, гадаад хөгжлийн зорилт, олон улсын нөхцөл байдлын өрнөл, онцлог зэргээс хамааран хоорондын харилцаанд нь багагүй өөрчлөлт гарсан бөгөөд энэхүү харилцааг тодорхой хэмжээгээр үечилж болох юм. Чингэх нь гурван орны хамтын ажиллагааны хөгжил, энэхүү харилцааны үр өгөөж, нөөц бололцоо, тулгамдсан асуудлуудыг олж харахад ач холбодолтой.

---

<sup>1</sup>Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. (1994 он)

Бид энэхүү харилцааг үечлэхдээ юуны түрүүнд олон улсын харилцаанд гарсан болон гарч буй үндсэн өөрчлөлт, хоёр хөршийн дотоод, гадаад бодлогоос улбаатай зарчмын өөрчлөлтүүд манай гурван орны харилцаанд хэрхэн нөлөөлсөн болон нөлөөлж байгааг эш үндэс болгон харилцааны үе шатыг тодорхойлохыг оролдов. Мөн Монгол Улс хөгжлийн чиг хандлагаа тодорхойлох, хөгжлийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ гадаад бодлогодоо хоёр хөршийн улс төр, эдийн засгийн хүчин зүйлийг хэрхэн харгалзан үзэж, ашиглаж ирснийг эш үндэс болгов. Хүйтэн дайны дараах гурван улсын харилцааг барагцаалан гурван үед хуваан тэдгээр харилцаанд гарсан өөрчлөлтүүд, онцлогийг доорх байдлаар тодорхойлохыг оролдов.

### ***Нэгдүгээр үе (1991-2011)***

Хэдий хүйтэн дайны дараа Монгол, Хятад, Оросын хоорондын харилцаа гурвалсан харилцааны хүрээнд явагдаагүй боловч тэдгээрийн харилцаа нь харилцан бие биетэйгээ уялдаатай байж харилцан нөхцөлдөж байсан нь бидний дээр тэмдэглэсэнээр гурван орон геополитикийн нэг орон зайд багтдаг, хөрш зэргэлдээ орнуудын хувьд улс төр, эдийн засгийн харилцан хамааралтай байдагтай холбоотой. Үүний нэг жишээ бол Хятадын засгийн газар Монголоос цэргээ гаргах нөхцөлд ЗХУ-тай харилцаагаа сэргээх тухай шаардлага тавьж байсан зэрэг юм. Нөгөөтэйгүүр 1991 онд ЗХУ задарч, ОХУ байгуулагдсаны дараа Монгол дахь Оросын нөлөө багасахад Хятад улс тэрхүү орон зайг дүүргэхийг хичээж байсан нь хоёр хөршийн аль аль нь Монгол Улсад өөрийн ашиг сонирхолтой байсаар ирснийг харуулж буй зүйл юм.

ЗХУ 1991 онд задарч, "Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл" (ЭЗХТЗ) үйл ажиллагаагаа зогсоосны улмаас болон мөн үүнээс өмнөхөн ЗХУ-ын зүгээс 1980-аад оны сүүлчээр Монголын эд бараанд гаалийн татварыг нэмэгдүүлснээр монголын эдийн засаг гүнзгий хямралд орсон. Монгол Улс нэг улсаас хэт хамааралтай байсны хор уршиг чухам энэ үед илтээр мэдэгдсэн юм. Монголд өрнөсөн ардчилсан хувьсгалын үеэр улс орноо ямар замаар хөгжүүлэх асуудал хурцаар тавигдаж, зах зээлийн замыг сонгож авсан болно. Гэвч тухайн үед улс орныг хөгжүүлэх тодорхой төсөөлөл хараахан бүрдэж амжаагүй, зах зээлийн эдийн засгийн зүй тогтлын талаарх мэдлэг дутмаг, зах зээлийн удирдлага менежментийг эзэмшсэн боловсон хүчин байгаагүй зэргээс хамаарч Монголын эдийн засагт хүндрэл үүссэнээр үл барам цаашдын хөгжилд ч маш олон асуудлыг дагуулсан. Харамсалтай нь энэ үед ЗХУ-ын тусламжаар бий болсон аж үйлдвэрийн чиглэл



бүхий эдийн засгийн суурь нуран унаж, ашигт малтмалын салбарыг хөгжүүлэх нэрийдлээр ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт Монгол Улсын эдийн засгийн гол чиглэл болон хувирав.

Тухайн үед Монгол Улс эдийн засагт учирсан хямралыг даван туулахын тулд Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банк, Япон, АНУ, Герман зэрэг орнуудтай хамтран ажиллаж мөн БНХАУ-тай эдийн засгийн хамтын ажиллагаагаа өрнүүлэх болов. Монгол Улс, БНХАУ-ын харилцаа хамтын ажиллагааны үндэс суурь нь 1994 онд байгуулагдсан Монгол-Хятадын найрамдал, хамтын ажиллагааны гэрээ байв. Тухайн үед Хятадад ид өрнөж байсан шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд их хэмжээний түүхий эд шаардлагатай байсан нь Монгол Улс эрдэс баялгаа гадагш нь зөөх бодлоготой яв цав нийцэж хоёр орны хооронд худалдаа-эдийн засгийн чиглэлээр маш эрчимтэй хамтын ажиллагаа өрнөв. Чухам энэ үед Хятад улс Монголын хамгийн том худалдааны түнш, хөрөнгө оруулагч болж хувирах эхлэл тавигдсан болно.

Нөгөөтэйгүүр тухайн үед БНХАУ-ын геополитикт таатай нөхцөл үүссэн нь хөрш зэргэлдээ Монголд Оросын нөлөө багассанаар Монголын гадаад орчинд үүссэн орон зайг эзлэн авах боломж бий болов. ОХУ-ын гадаад бодлого Өрнөдийн орнууд руу чиглэж барууны зах зээл дээр гарах сонирхолтой байсан зэрэг нь Монгол Улсын талаар явуулж байсан бодлогод нь шууд нөлөөлж Монголын талаарх байр суурь нь идэвхигүй болсон. Хэдий Монголд Хятадын бодлого идэвхижиж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа эрчимжиж улмаар Оросын эрх ашгийг хөндөж ирсэн ч ОХУ тухайн үед Монгол Улсын талаар идэвхигүй байр суурьтай байсаар байв. Монгол Улсын гадаад, дотоод нөхцөл байдлын талаар тухайн үед судалгаа хийж байсан барууны судлаачид бүтээл туурвилдаа Монгол дахь Оросын оролцоо, Оросын сигментийг онцгойлон дурдаагүй нь Монгол-Оросын харилцаа ямар түвшинд орсныг харуулах нэг үзүүлэлт юм<sup>2</sup>. Үүнийг мөн ОХУ-ын 1993 онд батлагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д Монгол Улсын талаар огт дурдаагүйгээс<sup>3</sup> ч харж болох юм.

---

<sup>2</sup> Camp A.A Mongolia in Northeast Asia-the NewRealities//Geopolitical relations betweenContemporary Mongolia and Neighboring Asian Countries.-Chinese Culture University, Taiwan,2004.;Fish M.S.The Inner Asia anomaly:Mongolia’s democratization in comparative perspective//Communist and Post-Communist Studies,-2001.№34; GinsburgT.Political Reform in Mongolia. Beetween Russia and China// Asian Survey.1995№5

<sup>3</sup> Основные положения концепции внешней политики РФутвержден распоряжением Б.Н.Ельцина от 23 апреля 1993г.-Внешняя политика и безопасность современной России.1991-2002. Хрестоматия в 4-х томах.Документы.М.,2002

Ийнхүү ЗХУ задарч түүний орон зайд байгуулагдсан ОХУ нь манай улсын хоёр дахь хөрш болов. ЗХУ задарч түүний нэг чухал субъект байсан ОХУ өөрийн хөгжлийн чиглэлээ, түүн дотор гадаад бодлогоо цоо шинээр тодорхойлох болсон. Монгол Улс өөрийн хөгжлийн замаа шинээр сонгосон зэрэг нь хоёр орны харилцаанд шинэ нөхцөл байдлыг үүсгэв.

Монгол Улс, ОХУ-ын хооронд байгуулагдсан “Найрамдал, сайн хөршийн хамтын ажиллагааны тухай тунхаглал”, 1993 оны “Монгол Улс, ОХУ-ын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” хоёр орны харилцааны үндэс суурь болж өгсөн ба тухайн үед хоёр орны харилцааны түвшин доогуур байснаас гадна хоёр орны хооронд өрийн асуудал хурцаар тавигдаж эхэлсэн.

Манай хөрш хоёр орон ОХУ, БНХАУ-ын хоорондын харилцааны хувьд гэвэл хоёр орон бие биенээ “нөхөрсөг улс” хэмээн хүлээн зөвшөөрсөн “ОХУ, БНХАУ-ын хоорондын харилцааны үндсийн тухай хамтарсан тунхаглал” (2000), мөн “ОХУ, БНХАУ-ын хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ (2001) болон 1964 оноос эхэлсэн хоёр талын хилийн маргааныг дуусгавар болгосон “ОХУ, БНХАУ хоорондын улсын хилийн зүүн хэсгийн нэмэлт хэлэлцээр” (2004) зэрэг байгуулагдсан нь хоёр орны харилцааг хэвийн болгох үндэс суурь тавигдсан. Гэвч хоёр орны харилцаа тухайн үедээ ч мөн цаашид ч тодорхой хугацаанд эрчимтэй хөгжиж чадаагүй. Хэдий тийм боловч хоёр хөрш орны хоорондын харилцаа хэвийн болж тогтворжсон нь манай улсын гадаад орчин баталгаажих нааштай нөхцөл байдлыг үүсгэв. Нөгөөтэйгүүр ЗХУ задарсны дараа ОХУ нь Монголын талаар идэвхитэй бодлого, хамтын ажиллагаа хэрэгжүүлээгүй нь Монголд Хятадын хүчин зүйл нэмэгдэх үндсэн нөхцөлийг бий болгосон. Монгол Улс нь гадаад бодлогын тунхаглалдаа үнэнч байж БНХАУ, ОХУ-тай харилцахдаа гадаад бодлогынхоо тэргүүлэх чиглэлээ хэмээн үзэж хоёр хөрштэйгээ эрх тэгш үндсэн дээр харилцахыг эрмэлзсээр ирсэн юм.

Ийнхүү ЗХУ задарч, хүйтэн дайн дуусгавар болсны дараа үе буюу 1991- 2000 оны эхний арван жилийн хугацааны Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хоорондын харилцаа харилцан хамаарлыг дүгнэхэд, энэ үед Монгол Улс хоёр хөрштэйгээ найрамдал, хамтын ажиллагааны үндэс суурийг тавьснаас гадна манай хоёр хөршийн харилцаа ч мөн хэвийн байдалд шилжиж ирээдүйн гурамсан харилцааны суурь тавигдах үндсэн нөхцөл бүрэлдсэн хэмээн үзэж болох.

## **Хоёрдугаар үе (2012-2016)**

Тухайн үед хэдий гурван улсын хоорондын харилцаа хоёр талт харилцааны хэлбэрээр хөгжиж байсан боловч 2012 оноос гурван талт харилцаа, хамтын ажиллагааны чиглэл бүрэлдэн бий болж эхэлсэн. Тухайн үед гурван талт харилцааны хамгийн өндөр түвшний механизм бол Монгол, Орос, Хятад хөрш гурван орны Гадаад хэргийн яам хоорондын гурван талт харилцаа байв. 2012 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Москва хотноо гурван улсын Гадаад хэргийн яам хоорондын найм дахь удаагийн зөвлөлдөх уулзалт анх удаа албан ёсны статустайгаар явагдсанаар гурван талт харилцааны механизм бүрэлдэн бий болсон. Тус зөвлөгөөнөөр гурван улсын хооронд улс төрийн болон түүхийн талаас шийдвэрлэгдээгүй асуудлууд байхгүйг талууд тэмдэглэж, цаашид гурван тал бие биенийхээ бүрэн эрх, аюулгүй байдал, язгуур эрх ашигтай холбоотой болон гурван улсын харилцаанд ач холбогдол бүхий асуудлаар харилцан хэлэлцэх, дэмжлэг үзүүлж ажиллахаа илэрхийлэв. Цаашид гурван тал худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн зэрэг салбарт хамтын ажиллагаа, солилцоог хөгжүүлэх, худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд уул уурхай, дамжин өнгөрөх тээвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалт, аялал жуулчлал, байгаль орчныг хамгаалах зэрэг салбарт гурван талт хамтын ажиллагааг өрнүүлэх нь чухал гэж тэмдэглэсэн. Энэ чиглэлээр манай улсын зүгээс зарим нэгэн асуудлыг ажил хэрэг болгох санаачилга гаргаж байсан ба тухайлбал НҮБ-ын Худалдаа хөгжлийн байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгээр Монгол, ОХУ, БНХАУ-ын хооронд транзит тээврийн гурван талт суурь хэлэлцээр санаачлан эхлүүлж энэ хүрээнд яриа хэлэлцээр явуулж төслийг үндсэндээ тохироод байсан боловч тодорхой шалтгаанаар хойшлогджээ<sup>4</sup>.

Тухайн үед гурвалсан хамтын ажиллагаа бодит ажил болж өгөхгүй байсан нь гурван орны хоорондын хоёр талт харилцаанаас ихээхэн хамаарч байв.

1. Хятад-Оросын тухайн үеийн хоёр улсын хоорондын харилцааны онцлогийг дурдвас, БНХАУ, ОХУ хоорондоо дээд хэмжээний стратегийн түншлэлийн харилцаатай, олон улсын тавцанд хоёр улсын нэгдмэл эрх ашгийг харилцан хамгаалдаг, дэлхийн хэмжээний тулгамдсан асуудлаар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл дээр нэг байр сууринаас ханддаг, зарим судлаачдын үзэж байгаагаар, Ази дахь олон улсын асуудлаар хоёр орны албан ёсны байр суурь

---

<sup>4</sup>Өнөөдөр сонин. 2013.09.09 ГХЯ-ны сайд Л.Болдтой хийсэн ярилцлага.

ижил төстэй, НҮБ-ын шинэчлэлийн асуудлаар нэгдмэл байр суурьтай, бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд ШХАБ, БРИКС-ийн хүрээнд хамтын ажиллагаа хэрэгжүүлдэг. Мөн ОУВС, Дэлхийн Банкны үйл ажиллагааг орлуулах өөр төрлийн олон улсын механизмыг байгуулах санал болон Орос, Хятад улсын оролцоотой долларыг газрын тосны худалдаанд хязгаарлах буюу хэрэглэхгүй байх тал дээр тус тус санал нэгддэг. Ази дахь газар нутгийн талаарх БНХАУ-ын маргаан дээр ОХУ дундын байр сууринаас найрсагаар хандаж буйд талархдаг.

Хэдий тийм боловч хоёр орны хооронд зөрчил, өрсөлдөөн оршсоор байсан бөгөөд тэдгээр нь зарим талаар намжмал өнгө аястай болсон ч өнөөг хүртэл хадгалагдсаар байгааг тэмдэглэх хэрэгтэй. Тэдгээрийн заримаас дурдахад: БНХАУ-ын зарим нэгэн томоохон хэмжээний төслүүд нь хэдий ОХУ-ын эрх ашгийг шууд хөндөхгүй ч Орос, Хятадын хүчний харьцаанд шууд нөлөөлж буй явдал. Тухайлбал, БНХАУ Төв Азийн орнуудтай худалдаагаа либералчилсан, газрын тос, байгалийн хийн хоолойг барьж байгуулсан, дэлхийн өнцөг бүрд Хятадын төрийн өмчит компаниуд ашигт малтмалын олборлолтод оролцож байгаа; ОХУ-ын оролцоогүйгээр БНХАУ-ыг Төв Азийн бүс нутгаар дамжуулан Европтой холбох тээврийн замын коридор байгуулах төлөвлөгөөний эхлэл тавигдаж байгаа. Хэрэв төмөр замын магистраль шугам байгуулагдахад ОХУ-ын “Транссиб”, “Севморпуть” нь олон улсын транзит коридорын жагсаалтаас хасагдах магадлалтай; ШХАБ нь Төв Ази руу нэвтрэх Хятадын хэрэгсэл болж байгаа болон ОХУ тус байгууллагад өөрийн санаачилгаа алдах нөхцөл үүсээд байгааг тухайн үеийн Оросын судлаачид сэтгэл зовнин тэмдэглэж байсан. БНХАУ-ын дэвшүүлсэн “Торгоны зам”-ын эдийн засгийн төсөл нь Оросын ашиг сонирхолыг шууд хөндөж байгаа хэмээн ОХУ үзэж Евразийн Холбооных нь үйл ажиллагаанд шууд саад болно хэмээн хардаг. Мөн Хятад, Орос улсууд нь Монгол дахь эрх ашгийн төлөө өрсөлдөж Монголыг глобал, гео-эдийн засгийн бодлого дахь багагүй хүчин зүйл хэмээн үздэг зэрэг юм. Нөгөөтэйгүүр өгүүлж буй үед Орос, Хятадын эдийн засгийн харилцаа харьцангуй доогуур түвшинд байсан зэрэг нь Орос улс Хятадын талаар “стратегийн тодорхой бус бодлого” (стратегическая неопределенность) хэрэгжүүлж байгааг шинжээчид тэмдэглэж байв<sup>5</sup>.

---

<sup>5</sup> М.Троцкий. Китайский фактор в Российско-Американских отношениях. Московский государственный институт международных отношений-  
<http://www.msk.ru/blog/ponarseurasia/1193614-eco>

Хэдий гурван орны хоёр талт харилцаанд өрсөлдөөн, зөрчлүүд байсан боловч тэдгээрийн харилцаанд нэгдмэл эрх ашиг зөрчлөөс хавьгүй их байсан юм. Гурван орны харилцаа цаашид хөгжих нөхцөлийг Хятад улс анх санаачилсан ба энэ нь Хятадын гадаад бодлого дахь шинэ чиг хандлагатай холбоотойгоор үүсэн бий болсон юм. Энэхүү бодлогын гол зорилго бол БНХАУ “сайн хөрш, найрсаг хөрш” үзэл санааны хүрээнд бүс нутгийнхаа нөлөөг тэлэх явдал байв. Тус бодлогын хэрэгжилтэд хөрш орнууд болох Монгол Улс, ОХУ зүй ёсоор багтаж байв.

Ши Жиньпин засгийн эрхэнд гарсныхаа дараахан Монгол Улс болон ОХУ-ын талаарх бодлогоо эрчимжүүлжсэн бөгөөд манай улстай стратегийн харилцаа тогтоосноос гадна ОХУ-тай илүү ойртох алхмуудыг хэрэгжүүлж эхэлсэн юм. Хятадын төвийн хэвлэл “Жэньмин жибао” сонинд тухайн үеийн Хятад, Оросын харилцааг анх удаа албан ёсоор тодорхойлон хоёр орны харилцааг эрчимжүүлэх талаар байр сууриа илэрхийлсэн байдаг. Түүнд өгүүлсэн нь: “ОХУ бол Хятадын стратегийн холбоотны хувьд байр суурь дээрээ баттай зогсож байгаа боловч эдийн засаг худалдааны салбарт болон Төв Азийн бүс нутаг дахь улс төрийн байр суурь нь Хятад улсынхаас зөрүүтэй. Хэдий тийм боловч тус бүрдээ ижил төстэйг нь сонгон авч ялгаатай зүйлээ орхиж, хоёр талын харилцаанд нэгдмэл эрх ашиг зөрчлөөс хавьгүй их байгааг харгалзан стратегийн харилцан итгэлцлэлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааны практик үйл ажиллагааг нэмэгдүүлэхээр эрмэлзэж буй нь хоёр талын маш том хамтын ойлголцол юм”<sup>6</sup> гэжээ.

Ийнхүү БНХАУ-ын гадаад бодлогын санаачилгууд гурван талт харилцаанд шинэ нөхцөл байдлыг үүсгэсэн нь тус гурван улсын хоорондын хоёр талт харилцаанд ч шинэ хандлагуудыг бий болгов. Тухайн үед Оросын тал Монголыг илүүтэй сонирхож эхэлсэн ба дээд хэмжээний хэд хэдэн айлчлал нь Орос улс, нэгэн цагт Монголд алдсан өөрийн орон зайг эргүүлэн авах сонирхолтой байгааг харуулав. Энэхүү байдал манай хөрш Хятад улсын анхаарлыг зүй ёсоор татсан нь мэдээж. ОХУ гэнэт Монгол Улс руу чиглэсэн идэвхитэй бодлого хэрэгжүүлсэн нь газар доорх баялгийг нь сонирхохоос гадна геостратегийн хувьд Монголыг алдахгүй гэсэн Оросын гадаад бодлогын чиглэлээр тайлбарлагдаж байв. ОХУ нь эдийн засгийн хувьд бэхжихийн сацуу дэлхийн хэмжээнд идэвхитэй гадаад улс төрийн бодлого явуулж, өөрийн орон зайгаа тэлэн бэхжүүлэх бодлого хэрэгжүүлж эхэлсэн байв. Үүнтэй уялдаатай ОХУ хил залгаа хийгээд удаан жил өөрийн

---

<sup>6</sup> Гурван улсын ерөнхий сайд нар Хятадад нэгэн зэрэг хийсэн айлчлал юу өгүүлэв? - “Жэньмин жибао” 2013.10

нөлөөнд барьж байсан Монгол Улсыг нөлөөнөөсөө гарахаас болгоомжилсон нь ойлгомжтой. Хэрэв чингэвээс олон зуун жилийн уламжлалтай Монголын талаар явуулж ирсэн Оросын бодлого талаар болж түүний геостратегийн бодлогод хохирол учирна гэсэн үг.

Орос улсын Монголын талаарх бодлого эрчимжсэн нь зөвхөн Хятад улс Монголтой идэвхитэй харилцаа өрнүүлсэнд бус Монгол Улс нь гуравдахь хөршийн бодлогоо тууштай баримталж байснаас гадна гадаад орчинд нь шинэ нөхцөл байдал үүссэнээр тайлбарлагдана. Энэ нь олон улсын хүчний харилцаанд үүссэн хүчний шинэ хуваарилалттай ч холбоотой юм.

Оросын улс төрийн конъюктурын судалгааны тэргүүлэх шинжээч Е.В.Бойко Монголын талаархи баримталж буй Оросын бодлогын талаар ийнхүү бичсэн: “Хэдий Монгол Улс нь ашигт малтмал, байгалийн онцгой их нөөц баялаг байхгүй боловч томоохон геополитикийн тоглогч болох их гүрнүүдийн хурц өрсөлдөөний бай болоод байна. Өнөөдөр Монгол нь Оросын сонирхолын хүрээлэлд багтаж байгаа боловч БНХАУ болон АНУ нь Монголыг Ази дахь түрэмгийллийнхээ түшиц газар хэмээн үзэж түүнийг өөрийн хяналтанд оруулахыг чармайж байна. ЗХУ энэ нутгийг орхиж явснаас хойш Өмнөд Солонгос, Япон мөн түүнд санаархаж байгаа билээ. Монголчууд өөрсдөө Оросыг итгэл даах, ашигтай түнш хэмээн үздэг. Нөгөөтэйгүүр Монгол Улс нь БНХАУ-тай хиллэдгийн хувьд ОХУ-тай нягт харилцаа тогтоосноор хил орчмоороо Оросын хүчин зүйлийг нэмэгдүүлэх юм. Монголын төлөө тэмцлийг Хятадын удирдлага явуулж байгаа бөгөөд Монгол Улстай хийж буй эдийн засгийн хамтын ажиллагаа нь Орос-Монголын хамтын ажиллагаатай харьцуулахад тоон үзүүлэлт, хэмжээгээрээ их юм. Хятадаар дамжин Монголын маш их хэмжээний ачаа тээвэр бусад орон руу чиглэдэг, Хятадын хөрөнгө оруулагчид Монголд маш идэвхитэй ажиллаж байна. Чингэхдээ Оросын бизнесменүүдийг бодвол Хятадын ажил хэрэгч хүмүүс нь улсын, хувийн гэхгүй том, дунд жижиг салбарт аль алинд нь анхаарлаа хандуулдаг” гэжээ.

Үнэхээр бидний дээр тэмдэглэснээр сүүлийн жилүүдэд Монголыг тойрсон олон улсын чанартай өрсөлдөөн бий болсон нь дэлхийн хэмжээнд явагдаж буй хүчний шинэ хувиралттай холбоотой. Нөгөөтэйгүүр зөвхөн геополитикийн хувьд их гүрнүүдийн анхааралд байсан Монгол нь гадаадынханы эдийн засгийн ашиг сонирхолыг төрүүлэх болсон юм. Чингэхдээ хоёр хөршийн болон зарим гуравдагч орнуудын манай улсын талаар явуулж буй бодлого нь зөвхөн эдийн засгийн ашиг сонирголоос үүдэн гарч буй биш энэ сонирхол илүү өргөн утгатай нь мэдээж.

Юуны түрүүнд хоёр хөршийн бодлогод эдийн засаг, улс төр, геополитикийн ашиг сонирхолын нийлбэр, гео-эдийн засгийн ашиг сонирхол манай оронд төвлөрч ирж байгааг илтгэж байна. Орос улс өнгөрсөн үе, ялангуяа ХХ зууны үеийн түүхийг зарим орнууд “засварлах” гэсэн оролдлого хийж буйг буруушааж хөрш зэргэлдээ орнуудтай тогтоож буй харилцаагаа дайсны эсрэг хамтран тэмцэж явсан өнгөрсөн үеийн түүхэн дурсамж, эдийн засгийн тусламж зэргийг эш үндэс болгон хоёр орны харилцааг түүхэн талаас нь үндэслэн “харилцааны уламжлал” хэмээн хүчин зүйлийг бий болгох бодлого баримтлах болов. Манай улс ч гэсэн Оросын энэхүү бодлогыг дэмжих нь бодит байдалд хоёр ард түмний туулсан түүхэн замналыг сануулж, хоёр улсын найрамдалт харилцааг бэхжүүлэх, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны маш чухал дэвсгэр болж өгөх талтай гэж үзэж буй. Нөгөөтэйгүүр энэ нь Оросын зөөлөн хүчний бодлого бөгөөд улс төр, эдийн засгийн харилцааг идэвхижүүлэхэд чухал хөшүүрэг болох ёстой ажээ.

Ийнхүү тухайн үеийн Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хоорондын харилцааг дүгнэхэд, хоёр хөрш орны зүгээс манай улстай харилцаагаа бэхжүүлэх сонирхол нь тэдгээрийн эдийн засаг, гадаад улс төр, геополитикийн эрх ашиг зэргээр тайлбарлагдах ба үүн дээр манай улсын ашиг сонирхол ч харилцан нөхцөлдөж ирсэн юм.

### **Гуравдахь үе (2016 оноос өнөө үе)**

Орчин үед манай хоёр хөрш орны гадаад улс төрийн бодлого, үйл ажиллагаа тэлж дэлхийн тавцанд глобал бодлогын томоохон тоглогчид болоод байна. Энэхүү хоёр орны харилцаа улам ойртон бэхжиж байгаа нь манай гурван улсын худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаанд ч чухал хөшүүрэг болж өгөх ёстой. Гурван орны хооронд өнөөгийн байдлаар хүчтэй яригдаж буй хамтын ажиллагааны төсөл бол эдийн засгийн нэгдсэн коридор болно. Тэгвэл энэхүү эдийн засгийн нэгдсэн коридор хэрэгжих үндэс суурь юу вэ гэсэн асуудал зүй ёсоор урган гарч ирэх ба энэ нь гурван улсын гурвалсан харилцааны өнөөгийн үе шатын зангилаа асуудал юм. Энэхүү төсөл нь манай гурван улсын дээд удирдлагын хүрээнд улс төрийн шийдлээ олчихоод байгаа. Гэвч энэхүү төсөл хэрэгжилтээ хүлээсээр байгаа бөгөөд төсөл хэрэгжих үндэс суурь нь манай хөрш хоёр орны гадаад дотоод бодлогын зорилго болон хоорондын харилцааны уялдаа холбоо, хамаарлаас ихээхэн шалтгаалах юм. Манай улсын хувьд хоёр хөрштэйгөө харилцан ашигтай эдийн засгийн коридортой болох нь түүхээсээ аваад эрмэлзэж байсан зүйлийн нэг мөн.

Энэхүү төслийг манай өмнөд хөрш БНХАУ-ын гадаад бодлогын зорилго, чиглэлийн өөрчлөлттэй холбон авч үзэх нь зүйтэй. БНХАУ-ын эдийн засаг хөгжихийн хирээр дэлхийн тавцанд үйл ажиллагаа өсөн нэмэгдэж, “глобал засаглал”-ын хэмжээнд өөрийн оролцоог үнэлэх болоод байгаа ба гадаад улс төрийн практик үйл ажиллагаа нь ч энэ чиглэлд хэрэгжих болсон. БНХАУ “баян чинээлэг хөрш” хөтөлбөрийг зарлан хөрш зэргэлдээ орнуудтай түншийн харилцаагаа эрчимжүүлж тэдгээртэй янз бүрийн түвшний стратегийн харилцаа байгуулах замаар улс төр, эдийн засгийн харилцаагаа хөгжүүлэх, өөрийн нөлөөгөө өсгөх зорилго тавьж байна. БНХАУ-ын дэвшүүлсэн “Нэг бүс, нэг зам” бодлого нь Хятадын бүсчилсэн бодлогын концепци бөгөөд уг төсөлд Хятадтай найрсаг харилцаатай, эдийн засгийн хувьд ашиг сонирхол нь нэг, бие биеэ нөхсөн, харилцан хамааралтай орнууд орж байгаа болон орох юм. Манай гурван улсын дээд удирдлагын хүрээнд улс төрийн шийдлээ олчихоод байгаа эдийн засгийн коридорын энэхүү төсөл “Нэг бүс, нэг зам” бодлого Хятадын гадаад эдийн засгийн маш том стратегийн хүрээнд хэрэгжих нь мэдээж. Учир нь энэхүү стратеги бол Хятад улсын дотоод хөгжилтэй маш их уялдсан тодорхой үе шаттай, маш сайн системчлэгдсэн бүс нутгийн бодлого бөгөөд энэхүү коридорын бүтээн байгуулалтыг ч тэрхүү стратегийн хүрээнд авч үзэх болов уу.

Орос улсын хувьд гэвэл ЗХУ задарснаас улбаалан ОХУ-ын олон улсын тавцан дээрх нөлөө эрс багассаныг нөхөх, алдагдсан нөлөөгөө сэргээх зорилго бүхий гадаад бодлого хэрэгжүүлсэн ба энэ чиглэлд амжилт олохын зэрэгцээ олон улсын хамтлагийн зүгээс шүүмжлэл эсэргүүцэлтэй тулгарч улс төр, эдийн засгийн хоригт ороод байгаа болно. Гадаад бодлогын хэрэгжүүлэлтэд хэт их анхаарал чиглүүлсний улмаас Өрнөдийн орнуудын хоригт өртөж эдийн засгийн байдал нь хүндэрч эдийн засгийн өсөлт нь 2% хүртлээ буурсан. Сүүлийн үед ОХУ, БНХАУ-тай харилцаа, хамтын ажиллагаагаа нэлээд эрчимжүүлэх хандлагатай байгаа нь хөрш зэргэлдээ орнуудын хооронд байх ердийн харилцаа, эдийн засгийн хувьд харилцан хамааралтай байдаг ерөнхий зарчимд нийцэж байгаа боловч Орос улсад Америк болон Өрнөдийн орнуудын зүгээс үзүүлж буй хоригийн улмаас Хятадтай хамтын ажиллагаа өрнүүлэх сонирхол нь нэмэгдсэн гэж хэлж болно. Ийнхүү ОХУ Азийн чиглэлд бодлогоо эрчимжүүлэх шаардлага гарч ирсэн ба гурвалсан эдийн засгийн коридорын үзэл баримтлал ч үүнтэй уялдаатай бий болсон гэж хэлж болно. Монгол Улсын хувьд бидний дээр тэмдэглэсэнчлэн хоёр хөрш оронтойгоо харилцан ашигтай эдийн засгийн коридортой болох нь энэхүү



хоёр орны хооронд хавчуулагдан орших газар зүйн хувьд, хязгаарагдмал байрлалтай улсын хувьд маш чухал ач холбогдолтой.

Хоёр хөрш орон маань глобал бодлого явуулдаг хоёр том гүрний хувьд гадаад улс төр, эдийн засгийн хувьд хэдий өөр өөрийн ашиг сонирхолтой боловч одоогоор АНУ-ын нөлөөлөл, “манлайлал”-ыг эсэргүүцэн “олон улсын системд тэнцвэр”-ийг бий болгох зарчимд ойртож байгаа болно. Орос, Хятадын энэхүү байр суурь бүр 1997 онд хоёр орны зүгээс Олон улсын шинэ дэг журам төлөвшүүлэх ба олон туйлт ертөнцийн талаарх хамтарсан мэдэгдэл гаргаж байснаас эхлэлтэй.<sup>7</sup> Энэхүү байр суурь нь өнөөгийн шинэ нөхцөлд улам эрчимжиж байгаа бөгөөд тэдгээрийг Америкийн эсрэг байр суурин дээр нэгдэж байна хэмээн олон улсын шинжээчид үзэж байгаа юм. Хэдий тийм боловч Орос, Хятадын харилцааг тийм бат бөх биш гэдгийг мөн онцолсоор байна. Тэдний үзэж буйгаар, энэ хоёр орон өрсөлдөгч том гүрнүүд иймээс хоёр орны харилцааны түлхүүр үг нь “өрсөлдөөн” бөгөөд тэдний ойртолт нь бодит биш. Эдгээр хоёр орон нь Төв Ази, Ойрхи Дорнод дахь нөлөөний төлөө өрсөлдөж байгаа мөн Хятадын хүн ам их, түүхий эдээр маш гачигдаж буй учир хүн ам цөөнтэй Сибирийг анхаарлын төвдөө байлгадаг, цаашид Хятадын нөлөө энэ бүсд байнга нэмэгдэх болно. Иймээс Хятад хүчирхэгжихийн хэрээр Оросын эрх ашгийг хөндөх болно гэдгийг тэмдэглэж байна. Райс Хадли Гэйт компаний (Rice Hadley Gates) судлаач Аня Мануэл “Атлантик” сэтгүүлд бичсэнээр сонин хэвлэлээр шуугиж байгааг эс тооцвол Орос, Хятадын хооронд АНУ, Япон, Европын холбооны улсуудын хоорондын харилцаа шиг тийм ойр харилцаа байхгүй гэдгийг онцолжээ. Мөн Азийн судалгааны үндэсний товчооны (National Bureau of Asian Research) мэдээлж буйгаар, тэдгээрийн хооронд цэрэг эдийн засгийн интеграци байхгүй боловч гадаад бодлогоо сүүлийн үед маш сайн уялдуулж байна. Тухайлбал, Алс Дорнодод бүс нутгийн зангилаа асуудлаар өөрсдийн байр сууриа ойртуулж байгаа нь Өрнөдийн орнуудын зүгээс тэдний геополитикийн эрмэлзлэлийг хазаарлах бодлогыг эсэргүүцэж байгаагийн илэрхийлэл юм. Гэвч тэдний ашиг сонирхол харилцан өөр, тэд жинхэнэ ашиг сонирхолоо одоохондоо хойш тавьж байна гэжээ.

Ийнхүү хоёр хөрш орны маань харилцаа ойртон нэгдэж байгаа нь манай улсын гадаад ойрын орчинд шинэ нөхцөл үүсч байгаагийн нэг илрэл юм. Гэвч энэхүү нөхцөлд гурван орны хооронд эдийн засгийн хамтын ажиллагаа өрнөх

---

<sup>7</sup>А.Нямдолжин.Орчин үеийн Орос -Америкийн харилцаа: хязгаарагдмал түншлэл –РАХ Mongolica. Монгол энх төр. Vol.3, 2017№2/7/, тал

боломж байгаа эсэх асуудал өнөө хүртэл нээлттэй хэвээр байгаа билээ. Учир нь хоёр хөрш орны харилцаанд улс төрийн харилцаа давамгайлж ирсэн бөгөөд эдийн засгийн харилцаа хоцрогдсон хэвээр байна. Эдийн засгийн харилцаанд нь багагүй бэрхшээл оршоор байгааг судлаачид тэмдэглэсээр байна. БНХАУ нь ОХУ-д хөрөнгө оруулах тэр бүр сонирхолгүй байгааг ОХУ-ын Ерөнхийлөгчийн хэвлэл мэдэллийн албаны дарга Дмитрий Песковын хэлснээс ч мөн харж болох юм. Тэрээр RT телевизд өгсөн ярилцлагадаа: “Хятад улс Орост хөрөнгө их оруулдаг гэж хэлэхэд хэцүү... манай хоёр орны харилцаанд Америкийн зүгээс манай улсад үзүүлж буй хориг нөлөөлдөг нь ажиглагддаг”<sup>8</sup> гэжээ. Хятад, Оросын хооронд байгуулсан нэлээд олон төсөл хэрэгжээгүй болон эхлэл төдий байгааг Оросын хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон судлаач нар тэмдэглэж байгаа юм. Тухайлбал, Хятад улс “Сибирийн хүч” (“Сила Сибири”)–ийн төслийн санхүүжилтийг “Газпром”-д тулган өгсөн, “Еврази” (Бээжин-Москва-Берлин) хурдан галт тэрэгний зам тавих төслөөс татгалзсан, хоёр талын хооронд тохиролцож байсан иргэний агаарын том хэмжээний онгоц зохион бүтээх төлөвлөгөө тасарсан ба Амар мөрөн дээгүүр баригдсан галт тэрэгний гүүр нь Оросын талын нэмэлт санхүүжилтээр тухайлбал, “Оросын шууд хөрөнгө оруулалтын сан”-гийн нэмэлт санхүүжилтийн үр дүнд баригдсан зэргийг Оросын тал дурдаж<sup>9</sup> байгаа болно. Алс Дорнодын Институтын орлогч захирал, Хятадын эдийн засаг, нийгмийн судалгааны Төвийн дарга А.Островский “Правда.Ру” сайтад өгсөн ярилцлагадаа: өнөөгийн байдлаар, манай улс Хятадтай хэрэгжүүлж буй хамтарсан онцын төсөл байхгүй. 2014 онд Москва-Бээжин (Москва, Нижний Новгород, Казань, Екатеринбург, Оренбург хүрээд цаашаа Казахстан орох) хурдан галт тэрэгний төмөр зам байгуулах гэрээ байгуулсан боловч өндөр өртөгтэй, зардлаа нөхөж чадахгүй гэсэн үндэслэлээр энэхүү төслөөс татгалзсан. ОХУ Хятад руу хийн хоолой тавьж байгаа бөгөөд хүчин чадал нь жилд 55 тэрбум.куб байх ажээ. Үүнээс гадна Владивосток, Зарубино дахь усан боомт дахь “Приморье-1”, “Приморье-2” хоёр төслөөс өөр төсөл байхгүй энэ төслийг хэрэгжүүлэхийн тулд Амар мөрөн дээгүүр төмөр замын гүүр барих шаардлагатай ажээ. Ийнхүү хоёр орны эдийн засгийн харилцаа улс төрийн харилцаанаас хоцорч байгаа бөгөөд энэ нь тодорхой шалтгаануудаар тайлбарлагдана. Тэдгээр шалтгаанууд нь хоёр орны харилцаанд оршоор байсан

---

<sup>8</sup>Песков.Д Интервью RT от 3июня 2019г <https://www.pravda.ru/economics/1419900-china/>

<sup>9</sup><https://www.pravda.ru/economics/1419900-china/>

хүчин зүйл байхаас гадна мөн хоёр орны харилцаанд шинээр үүссэн нөхцөл байдаг.

Хоёр орны харилцаанд шинээр үүссэн нөхцөл байдал бол БНХАУ ОХУ-тай төсөл хэрэгжүүлж байгаад тэдгээрээс гардаг нь ОХУ-тай хамтарсан учир "Америкийн эсрэг этгээдүүдийн үйлдлийг зогсоох санкци" (CAATSA) хэмээх хуулиар хоригт мөн давхар өртөгтэй холбоотой ажээ.<sup>10</sup> ОХУ-ын Ерөнхийлөгчийн хэвлэл мэдээллийн албаны дарга Д.Песков Хятад, Оросын эдийн засгийн хамтын ажиллагаанд Америкийн санкци нөлөө үзүүлдэг гэж онцолж хэлсэн байсан нь чухам үүнтэй холбоотой юм. ОХУ-ын Төв банкны мэдээлснээр, 2018 оны байдлаар ОХУ-д Хятад улсын зүгээс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 24%-аар буурч 3.592 тэрбум доллараас 2.623 тэрбум доллар хүртэл буурчээ. Нэг жилийн дотор Хятадын хөрөнгө оруулагчид Оросын эдийн засгийн бодит сектороос 969 сая долларыг татан авсан ба үүнээс 80% буюу 774 сая доллар нь хамтарсан үйлдвэрүүдийг татан буулгаснаар татагдан гарсан ба улмаар Оросын компаниуд дахь Хятадын хөрөнгө оруулалт 40% (1.932- 1.158 тэрбум доллар хүртэл) буурсан байна. Үлдсэн 195 сая доллар өрөнд тооцсон<sup>11</sup> байна.

Орост Хятадын хөрөнгө оруулалт хангалтгүй байгааг Оросын шинжээчид хөрөнгө оруулалтын нөхцөл байдал тааруугаас болж буй гэж тэмдэглэдэг. Учир нь Орос улс хүнд суртал ихтэй, өмч хөрөнгөө хамгаалах нөхцөл, хуулийн систем нь маш эрсдэлтэй ажээ. Нөгөөтэйгүүр Хятад улсын төрийн зүгээс бизнесийн үйл ажиллагаан дахь оролцоо нь хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаанд хүндрэл учруулдаг гэдгийг Оросын шинжээчид тэмдэглэж<sup>12</sup> байна. Мөн ОХУ Баруунтай үг хэлээ ололцох нь дээр бөгөөд глобалчлалын үр ашиг давуу эрхийг хэрхэвч алдаж болохгүйг<sup>13</sup> цохон тэмдэглэж байгаа юм.

Орос, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны боломжийн талаар доктор А.Островский ярихдаа: "нэгдүгээрт, хоёр орны улс төрийн харилцаа хөгжсөн нь эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд тус дөхөмтэй. Чингэхдээ Орос, Хятадын эдийн засгийн хэрэгцээг хангах хүчин чадалгүй байгаад гол учир шалтгаан оршино" гэжээ. 1995 онд манай хоёр орны эдийн засгийн хэмжээ багтаамж хүчин чадал ижил төстэй байсан. Гэтэл өнөөдөр Хятад үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээгээр Оросыг 8 дахин давж байна. Хятадын хэрэгцээ их,

---

<sup>10</sup><https://www.pravda.ru/economics/1419900-china/>

<sup>11</sup><https://www.pravda.ru/economics/1419900-china/>

<sup>12</sup>[https://www.pravda.ru/news/economics/1394211-economics/По\\_просьбе"Правды.Ру"](https://www.pravda.ru/news/economics/1394211-economics/По_просьбе)

<sup>13</sup>Мөн тэнд

ялангуяа Оросын газрын тос, байгалийн хий, мод, загас, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг авах маш сонирхолтой байдаг. Гэтэл Хятадын зах зээл 1.4 тэрбум хүн бөгөөд Орос энэхүү зах зээлийг хангах боломжгүй юм. Чингэхдээ ОХУ БНХАУ-тай эдийн засгийн харилцааны боломжоо бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгааг дурдаад тухайлбал, өнөө ОХУ Хятадад зөвхөн нэг цөмийн цахилгаан (атомын) станц барьж байхад Америк, Франц нь Оросоос хэд дахин их цөмийн цахилгаан реакторыг барьж байгааг дурджээ. Мөн Орос-Хятадын худалдаа өөр орны валютаар гол төлөв ам.доллараар Америкийн банкуудыг дамжин гүйлгээ хийдэг. Энэ нь өөрийн эрхгүй (автоматаар) хоригт орох нөхцөлийг бүрдүүлдэг. Иймээс рубль юаниар худалдаа хийх нь хоёр орны худалдааг хөгжүүлэх чухал хөшүүрэг<sup>14</sup> хэмээжээ.

Ийнхүү Орос, Хятадын эдийн засгийн харилцааны ерөнхий төлвийг дүгнэснээс үзэхэд ерөнхий дүр зураг ийм байна. Нөгөөтэйгүүр геополитикийн ашиг сонирхол, өрсөлдөөний хүчин зүйл энэхүү харилцаанд хэвээр байгааг цохон тэмдэглэх хэрэгтэй. Өнөө ОХУ эдийн засгийн хувьд хүнд байдалд байгаа нь Хятад улстай харилцан ашигтай, энэ тэнцүү гараанаас бизнесийн орчин бий болгож чадахгүй нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд саад тотгор болж байгааг үгүйсгэж болохгүй. Энэ нөхцөлд эдгээр улсууд нь манай орны сонирхож буй том мега төсөлд хамтрах уу гэсэн асуудал зүй ёсоор тавигдаж байна. Гурвалсан харилцаа хөгжих ялангуяа маш том эдийн засгийн төслийн хүрээнд хөгжихөд бэрхшээл байгааг судлаачид онцлон тэмдэглэсээр байна. Үүнд юуны түрүүнд гурван улсын хөгжлийн түвшин өөр өөр гэдгийг судлаачид цохон тэмдэглэдэг бөгөөд эдийн засгийн хувьд хамгийн хөгжилтэй нь Хятад улс, Орос газрын тос, хий экспортлогч орон, тэндээс хангалттай хөрөнгө орж ирдэг учир өрсөлдөх чадвартай, харин Монгол Улсын эдийн засаг хүнд байдалд байгаа ба ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдсан зэргийг цохон тэмдэглэдэг. Нөгөөтэйгүүр зах зээлийн чиглэл нь харилцан өөр өөр. ОХУ нь Өрнөдийн зах зээл рүү чиглэгдсэн ба Азийн бодлого нь тэр бүр тодорхой бус. Хятадын зах зээл хэдий өргөн хүрээнийх боловч гол төлөв зүүн тийш чиглэгдэж байгаа. Монгол Улсын хувьд Хятадын зах зээлээс хэт хамааралтай, зах зээлийн энэхүү инерцийг давахад хүндрэлтэй.

Гурвалсан эдийн засгийн коридор бий болоход саад учруулах бас нэг хүчин зүйл нь гурван улсын хөгжлийн стратеги нь ч зарчмын хувьд өөр. БНХАУ

---

<sup>14</sup><https://www.pravda.ru/economics/1419900-china/>

төлөвлөгөөт эдийн засагтай, ОХУ нь зах зээлийн эдийн засагтай боловч бүлэглэлийн сонирхол хүчтэй, Монгол Улс нь “Үндэсний хөгжлийн төлөвлөгөө”, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” зэрэг бодлогын чанартай хөтөлбөрүүдтэй боловч засгийн эрхийг барьж буй намын эдийн засгийн хөтөлбөрийг гол төлөв мөрдлөг болгодог ба маш хүчтэй лоббийн зарчим үйлчилдэг зэрэг юм.

Гурвалсан харилцааны боломжуудыг харахад, гурван орны удирдлагын түвшинд тохиролцсон 32 төслийн ихэнхи нь хэрэгжих боломжтой гэж харагддаг. Гэвч эдийн засгийн коридор зэрэг мега төслийн хувьд санхүү эдийн засгийн боломж, зах зээлийн инерци нь давамгайлдаг. Үүнийг нотлох түүхэн баримт бол Хиагтын гурван улсын худалдааны зам. Тухайн үед Хятадын худалдааны картелиуд Алс Дорнод руу худалдаа хийх сонирхолгүй байсан учир Алс Дорнод руу гарах замыг хааж байв. Оросын хаант улс үүнтэй тэмцэхийн тулд хүчээр Эрхүү хотноо Худалдааны төв байгуулж, Хиагтын худалдааны замыг хааж Алс Дорнодод худалдааны замыг хөгжүүлсэн байдаг. Харин өнөөдөр Монгол руу гарах гарцыг бодолцож байгаа боловч манай хоёр хөрш харилцан ашигтай, нэгэнт бүрэлдэн бий болсон эдийн засгийн коридоорыг бэхжүүлэн хөгжүүлэх сонирхолтойг судлаачид онцолж байгаа бөгөөд хоёр хөршийн хамтын бодит харилцаанаас ч харагдаж байгаа болно.

Нөгөөтэйгүүр өнөө ОХУ нь Сибирийг хөгжүүлэх тодорхой төлөвлөгөөгүй бөгөөд санхүү эдийн засгийн байдал хүнд байгаа өнөөгийн нөхцөлд энэ бүс нутагт эдийн засгийн коридор байгуулахад тэр бүр бэлэн бус бололтой. Үүнтэй холбоотойгоор тус коридорын дамжин өнгөрөх, тус төсөлд оролцох Буриад, Тува зэрэг ОХУ-ын субъектуудын эдийн засгийн хөгжлийн түвшин доогуур, Оросын Холбоонд маш их өртэй, тэрхүү өр нь улам нэмэгдэж байгаа нь орон нутгийн чанартай хөгжлийн боломжийг боомилж байгааг судлаачид тэмдэглэж байна. Гэвч сүүлийн үед гурван улсын гурван талт харилцаа нэлээд идэвхижиж байгааг гурван талыг холбосон авто замыг байгуулах хамтарсан төсөл хэрэгжиж эхэлсэн, гурван улсын хооронд худалдаа эдийн засгийн чөлөөт худалдааны бүс байгуулах төсөл хэрэгжилтийнхээ эхний шатнаас гарах хандлага тодорч буй зэрэг нь хамтын ажиллагаа урагшлах найдлага, хүлээлтийг бий болгож байна.

Цаашид гурван улсын эдийн засгийн коридорын төсөл хэрэгжих боломж нээлттэй хэвээр байгаа бөгөөд ямартай ч улс төрийн хувьд гурван орны дээд хэмжээний түвшинд нэгэнт тохиролцсон нь цаашид биеллээ олох хүлээлт байгааг илтгэж байгааг дахин тэмдэглэх хэрэгтэй. Нөгөөтэйгүүр энэхүү төсөл бодит зүйл

болж хараахан биелэгдээгүй боловч манай гурван улс энэ төслийн хэрэгжилтийн талаар ярьж төлөвлөж байгаа нь гурвалсан харилцаа, хамтын ажиллагаанд эерэг тал байгааг бодитойгоор харуулж байна. Үүнийг ч В.Путин 2019 онд болсон “Нэг бүс нэг зам” форумын үед хэлсэн үгэндээ: “Евразийн эдийн засгийн хамтын ажиллагааны гишүүн орнууд Хятадын “Нэг бүс, нэг зам” төсөлд нэгдэхэд бэлэн байгаа учир нь энэхүү төсөл Орос улсын Евразийн хамтын ажиллагааны өргөн түншлэлийг бий болгох тухай үзэл санаатай ижил төстэй юм” гэж хэлснээс харж болох юм. Нөгөөтэйгүүр хятад судлаач А.Островскийн оновчтой хэлсэнээр энэхүү төсөл эдийн засгийн хувьд маш ашигтай гээд “Транссиб” гэхэд л Сибирийн хотуудын хувьд энэ бол зам харилцааны дэд бүтэц. Зам харилцаа хаана байна тэнд эдийн засгийн хөгжил байдаг. Зам харилцааны дэд бүтэц байхгүй бол зам ч байхгүй эдийн засаг ч байхгүй юм.”

Манай улсын хувьд гурвалсан харилцааны хамтын ажиллагааг эдийн засгаа хөгжүүлэх чухал гарц хэмээн харж байгаа ба Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Дорнын форум (2019) дээр Азийг хамарсан “Эрчим хүчний нэгдсэн супер сүлжээ” байгуулах санаачилга гаргасан нь үүний тод жишээ юм. Мөн манай улсын нутаг дэвсгэрээр хийн хоолой дамжин өнгөрүүлэх талаарх боломжийг судлах талаарх ОХУ-ын ерөнхийлөгчийн өгсөн амлалт зэрэг нь гурван талт хамтын ажиллагаанаас хүлээх маш том хүлээлт юм.

Ийнхүү гурван улсын найрамдал, хамтын ажиллагааны уламжлал, ашиг сонирхол, газар зүйн байрлал, харилцан итгэлцэл нь тэдгээрийг нэг цэг дээр аваачих бодит нөхцөл бөгөөд манай хөрш гурван орны харилцааг гурвалсан хэлбэрээр хөгжих хөрсийг бий болгосоор байна.

Бид тус өгүүлэлдээ хүйтэн дайны дараа гурван улсын харилцаа хэдий аажим ч гэсэн хэрхэн урагшилж буйг харуулахыг зорив. Харин энэхүү гурван талт харилцаа, хамтын ажиллагаа нь бодитойгоор хэрэгжих нь маш олон зүйлээс хамаарах нь мэдээж бөгөөд юуны түрүүнд манай хоёр хөршийн ашиг сонирхол нийцэлд хүрэх шаардлагатай байгаагаас гадна манай гурван улсын эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжил, гадаад орчны таатай нөхцөл байдлаас ихээхэн хамаарах юм.

***Periods of trilateral relations between  
Mongolia, Russia, China and their features***

*Natsagdorjiin Ariungua*

*Leading Researcher, Institute of International Relations,  
Academy of Sciences of Mongolia, doctor (Ph.D)*

**Abstract.** *After the end of the Cold War, as a result of changes in the political and economic situation, with the new formation of internal and external tasks of Mongolia, Russia, China, as well as as a result of fundamental changes in the international arena, relations between the three countries underwent considerable changes. Although bilateral relations prevail in the relations of the three countries, however, the fact of the existence of a third party has always been taken into account, which is explained by the fact that our countries belong to one geopolitical environment. The author of the article tries to trace the geopolitical relationship between the three countries and addresses the issue of the importance of its influence on bilateral relations, as well as on the formation of formats of triangular relations.*

**Key words.** *The period after the end of the Cold War, relations between the three countries, coincidence of interests, expectation*

#### **Ашигласан материал**

1. Н.Ариунгуа. БНХАУ бол Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл мөн- Олон улс судлал.2009.№1
2. Н.Ариунгуа. Монгол Улсын гадаад орчны ойрын хүрээлэл ба БНХАУ- Олон улс судлал.2010.№3,4
3. Н.Ариунгуа. Монгол, Хятадын харилцаан дахь шинэ нөхцөл байдал- Олон улс судлал.2014.№2
4. Бойкова.Е.В. Россия-Монголия-Китай: каковы перспективы сотрудничества?-Ногоон хөгжил-XXI зууны гурван талт хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл.Улаанбаатар, 2014
5. 朴键一。冷战后东北亚新变局与中蒙俄战略合作-/Пяо Зянь И.Зүүн хойт Азийн өөрчлөлт шинэчлэл болон Хятад, Монгол,Оросын хамтын ажиллагаа-Ногоон хөгжил-XXI зууны гурван талт хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл.Улаанбаатар, 2014
6. 福景筠。中俄推进区域合做战略的利益交及蒙古的应对 /Фу Зин Юн.Хятад, Оросын бүс нутгийн хамтын ажиллагааны стратегийн ашиг сонирхолын нийцэл Монгол Улсад хэрхэн тусах нь/- Ногоон хөгжил-XXI зууны гурван талт хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл.Улаанбаатар, 2014
7. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал /1994 он/

8. А.Нямдолжин.Орчин үеийн Орос -Америкийн харилцаа: хязгаарагдмал түншлэл –PAX Mongolica . Монгол энх төр. Vol.3, 2017№2/7/
9. Camp A.A Mongolia in Northeast Asia-the NewRealities//Geopolitical relations between Contemporary Mongolia and Neighboring Asian Countries.-Chinese Culture University, Taiwan,2004.
10. Fish M.S.The Inner Asia anomaly:Mongolia’s democratization in comparative perspective//Communist and Post- Communist Studies,-2001.№34
11. GinsburgT.Political Reform in Mongolia. Beetween Russia and China// Asian Survey.1995№5
- 12.Основные положения концепции внешней политики РФ утвержден распоряжением Б.Н.Ельцина от 23 апреля 1993г.-Внешняя политика и безопасность современной России.1991-2002. Хрестоматия в 4-х томах.Документы.М.,2002
- 13.Өнөөдөр сонин. 2013.09.09 ГХЯ-ны сайд Л.Болдтой хийсэн ярилцлага.
- 14.М.Троцкий. Китайский фактор в Российско-Американских отношениях. Московский государственный институт международных отношений-  
<http://www.msk.ru/blog/ponarseurasia/1193614-eco>
- 15.Гурван улсын ерөнхий сайд нар Хятадад нэгэн зэрэг хийсэн айлчлал юу өгүүлэв?- “Жэньмин жибао” 2013.10
- 16.ПесковД. Интервью RT от Зиюня 2019 года-  
<https://www.pravda.ru/economics/1419900-china/>
17. <https://www.pravda.ru/economics/1419900-china/>
18. <https://www.pravda.ru/news/economics/1394211-economics/По> просьбе"Правды.Ру"
19. <https://www.pravda.ru/economics/1419900-china/>
20. <https://www.pravda.ru/news/economics/1394211-economics/По> просьбе "Правды.Ру"



ОРОС, ХЯТАДЫН СОЁЛ, БОЛОВСРОЛЫН  
ХАРИЛЦААНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ\*

*Чойжамцын Батцэцэг*

*ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн*

*Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D)*

*E-mail хаяг: [battsetseg\\_ch@mas.ac.mn](mailto:battsetseg_ch@mas.ac.mn)*

**Хураангуй:** *Эл өгүүлэлд манай хөрш Орос, Хятад хоёр улсын хооронд 90-ээд оноос хойш өнөөг хүртэл хэрэгжүүлж буй соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбарт байгуулсан гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагааны механизм, үйл ажиллагааны онцлог, боловсролын байгууллагуудын хоорондын холбоо, оюутан солилцоо, бүс нутаг хоорондын харилцаа, бодит үр дүнг тодорхойлно. Мөн ОХУ, БНХАУ-ын хоорондын стратегийн түншлэлийн харилцаа нь зөвхөн улс төр, худалдаа-эдийн засгийн хүрээнд бус мөн соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбарт тэргүүлж байгаа тухай өгүүлнэ.*

**Түлхүүр үг:** *Орос, Хятадын соёл, боловсролын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, оюутан солилцоо, бүс нутгийн харилцаа*

Монгол Улс нь хоёр их гүрний дунд зөвхөн хоёр хөрштэй хил залгаж оршдог газарзүйн байршилтайн хувьд тэдгээрийн хоорондын харилцааны төлөв байдал манай орны хувь заяа, эрх ашигт ихээхэн нөлөөлдөг. Иймд бид Орос, Хятадын хоорондын улс төр, нийгэм-эдийн засаг, соёлын аливаа харилцаа, хамтын ажиллагааны өрнөл, бууралтыг сонирхон судалж байх нь зүйн хэрэг юм. Ялангуяа олон улсын харилцаа, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал түргэн хувьсан өөрчлөгдөж буй өнөө үед Монгол, Орос, Хятад гурван улсын эдийн засгийн коридорынбүтээн байгуулалтын асуудлаар хэлэлцэж, түүн дотор улс төр, эдийн засаг, дэд бүтцийн талаар гурван талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх арга зам, хамтран ажиллах механизмын талаар судалж бичиж байна. Мөн түүнчлэн Монгол-Хятадболон Монгол-Оросын соёл, боловсрол, хүмүүнлэгийн харилцаа, хоёр талт хамтын ажиллагааны тухай манай улсад хэвлэгдсэн судалгааны өгүүллүүд харьцангуй элбэг байдаг. Харин ОХУ, БНХАУ-ын хоорондын соёл, боловсрол,

---

\* Олон улс судлал сэтгүүл, 2019№1(109), тал 64-79 DOI: <https://doi.org/10.5564/jis.v0i1.1254>

хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааны асуудлаар манай судлаачдын бичсэн өгүүлэлхараахан нийтлэгдээгүй гэж хэлж болно. Өнөө бид “Хүйтэн дайнаас хойшхи Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа” сэдвээр судалгаа хийж байгаа бөгөөд уг ажлын дэд сэдвийн хүрээнд гурван орны гурван талт соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбарын харилцаа, хамтын ажиллагааны төлөв байдлыг судалж бичиж байна. Үүнтэй уялдуулан хоёр хөршийн хоорондын эл салбарын харилцаа, хамтын ажиллагаа хэрхэн өрнөж буй талаар тоймлон хүргэхийг зорив.

ОХУ, БНХАУ нь нийтлэг хамгийн урт хилийн заагтай, түүхийн ижил төстэй адилтгах талууд ихтэй, хоорондоо ямарваа нэгэн харилцаа, хамтын ажиллагаагүйгээр оршин тогтнож үл чадах хөрш орнууд юм. Орос, Хятадын хоорондын соёл хүмүүнлэг, боловсролын салбарын харилцааны түүхээс харахад, бүр эртнээс харилцан бие биенээ сонирхож, холбоо тогтоож байжээ. XX зууны дунд үе буюу БНХАУ байгуулагдснаас хойш социалист орнуудын найрамдалт харилцааны үр дүнд хоёр орны соёлын харилцаа, хамтын ажиллагаа маш идэвхтэй өрнөж байсан юм. Энэ хугацаанд ЗСБНХОУ нь БНХАУ-ын үндэсний боловсон хүчнийг бэлтгэхэд ихээхэн түлхэц болж байсан хийгээд Зөвлөлтөд боловсрол эзэмшсэн хятадын тэдгээр сэхээтнүүд улс орныхоо шинэчлэлд асар их хувь нэмэр оруулсан тухай Оросын судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, ЗХУ нь 1952-1966 оны хооронд БНХАУ-д 25 мянган залуу мэргэжилтнийг янз бүрийн чиглэлээр бэлтгэж өгсөн байдаг. Энэхүү боловсролын хамтын ажиллагаа, оюутан солилцоо нь хоёр орны залуу үеийнхний найрамдлыг гүнзгийрүүлэхэд түлхэц болж иржээ. Хүйтэн дайны дараа ЗХУ, БНХАУ-ын хоорондын харилцааг сэргээхэд энэхүү найрамдал маш чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Учир нь 60-аад оны сүүлчээс 80-аад оны сүүлч хүртэлх хорин жилийн хугацаанд хоёр орны харилцаанд хүндрэл гарч, харьцангуй царцанги байдалтай байсан билээ.

Чингээд XX зууны сүүлчээр дэлхий дахинд гарсан өөрчлөлтийн явцад Орос, Хятадын харилцааны сөргөлдөөн эцэс болж, хоёр орны харилцаа сэргэж эхэлсэн юм. Ялангуяа 1991 оноос эхлэн ОХУ, БНХАУ-ын улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, цэрэг батлан хамгаалах, соёл, боловсрол зэрэг олон салбарын харилцаа, солилцоо, хамтын ажиллагаа харьцангуй хурдацтай хөгжих болсон байна. ОХУ-ын Ерөнхийлөгч Б.Н.Ельцин БНХАУ-д 1992 оны 12 дугаар сард айлчилсан бөгөөд айлчлалын зорилго нь эдийн засаг, техник болон цэрэг армийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэн бэхжүүлэхэд чиглэгдэж байв. ОХУ, БНХАУ-ын

анхны дээд хэмжээний уулзалтын үеэр “ОХУ болон БНХАУ-ын хоорондын харилцааны эрх зүйн үндсийн тухай хамтарсан Тунхаглал”<sup>15</sup>-ыг баталсан юм. Уг тунхаглалын 19 дүгээр зүйлд: ... талууд соёл урлаг, боловсрол, мэдээлэл, аялал жуулчлал болон биеийн тамирын салбарын харилцаа хийгээд хоёр улсын залуучуудын хоорондын солилцоог өргөжүүлэн хөгжүүлэх, мөн соёлын байгууллагуудын шууд харилцаа, иргэд хоорондын холбоог дэмжих, талууд хоёр орны хэл, уран зохиолыг харилцан зааж сургах”-ын ач холбогдлыг чухалчилсан байна. Мөн талууд соёлын салбарын боловсон хүчнийг сургах, үндэсний соёлын өвийг хамгаалах, орчуулан хэвлэх, сургуулиудын хооронд харилцаа хөгжүүлэх зэрэг салбарт хамтран ажиллах”<sup>16</sup> тухай тодорхойлжээ. Улмаар хоёр улсын Засгийн газрын 1992 оны 12 дугаар сарын 18-нд үзэглэсэн соёлын салбарт хамтран ажиллах тухай гэрээ, Засгийн газар хоорондын болон хоёр орны хэлтэс тасгуудын хоорондын ойрын жилүүдэд гүйцэтгэх соёлын салбарын хамтын ажиллагааны Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Цаашилбал ОХУ, БНХАУ-ын хоорондын хамтын ажиллагааны үндсэн хөдөлгөгч механизмыг боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир спортын салбарт бүрдүүлж, Орос, Хятадын хүмүүнлэгийн хамтын ажиллагааны коммис (үүнд: 5 дэд комисс, 3 ажлын хэсэг багтсан) байгуулжээ. Чингээд 1993 он гэхэд ОХУ, БНХАУ-ын хоорондын найрамдалт, харилцан ашигтай хамтын ажиллагаа шинэ шатанд гарав. Энэ үед хоёр орны бүх талын харилцаа: улс төр, эдийн засаг, цэрэг арми, соёл боловсролын харилцаа маш хурдацтай хөгжиж эхэлсэн байна.

Чингээд 1996 оноос ОХУ, БНХАУ-ын харилцаа чанарын шинэ түвшинд гарч, дэлхийн улс төрийн тавцанд нөлөөлөх болсон юм. Энэ үед хоёр улсын Засгийн газрын тэргүүний уулзалтыг жилд нэгээс цөөнгүй удаа зохион байгуулах, цаашилбал бүр тогтмолжуулах механизм<sup>17</sup> үйлчилж эхэлсэн гэж хэлж болно. Улмаар 1997, 1998 онд хоёр улсын Соёлын яамны ивээл дор ОХУ-д Хятадын

---

<sup>15</sup>Орос-Хятадын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл 1949-1999 он. М. 1999. т.132 - 133.

<sup>16</sup>Орос-Хятадын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл. Хоёрдугаар хэсэг /1949-2003/ УБ., 2003. Т.160

<sup>17</sup>Соглашение между Правительством РФ и Правительством КНР о создании и организационных основах механизма регулярных встреч глав правительств России и Китая. Сборник Российско-китайских договоров 1949-1999 гг. - М., 1999. - С. 396; Протокол I заседания Комиссии по подготовке регулярных встреч глав правительств России и Китая. Сборник Российско-китайских договоров 1949-1999 гг. -М., 1999. - С. 399.

соёлын өдрүүд, БНХАУ-д Оросын соёлын өдрүүдийг<sup>18</sup> ээлжлэн зохион байгуулсан байна. Мөн 1999 онд БНХАУ байгуулагдсаны 50 жил, Орос-Хятадын хооронд дипломат харилцаа байгуулсны 50 жилийн ойн арга хэмжээний хүрээнд олон үйл явдал болжээ.

Улмаар БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч Ли Ланьцин 2000 оны 12 дугаар сард ОХУ-д айлчлах үеэр “ОХУ-БНХАУ-ын Засгийн газрын хооронд 2001-2002 онд хэрэгжүүлэх соёлын хамтын ажиллагааны Хөтөлбөр” болон “ОХУ-ын Соёлын Яам болон БНХАУ-ын Соёлын Яамны хоорондын 2001-2002 оны хамтын ажиллагааны Протокол”-д тус тус гарын үсэг зуржээ. Мөн Орос-Хятадын боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир спортын салбарт хамтран ажиллах талаар ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга В.И.Матвиенко, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч Ли Ланьцин нарын хийсэн анхны хуралдаанаар дээрх салбарт хамтран ажиллах дэд комисс байгуулагдсан байна. Ийнхүү ОХУ, БНХАУ-ын анхны дээд хэмжээний уулзалтаас хойш хоёр улсын харилцаа эрчимтэй хөгжиж, цаашид хоёр улс шинэ хэлбэрийн харилцааг гүнзгийрүүлэн бэхжүүлэх, хоёр орны харилцааны хэтийн төлөв, XXI зуунд хоёр орны харилцааг цоо шинэ түвшинд гаргах, хоёр орны хамтын ажиллагааны маш их нөөцийг дээд зэргээр оновчтой ашиглах том зорилтуудыг дэвшүүлэн тавьсан юм.

Шинэ зууны гараанаас эхлэн өнөө хүртэл ОХУ, БНХАУ хамтран хоёр орны төрийн тэргүүний харилцан айлчлалыг жил бүр тогтмолжуулах механизмыг бүрдүүлжээ. Тухайлбал, 2000-2018 он хүртэлх хугацаанд хоёр орны төрийн тэргүүний айлчлал 19 удаа болж, Москва, Бээжинд хамтын ажиллагааны олон чухал баримт бичигт<sup>19</sup> гарын үсэг зуржээ. Эдгээр гэрээ хэлэлцээрийн дотор “Соёлын хамтын ажиллагааны тухай гэрээ”<sup>20</sup> багтаж буй. Энэ гэрээ нь хоёр улсын засгийн газар хоорондын соёлын салбар хүрээнд хийсэн анхны урт хугацааны баримт бичиг болсноороо онцгой ач холбогдолтой болж, ОХУ, БНХАУ-ын соёлын харилцааны хөгжлийн гэрээ эрхийн суурь үндэс нь болжээ.

---

<sup>18</sup> План культурного сотрудничества между Правительством Российской Федерации и Правительством Китайской Народной Республики на 1997, 1998 гг. (принят в г. Пекин 27.06.1997 г.) [Электронный ресурс]. - Режим доступа: <http://www.lawmix.ru/abrolaw/10084>

<sup>19</sup>Цуй Хэн, Фу Лин. Трехстороннее взаимодействие между Китаем, Европейские странами и России: изменения и перспективы. Даяаршил ба өнөөгийн Еврази: түүх, хандлага, өөрчлөлтийн сорил. УБ., 2018 т.79

<sup>20</sup>Орос-Хятадын хамтарсан Тунхаглал. Проблемы Дальнего Востока.сэтгүүл.1993.№1. - т.5.

Нөгөөтэйгүүр ОХУ, БНХАУ-ын хооронд байгуулсан хүмүүнлэгийн салбарт 1990-2000 оны эхэн хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр: *нэгд*, хоёр орны төрийн байгууллагуудын хоорондын гэрээ, хэлэлцээр (соёл, шинжлэх ухаан, боловсролын болон бусад яам); *хоёрт*, орон нутгийн засаг захиргааны хооронд бүс нутгийн төвшинд олон талт солилцооны хүрээнд хийгдсэн гэрээ хэлэлцээр; *гуравт*, шинжлэх ухаан, соёл, боловсрол, биеийн тамир спортын салбарт бие даасан байгууллагуудын хоорондын хоёр талт гэрээ, хэлэлцээр (шинжлэх ухааны академи, театр, музей, олон нийтийн байгууллагууд, сургуулиуд хоорондын гм.); *дөрөвт*, хоёр улсын ард иргэд хоорондын хувийн төвшинд хийгдсэн гэрээ хэлцэл багтаж буйг тэмдэглэх хэрэгтэй.

Шинэ зуунд хоёр орны соёлын хамтын ажиллагаа харилцан ярианы хэлбэрт шилжиж, өөр өөрийн соёлын онцлогийг хадгалсан, соёлын харилцан ашигтай хамтын ажиллагааны шинэ загвартай болсон байна. Өнөө хоёр тал соёлын хамтын ажиллагааны үндсэн дээр аль аль нь өөрийн үндэсний соёлыг нийгмийн шинэчлэлд чиглүүлэн идэвхтэй сэргэн мандуулж буйг<sup>21</sup> харж болно. Цаашид хоёр улсын Соёлын яамны ивээл дор ОХУ-д Хятадын соёлын өдрүүд, БНХАУ-д Оросын соёлын өдрүүдийг<sup>22</sup> 2003, 2004 онд ээлжлэн зохион байгуулав. Ялангуяа хоёр талын соёлын салбарын хамтын ажиллагаа 2006, 2007 онд улам эрчимжсэн нь эхлээд БНХАУ-д “Оросын жил”, дараа нь ОХУ-д “Хятадын жил” болсон холбоотой гэж зарим судлаач үзэж байна. Эдгээр санаачлагын хүрээнд хоёр орны ард түмний хоорондын харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх, найрамдал нөхөрлөлийг бэхжүүлэхэд түлхэц болохсоёлын маш олон арга хэмжээ зохиогдсон юм. Тухайлбал 2006 оныг БНХАУ-д “Оросын жил” болгон тунхагласан бөгөөд 2006 оны 3 дугаар сарын 21-нд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин БНХАУ-д албан ёсны айлчлал хийх үеэр БНХАУ дахь “Оросын жил”-ийн үйл ажиллагааг албан ёсоор нээсэн байна. Энэ “Оросын жил”-ийн голлох арга хэмжээг 2006 оны 11 дүгээр сард Бээжин хотноо Оросын аж үйлдвэр, шинжлэх ухаан, эмнэлэгийн болон бусад салбарт олсон ололт амжилтыг цогцоор харуулсан Оросын Үндэсний томоохон үзэсгэлэнг нэрлэсэн байна. Мөн үеэр Оросын үйлдвэр, аж ахуйн нэгжүүд Харбины худалдаа эдийн засгийн яармаг, Шэньжэнд олон улсын өндөр технологийн яармаг, Шанхайн

---

<sup>21</sup>ГочэнЧжао.КультурноевзаимопознаниеКитаяи Россиисновываєтьсяна желаниии стремлениинародовдвухстран.28.06.2012//<http://infoshos.ru/ru/?idn=10126>

<sup>22</sup>План культурного сотрудничества между Правительством Российской Федерации и Правительством Китайской Народной Республики на 1997, 1998 гг. (принят в г. Пекин 27.06.1997 г.) [Электронный ресурс]. - Режим доступа: <http://www.lawmix.ru/abrolaw/10084>

олон улсын аж үйлдвэрийн яармаг болон Хятадын бусад худалдаа аж үйлдвэрийн үндсэн яармагт оролцжээ. Шанхайн олон улсын аялал жуулчлалын яармагт Нэгдсэн Оросын үзүүлэн ханыг бэлтгэн тавьсан нь хятадуудын сонирхлыг ихэд татсан байна. Түүнчлэн 2006 оны 1 дүгээр сард Бээжин хотноо Вологодский мужийн танилцуулга болж, Приморийн хязгаар, Эрхүү, Камчатка болон Ульяновскийн удирдагчид БНХАУ-д айлчилжээ. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины айлчлалын үеэр 3-р сард ОХУ, БНХАУ-ын тэргүүлэх 10 их дээд сургуулийн ректорын форум болж, Оросын боловсролын үйлчилгээний үзэсгэлэн гарсаны сацуу их дээд сургуулиудын харилцаа холбооны хүрээнд цуврал арга хэмжээ хэрэгжүүлжээ.<sup>23</sup>

2007 оны 1, 2 дугаар сард гэхэд л БНХАУ-д болсон “Оросын жил”-ийн үйл ажиллагаанд ойролцоогоор 30 гаруй арга хэмжээ зохион байгуулагдсан байна. 2007 оны 1 дүгээр сарын 1-нд ОХУ-д болсон “Хятадын жил”-ийн нээлтийг хоёр орны тэргүүн харилцан баярын цахилгаан утас илгээснээр эхэлжээ. Ийнхүү 2007 оны эхээр БНХАУ-ын дарга Ху Жиньтао ОХУ-д айлчилж, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины хамт “Хятадын жил”-ийн нээлтийн ёслолд оролцсон байна. ОХУ-д болсон “Хятадын жил”-ийн хүрээнд хоёр талын тохиролцсон төлөвлөгөөний дагуу 200-аад арга хэмжээ зохион байгуулагдсны 10 гаруй нь төрийн дээд түвшний хэмжээнд болсныг онцлон тэмдэглэж байна. Ийнхүү хоёр орны арга хэмжээ амжилттай хэрэгжүүлсэн туршлагыг үндэслэн хоёр орон хамтран 2009, 2010 онд “Орос хэлний жил” болон “Хятад хэлний жил”-ийг харилцан зохион байгуулав. Хоёр улсын энэ “хэлний жил”-ийн хүрээнд зохиогдох арга хэмжээг зөвхөн хэл шинжлэлээр хязгаарлаагүй бас соёл, боловсрол, хэвлэл мэдээлэл, кино болон бусад салбарын үйл ажиллагааг хамруулсан байна. Үүнээс үүдээд хоёр хөршийн хооронд хэрэгжүүлж буй соёлын хамтын ажиллагааны цар хүрээ өргөн дэлгэр, зөвхөн нэг хот, мужаар хязгаарлагдахгүй, хоёр орны олон газар нутгийг хамарч байдгаараа Монгол Улстай хэрэгжүүлж буй хоёр хөршийн соёлын үйл ажиллагаанаас ялгаатай гэдгийг хэлэх нь зүйтэй.

Чингээд 2010 оны 9 дүгээр сарын сүүлчээр Хятадын Соёлын төвийг Москвад, Оросын Соёлын төвийг Бээжинд тус тус нээсэн нь хоёр орны соёлын харилцааны хөгжилд цоо шинэ хуудас нээжээ. Тухайлбал, уг Соёлын төвөөр ОХУ-ын

---

<sup>23</sup>Хятад дахь “Оросын жил”. Хятадад хийсэн албан ёсны айлчлалын тухай. 12.12.2007//<http://archive.kremlin.ru/events/articles>; РомановС. «Гуманитарное»сотрудничествоРоссиии Китая.31.05.2013// <http://www.atrinfo.ru/commentary/hum>

Ерөнхийлөгч Д.Медведев БНХАУ-д 2010 оны 9 дүгээр сарын 27-нд айлчлах үеэрээ, мөн ОХУ-ын Үнэн алдартны шашны сүмийн тэргүүн хамба лам Кирилл нар тус тус зочилсон нь Орос, Хятадын хоорондын соёлын хөгжилд маш их ач холбогдолтой болсон байна. Оросын Үнэн алдартны шашны сүмийн тэргүүний Хятадад хийсэн айлчлалын тухайд, хэдийгээр энэ айлчлал түүхэн хэмжээний үйл явдал мөн боловч хожим бид жинхэнэ бодит ач холбогдлыг үнэлэх болно гэж Оросын зарим судлаач, шинжээч бичсэн байна. Чингээд энэ айлчлал нь БНХАУ-д Оросын шашны тэргүүний маш өндөр түвшинд хийсэн анхны айлчлал бөгөөд хоёр орны ард түмний хоорондын хамтын ажиллагаа, найрамдлыг бэхжүүлэхэд маш чухал алхам болсон. Энэ бол зөвхөн нийгмийн зүтгэлтэн, өнөө цагийн чухал сэтгэгчийн хувьд бус, түүхийн 300 гаруй жилийн хугацаанд Оросын Үнэн алдартны сүмийн тэргүүний Хятадад хийсэн айлчлал гэдгээрээ онцлогтой. Цаашид Орос дахь бусад уламжлалт ислам, болон буддийн шашны төлөөлөгчид ийм арга хэмжээг авч явуулах нь зүйтэй хэмээн үзжээ. БНХАУ-д мөн ислам, буддийн шашны төлөөлөл өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн байдгийг энд хэлэх хэрэгтэй.

Нөгөөтэйгүүр Орос, Хятадын соёлын харилцааны хөгжилд хоёр талын соёл болон кино урлагийн салбар хүрээний хамтын ажиллагааны дэд комисс (Орос-Хятадын Засгийн газар хоорондын хүмүүнлэгийн хамтын ажиллагааны талаархи комиссын бүрэлдэхүүнд ордог)-ын үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Тэдгээр комиссын хүмүүнлэгийн салбарт хэрэгжүүлж буй хамтын ажиллагаа нь хоёр талын хэлхээ холбоог өргөжүүлэн тэлэхэд оршиж буй аливаа асуудлыг зохицуулан шийдвэрлэхийг чухалчилдаг. Цаашилбал ОХУ, БНХАУ-ын харилцааны стратегийн түншлэлийн суурь үндсийг бүрэлдүүлэх, хөгжлийг бүхэлд нь урагшлуулахад түлхэц болох ажээ. Ийнхүү хоёр орны хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагаа улам эрчимтэй хөгжиж, хоёр улсын хооронд томоохон төслүүд амжилттай хэрэгжиж байгаа нь 2014-2015 оныг найрамдалт залуусын солилцооны жил, 2016-2017 оныг Орос, Хятадын Хэвлэл мэдээллийн жил, 2018-2019 оныг Орос, Хятадын бүс нутаг хоорондын харилцааны жил<sup>24</sup> болгосноос харж болох юм.

Үүнээс гадна хоёр орны соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбарын төслүүд нь ШХАБ, ЮНЕСКО болон бусад олон улсын байгууллагуудын хүрээнд хэрэгжиж байгааг онцлон дурьдах нь зүйтэй. Тухайлбал, ШХАБ-ын тэргүүлэх нэг чиглэл бол хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагаа юм. ШХАБ байгуулагдсанаас хойш

---

<sup>24</sup>人民日报“Рэньминь рибэо” сонин. Хятад хэлээр. 2018.09.12

гишүүн орнууд соёл, боловсрол, байгаль хамгаалал, залуучуудын талаархи бодлого, аялал жуулчлал, биеийн тамир спорт, хэвлэл мэдээлэл<sup>25</sup> зэрэг салбарт үйл ажиллагаа явуулж байна. Мөн Орос дахь Күнзийн институт болон “Оросын төв”, “Соёлын төв”-ийн хүрээнд үндэсний хэл соёлоо дэлхий дахинд түгээн дэлгэрүүлж буй. Ялангуяа “Үндэсний жил”, “Үндэсний хэл”-ний жилийг тус тус явуулсны дараа жуулчдын тоо нэмэгдсэн ба Хятад улсад суралцагч оросуудын тоо, Орос улсад суралцах хятадуудын тоо ч үлэмж өсчээ. Ийнхүү хоёр орны соёл, урлагийн талаархи томоохон ашиг сонирхол нь тэдгээрийг ойртуулахад бас нэг чухал түлхэц болж байна. Нөгөөтэйгүүр Хятадын олон мянган жилийн соёл иргэншил болон Оросын хосгүй нандин уламжлалт соёл эдгээр хоёр орны ард түмнийг татах сонирхол, үеэс үед дамжин ирснийг гэрчилж байна.

Боловсролын салбарын тухайд, Орос, Хятадын боловсролын салбарын хамтын ажиллагааг дараах үе шатанд хувааж авч үзэж болох юм. Үүнд: 1-р үе шат 1990-1992 он, энэ үед хоёр орны хоорондох сөргөлдөөн намжиж, харилцаа хэвийн болох үе; 2-р үе шат 1993-1995 он, энэ үеэр хоёр талын соёл, боловсролын харилцаа сайжирсан. Өөрөөр хэлбэл, Орос, Хятадын найрамдалт, харилцан ашигтай хамтын ажиллагаа шинэ шатанд гарчээ. Энэ үед Орос Хятадын бүх талын харилцаа: улс төр, эдийн засаг, цэрэг арми, соёл боловсролын харилцаа түргэн хөгжих болсон тухай дээр дурьдсан. Энэ үед 1995 оны 6 дугаар сарын 26-нд “Боловсролын тухай болон эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх, тэгш солилцооны тухай” баримт бичигт гарын үсэг зуржээ. 3-р үе шат буюу 1996-2000 он стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон үе, өөрөөр хэлбэл, 1996 оноос ОХУ, БНХАУ-ын харилцаа чанарын шинэ төвшинд гарахын сацуу хоёр орны боловсролын салбарын хамтын ажиллагаа болон соёлын солилцооны хөгжил мөн шинэ шатанд гарсан. 4-р үе шат хоёр орны хооронд сайн хөршийн найрсаг, хамтын ажиллагааны эрин үе буюу 2001 оноос эдүгээ хүртэлх хугацааг оруулж болох юм. 2001 оны 6 дугаар сард хоёр тал “Сайн хөршийн, найрамдалт, хамтын ажиллагааны гэрээ”<sup>26</sup>-нд гарын үсэг зурсан нь түүхэн баримт бичиг болжээ. Уг гэрээг байгуулсны дараа хоёр улсын соёл, боловсролын үйл ажиллагаа улам идэвхжиж эхэлсэн байна. Нөгөөтэйгүүр БНХАУ-д ОХУ-тай хамтарсан боловсролын салбарын үйл ажиллагаа ялангуяа боловсон хүчнийг хамтран бэлтгэх тал дээр

---

<sup>25</sup> Е.В.Бойкова. ШХАБ-ын гишүүн орнуудын хүмүүнлэгийн хамтын ажиллагааны асуудлууд. “Олон улс судлал” сэтгүүл. 2018№1(108) т.19

<sup>26</sup> Договор о добрососедстве, дружбе и сотрудничестве между РФ и КНР // Российская газета. - 2001. - 17 июля; Проблемы Дальнего Востока. - 2001. - №5. - С.6- И.



улам өргөжин тэлэхийн зэрэгцээ Хятадад орос хэл сурах сонирхогчдын тоо өсч, хятад залуус орос хэл шамдан суралцах болов. Хэл сурах нь олон янзын соёлыг танин мэдэх арга бөгөөд эндээс үүдээд асар том ашиг сонирхол бий болдог. Хэдийгээр Хятадад нэг талаас орос хэлний мэргэжилтэн багш нар буй болж, орос хэл сурах сонирхол нэмэгдэж байгаа ч яг нарийн мэргэжлийн тухайлбал, инженер, технологи, биологи, хими, уул уурхай, газрын тос, эрчим хүч, банк санхүү гм нарийн мэргэжлийн орос хэлний орчуулагч хангалтгүй байгаа талаар Хятадын хэвлэлд дурдсан байна. Хятадын оюутнууд зөвхөн орос хэл сурах сонирхолтойгоос гадна мөн инженер, эрчим хүч, химийн чиглэлээр бакалавр, магистрийн хөтөлбөрт хамрагдах ихээхэн боломжтой болжээ. Нөгөөтэйгүүр БНХАУ-ын Гэгээрлийн яамны Дээд боловсролын хэлтсээс хятадын их дээд сургуулиудад орос хэлээр сурах бичгийг боловсруулах хөтөлбөрийг баталсан байна. Энэ шийдвэртэй холбогдуулан Хятадад орос хэлний шинэ сурах бичиг, гарын авлагыг иж бүрнээр нь хэвлэжээ. Одоогоор “Орос хэл”-ний мэргэжилтэн багш нар хятадын 120 гаруй их дээд сургуульд багшилж байна.<sup>27</sup>

XXI зууны эхээр БНХАУ боловсролын салбарынхаа шинэчлэлийг чухалчлан, БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс 2010 оны 8 дугаар сард “БНХАУ-ын боловсролын салбар дахь дунд, урт хугацааны инноваци болон хөгжлийн мастер төлөвлөгөөг (2010-2020)”<sup>28</sup> баталсан. БНХАУ-д ийнхүү Боловсролын салбарыг бүх талаар өөрчлөн шинэчлэх ажлыг эхлүүлснээр XXI зууны шилдэг мэргэжилтнийг бэлтгэх, салбар чиглэлээр нарийн мэргэжил эзэмшүүлэхээр гадаад дотоодын их дээд сургуулиудад суралцуулах боломж нээгджээ. Энэ шинэчлэл нь хоёр орны боловсролын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд ч ихээхэн түлхэц болж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд ОХУ-ын 150 гаруй их дээд сургууль, БНХАУ-ын 600 их дээд сургуультай түншлэлийн харилцаа тогтоосон нь стратегийн ач холбогдолтой болж байна. ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээлснээр, Орос, Хятадын их дээд сургуулиудын хооронд ойролцоогоор шууд 900 гаруй гэрээнд гарын үсэг зурсан ба мөн тодорхой хүрээнд их дээд сургуулийн 8 холбоо байгуулаад байгаа ажээ. Өнөө хоёр орны хамтын ажиллагааны төсөлд оролцож буй их дээд сургуулиудын тоо 150-иас давсан

---

<sup>27</sup>Россия. Китай>Образование, наука>минобрнауки.рф, 11 сентября 2018>№ 2726762

<sup>28</sup>中共中央国务院印发《国家中长期教育改革和发展规划纲要（2010-2020年）》，  
<http://theory.southcn.com> /”Төрийн дунд урт хугацааны боловсролын өөрчлөлт шинэчлэл болон хөгжлийн хэтийн төлөвлөгөөний хөтөлбөр”-ийг ХКН-ын Төв хороо, Төрийн Зөвлөл хэвлүүлэн нийтлүүлэв/

бөгөөд түүний дотор мөн “5-100 төсөл” гэсэн төсөлд их дээд сургуулиуд оролцож байна. Ийнхүү ОХУ-ын их дээд сургууль БНХАУ-ын ойролцоогоор 600 гаруй их дээд сургуультай түншлэлийн харилцаа тогтоожээ. Үүнд: Бээжингийн политехникийн их сургууль, Харбины политехникийн их сургууль, Цинхуа их сургууль, Бээжингийн Сансрын их сургууль, Өмнөд Хятадын технологийн их сургууль, Зүүн хойд багшийн их сургууль, Дорнод хятадын багшийн их сургууль, Зянсугийн багшийн их сургууль орно.<sup>29</sup> Оросын статистикийн мэдээгээр, ОХУ-ын их дээд сургуульд 2014-2015 болон 2015-2016 оны хичээлийн жилд бакалавраар 109 мянга, магистрийн сургалтанд 12 мянган хятад оюутан хамрагджээ. Ялангуяа дээр дурдсан “5-100 төсөл”-ийн хүрээнд их сургуульд хятад оюутны тоо нэмэгдэх хандлагатай болжээ.<sup>30</sup> Ийнхүү Орос, Хятадын хоорондын стратегийн түншлэлийн харилцаа ялангуяа дээд боловсролын салбар болон шинжлэх ухаан-зохион бүтээх үйл ажиллагааны хүрээндасар ихээр хөгжиж байна. Нөгөөтэйгүүр хоёр орны ялангуяа хил орчмын бүс нутагт хятад, орос хэл эзэмших сонирхол тасралтгүй өсөх хандлагатай байна. Энэ нь тухайлбал, Өвөр Байгалийн хязгаарын их дээд сургуулиудад, мөн Хятадын Зүүн хойд бүс нутгийн их дээд сургуулиудад ажиглагдаж байна. Ийнхүү Орос-Хятадын хамтарсан үйл ажиллагаа орон нутгийн хүрээнд ихээхэн хэрэгжиж, бүс нутаг хоорондын харилцаа холбоо хөгжихийн сацуу соёл хүмүүнлэгийн салбарын үйл ажиллагаа ч идэвхжиж иржээ. ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Оросын зүүн бүс нутгийн хөгжилд анхаарлаа хандуулахаа ч илэрхийлсэн байгаа. Чингэснээр хоёр талын цаашдын хамтын ажиллагааны хөгжлийг “Алс Дорнодын хөгжлийн стратеги”-д чиглүүлэхэд ач холбогдолтой болжээ. Мөн түүнчлэн БНХАУ-ын дарга Ши Жиньпин Дорнын эдийн засгийн IV форумд оролцсон нь БНХАУ-ын Зүүн хойд бүс нутаг болон ОХУ-ын Алс Дорнодын бүс нутгийн хооронд цаашид харилцан ашигтай хамтран ажиллахад, мөн түүнчлэн хоёр орны хил орчмын бүс нутгийн хоорондын үйл ажиллагаанд түлхэц болсон юм.

Чингээд Оросын Алс Дорнодын бүс нутаг нь Орос, Хятадын хамтарсан төслийг хэрэгжүүлэх ирээдүйтэй талбар гэдгийг хоёр тал олж харсан байна. 2009 оны 9 дүгээр сард Орос, Хятадын тэргүүн Оросын Дорнод Сибирь болон Алс Дорнодын бүс нутаг- Хятадын Зүүн хойд бүс нутгийн хооронд 2018 он хүртэл хил

---

<sup>29</sup>光明日报.«Гуанмин рибэо» сонин. 2017.12.13. 俄中两国教育合作将在哪些领域出彩 - 访俄罗斯联邦教育与科学部副部长柳德米拉·奥戈罗多娃. Хятад хэлээр.ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яамны орлогч сайд Огородова-тай: Орос-Хятадын боловсролын салбарын хамтын ажиллагаа хэрхэн хөгжиж байгаа талаар хийсэн ярилцлага.

<sup>30</sup>Мөн тэнд.

орчмын бүс нутгийг хөгжүүлэхэд түлхэц болох хамтын ажиллагааны Хөтөлбөрийг<sup>31</sup> баталсан юм. Тухайлбал, Орос, Хятадын бүс нутгийн засаг захиргааны түвшинд түншлэлийн 234 гэрээ хэлэлцээр байгуулсны дотор 91 нь Холбооны субъектын хэмжээнд, 143 нь орон нутгийн засаг захиргааны түвшинд хийгджээ. Оросын Холбооны 51 субъект нь БНХАУ-ын орон нутгийн хэмжээнд хамтын ажиллагааны гэрээтэй бөгөөд Хятадын 91 орон нутагтай ах дүүгийн болон түншлэлийн харилцаатай<sup>32</sup> байна. Ийнхүү хоёр талын орон нутгийн хамтын ажиллагаа тогтмолжиж, өргөжин тэлж байгаа нь ОХУ болон БНХАУ-ын хоорондын харилцаа шинэ онцлогтой болж буйг харуулж байгаа юм. Тиймээс ч 2018, 2019 оныг Орос, Хятадын бүс нутаг хоорондын харилцааны жил<sup>33</sup> болгосон нь орон нутгийн хөгжилд ихээхэн ач холбогдолтой болж байна.

### **Дүгнэлт**

ОХУ, БНХАУ бол маш том хөршүүд, хөгжил цэцэглэлт, аюулгүй байдлын талаар аль аль нь өөрийн гэсэн ашиг сонирхолтой улс юм. Өнөөдөр БНХАУ нь зөвхөн дэлхийн хоёрдогч эдийн засагтай орон төдийгүй улс төрийн болон цэргийн хүчин чадлын нөлөө нь түргэн өсч байгаа орон юм. Орос улс хэт их гүрэн байхаа больсон хэдий ч, тэдний нийт хүчин чадлыг анхаарахгүй байхын аргагүй юм. Орос, Хятад нь харилцанбие биенээ нөхөж, маш сайн дэмждэг. Орос, Хятадын харилцааны хөгжлийн хэтийн төлөв нь “бүх талын стратегийн харилцаа хамтын ажиллагаагаа аажмаар гүнзгийрүүлэхэд чиглэгдэж байгаа” бөгөөд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Орос, Хятадын харилцааг тодорхойлохдоо “найз нөхдийн хоорондын түншлэлийн онцгой харилцаатай”<sup>34</sup> гэж нэгэнтээ хэлсэн юм.

Дээр өгүүлсэн Орос, Хятадын соёл, боловсролын харилцаа, хамтын ажиллагааны төлөв байдлаас харахад, хоёр талын хамтын ажиллагааны бүтэц, хоёр орны хоорондоо дамжуулж буй “зөөлөн хүч”-ний бодлогын шинж чанар нь гол төлөв бодит туршлага, үйл ажиллагаанд харилцан үйлчилж байна. Нэг талаас, БНХАУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж буй соёлын зөөлөн хүчний бодлогодоо ялангуяа хилийн чанадад хятад хэл соёлыг хөгжүүлэхэд маш их анхаарал тавьж байна. Нөгөө талаас ОХУ ч мөн адил гадаад орнуудад хэл соёлоо түгээн

<sup>31</sup>[http://www.mid.ru/ru/maps/cn/-/asset\\_publisher/WhKWb5DVBqKA/content/id/2320455](http://www.mid.ru/ru/maps/cn/-/asset_publisher/WhKWb5DVBqKA/content/id/2320455)

О российско - китайских отношениях стратегического партнерства.

<sup>32</sup> <http://www.mid.ru/strategiceskoe-partnerstvo-s-kitaem>

<sup>33</sup> 人民日报。Рэньминь рибэо” 2018.09.12

<sup>34</sup> 王海运：中俄关系为何能“坚如磐石” 环球网。 <http://opinion.huanqiu.com/hqpl/2019-01/14032620.html>

дэлгэрүүлэхэд маш их хүчин чармайлт гаргаж байна. Өнөөгийн ОХУ, БНХАУ-ын хоорондын стратегийн түншлэлийн харилцаа нь зөвхөн улс төр, худалдаа-эдийн засгийн хүрээнд бус мөн соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбарт урьд хожид байгаагүй тэргүүлэх чиглэлд хүрч байна. Энэ нь хоёр орны соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбарын харилцаа, хамтын ажиллагааны хууль эрхзүйн орчин Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрээр баталгаажиж, цаашид улам өргөжүүлэн хөгжүүлэх үндсийг бүрдүүлсэнтэй холбоотой.

### ***The Aspects Current Situation of Cultural and Educational Relationship between Russia and China***

*Chojjamtsiin Battsetseg*

**Abstract:** *The paper explores actual results and impacts of contracts and agreements, legal environment, features of cooperative mechanism and activities, regional cooperation, inter-organizational collaboration, and student exchanges in cultural, educational and humanitarian sectors between Russia and China since 1990. Furthermore, the author argues that the relationship of strategic partnership between the two countries took priorities over not only political and economic issues but also cultural, educational and humanitarian spheres.*

**Keywords:** *Collaborative contracts and agreements on culture and education between Russia and China, student exchanges, regional relationship*

#### **Ашигласан материал**

1. Орос-Хятадын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. 1949-1999 он. М. 1999.
2. Орос-Хятадын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл. Хоёрдугаар хэсэг /1949-2003/ УБ., 2003.
3. Сборник Российско-китайских договоров 1949-1999 гг. - М., 1999
4. Даяаршил ба өнөөгийн Еврази: түүх, хандлага, өөрчлөлтийн сорил. УБ., 2018
5. Проблемы Дальнего Востока.сэтгүүл.1993.№1, 2001. - №5.
6. “Олон улс судлал” сэтгүүл. 2018№1(108)
7. Российская газета. - 2001. -17 июля;
8. 人民日报“Рэньминь рибао” сонин.2018.09.12
9. 光明日报.”[Гуанмин рибао](#)” сонин.2017.12.13
10. 中共中央国务院印发《国家中长期教育改革和发展规划纲要（2010-2020年）》

МОНГОЛ-ОРОСЫН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН  
ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХЭТИЙН ТӨЛӨВ\*

А.Нямдолжин

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн  
Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D).

E-mail хаяг: [nyamdoljin@mas.ac.mn](mailto:nyamdoljin@mas.ac.mn)

**Хураангуй:** Зохиогч Монгол, Оросын боловсролын салбар дахь хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх бодит туршлага дээр үндэслэн тус салбарын үндсэн чиглэлүүдийг тодорхойлон, харилцааны онцлогийг харуулахын зорьлоо. Түүнчлэн Монгол-Оросын боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагааны хууль эрх зүйн орчны талаар тусгайлан тусгасан болно. Өгүүлэлд ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр оросын их, дээд сургуулиудад элсэн суралцах боломж, хөтөлбөрийн хүрээнд монгол оюутны тоог нэмэгдүүлэх шаардлагатай талаар статистикт суурилан судалжээ.

**Түлхүүр үгс:** Монгол, Орос, боловсролын салбар, хамтын ажиллагаа

Монгол, Оросын боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосон цагаас эхлэн эдүгээ 100 орчим жил үргэлжлэн хөгжиж байна. 1922 оны 3 дугаар сард Монгол Ардын засгийн газар ардын боловсролыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор монгол хэл мэддэг Зөвлөлтийн багш-зөвлөхүүдийг урих тухай тогтоол гаргаж байжээ.<sup>35</sup> 1924 онд хуралдсан МАХН-ын III их хурлаас "...гадаадын боловсорсон улсын эрдэмд суралцах нь чухал тул ... монгол бичиг үсэгтэй бөгөөд сурах төлөвтэй, зан чанар сайтай, бие махбод эрүүл хүмүүсийг явуулж, эрдэм боловсролыг сурган хүмүүжүүлэх нь зүйтэй" гэсэн шийдвэр гаргажээ. 1930-аад онд Москва, Ленинград, Эрхүү, Улаан-Үд зэрэг хот монгол оюутнуудыг бэлтгэн сургадаг гол төв болж, Ленинград, Эрхүүгийн дээд сургуулиудын дэргэд монгол оюутнуудад зориулсан орос хэлний бэлтгэл анги нээгдэв. 1922 онд Москвагийн Дорно дахины

\* Олон улс судлал сэтгүүл, 2018№1(108), тал 40-63 DOI: <https://doi.org/10.5564/jis.v0i1.1121>

<sup>35</sup> Г.Пүрэвсамбуу, Я.Индра. Монголия и Россия: вечные соседи. УБ.2009. стр.60

хөдөлмөрчдийн коммунизмын их сургуульд (КУТВ) 15 хүн, 1924 онд Ленинградын Дорно дахины хэлбичгийн их сургуульд 18 хүн, 1925 онд Герман, Франц зэрэг улсад 35 залуусыг илгээж байлаа. 1922 онд 10, 1926 онд 150, 1937 онд 314, 1940 он гэхэд 739 монгол оюутан, залуус ЗХУ-ын их, дээд сургуулиудад суралцан төгсчээ.

1930-аад оны эхээр Эрхүүгийн их сургуульд багш, хүн, малын их эмч нар, радио холбооны ажилтан, бүжигчин нарыг бэлтгэхийн сацуу Хиагтад дунд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж байлаа. 1960-аад онуудад монгол оюутнуудыг уул уурхай, эрчим хүч, барилгын салбаруудад инженер-техникийн чиглэлээр бэлтгэж эхлэв.

Монгол оюутнуудын ЗХУ-д суралцаж байсан оргил үе нь 1980-аад он юм. Жилд 1300 гаруй оюутан Зөвлөлт Холбоот Улсын их, дээд болон дунд мэргэжлийн, 1000-аад оюутан техник мэргэжлийн сургуулиудад тус тус элсэн суралцаж байв. Эрхүү хотод 2000, Москвад 1000 гаруй, Ленинград хотноо 800-аад оюутан 200 гаруй төрлийн мэргэжлээр 287 их, дээд, тусгай мэргэжлийн сургуулиудад сурч байв. Монголын эрдэмтдийн 60 гаруй хувь, инженер техникийн мэргэжилтнүүдийн 50 гаруй хувь нь ЗХУ-д төгссөн байдаг байна. Ийнхүү 1922-1990 онд ЗХУ-ын их, дээд сургуулиудад бэлтгэгдсэн өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн үндэсний боловсон хүчний бүхэл бүтэн үе бүрэлдэн төлөвшиж, монголын шинжлэх ухаан, нийгмийн бүх салбар дахь бүтээн байгуулалт, улс орны хөгжил, дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан ба өнөөдөр ч монголын боловсон хүчнийг бэлтгэхэд оросын тал дэмжлэг үзүүлсээр байна.

Социалист замналаар замнасан 70 жилийн хугацаанд монголчууд их гүрний нөлөөнд байсан хэдий ч тусгаар тогтнолоо бататган, нийгмийн болон боловсролын салбарт томоохон дэвшилд хүрч чадсан юм. Үүний нэг тод жишээ бол Монгол улс бичиг үсэг үл мэдэх явдлыг арилган иргэдээ боловсролтой болгоход ихээхэн анхаарлаа хандуулж байв. Монголчууд одоогоос 40 шахам жилийн өмнө нийт хүн амын 98.3% нь бичиг үсэг тайлагдсан амжилтаараа НҮБ-ын ЮНЕСКО-д бүртгэгдэн, дэлхийд гайхагдаж байсан нь социалист нийгмийн зөвлөлт маягийн боловсролын тогтолцооны үлдээсэн өв гэж тодорхой хэмжээнд үзэж болох бөгөөд өнөөдөр ч дэлхийд хамгийн өндөрт тооцогдох үзүүлэлт хэвээр байна. Бичиг үсгийн өндөр түвшин нь орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан мэдээлэл түгээх, ашиглах боломжийг олгох суурь, нөхцөл давуу байдал болж байна.

Өнгөрсөн зууны 80-90-ээд оны зааг дээр дэлхий дахинд гарсан улс төр, эдийн засгийн тогтолцооны эрс өөрчлөлт, түүний дотор манай хоёр оронд өрнөсөн ардчилсан үйл явцын дүнд Монгол Улс болон ОХУ-ын хоорондын харилцаанд шинэ үе эхэлсэн юм. Шинэ үеийн утга учир нь хоёр орон ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжих ээдрээ төвөгтэй гараан дээр Монгол-Оросын харилцааг бүхэлд нь эрх тэгш, харилцан ашигтай байх, хоёр орны ард түмний олон зууны оюуны болон соёлын уламжлал, үнэт зүйлд тулгуурлан орчин үеийн чиг хандлага, бодит нөхцөлд нийцүүлэн уламжлалт нягт хэлхээ холбоог бататган бэхжүүлэх, өөрчлөн хөгжүүлэхэд оршиж байлаа.

Шилжилтийн үеийн энэ амаргүй хүнд нөхцөл байдлын улмаас манай хоёр улс системийн гүнзгий хямралд нэг зэрэг өртөж, хамтын ажиллагааны бараг бүх салбар зогсонги байдалд орж, түүний дотор боловсролын салбарын харилцаа ихээхэн уналтанд орсон үе байв. Бий болсон нөхцөл байдалд улс бүр гадаад орчноо дүгнэж, гадаад харилцааны чиглэлүүдээ тодорхойлох, хоорондын харилцааны эрх зүйн үндсийг шинэчлэхэд гол анхаарлаа хандуулав.

Монгол-Оросын харилцааны стратегийн түншлэлийн түвшинг тодорхойлсон дараах баримт бичгүүдэд хоёр орны боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагаа тусгалаа олж, хууль эрх зүйн орчны нөхцөлөөр баталгаажиж ирсэн. Тухайлбал: 1993 оны 1 дүгээр сарын 20-нд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатын ОХУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр Монгол, Оросын хооронд байгуулсан “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2000 оны 11 дүгээр сарын 14-нд Монгол Улсад айлчлах үеэр байгуулсан “Улаанбаатарын тунхаглал”, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр 2006 оны 12 дугаар сарын 8-нд ОХУ-д айлчлах үеэр байгуулсан “Москвагийн тунхаглал”, 2009 оны 8 дугаар сарын 25-нд ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведев Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Монгол Улсад айлчлах үеэр байгуулсан “Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх тухай Тунхаглал” юм. Хоёр орны хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай Тунхаглалын хүрээнд хоёр тал шинжлэх ухаан, техник, соёл, боловсролын салбарт хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх талаар санал солилцож, ОХУ-д суралцах монгол оюутны тоог нэмэгдүүлэх, Монгол Улсад Оросын боловсролын байгууллагын салбаруудыг байгуулан ажиллуулах, хоёр орны их дээд сургуулиудад суралцагсдад тэтгэлэг олгох зэргээр хамтран ажиллахаар тохиролцсон.

Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын Засгийн газар хоорондын 1995 оны 4 дүгээр сарын 5-ны боловсрол, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны тухай хэлэлцээр нь боловсролын салбарын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс болж, талууд хэрэгцээ, боломжийн дагуу суралцах оюутанд тэтгэлэг харилцан олгох, боловсролын байгууллагуудын хооронд шууд харилцаа тогтооход туслалцаа үзүүлэх, хоёр улсын хэлийг судлах ажлыг харилцан хөхиүлэн дэмжихээр тохиролцсоны дагуу хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна.

Өнгөрсөн 25 жилийн хугацаанд гадаадад сурч байгаа монгол оюутнуудын тоо эрс өсч, 70 мянгад хүрсэний 70 орчим хувь нь БНХАУ, ОХУ, БНСУ, Япон болон АНУ-д суралцаж байна. Монгол Улсын Засгийн газар 1990 оноос хойш Орос, Хятад, Польш, Унгар, Энэтхэг, Австри, Турк, Солонгос зэрэг 14 улс оронтой Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр байгуулснаар 2000-2014 онуудад 8500 орчим оюутныг тэтгэлгээр гадаадад суралцуулахаар илгээсэн байна. Эдгээр орнуудын дотор хамгийн өргөнөөр тэтгэлэг олгодог оронд ОХУ, БНХАУ орж байна.

2003 оны 6 дугаар сарын 26-нд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Боловсролын баримт бичиг, эрдмийн зэрэг, эрдмийн цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан ба энэхүү хэлэлцээр нь 2006 онд баталгаажсан.

Их Британийн QS компаниас дэлхийн дээд боловсролын тогтолцооны чанарын үзүүлэлтээр ОХУ 26-д багтсан байна. ОХУ-ын их дээд сургуульд жил бүр гадаадын 150 орны 270 мянган оюутан элсэн сурч байгаагийн дотор 15 мянган оюутанд квот олгон Оросын төсвийн хөрөнгөөр суралцуулж байна. Эдгээрийн дотор Монгол оюутнууд Хятад, Вьетнамын дараа дээгүүр ордог бөгөөд ОХУ-ын 26 хотын 109 их дээд сургуульд 2000 гаруй оюутан сурч байна.

Өнөөдрийг хүртэл монголчууд Оросын дээд боловсролын тогтолцоо, шинжлэх ухааны суурь судалгааг өндрөөр үнэлсэн хэвээр байгаа бөгөөд хоёр орны сайн хөршийн харилцаанд ихээхэн эерэг хүчин зүйл болж байдаг. 1994 оноос Монгол Улс, ОХУ-ын Засгийн газрын хоорондын хэлэлцээрийн дагуу ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр оросын их, дээд сургуулиудад элсэн суралцах боломж олгох болсноор монголын 30 оюутан сургаж эхэлж байсан бол 1996 онд 90 оюутан, 1999 онд 130, 2000 онд 150, 2004 онд 200, 2014 онд 383, 2015 онд 350, 2017 онд 450, 2018 онд 500 болж өсжээ. 2000-2013 онд ОХУ-ын их дээд сургуульд тэтгэлгээр



2760 оюутан залуус суралцсан байна.<sup>36</sup> ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр суралцах монгол оюутны тоог нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 2014 оны 9 дүгээр сарын 3-нд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монгол Улсад айлчлах үеэр Монгол Улсын Засгийн газраас ОХУ-д сургах оюутны тоог мянгад хүргэх санал тавьсан. Айлчлалын үеэр онцлох нэг гэрээ хийгдсэн нь ОХУ-ын “Роснефть” компаний тэтгэлгээр ОХУ-ын И.М.Губкины нэрэмжит Нефть, хийн их сургууль, М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын их сургууль зэрэг оросын шилдэг их, дээд сургуулиудад монголын 10 оюутан суралцуулах гэрээ байгуулсан. Тус гэрээний дагуу 2015 оны хичээлийн жилээс эхлэн 10 оюутан тэтгэлэгт хамрагдан суралцаж байна.

Монгол Улс гадаадын оюутнуудад бусад улсуудын адил тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх эдийн засгийн нөөц бололцоо хомс хэдий ч тус улсад суралцаж буй гадаад оюутаны тоо 2002 оноос хойш хурдацтай нэмэгдэж 2016-2017 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр гадаадын 32 орны 1520 иргэн сурч байгаагийн 850 (55.9%) нь бакалаврын (монгол хэлний бэлтгэл ороод), 497 (32.7%) нь магистрын, 173 (11.4%) нь докторын сургалтын хөтөлбөрт хамрагдаж байна. Эдгээр суралцагчдын 104 (6.8%) нь хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр, 1261 (83.0%) нь хувийн, үлдсэн 155 нь (10.2%) бусад зардлаар суралцаж байна.<sup>37</sup> ОХУ-аас Монгол Улсад 182 оюутан суралцаж байна. Монголын их сургуулиуд монгол хэл сурах оюутнуудад тэтгэлэг олгодог.

ОХУ-ын Москва хотноо 2018 оны 2 дугаар сарын 26-28-ны хооронд хуралдсан Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын комиссын ээлжит 21-р хуралдааны үеэр Боловсрол, шинжлэх ухааны хамтын ажиллагааны дэд комиссын 5 дугаар хуралдаан болж, тус салбарын хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцэж, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яам хороонд 2018-2020 онд хамтран ажиллах хөтөлбөрийн төслийг үзэглэж, соёлын салбарт 2018-2020 онд хамтран ажиллах хөтөлбөр байгуулахаар тохиролцов. Түүнчлэн ОХУ-ын их, дээд сургуульд суралцах монгол оюутны тоог нэмэгдүүлж 500-д хүргэсэн ба ерөнхий боловсролын тусгай сургуулийн албан хаагч, багш-сэтгэл зүйч, согог зүйч багш,

<sup>36</sup> <http://www.mfa.gov.mn/?p=28020>

<sup>37</sup> Дээд боловсролын салбарын 2016-2017 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн танилцуулга. // <http://www.mecss.gov.mn/data/1702/HigherSta1617ab>

хэл засалч багш нарыг ОХУ-д бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах талаар оросын талтай тохиролцсон байна.

Монгол Улс, ОХУ-ын их, дээд сургуулиудын хоорондын хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байгаагийн дээр манай улсад Оросын их, дээд сургуулиудын салбарууд байгуулагдан ажиллаж эхэлсэн нь хамтын ажиллагааны түүхэн дэх шинэ хэлбэр юм. Өнөөгийн байдлаар Плехановын нэрэмжит Эдийн засгийн Академи, Дорнод Сибирийн Технологи, удирдлагын их сургууль, Эрхүүгийн Зам харилцааны улсын их сургуулийн Улаанбаатар дахь салбар сургуулиуд үйл ажиллагаагаа явуулж, манай боловсролын тогтолцоонд байр сууриа эзлэн тодорхой хувь нэмэр оруулж байна.

Сүүлийн жилүүдэд ОХУ нь орос хэлийг бусад улс орнуудад сурталчлах, орос хэлний багш нарыг бэлтгэх, дадлага хийлгэх, зуны сургалтанд хамруулах, онлайн сургалт зохион байгуулах, орос орны хэл, соёл, уламжлалыг бусад улс оронд түгээн дэлгэрүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрүүдийг эрчимтэй хэрэгжүүлж байна. Орос хэл бол Европт хамгийн тархсан хэл. Дэлхийн 260 сая хүн орос хэлээр ярьдаг. Энэ тоогоороо дэлхийд 8-д орж байна. Орос хэлээр дамжуулан олон мянган монгол хүн өндөр боловсрол төдийгүй дэлхийн соёлын үнэт зүйлс, шинжлэх ухааны мэдлэг хүртэх боломжийг олж авч байдаг. Орос улсын хувьд орос хэл мэддэг хүний тоо өсөхийг сайшаан дэмждэг. Энэ нь хоёр талын харилцааг бэхжүүлэх шинэ боломжийг бий болгож байдаг.

БСШУ-ны сайд Ж.Батсуурь 2016 оны 11 дүгээр сарын 28-нд ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд МУБИС-д Орос хэлний сургалтын төвийг ОХУ-ын М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн Их сургуулийн дэмжлэгээр байгуулахаар болсон байна. Түүнчлэн 2017-2018 оны хичээлийн жилд орос хэлний бэлтгэл анги нээн хичээллүүлж эхэлсэн бөгөөд ингэснээр дараагийн жилүүдэд ОХУ-д суралцах залуусыг нэг жилийн бэлтгэл курст суралцуулаад, тус улсын тэтгэлэгт хамруулах боломж бүрджээ. БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа 2018 оны 11 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд ОХУ-д хийсэн айлчлалын хүрээнд хоёр орны “Боловсрол, шинжлэх ухааны салбарт 2018-2020 онуудад хамтран ажиллах тухай Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон Оросын Холбооны Улсын Шинжлэх ухаан, дээд боловсролын яам хоорондын хөтөлбөр”, “Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, ОХУ-ын Соёлын яам хоорондын 2018-2020 оны Хамтын ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, ОХУ-ын Спортын яам хоорондын Биеийн тамир, спортын

салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичигт тус тус гарын үсэг зурсан байна.

ОХУ Алс Дорнод, Сибирийн бүсийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд өндөр технологи бүтээгч Азийн орнуудтай боловсрол, инноваци, өндөр технологийн салбарт хамтран ажиллах бодлого баримталж байна. Монгол Улс ОХУ хоорондын олон жилийн найрсаг, сайн хөршийн харилцааны уламжлал дээрээ тулгуурлан ОХУ-ын энэ бодлогын хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал юм. 2014 оны 11 дүгээр сарын 14-нөөс эхлэн хоёр улсын иргэд харилцан визгүй зорчиж эхэлсэн явдал худалдаа, эдийн засагт төдийгүй, боловсрол, соёл, шинжлэх ухаан, хүний нөөцийн солилцоонд чухал ач холбогдолтой алхам болсон юм.

### **Дүгнэлт**

Монгол Улс 1990 оноос өмнөх 70 жилийн хугацаанд ЗХУ-ыг түшиглэх гадаад бодлого хэрэгжүүлж ирсэн ба хоёр орны боловсролын уламжлалт харилцаа нь манай улсад чадварлаг боловсон хүчин бэлтгэх, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр үнэтэй хувь нэмэр оруулж, дорвитой тусламж үзүүлсээр байна. Боловсрол, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагаа нь хоёр орны иргэд хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх гол үндэс болж байдаг.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд уул уурхай, төсөөлөгдөж буй ажлын байрны тоо нь мэргэжилтэй Монгол боловсон хүчний нөөцөөс даваад байна. Энэ байдал ялангуяа технологи, инженерийн салбарт хүчтэй мэдрэгдэж байгаа юм. Монголын эдийн засгийн хөгжилд, ялангуяа өндөр зэрэглэлийн мэргэжлийн болон бизнесийн удирдлагын албан тушаалд гадаадын ажилчид давамгайлах хандлагатай байна. Ийм нөхцөлд ОХУ-ын Засгийн газраас Монголын талд олгодог тэтгэлгийг үр дүнтэй ашиглах, нэн эрэлт хэрэгцээтэй байгаа уул уурхай, шинжлэх ухаан, дэд бүтэц, ургамал, байгаль орчин хамгаалал, мал эмнэлэг, нарийн мэргэжлийн инженер, техник, технологийн салбаруудад мэргэжлийн чадварлаг боловсон хүчин бэлтгэх, боловсролын байгууллага хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, бодит үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллах нь хоёр орны стратегийн түншлэлийн харилцааны хэтийн төлөвийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Ашиглаж болох боломжууд нь эрсдэл, сорилт ээлжлэн байгаа энэ үед эдийн засгийн хурдацтай өсөлт монголчууд, Монголын нийгмийн чадавхийг сорихын зэрэгцээ боловсролын салбарт төр засгийн үүрэх ачааллыг нэмэгдүүлэн, мөн шинэ

боломжуудыг нээж өгч байна. Олон салбарт, ялангуяа техник, технологийн салбарт өндөр боловсрол эзэмшсэн, мөн эзэмших чадавхитай монголчуудын тоо нэмэгдэж байгаа нь шинэ боломж болж байгаа бол гадны нөлөө нэмэгдэн, чадварлаг монголчууд өөр улс орон, өөр салбарт татагдах эрсдэл бас байгааг анхаарах хэрэгтэй болов уу.

### **Cooperation perspectives on education sector of Mongolia-Russia**

A.Nyamdoljin.

Leading researcher, PhD, Institute of International Affairs, MAS, Mongolia

E-mail: [nyamdoljin@mas.ac.mn](mailto:nyamdoljin@mas.ac.mn)

**Abstract:** The author, based on practical experience in the implementation of bilateral cooperation between Mongolia and the Russian Federation in the field of education, reveals the main directions of this cooperation and analyzes its key features. The current regulatory and legal framework for Mongolian-Russian cooperation in the field of education is analyzed separately. The article provides a statistical analysis of the number of students studying in Russian universities, the number of programs, the budget quota allocated for training Mongolian students in Russian universities. And the number of Mongolian students studying various forms of training in Russian educational institutions should increase.

**Key words:** Mongolia, Russia, field of education, cooperation

#### **Ашигласан материал:**

1. В.В.Грайворонский. Монголия в начале XXI века (политика, экономика, общество). Москва. ИВ РАН. 2017. стр. 248, 249
2. Г.Пүрэвсамбуу, Я.Индра. Монголия и Россия: вечные соседи. УБ.2009. стр.60
3. А.Нямдолжин. Монголо-Российские отношения на современном этапе. УБ. Битпресс. 2016. стр. 42
4. А.Нямдолжин. Сотрудничество в области науки и образования. /Современные Российско-Монгольские отношения: модели и сценарии. Улан-Удэ. 2013. стр.106, 107
5. А.Нямдолжин. “Мягкая сила” в Монголо-Российских отношениях. /Россия-Монголия: история, вызовы XXI века, перспективы. Улан-Батор. 2017. стр.112-113.

**МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛ БА ГАДААД БОДЛОГЫН  
ТУЛГЫН ГУРВАН ЧУЛУУ\***

Ж.Баясах

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн захирал,  
доктор (Sc.D), профессор Email: [bayasakhjk@gmail.com](mailto:bayasakhjk@gmail.com)

Монголчууд тэртээ 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Чин гүрний эрхшээл нөлөөнөөс салж, туурга тусгаар улс юугаан сэргээн мандуулсан түүхт өдрөөс хойш 106 он улирчээ. XX зуунд болж өнгөрсөн 1911, 1921, 1990 оны түүхэн хэрэг явдлууд нь Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил дэвшлийг нээсэн түүхэн оргил үеүүд байв. Монгол Улсын тусгаар тогтнол бол үе үеийн Монголын ард түмний амь бие, итгэл, сэтгэл, зүтгэлээр бэхжин тогтносоор ирсэн юм. Түүнээс гадна мөнхийн хөрш Орос, Хятад гүрнүүд болон дэлхийн бусад гуравдагч орнуудын хүчин зүйл ч шийдвэрлэх нөлөөтэй байсныг бидний туулсан түүх гэрчилнэ. Улс орны гадаад харилцааны тулгын гурван чулууг манай ард түмний эрхэм дээд язгуур эрх ашигтай тэнцвэржүүлэн зохируулж, Монгол төрийн гал голомтыг өнөд бадраах төрийн залгамж бодлого түүхэн аль ч цаг үед амьд оршсоор байсан, цаашид ч мөнх оршсоор байх болно. Энэхүү өгүүлэлдээ бид Монгол Улсын тусгаар тогтнолд гадаад бодлогын тулгын гурван чулуу болох хөрш хоёр их гүрнүүд болон гуравдагч орнуудын хүчин зүйлс өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн хэлхээнд хэрхэн нөлөөлж буй тухайд эрхэм Та бүхэнтэй санал солилцож, эргэцүүлэн тунгааж явдаг зарим бодлоо товч боловч хуваалцахыг зориллоо.

**XX зууны Монгол улсын гадаад бодлогын түүхэн нөхцөл**

XX зуун бол Монгол үндэстний тусгаар тогтнолоо сэргээн тунхаглах, бэхжүүлэн хамгаалахын төлөөх тэмцлийн зуун байсан бөлгөө. Улс гэрээ хэмээх монголчуудын үндэсний үзэл санаа нэгэн үед их гүрнүүдийн улс төр, геополитикийн ашиг сонирхолтой зөрчилдөх, нэгэн цагт зохицон эвлэрэх зэргээр агуулга, хэлбэрийн хувьд хувьсан өөрчлөгдсөөр Монгол үндэстний тусгаар тогтнол, улс орны замнал хувь заяанд энэ нь түүхэн нөлөө үзүүлсээр иржээ.

---

\* Пакс Монголика сэтгүүл. 2017№1 тал 3-19

Аливаа улсын оршин тогтнохуй нь гадаад орчин, дотоод байдал гэсэн хоёр хүчин зүйлийн нөлөөллөөс хамаарч байдаг. Гадаад орчны нөлөөлөл нь тухайн улсыг хүрээлж буй улс орнуудын болон тухайн улсын үндэсний ашиг сонирхол хоорондын харилцаа, шинж агуулгаас үүсдэг тул Монгол улсын хувьд үндэсний аюулгүй байдал нь олон улсын нөхцөл, нэн ялангуяа хөрш хоёр орны хүчний болон эрх ашгийн тэнцвэрт байдлаас ихээхэн хамаарч иржээ. Үүнийг Монгол Улсын туулж өнгөрүүлсэн түүхэн үйл явц тод харуулдаг ба одоо ч энэ байдал үргэлжилсээр байна.

XX зууны Монгол Улсын тусгаар тогтнолд Орос, Хятад хөрш орнуудын түүхэн нөлөө шийдвэрлэх байр суурийг эзэлсээр ирсэн. Ингэснээр монголчууд өнгөрсөн зуунд ЗХУ-ын ашиг сонирхол, нөлөөний хүрээг хүлээн зөвшөөрч дагасан билээ. Гэвч гуравдагч орнуудтай харилцаа тогтоох эрмэлзлэл Монгол Улсад ямагт байсаар иржээ.

Түүхийн туршид Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын амин чухал асуудлууд зөвхөн хоёр хөршөөс хамаарах бус дэлхийн бусад орноос хамааралтай байх нь чухал гэсэн үзэл санаа бүрэлдэн буй болжээ. Энэ үзэл баримтлал нь ямар нэгэн онол урсгалын үндсэн дээр бус харин түүхэн нугачаан дунд амьдралын эхээр буй болсон үзэл санаа байсан юм. Хэдийгээр 2011 онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд анх удаа албан ёсоор томъёологдсон боловч “Гуравдагч хөрш”-ийн бодлого Монгол Улсын гадаад бодлого дахь шинэ зүйл огтоос биш юм.

1911 онд Олноо өргөгдсөн Монгол улсын Засгийн газар АНУ, Япон, Их Британи, Герман, Франц, Голланд зэрэг улсын Засгийн газарт хандан захидал илгээж, тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, худалдааны болон бусад харилцааг хөгжүүлэх санал тавьж байжээ. Энэ бүхэн Гуравдагч орнуудад албан ёсоор хандсан 106 жилийн өмнөх дипломат оролдлого байлаа.

1920-1930 онд Монгол улс АНУ, Герман, Япон зэрэг Өрнө, Дорнын олон улс орнуудтай худалдаа, боловсролын харилцаа тогтоож, тэдгээр орнуудын хөрөнгө оруулалттай үйлдвэр, аж ахуйн газрууд Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж, монгол оюутан сурагчид Европт боловсрон суралцаж байлаа. Гэвч энэ байдал дотоод, гадаадын хүчний шахалт дарамтын улмаас удаан үргэлжлээгүй юм. 1928-1990 онд манай улс ЗХУ болон социалист системийн хүрээлэлд багтсан тул “Гуравдагч хөрш”-ийн бодлого явуулах түүхэн хэрэгцээ шаардлага, боломж,

бололцоо байсангүй. Гагцхүү 1990 оны хувьсгалын дүнд ардчилал, шинэчлэлийн замд тууштай орсон цаг үеэс манай улс өөрийн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулах боломжтой болжээ.

Монголчууд хөрш ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхийн зэрэгцээ гадаад бодлогын тулгын гурван чулууг тэнцвэржүүлэх бодлогыг хамтад нь баримталж, ХХ зууны эхнээс гуравдагч хөршөө хайж эрэлхийлж байсан түүхэн туршлагаа дахин сэргээв. Гэвч гуравдагч хөршийн бодлогыг цэгцтэйгээр ойлгох, бодлогын түвшинд томъёолох, боловсруулах талаар авч үзсэн үе бол яахын аргагүй 1992 оны Ардчилсан Үндсэн хуулийн үзэл санааны дараах он жилүүдтэй холбогдож байна.

Монгол Улс мөнхийн хөрш их гүрнүүдтэй харилцах мянганаар тоологдох баялаг уламжлал, түүхтэй орон. Харин ХХ зууны түүхэн нөхцөл сургамж, Монгол Улсын үндэсний эрх ашгаас улбаалан гуравдагч орнуудтай харилцах бие даасан үзэл баримтлал, бодлогоо олж авчээ. Гэвч эцсийн дүндээ улс орныхоо үндэсний ашиг сонирхлын тэнцвэрийг буй болгохыг зорьсон гадаад бодлогын тулгын гурван чулууны тэнцвэрт бодлого нь Орос, Хятад улсуудтай харилцаагаа хэрхэн тасралтгүй хөгжүүлэхээс ихээхэн хамаарна. Энэ нь бид хоёр хөршийнхөө амин чухал эрх ашгийг хэрхэн харгалзан үзэхээс шалтгаалах нь тодорхой байна. Тийм ч учраас Монгол улсын гадаад бодлогыг Хөрш улсууд- Монгол улс-Гуравдагч хөрш орнууд гэсэн цогц утгаар нь хөгжүүлэх нь үр дүнтэй байх болно.

Энэ дашрамд зориуд өгүүлэхэд, Хөрш болон Гуравдагч орнуудаас Монгол Улсын тусгаар тогтнолд үзүүлсэн түүхэн нөлөөлөл, хүчин зүйлс, цаашдын төлөвийг судлахад энэ чиглэлд явуулсан манай улсын түүхчдийн судалгаа суурь болсоор иржээ. Үнэхээр ч өнөөдөр 106 жилийн ойг нь ёслон тэмдэглэж байгаа энэхүү үйл явцын түүхэн нөхцөлийг ухааран ойлгохгүйгээр цаашдын зөв бодлого, үзэл баримтлал, үйл ажиллагаа ончтой явагдаж чадахгүй нь хэн бүхэнд тодорхой юм.

Нэрт түүхч Л.Дэндэв, Магсар хурц, Хэрээд Л.Жамсран, Ц.Пунцагноров, Ш.Сандаг нараас эхтэй 1911 оны үндэсний тусгаар тогтнолын түүхийн судалгаань өдгөө шинэ цагийн онол, аргазүйн хандлагаар баяжин хөгжсөөр О.Батсайхан, Ж.Урангуа, Ц.Батбаяр, Т.Төмөрхүлэг, Р.Болд тэргүүтэй эрдэмтэдөөрсдийн олон бүтээлд ХХ зуунд хөрш болон гуравдагч орнуудаас Монгол Улсын тусгаар тогтнолд үзүүлсэн түүхэн нөлөөлөл, хүчин зүйлийг тодруулан судалж дүгнэлт өгсөн байна.

Социализм байгуулалтын жилүүдэд цаг үеийн шаардлагаар эл асуудлын мөн чанарыг бүрэн утгаар судлах, олон нийтэд хүргэх байдал хязгаарлагдаж байсныг бид мэднэ. Гэвч энэ бол зөвхөн Монгол оронд байсан “зовлон” биш ээ. Дэлхийн социалист системийн орнууд бүгд л энэ замыг туулсан юм. 1960-1970-аад оны эхээр манай түүхчдийн дундаас орон судлаач, олон улсын харилцаа судлалын үндэсний боловсон хүчин анх бэлтгэн тусгайлсан мэргэжлийн байгууллагыг бий болгожээ.

Ирэх 2018 онд манай ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн хамт олон энэхүү түүхт үйл явдлын хагас зуун жилийн ойг ёслол тэмдэглэхээр бэлтгэж буйгаа Та бүхэнд энэ өдөр хүндэтгэлтэйгээр дуулгахдаа таатай байна.

Монгол Улсад 1990-ээд оноос өрнөсөн ардчилал, чөлөөт зах зээлийн харилцааны үйл явц амжилтад хүрч, тус улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа батлан гаргаснаар Монгол Улсын гадаад харилцаа нэн шинэ агуулгаар баяжин хөгжих замд орж, нээлттэй, олон тулгуурт, эрх тэгш гадаад бодлогыг явуулах болсон билээ. Өөрөөр хэлбэл, 1911, 1921 оны үндэсний хувьсгалаар дэвшүүлэн тавьж, он цагийн ээдрээ нугачаанд сарнин замхарч, түүхийн сорилт, шалгуурт шалгагдсан монголчуудын улсын дайтай улс байх язгуур ашиг сонирхол бүрэн утгаараа хэрэгжих үүд хаалга энэ үеэс бидний өмнө нээгдсэн байна.

Гадаад бодлогын дээрх үзэл баримтлал, олон талт харилцааны үр хаялга нь Монголын түүх, орон судлал, олон улсын харилцааны хөгжлийг шинэ шатанд гаргав. Өнөөдөр эрдэмтэн бидэнд гадаад харилцааны олон талт асуудлаар орчин үеийн онол, арга зүйн бодит хандлага, чиглэл бүхий судалгааг явуулах, бодит үнэлэлт дүгнэлт өгөх, гадаадын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай өргөн агуулгаар хамтран ажиллах түүхэн боломж нээлттэй болжээ.

### **Монгол Улсын өнөөгийн гадаад бодлогын “Тулгын гурван чулуу”**

Монгол Улсын хойд хөрш ОХУ нь дэлхийн хамгийн том газар нутагтай, цөмийн зэвсэгтэй сэргэн мандаж буй гүрэн бол, урд хөрш БНХАУ\* дэлхийн хамгийн олон хүн амтай, цөмийн зэвсэгтэй, үсрэнгүй урагшилж буй эдийн засагтай орон болоод байна. Бидний мөнхийн хөрш их гүрнүүд хоёул өөрсдийн бие даасан

---

\*2012 оны 11 дүгээр сард хуралдсан ХКН-ын XVIII их хурал Хятад улсын 100 жилийн ойгоор буюу 2049 онд БНХАУ баян чинээлэг, хүчирхэг, ардчилсан, соёл иргэншил бүхий төгс шинэчлэгдсэн социалист улс болно гэдгийг зарлаж, Хятад улс бол «дэлхий дээрх хамгийн том хөгжиж буй орон» хэмээн дүгнэв.



онцлог бодлого, байр суурьтай юм. Иймд, Монгол Улсыг геополитикийн нэн өвөрмөц байршилтай цорын ганц орон гэж үздэг. Монгол Улсын өнөөгийн хөгжлийн үйл явцад хоёр их хөрш болон гуравдагч орнуудаас үзүүлж буй хүчин зүйлийг бодитоор үнэлэх үүднээс дараах үйл явдлуудыг та бүхэнд эргэн сануулахыг хүсэж байна.

### Монгол Улс, ОХУ-ын стратегийн түншлэл

Монгол Улс, ОХУ-ын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай 1993 оны 1 дүгээр сарын 20-ны гэрээ, 2000 оны 11 дүгээр сарын 14-ний Улаанбаатарын болон 2006 оны 12 дугаар сарын 8-ны Москвагийн тунхаглалуудын шинэ зууны хоёр улсын харилцааны үндэс болсоор байв.

Хоёр улсын харилцааны түүхэн уламжлал болон шинэ зуун гарсаар байгуулсан харилцаа, хамтын ажиллагааны дээрх баримт бичгүүдэд үндэслэн хоёр улс 2009 оноос Стратегийн түншлэлийг хөгжүүлж эхэлснээр Монгол Улстай стратегийн түншлэлийн харилцааг хамгийн анх тогтоосон орон ОХУ болсон билээ.

Монгол, Оросын харилцаа сүүлийн жилүүдэд идэвхжиж, зөвхөн өндөр, дээд түвшний уулзалт төдийгүй яам, газар, төрийн бус байгууллага, иргэд хоорондын харилцаа мэдэгдэхүйц нэмэгдэж байна. Гэвч Монгол, Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа улс төрийн харилцааны түвшинг гүйцэхгүй хэвээр байна. Хоёр орны худалдааны хэмжээ нэмэгдэхгүй, худалдааны бүтцэд дорвитой өөрчлөлт ороогүй байна. Иймд цаашид Монгол Улсын бараа, бүтээгдэхүүнийг ОХУ-д экспортлох таатай нөхцөлийг бүрдүүлэх, нэн ялангуяа манай хөдөө аж ахуйн гаралтай барааг хил залгаа Оросын мужуудад нийлүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллах шаардлагатай болсоор байна.

В.Путин 2012 оны 3 дугаар сард ОХУ-ын Ерөнхийлөгчөөр 3 дахь удаагаа сонгогдсоны дараа гадаад анхны айлчлалаа мөн оны 6 дугаар сард БНХАУ-аас эхэлж, хоёр орны бүх талыг хамарсан стратегийн түншлэл (*Россия и Китай выйдут на новый уровень отношений-уровень всеобъемлющего стратегического партнерства*)-ийг шинэ түвшинд хүргэх тухай “Бээжингийн Тунхаглал”-д гарын үсэг зурсан. Энэ нь Монгол Улстай байгуулсан “Хамтарсан Тунхаглал”-ын үзэл санаатай ижил утгатай юм. Хоёр их гүрний бүх талын түншлэл, хөгжлийн хамтын ажиллагаанаас бид ухарч холдох биш, харин ч санаачлагатайгаар хамтран ажиллах нь чухал болж байна.

ОХУ, БНХАУ-ыг холбосон хурдны автозам барих, хил орчмын худалдааны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хил дамнасан худалдааны чөлөөт бүс байгуулах зэрэг асуудлаар ОХУ-тай явуулсаар ирсэн яриа хэлэлцээний агуулга, цар хүрээг улам бүр нэмэгдүүлэх шаардлагатай.

Монгол, Оросын худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимжүүлэх хүрээнд манай хоёр улс 2016 оны 4 дүгээр сард ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавров Монгол Улсад айлчлах үеэр “Монгол-Оросын Стратегийн түншлэлийг хөгжүүлэх Дунд хугацааны хөтөлбөр”-т гарын үсэг зурсан нь ихээхэн ач холбогдолтой үйл явдал болсон. Өнөөдөр бид энэхүү хөтөлбөрийн агуулгыг Монгол Улсын БНХАУ-тай байгуулсан Стратегийн иж бүрэн түншлэл байгуулах хөтөлбөртэй харьцуулан судлах ялгаатай болон ижил төстэй талыг нь авч үзэх нь ач холбогдолтой гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2017 оны 9 дүгээр сард ОХУ-д ажлын айлчлал хийж, Владивосток хотноо болсон Дорнын эдийн засгийн чуулга уулзалтад оролцох үеэрээ ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинтай уулзаж, хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааг улам бүр идэвхжүүлж, харилцааг шинэ түвшинд гаргах хүсэлтээ илэрхийлэн тодорхой ажил хэрэгч саналуудыг гаргасан. Тухайлбал, ОХУ, Япон улстай хамтарсан аж ахуйн нэгж байгуулж, Тавантолгойн сайн чанарын коксжих нүүрсийг дэлхийн зах зээлд гаргах зорилгоор ОХУ-ын Алс Дорнодын бүс нутаг дахь боомтын хүчин чадлыг ашиглан ажиллах саналыг тавьсан юм.

#### Монгол Улс ба БНХАУ-ын стратегийн түншлэл

2011 оны 6 дугаар сард Монгол Улс, БНХАУ-ын харилцааны цаашдын чиг хандлагыг *стратегийн түншлэлийн харилцаанд тулгуурлан хөгжүүлэхээр* шийдвэрлэсэн Бээжингийн “Хамтарсан Тунхаглал”-ыг, 2013 оны 10 дугаар сарын 25-нд Улаанбаатар хотноо хоёр улсын Ерөнхий сайд нарын гарын үсэг зурсан «Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр» нь өнөөгийн хамтын ажиллагааны газрын зураг болж байгаа юм.<sup>38</sup> 2014 оны 8 дугаар сард хоёр улсын төрийн тэргүүнүүд өргөтгөсөн хэлэлцээ хийж, Монгол, Хятадын харилцааг *Иж бүрэн түншлэлийн*

---

<sup>38</sup> Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр, Улаанбаатар, 2013.10.25.

*стратегийн харилцаанд хүрсэн хэмээн дүгнэснээр уг харилцааг хөгжүүлэх тунхаглалд гарын үсэг зуржээ.*<sup>39</sup>

Талууд Монгол, Хятадын харилцааны өндөр түвшинд хөгжиж буй таатай үндэс суурь болон бодит шаардлагад үндэслэн, хоёр улс, хоёр ард түмний нийтлэг эрх ашигт нийцсэн стратегийн түншлэлийн харилцааг улам бүр гүнзгийрүүлэх хамтын хүсэл эрмэлзлийн дагуу “мөнхөд итгэлтэй, хариуцлагатай сайн хөрш, сайн түнш, сайн нөхөр байх”-ын тулд Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны түвшинг дээшлүүлэн Монгол, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоохоор санал нэгтэй байгаагаа илэрхийлсэн.

Монгол Улс, БНХАУ-ын талууд хоёр улсын өндөр, дээд түвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалж, олон улсын арга хэмжээний үеэр уулздаг уламжлалыг үргэлжлүүлж, бусад арга хэлбэрийг ашиглан стратегийн хэлхээ холбоогоо улам бэхжүүлэхийн зэрэгцээгээр НҮБ, АСЕМ, Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурал, АСЕАН-ы Бүс нутгийн чуулга, ШХАБ, “Их Түмэн санаачилга” зэрэг олон талт байгууллага болон хамтын ажиллагааны механизмын хүрээн дэх уялдаа, зохицуулалтаа цаашид бататгахаар тохиролцоод байна.<sup>40</sup>

2016 оноос Монгол Улс, БНХАУ-ын харилцаа, хамтын ажиллагаа уул уурхай, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагааны зэрэгцээ хөдөө аж ахуй, барилгын салбарт голлон чиглэгдэх байна. Монгол Улс БНХАУ-ын талаас дэвшүүлсэн Нэг бүс, нэг зам хэмээх XXI зууны шинэ “Торгоны зам”-ын санаачилгын хүрээнд Хятад, Монгол, Оросын эдийн засгийн дамжуулан өнгөрүүлэх бүс байгуулах саналыг дэмжин хамтран ажиллахаа 2017 онд илэрхийлээд байна.

#### Монгол Улс ба Гуравдагч хөрш орнуудын түншлэл

Хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй орны хувьд гуравдагч хөршийн бодлого нь гайхмаар үзэгдэл биш юм. Түүхэн үйл явцыг эргэн харвал монголчууд ХХ зууны эхэн үеэс гуравдагч хөршийг ямагт эрмэлзсээр иржээ. Гэвч энэхүү эрмэлзэл, үзэл санаа нь олон улсын байдал, гадаад, дотоод нөхцөл байдлаас шалтгаалан нэгэн үе бүдгэрэн буурч, бас нэгэн үед асаж сэргэж байсан түүхтэй.

---

<sup>39</sup>Монгол Улс, БНХАУ-ын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан Тунхаглал, Улаанбаатар, 2014.08.21.

<sup>40</sup>Монгол Улсын гадаад бодлогын Хөх ном-2016, Монгол Улсын Гадаад харилцааны яам, Улаанбаатар, 2017, 13 дугаар тал.

Гуравдагч хөршийн бодлого бол улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт өндөр хөгжилтэй ардчилсан орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой цогц ойлголт гэж тодорхойлдог. Өнөөдөр гуравдагч хөршийн бодлого нь “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” зэрэг тулгуур бичиг баримт бичгүүдэд болон “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Гадаад бодлогыг эдийн засагжуулах хөтөлбөр”-т тусгалаа олоод байна. Энд онцлон тэмдэглэхэд, Монгол Улс хөрш орнуудтайгаа найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлснээр “Гуравдагч хөрш”-ийн бодлогоо хэрэгжүүлэх үүд хаалга нээгдэх юм. Өөрөөр хэлбэл, Гуравдагч хөршийн бодлого бол ОХУ болон БНХАУ-тай харилцах харилцаатай холбогдол бүхий цогц асуудал болно.

Монгол Улс өөрийн хүрээлэн буй геополитикийн орчинд хөрш орнуудаас гадна гуравдагч орнуудтай түншлэлийн харилцааны эрхзүйн үндсийг бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна. Монгол Улс 1997 онд Японтой *«Иж бүрэн түншлэл»*, 2010 онд *«Стратегийн түншлэл»*, 1999 онд БНСУ-тай *«Харилцан нөхсөн хамтын ажиллагаа, хөгжлийн түншлэл»*, 2006 онд *«Сайн хөршийн найрамдал, хамтын ажиллагааны түншлэл»*, 2011 онд *«Иж бүрэн түншлэл»*, 2004, 2005 онд АНУ-тай *«Стратегийн түншлэл»*, 2004 онд Канадтай *«Өргөн хүрээтэй түншлэл»*, 2005 онд Түрк улстай *«Иж бүрэн түншлэл»*, 2007 онд Австрали улстай *«Өргөтгөсөн түншлэл»*, 2007 онд Казахстантай *«Өргөн хүрээтэй түншлэл»*, 2008 онд ХБНГУ-тай *«Иж бүрэн түншлэл»*, 2009 онд Энэтхэгтэй *«Иж бүрэн түншлэл»*, 2011 онд Украинтай *«Олон талтай хамтын ажиллагааны түншлэл»*, 2013 онд ЕХ-той *«Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр»*-ийн харилцааны эрхзүйн баримт бичгүүдийг тус тус байгуулжээ.

Түншлэлийн харилцаа нь хамтын ажиллагааны ямар нэг хатуу тогтсон үзэл сурталд тулгуурладаггүй, харин улс орнуудын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох, тэгш эрхтэй, харилцан ашигтай, хөгжлийн нийтлэг эрх ашиг, сонирхлыг тэргүүн зэрэгт тавих, улс бүрийн ялгаатай соёл иргэншил, амьдралын ёс жаягийг ойлгон хүндэтгэх, зөвшлийн үндсэн дээр шийдвэр гаргана гэж үйл ажиллагаандаа баримтлах зарчмаа тодорхойлж байна. Тиймээс түншлэл нь «гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээнд “иж бүрэн” байж болно, “стратегийн” байж болно, “олон талтай”, эсвэл “өргөн хүрээтэй” байж болох ба “оюун санааны” түншлэл ч байж болох юм.

Өнөөдөр “Гуравдагч хөрш”-бодлогын хүрээнд Өрнө, Дорнын орнуудын Монгол Улстай эдийн засгийн талаар хамтран ажиллах бодит нөхцөл, сонирхлыг буй болгох асуудал тодорхой сорилтуудтай тулгарсаар байна. Монгол Улс Өрнө, Дорнын улсуудтай харилцахдаа анхнаасаа харилцаагаа тасралтгүй жигд хөгжүүлж чадвал “Гуравдагч хөрш”-ийн бодлого амжилттай хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

Үүнээс гадна “Гуравдагч хөрш”-ийн бодлого амжилттай хэрэгжих гол үндэс бол Монгол Улс, хоёр хөрш болон “гуравдагч хөрш” хэмээх тулгын гурван чулууны тэнцвэрийг хангах явдал мөн. Ялангуяа “Гуравдагч хөрш” орнуудтай хөгжүүлэх эдийн засгийн бодит харилцаа, хамтын ажиллагаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах гол хүчин зүйлийн нэг болно. Монгол улс өнөөдөр хүн ам, зах зээлийн багтаамж багатай, аж үйлдвэржүүлэлт хөгжөөгүй байгаа нь “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэхэд хүндрэл болж байна. Учир нь “Гуравдагч хөрш” орнуудаас өнөөдөр манай улстай аль салбарт хамтарч ажиллахаа тодорхойлж мэддэггүй нөхцөл байдал үүсдэг болоод уджээ.

Харин сүүлийн жилүүдэд Монгол улсад эрдэс баялаг, эрчим хүчний түүхий эдийн ихээхэн нөөц илэрсэнтэй холбоотойгоор манай хоёр хөрш болон “гуравдагч хөрш” орнууд уул уурхайн салбарт анхаарлаа хандуулж эхлээд байна. Ингэснээр эдийн засгийг солонгоруулах буюу олон төрөлтэй болгох нь дээрх бодлогын нэг чухал үндэс болох учиртай. Ингэснээр “гуравдагч хөрш” орнуудтай ганц чиглэлд бус олон чиглэлд харилцан ашигтай хамтран ажиллах боломж нээгдэх юм. Монгол улсын Гуравдагч хөршийн бодлогын талаар хоёр хөрш ОХУ, БНХАУ-аас улсаас албан ёсоор эсэргүүцэж байр сууриа илэрхийлсэн тохиолдол үгүй ч мөн эсрэгээрээ энэхүү бодлогыг сайшаасан, дэмжсэн үйлдэл ч гаргаагүй байна. Харин хөрш орнуудын стратеги, геополитик судалдаг эрдэмтдийн хувьд янз бүрийн сөрөг гэмээр санал дүгнэлт гаргасан нь бий. Гэвч үнэн хэрэгтээ өнөөдөр Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал хоёр хөршөөс ихээхэн хамааралтай хэвээр байна. “Гуравдагч хөрш” орнууд”-аас ирэх нөлөөлөл энэхүү хамаарлыг сааруулж чадаагүй байна. Энэ байдал нь эцэстээ “Гуравдагч хөрш” орнуудаас гэхээсээ илүүтэй манай улс дахь дотоодын улс төрийн тогтворгүй байдал, бодлогын уялдаа холбоо, залгамж чанар, хууль-эрхзүйн орчин, эдийн засгийн чадамж, дан ганц уул уурхайг шүтсэн эдийн засгийн явцуу байдалтай холбоотой болж байна.

Өнөөдөр манай улсад эдийн засаг, аюулгүй байдал, хөгжлийн баталгааг хангах гуравдагч хөршийн бодлого хэрэгтэй байсаар байна. Энэ асуудлыг Монгол Улс цаашид ч дэвшүүлэн тавих болно. Учир нь манай “Гуравдагч хөрш”-ийн бодлого бол найрамдалт харилцаатай мөнхийн хоёр хөрш улсынхаа эсрэг чиглэсэн бодлого биш, харин Монгол улсын нэр нөлөөг олон улсад даацтай хүргэх, бүс нутгийн ардчилал, энх тайван, тогтвортой байдал, эдийн засгийн интеграцид идэвхтэй оролцох түншлэлийн бодлого юм.

### **Дүгнэлт**

Монгол Улсын гадаад бодлогын түүхэн нөхцлийг дүгнэн өгүүлэхэд, ХХ зууны Монгол улсын тусгаар тогтнолын түүхэнд хөрш Орос, Хятад гүрнүүд түүхэн нөлөөг үзүүлсэн нь дамжиггүй. Гэвч үүний нэгэн адилаар Монгол Улсаас хөрш Орос, Хятадын ард түмний тусгаар тогтнолын үйл явцад сорилт бэрхшээл тулгарсан үед “сэтгэлийн тус багадахгүй” гэдгээр дэмжин тусалж, хувь нэмрээ оруулж байсан нь түүхэн үнэн юм.

ЗХУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд ноцтой аюул учирсан Дэлхийн II дайны хүнд бэрх жилүүдэд Монголчууд Оросын ард түмэнд “Зовох цагт нөхрийн чанар танигдана” гэдгээр өөрт байгаа боломжоо шавхан тусалж байлаа. 1945 оны Чөлөөлөх дайнд БНМАУ-ын Ардын армийн 80 мянган цэрэг дайчид Өвөр Монгол, Хятадын ард түмнийг Японы түрэмгийллээс чөлөөлөхийн төлөө мөр зэрэгцэн тулалдаж, ялалт байгуулсан түүхтэй. Энэ бүхнээс дүгнэж үзвэл өнгөрсөн зуунд их гүрнүүдээс Монгол Улсын тусгаар тогтнолд зөвхөн нөлөөлж ирсэн бус Монгол Улс ч хоёр их гүрний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, аюулгүй байдлыг бэхжүүлэн хамгаалахад бодит хувь нэмрээ оруулж байсныг мартаж учиргүй юм. Гэвч өнөөдөр Монгол Улсын ХХ зууны түүхэн сургамжийг эргэн харвал бидний өнгөрсөн түүхт бичлэгт номлогдож ирсэн олон үйл явдал огтоос өөр агуулгатай байсныг ч энд дурдах ёстой. Тухайлбал, ДИУ, БНМАУ-ыг хүлээн зөвшөөрсний дараахан ЗХУ, БНМАУ-ыг бүрэн хүлээн зөвшөөрч “Нөхөрлөл ба харилцан туслалцах тухай гэрээ”-г анх удаа байгуулж, Улаанбаатарт суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газраа ЗХУ-ын Элчин сайдын яам болгон өөрчилж байсныг<sup>41</sup> социалист нийгмийн төлөөх жилүүдэд огт дурсдаггүй байлаа.

---

<sup>41</sup>Хэрээд Л.Жамсран, Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт, Улаанбаатар, 1997, 274 дүгээр тал.

Дэлхийн олон улсын харилцааны үйл явцын өрнөл, үзэл суртлаар хөшиглөн тусгаарласан “Хүйтэн дайн”-ы он жилүүдэд Монголын ард түмэн 1911, 1921 оны хувьсгалаар дэвшүүлсэн улс төр, эдийн засгийн бүрэн эрх чөлөөгөө ханган жинхэнэ утгаар бие даан оршин тогтнох язгуур хүсэл зорилгодоо бүрэн хүрч чадаагүй билээ.

Гэвч өнөөдрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдлыг авч үзвэл дээрх дүгнэлт бүрэн утгаар хэрэгжсэн гэж үзэхэд учир дутагдалтай байна. Энэхүү учир дутагдлаа засаж арилгах нь энэ цаг үеийн бүх монголчуудын түүхийн өмнө хүлээх хариуцлага байх ёстой. Бид өнөөдрөөс өнгөрсөн түүхийг хялбаршуулан шүүж, уран гоё үгээр зэмлэн шүүмжлэх хялбархан боловч 1911 оноос хойших 106 жилийн туулсан түүхэн нөхцөл байдал бүрийг ухаалгаар зөв ойлгож байх нь нэн чухал юм.

БНМАУ-ын төлөө амь бие, итгэл, сэтгэл, зүтгэлээ зориулсан өвөг дээдэс, ахмад үеийнхэн маань өөрийн улсаа “бамбай улс”, “дагуул улс”, “жийргэвч улс” гэж хэзээ ч нэрлэж байгаагүй атал тэрхүү түүхэн нөхцөлд амьдарч байгаагүй залуу үеийнхэн сүүлийн жилүүдэд гадны үзэл онолын нөлөөнд автаж, аливаа түүхэн үйл явцын уг мөн чанарыг ухаж ойлгохгүйгээр хөнгөн өнгөцхөнөөр хандах үзэгдэл бага биш болсныг дор бүрнээ бодууштай санагдаж байна.

Монгол Улсын гадаад бодлогын өнөөгийн байдал, хэтийн төлөвийг эргэцүүлэхүйд, 2011 оны 2 дугаар сард шинэчлэн батлагдсан “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-д «ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ»<sup>42</sup> гэж заасан нь 1994 оны Гадаад бодлогын заалтыг дахин нотолсон хэрэг болсон юм.

Монгол Улсаас мөнхийн хөрш ОХУ, БНХАУ-тай гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлж, худалдаа, эдийн засаг, боловсрол, соёлын салбарт бодитоор хамтран ажиллах талаар сүүлийн жилүүдэд эрчимтэй анхаарч байна. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын “Улаанбаатарын уулзалт”-ын санаачилгыг хэрэгжүүлэх талаарх анхны гурван талт дээд уулзалтыг 2014 оны 9 дүгээр сарын 11-нд Тажикстаны нийслэл Душанбе хотноо амжилттай зохион

---

<sup>42</sup> **Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Улаанбаатар, 2011.**

байгуулсан. Хоёр дахь Гурван талт дээд хэмжээний уулзалтыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар 2015 онд ОХУ-ын Уфа хотноо амжилттай зохион байгуулсан. Улмаар 2016 оны 6 дугаар сард Ташкент хотноо Монгол, Орос, Хятадын Ерөнхийлөгч нар гурав дахь удаагаа Дээд хэмжээнд уулзсан билээ. Уулзалтаар Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын “Улаанбаатарын уулзалт”-ын агуулга, зарчмыг хэлэлцэж байх асуудлын тухай Монгол Улсын санаачилгын талаар тийнхүү хэлэлцэж, тодорхой ойлголцол, тохиролцоонд хүрч чадсан нь Монгол Улсын гадаад бодлогын шинэ парадигм болсон юм.

Энэ үеэр Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хооронд “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”, “Зарим нэр төрлийн бараанд хийсэн гаалийн хяналтын дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр”-ийг тус тус байгуулжээ. Мөн энэхүү дээд хэмжээний уулзалтын хүрээнд 2016 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Москва хотноо Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэр гүйцэтгэх тухай Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Ийнхүү Монгол, Орос, Хятадын төрийн тэргүүн нарын дээрх гурван талт уулзалтын хүрээнд гурван улсыг дамнасан “Эдийн засгийн коридор”-ыг байгуулахаар тохиролцож, манай талаас санаачилсан “Хөгжлийн зам” олон улсын төслийнхөө дагуу бид төмөр зам, автозам, хий болон газрын тос дамжуулах хоолой, цахилгаан дамжуулах шугам, шилэн кабель байгуулахыг хөрш орнуудад санал болгон бодит ажил хэрэг болгох үлдээд байна. Төмөр замын салбарт ОХУ-тай хамтран “Улаанбаатар төмөр зам”-ын хүчин чадлыг нэмэгдүүлж, дамжин өнгөрөх тээврийн томоохон цэг болгох боломжтой бөгөөд баруун, зүүн бүсээр дайрах хоёр шинэ коридорыг байгуулж боломжтой нь харагддаг. Автозамын тухайд 2014 онд анх удаа хатуу хучилтат замаар Орос-Хятадыг Монголын нутгаар холбосон үйл явдал болсон. Баруун бүсийн нутагт, тухайлбал, Баян-Өлгий, Ховд аймгаар дайрсан Орос-Хятадыг холбосон босоо тэнхлэгийн авто замыг 2016 онд ашиглалтад оруулаад байна. Түүнчлэн зүүн бүсийн нутагт босоо тэнхлэгийн авто замыг мөн тавих ёстой.

Цаашид гурван талт хамтын ажиллагааны хүрээнд гурван улсыг дамнасан дэд бүтцийн бүтээн байгуулалт, дамжин өнгөрөх тээвэр, аж үйлдвэрийн хамтын ажиллагаа, худалдааг хөнгөвчлөх, эрчим хүч, аялал жуулчлал, байгаль орчин, боловсрол, соёл, шинжлэх ухаан, техник, хүмүүнлэгийн болон эрүүл мэндийн



салбарт бодит үр өгөөжөө өгсөн төслүүдийг хэрэгжүүлж, үр дүнд хүрэх талаар идэвхтэй хамтран ажиллах шаардлагатай байна.

Гурван талт хамтын ажиллагааны хүрээнд Дээд хэмжээний уулзалт тогтмолжиж, гурван улсыг дамнуулсан эдийн засгийн коридор бий болгохоор тохиролцсон нь Монгол Улс, ОХУ, БНХАУ хамтдаа цаашид эдийн засгийн хөгжилд түлхүү анхаарах болсноо зарласан хэрэг болсон. Эндээс дүгнэхэд өнөөдөр Монгол Улс энэхүү гурамсан харилцааны идэвхтэй оролцогч, нэн таатай холбогч “суваг” болох бүрэн боломж нээгдсэн хэмээн дүгнэж болохоор байна.

Бид мөнхийн хоёр их хөрш ОХУ, БНХАУ-тай стратегийн түншлэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ “Гуравдагч хөрш”-ийн бодлогоо тогтвортой хэрэгжүүлэх чухал юм. Гэвч Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлогын ирээдүйн төлөвийг шинжлэхүйд Монгол улсад гадаад орчны нөлөөллөөс гадна дотоодын экологийн хямрал, нийгэм-эдийн засгийн доройтол, хүн амын ядуурал, авлигал, шинжлэх ухаан-технологийн хоцрогдол илүүтэй бэрхшээл болох магадлалтай байна.

Манай “Гуравдагч хөрш”-ийн бодлогод нийгмийн дотоод тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, сул талуудаа арилгахад гуравдагч түнш орнуудын бодит дэмжлэг, сонирхлыг хандуулах нь чухал байна. Гэвч нэн тэргүүнд Монгол Улсын хувьд хөрш Орос, Хятадын аль нь ч “Гуравдагч хөрш”-өөс илүү чухал ач холбогдолтой байна гэдгийг ямагт санах нь зүйтэй.

Иймд улс орныхоо түүхэн туршлагыг харгалзан ашиг сонирхлын тэнцвэрийг буй болгохыг зорьсон “Гуравдагч хөрш”-ийн бодлогоо амжилтад хүргэх эсэх нь Орос, Хятад улсуудтай харилцаагаа хэрхэн цааш нь тасралтгүй хөгжүүлэхээс ихээхэн хамаарна. Энэ нь бид хоёр хөршийнхөө амин чухал эрх ашгийг хэрхэн харгалзан үзэхээс шалтгаалах болно. Тийм ч учраас Монгол улсын гадаад бодлогыг Монгол улс-Хөрш улсууд-Гуравдагч хөрш орнууд гэсэн гадаад бодлогын тулгын гурван чулуунд ямагт суулган авч явах нь чухал гэдгийг онцлон тэмдэглэж байна.

### **Ашигласан материал**

1. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Улаанбаатар, 2011.
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Улаанбаатар, 2010.
3. Гадаад бодлогыг эдийн засагжуулах хөтөлбөр, Улаанбаатар, 2009.

4. Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр, Улаанбаатар, 2013.10.25.
5. Монгол Улс, БНХАУ-ын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан Тунхаглал, Улаанбаатар, 2014.08.21.
6. Монгол Улсын гадаад бодлогын Хөх ном-2016, Монгол Улсын Гадаад харилцааны яам, Улаанбаатар, 2017, 13 дугаар тал.
7. Их гүрнүүдийн хүрээлэлд орших улсын бодлого: Монгол улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого, Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, Улаанбаатар, Мөнхийн үсэг, 2011, 173 тал.
8. Монгол Улсын байнга төвийг сахих статус: Сорилт ба боломж эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, МУИС-ийн ОУХНУ Сургууль, Улаанбаатар, 2016.
9. Хэрээд Л.Жамсран, Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт, Улаанбаатар, 1997.
10. Ж.Баясах, Монгол Улс ба Хөрш орны гадаад бодлого, Улаанбаатар, 2015.
11. Р.Болд, Геополитик ба Монгол, Нээлттэй лекц, Улаанбаатар, 2017, 31 тал.
12. Л.Хангай, Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагаа, Улаанбаатар, 2016.

# ГОРБАЧЁВЫН “ПЕРЕСТРОЙКА”: МОНГОЛЫН ТАЛААРХИ ЗХУ-ЫН АШИГ СОНИРХОЛЫН ӨӨРЧЛӨЛТ\*

Д.Алтай

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор

## **Perestroika of Gorbachev: Russia’s consideration for Mongolia’s Interests during the period**

***Abstract** The author analyzes some issues concerning “the Perestroika”, the collapse of the Soviet Union and communist bloc during the 1985-1991. This period with regard to the shift of Mongolian society specifically on foreign policy issues are presented in this paper. In which during this time Mongolia began to defend its own national interest in relationship with other countries, such as the former Soviet Union.*

### **Нэг. “Перестройка”-ийн үед ЗХУ-ын дотоод, гадаад бодлогод гарсан өөрчлөлт**

1985 оны 3 дугаар сард ЗХУКН-ын ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдсон М.С.Горбачёв тус намын Төв Хорооны бүгд хурал дээр шинэчлэлийн стратегийг танилцуулахдаа “хурдасгал” (ускорение) гэдэг үгийг хэрэглэсэн байдаг. Үйлдвэрлэлийн хэрэгслийн хөгжил, нийгмийн хүрээ, намын байгууллагуудын үйл ажиллагаа, хамгийн гол нь шинжлэх ухаан техникийн дэвшил зэрэг бүх зүйлийг “хурдасгах” ёстой гэж тэрээр үзэв. Эхэндээ Горбачёвын үзэл санаа социалист үзэл баримтлалын хүрээнд томъёологдож байжээ. Тиймээс ч 1987 онд “Өөрчлөн байгуулалтын зорилго бол социализмын ленинч үзэл баримтлалыг онол, практикийн хувьд бүрэн сэргээх явдал мөн”<sup>43</sup> гэж хэлж байсан удаатай. Зөвлөлт нийгмийн хувьд Горбачёвын “ил тод байдал”, “улс төрийн шинэ сэтгэлгээ” нь эрс шинэчлэгч, содон соргог үзэл санаа байв. Судлаачид Горбачёвын шинэтгэлийг

---

\* Монгол Улсын гадаад харилцаа: түүх, орчин үе өгүүллийн эмхэтгэл, УБ, Соёмбо принтинг, 2018, 301-314-р тал.

<sup>43</sup> М.С.Горбачёв “Октябрь өөрчлөн байгуулалт: хувьсгал үргэлжилж байна”.1987.11.02.,УХГ, Улаанбаатар, 1987, 33 дахь тал.

хоёр үе шаттай өрнөсөн хэмээн үздэг. Эхэндээ Коммунист намын чиг шугамыг аядуу шүүмжилж, улс орон хямралын өмнөх байдалд байгаа гэж үзсэн. Тиймээс ч нийгэм-эдийн засгийн хөгжлийг “хурдасгахын” тулд үйлдвэрлэлийн ба гүйцэтгэлийн сахилга батыг дээшлүүлэх, намын байгууллага, боловсон хүчинтэй ажиллах явдлыг эрс сайжруулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд улсаас хатуу хяналт тогтоох болон, архидан согтуурахтай тэмцэх зорилтуудыг дэвшүүлсэн байдаг. Харин 1987 оны сүүлчээр Горбачёв шинэчлэлийн шинэ стратегид шилжсэн билээ. Гол анхаарлаа улс төрийн ардчилалд төвлөрүүлж, засгийн эрхээс хуучинсаг үзэлтнийг зайлуулах, захиран тушаах тоталитари системийг халж, эдийн засаг ба нийгмийн чадавхийг сэргээх үүрэг бүхий нэг ёсны “ардчилсан социализмын Зөвлөлт загварыг боловсруулахыг зорив. Энэ чиглэлд хийсэн нэг ажил нь бүх шатны Зөвлөлүүдийн депутатуудыг өрсөлдөөний зарчмаар, олон нэр дэвшигчийг өрсөлдүүлэн сонгуулийг зохион байгуулсан явдал байв. Эдийн засгийн шинэчлэлийн чиглэлд аж ахуйн тооцоот таваар зах зээлийн социализмыг нэвтрүүлэх оролдлого хийсэн юм. Гэвч шинэ санаачлагагууд хэрэгжих явцдаа огт өөр үр дүн авчирсан билээ. Эдийн засгийн шинэчлэл амжилтгүй болж, харин улс төрийн ардчилал цэцэглэн хөгжиж, Горбачёвт захирагдахааргүй эрч хүчээ авав. Ил тод байдал нь олон ургальч үзлийг хөгжүүлэн олон намын системийг бүрэлдүүлж эхэлсэн ба иргэний нийгмийн үндэс суурь бий болох, засаглалын хуваарилалтыг шинэчлэх үйл явц болон өрнөв. Ил тод байдлыг өрнүүлснээр Зөвлөлт нийгэмд улс төрийн ардчилал эрчимтэй хөгжив. Шинэчлэлийн хоёр дахь шатанд ЗХУ-д байгуулсан социализмын загвар нь “гажуудсаныг” арга буюу хүлээн зөвшөөрч, ардчиллыг бүх талаар хөгжүүлж, “хүнлэг социализмыг” байгуулах зорилтыг дэвшүүлсэн юм. Нийгмийн удирдлагын бүх хүрээнд ардчиллыг хөгжүүлснээр захиран тушаах тоталитар системийг халж, өрсөлдөөнийг өрнүүлэн нийгмийн динамик хөгжлийн механизмуудыг бүрдүүлнэ гэж Горбачёв үзжээ.

Улс төрийн хүрээнд Горбачёвын хийсэн нөгөө нэг ажил нь ЗХУКН-ын XIX бага хурал (1988 оны 6 дугаар сар) байв. Энэ хурлаас улс төрийн чухал шийдвэрийг гаргасан ба үүнд: иргэний нийгэм, эрх зүйт төрийн тухай, аж ахуй төрийн байгууллагыг удирдах үүргээс намын байгууллагуудыг чөлөөлөх, Зөвлөлүүдийн үйл ажиллагаанд парламентат ёсыг сэргээх, Бүгд Найрамдах Улсууд, автономит байгууллагуудын эрх мэдлийг нэмэгдүүлж, төв ба орон нутгийн эрх мэдлийг нарийвчлан тогтоож, үндэстэн хоорондын харилцааг шинэчлэх зэрэг юм.

Гэсэн ч Горбачёвын хэлж ярьсан зорилтууд бодит ажил хэрэг болж, үр дүнгээ харуулж чадаагүй юм. 1988 онд эдийн засгийн төлөвлөгөөт үзүүлэлтүүд тасарч, хүнсний ба өргөн хэрэглээний барааны хомсдол нүүрлэв. Улс төрийн байдал ч түвэгтэй болж, Горбачёвын нэр хүнд унаж эхлэв. Үндэсний радикал ба улс төрийн радикал гэсэн хоёр 2 урсгал төлөвшиж, эхнийх нь БНУ-ын эрх мэдлийг нэмэгдүүлэх, ЗХУ-ын холбоог шинэчлэхийг шаардаж байсан бол нөгөө нь эдийн засгийн ба бусад шинэчлэлийг гүнзгийрүүлэхийг онцолж байв. Энэ хоёр урсгалын шаардлагууд ихэнх тохиолдолд давхцаж байв. Тухайлбал: хувийн өмч, улс төрийн олон ургальч үзэл, олон намын систем зэргийг адилхан хүлээн зөвшөөрч байв.

1989 оны 5 дугаар сарын 25-ны өдөр ажлаа эхэлсэн ЗХУ-ын Ардын депутатуудын анхдугаар их хурлын явцад шинэчлэгчид, хуучныг санагалзагчид, төвийг сахигч нарын хооронд зөрчил хурцдаж, ЗХУКН-ын улс төрийн монополи эрх, өмчийн олон хэлбэрийн холимог эдийн засгийг хүлээн зөвшөөрөх, удирдах албан тушаалтны эрх дархыг цуцлах асуудлаар байр суурь зөрчилдөв. 1990 оны эхээр Горбачёв шинэчлэгч радикалуудын шаардлагыг хүлээн зөвшөөрч, хариуд нь ЗХУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаалыг бий болгов. Энэ нь түүний хүсэл сонирхолтой нийцэж байв. 1990 оны 3 дугаар сард хуралдаж эхэлсэн ЗХУ-ын Ардын депутатуудын III их хурал Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд байсан ЗХУКН-ын онцгой эрхийн тухай заалтыг хасаж, 60-аас доош хувийн саналаар Горбачёвыг ЗСБНХУ-ын Ерөнхийлөгчөөр сонгосон билээ. Нэр хүнд нь олон түмний дунд унасныг мэдэрсэн тэрээр бүх ард түмний сонгуулиар бус, харин депутатуудаар өөрийгөө ийнхүү сонгуулжээ.

Энэ үеэс радикал үзэлтнүүд улс төрийн шинэ намыг байгуулж, 1990 оны эхний хагаст коммунизмын эсрэг байр сууринд шилжиж, либерал зарчмуудыг хүлээн зөвшөөрсөн юм. Либерал үзэлтний удирдагч нэрт эрдэмтэн А.Д.Сахаров таалал төгсөж, радикал хэсгийн хошуучлагчаар Б.Н.Ельцин тодорсон билээ. 1991 оны 6 дугаар сарын 12-ны өдөр болсон ард түмний ардчилсан сонгуулиар тэрээр 57,3 хувийн санал авч Оросын Холбооны Улсын анхны Ерөнхийлөгчөөр сонгогдов. Өөрчлөн байгуулалтын төгсгөл үйл явцаас энд цухас дурьдахад: Азербайджан, Армян, Гүрж, Литва зэрэг БНУ-ын эдийн засгийн хямрал гүнзгийрч, улс төрийн хямрал болон даамжирсан нөхцөлд Зөвлөлтийн удирдлага БНУ-ын эрх мэдлийг өргөжүүлсэн Холбооны шинэ гэрээг бэлтгэх шийдвэр гаргасан ба 1991 оны 8 дугаар сарын 20-ны өдөр гарын үсэг зурахаар төлөвлөсөн. Гэвч үүнд Зөвлөлтийн хуучинсаг удирдлагын 1991 оны 8 дугаар 19-д төрийн эргэлт хийх оролдлого саад

болсон билээ. Харин энэхүү үйл явц нь Горбачёвыг ЗХУКН-ыг татан буулгах тухай зарлиг гаргах, ЗХУКН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалаас татгалзахад хүргэсэн юм. Ийнхүү ЗСБНХУ-ыг тогтоон барьж байсан коммунист нам-төрийн нэгдмэл удирдлагын бүтэц задран унав. Энэ нөхцөл байдал ЗХУ-ын бутралыг түргэтгэсэн билээ. 1991 оны 12 дугаар 21-ний өдөр “Тусгаар тогтносон улсуудын нөхөрлөл байгуулагдсанаар ЗСБНХУ оршин тогтнохоо” больж Горбачёвын засаглал дуусгавар болов. АНУ-ын “Вашингтон пост” сонинд Горбачёвын засаглалын бодлогын үр дүнг дараахи тоогоор илэрхийлжээ. Үүнд: ЗХУ-ын алтны нөөц 1985 онд 2500 тн байсан бол 1991 онд 240 тн хүртэл буурч, улс төрийн хоригдлын тоо 600 байснаа нэг ч үгүй болж, Зөвлөлтийн эдийн засгийн өсөлт 2,3 хувь байснаа хасах 11 хувь хүртэл буурч, гадаад өр 4 дахин нэмэгдэж 52 тэрбум ам.доллар болж, улс төрийн ганц нам (ЗХУКН-ыг хэлж байна) байснаа албан ёсоор бүртгэгдсэн 12 намтай<sup>44</sup> болсон гэж бичжээ. “Горбачёвт өөрчлөн байгуулалтын үзэл санааны тодорхой үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр байхгүй байсны сацуу тодорхой бодит ажил, арга хэмжээгээр өөрчлөн байгуулалт нь бэхжин батжиж чадаагүй. Удирдлагын буруутай үйл ажиллагааны уршгаар тэр нь улс төр-эдийн засгийн хурц хямрал болон хувирч, улмаар эрх мэдлийн төлөө нээлттэй тэмцэл болон даамжирч, төрийн болон нийгмийн байгууллага задран унах үйл явцыг хянах чадвар алдагдаж, үйлдвэрлэл зохион байгуулалтгүй болж, эрх баригч дээд бүлэглэл өөрчлөгдөн, ОХУ бүрэн эрхт байдлаа тунхаглах, ЗСБНХУ сүйрэн унах, шинэ биеэ даасан тусгаар улсууд байгуулагдах үйл явц өрнөсөн”<sup>45</sup> гэж судлаач В.В.Грайворонский 1990-1991 оны түүхэн үйл явцыг дүгнэн бичсэн нь бодитой ажгуу.

Ийнхүү Горбачёвын “перестройка”-ийн үзэл санаа эхэндээ социализмыг боловсронгуй болгох, дараа нь “ардчилсан социализм”, улмаар “хүнлэг энэрэнгүй социализм”-ын агуулгаар өрнөж эцэст нь ил тод байдал, олон ургальч үзэл санааны үр дүнд либерал ардчилсан зарчмыг хүлээн зөвшөөрч, улмаар ЗХУ-ад байгуулсан социалист нийгэм явуургүйг илчлэн нэг намын ноёрхолд суурилсан тоталитари дэглэм задран унахад хүргэсэн байна. ЗХУ-ын бутрал нь сталинч маягийн захиран тушаах-хүнд сурталт, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг бүхий социализмын загвар хөгжих ирээдүйгүйг харуулсан юм. ЗХУ-ын бутран унасан явдал дэлхий

<sup>44</sup>.”XX зууны дэлхийн түүх”. Улсын Багшийн Их Сургууль, Улаанбаатар, 2001, 418 х. 68-69 дахь тал

<sup>45</sup>В.В.Грайворонский “Реформы в социальной сфере современной Монголии”. Москва, ИВ РАН, 2007, с.8

дахины үйл явц, олон улсын харилцаанд гүнзгий нөлөө үзүүлж, эсрэг тэсрэг социалист ба капиталист ертөнцөд хуваагдах байдал төгсөхөд хүргэв. Харин Орос орны шинэчлэлийн гурав дахь үе Ерөнхийлөгч Б.Н.Ельцины удирдлаган дор өрнөв.

М.С.Горбачёвын “перестройка”-ийн үзэл санаа нь ЗХУ-ын гадаад бодлогод олон өөрчлөлт дагуулсан билээ. “Хүйтэн дайны” хурцадмал олон улсын байдлыг зөөлрүүлж, цэргийн зардлыг багасгах арга замыг эрэлхийлэх олон шийдвэр гарсан юм. Тухайлбал, Европ дахь дунд тусгалын Америк, Зөвлөлтийн пуужингуудын “тэглэх хувилбар”, батлан хамгаалах чадавхийн зохимжтой түвшний тухай үзэл баримтлал, 1986 оны 7 дугаар сард Горбачёв Владивосток хотноо хэлсэн үгэндээ Ази, Номхон далайд цөмийн зэвсэг дэлгэрүүлж, нэмэгдүүлэх замд хориг саад тавих тухай, Номхон далайд цэргийн хөлөг онгоцны идэвхжилийг бууруулж, Азид зэвсэгт хүчин, ердийн зэвсэглэлийг хорогдуулах тухай, бүс нутагт итгэлцэх, хүч үл хэрэглэх арга хэмжээг дэмжих зэрэг шинэлэг санаачилгыг дэвшүүлсэн. ЗХУ-ын удирдлага АНУ-тай цөмийн зэвсгээр өрсөлдөн хөөцөлдөж байсан үзэл баримтлалаас татгалзах, дэлхий дахинаа цөмийн зэвсгийг бүрэн хураах, Варшавын Гэрээний байгууллага ба НАТО-г зэрэг татан буулгах санаачилга гаргасан ба 1987 оны 12 дугаар сард АНУ-тай “Дунд ба ойрын тусгалтай пуужинг устгах” тухай гэрээнд гарын үсэг зурсан юм. 1988 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Мальтад болсон Америк, Зөвлөлтийн дээд хэмжээний уулзалтаар М.С.Горбачёв, Дж.Буш нар үүгээр “хүйтэн дайн” төгсгөл болох болно хэмээн анх удаа мэдэгдсэн билээ. Улмаар ЗХУ “хүйтэн дайны” бодлогоос татгалзаж, 1985-1989 онд Афганистанаас цэргээ бүрэн гарган 1988 оны 12 дугаар сарын 6-ны өдөр болсон НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн хуралдаан дээр Зөвлөлтийн армийг цомхотгож, энгийн зэвсгээ хорогдуулж байгаа төлөвлөгөөг танилцуулсан ч хожим Варшавын Гэрээ л татан буугдаж харин НАТО хэвээр үлдсэн билээ.

ЗХУ-ын гадаад бодлого хуучин коммунист блокийн орнуудын хувьд ч эрс өөрчлөгдсөн юм. Эдгээр оронд 80-аад оны дундаас нийгэм-эдийн засгийн тулгамдсан олон асуудал хуримтлагдаж, улмаар хямралт байдлын нөхцөл бүрдсэн билээ. Хямралыг даван туулах арга замыг эрэлхийлэхэд Горбачёвын өөрчлөн байгуулалтын үзэл санаа түлхэц үзүүлсэн хэдий ч хэрэгжүүлэлгүй цаг хугацаа алдсан тал бий. Зарим социалист орны удирдагчид харзсан байдалтай, социализмын алдаа дутагдлыг засаж, сайжруулах боломжтой гэж үзсэн бол нөгөө нэг хэсэг нь эрс шинэчлэлийн чиг шугамыг баримталж байлаа.

Горбачёвын улс төрийн шинэ сэтгэлгээний үзэл санаанд социалист орнуудын хамтын ажиллагаанд өөрчлөлт хийх санал туссан ба эдгээрээс дурьдвал:

- Социалист орнуудын удирдлага улс төрийн хүрээний амьдралд “Нам бүр биеэ даах, өөрийн орны асуудлыг бие даан шийдвэрлэдэг эрхтэй байх, ард түмнийхээ өмнө хариуцлага хүлээдэг байх нь зайлшгүй зарчим”<sup>46</sup> болгож мөрдөхийг Горбачёв онцолсон юм. ЗХУКНам социалист орнуудын эрх баригч намуудад улс төр, эдийн засгийн аливаа шийдвэр гаргахад үзэл суртлын шалтгаанаар нөлөөлөхөөс татгалзах хэрэгтэй гэж тэрээр үзжээ.

- Эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны хувьд гэвэл харилцан ашигтай байх, харилцан туслах зарчмыг мөрдөхийг чухалчилж байв. Шинжлэх ухаан техник, эдийн засгийн дэвшилд буурьтай үсрэлт хийх, ЭЗХТЗ(Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл нь социалист орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааг зохицуулах үүрэгтэй байгууллага байсан ба тэрээр 1962-1991 онд ажилласан)-ийн үйл ажиллагаанд захиргааны арга зонхилж буйг өөрчлөх, элдэв Хороо, Комиссын тоог цөөлөх, эдийн засгийн хөшүүрэг, саначилгыг дэмжих нь зүйтэй гэдгийг Горбачёв онцолж байлаа. ЭЗХТЗ нь үндэстнийг захирах байгууллага биш учраас асуудлыг олонхийн саналаар биш, харин зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэх нь зөв гэж үзжээ.

Эдгээр санал нь тухайн үедээ шинэлэг зүйл байсан ба БНМАУ-ын хувьд ч чухал ач холбогдолтой байв. Учир нь Монгол-Оросын хамтын ажиллагаа, ялангуяа худалдаа-эдийн засгийн харилцааг шинэ өнцгөөс харах боломжийг өгсөн. Ийнхүү социалист орнуудтай ЗХУ-аас харилцаж ирсэн уламжлалт харилцаа хамтын ажиллагааны асуудалд шинэ хандлага гарч эхэлсэн гэж хэлж болно. Хуучин социалист орнуудын хувьд социалист тогтолцооны нийтлэг эрх ашгийг илүүд эрхэмлэж үндэстний эрх ашгийг огоорох тоглоомын дүрэм үйлчилж байлаа. Энэ хамтын ажиллагаанд ЗХУ голлох байр суурьтай байж, “ах дүүгийн харилцаа”, “социалист интернационализмын” далбаан дор үзэл сурталжсан, тэгш бус харилцаа зонхилж байв. Энэ нь дэлхийн хөгжилтэй орнуудаас техник технологийн дэвшлийн хувьд хоцрогдох, эдийн засгийн хөшүүрэг, санаачлагыг боогдуулах, өрсөлдөөн хумигдахад нөлөөлсөн юм. Социалист орнуудад бие даасан тусгаар улсын хувьд үндэстний эрх ашгаа дээдлэн харилцан ашигтай, тэгш худалдаа-

---

<sup>46</sup>М.С.Горбачёв “Өөрчлөн байгуулалт шинэ сэтгэлгээ манай оронд болон дэлхий дахинд”. УХГ, Улаанбаатар, 1988,201-202 дахь тал



эдийн засгийн харилцааг хөгжүүлэх хүсэл эрмэлзлийг төрүүлсэн. Горбачёвын өөрчлөн байгуулалтын үзэл санааг дэмжих хүсэл зориг социалист орнуудын удирдагч нарын хувьд харилцан адилгүй, тэдэнд бэлэн боловсруулсан төлөвлөгөө байхгүй, хувь хүний улс төрийн зориг дутагдах зэрэг хүчин зүйл нөлөөлсөн юм. Гэвч өргөн агуулгаар Горбачёвын улс төрийн шинэ сэтгэлгээ, ил тод байдал нь ЗХУ-ад төдийгүй, социалист орнууд, дэлхий дахинд хүчтэй нөлөөлж, өргөн дэмжлэгийг хүлээсэн билээ.

### **Хоёр. “Перестройка”-ийн үе дэх Монголын талаархи ЗХУ-ын ашиг сонирхлын өөрчлөлт**

#### Цэрэг-улс төрийн ашиг сонирхол

ЗХУ байгуулагдсан цагаас ангич, үзэл сурталжсан шинжтэй гадаад бодлого явуулж байсан ба энэ нь их гүрний үндэстний эрх ашгаас үүдэлтэй байсан нь илэрхий. Хаант Оросын гадаад бодлого нь Зөвлөлт засгийн үед Коммунист намын удирдлаган дор коммунизм, пролетарийн интернационализмын үзэл санааг даян дэлхийд түгээх, Зөвлөлтийн нөлөөг өргөжүүлэх ашиг сонирхлоор солигдов. Их гүрний үндэстний эрх ашиг хэвээр үлдэж, хэлбэр нь өөрчлөгдсөн билээ. Горбачёвын “перестройка” эхэлснээр дэлхий дахины дэг журамд нийцсэн гадаад бодлого явуулах, зарчмуудаа эргэн харах эхлэл тавигдав. Тухайлбал, ЗХУ-ын гадаад бодлогын өөрчлөлтийн нэг чухал чиглэл нь ЗХУ-аас Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай харилцаагаа өргөтгөх явдал байсан ба энэ чиглэлээрхи багц санаачилгыг Горбачёв 1986 онд Владивосток хотноо хэлсэн үгэндээ дэвшүүлэн гаргажээ. Үүнд БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгох асуудал чухал ач холбогдолтой байв. Харин Хятадын талаас зөвлөлт хятадын харилцааг хэвийн болгоход хэд хэдэн болзол тавьж байсны нэг нь Монголын нутаг дэвсгэрээс Зөвлөлтийн цэргийг гаргах асуудал байв.

Зөвлөлтийн цэргийг БНМАУ-ын нутаг дэвсгэрт байрлуулсан цаг хугацаа ЗХУ, БНХАУ-ын хоорондын харилцаа эрс хүйтэрсэн үетэй давхацдаг. ЗХУ “хүйтэн дайны” үед өөрийн цэрэг аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашгийн үүднээс өөрийгөө тойруулсан “жийргэвч” холбоотон орнуудаар хүрээлүүлсэн бодлого явуулж байлаа. Эдгээрт Зүүн Европын социалист орнууд хамаардаг байсан ба тэдгээртэй Варшавын Гэрээний хэлэлцээр байгуулан цэрэг-улс төрийн холбооны үндсэн дээр ЗХУ харилцаж байв. БНМАУ ч “жийргэвч” холбоотон орны үүргийг гүйцэтгэн ЗХУ-ын өмнөт хилийг хамгаалах, Ази тивийн аюулгүй байдлын нэгэн

баталгаа болохын хувьд ЗСБНХУ-тай цэрэг-улс төрийн холбоотны харилцааг тогтоосон юм.

Тухайн үеийн Монгол-Зөвлөлтийн харилцааны эрх зүйн үндсэн баримт бичиг нь 1966 онд байгуулсан “БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд найрамдал, хамтын ажиллагааны болон Харилцан туслах тухай Гэрээ” байсан юм. 1921, 1936, 1946 онд хоёр орны хооронд өмнө байгуулсан Гэрээ, хэлэлцээрийн зарчимд тулгуурласан 1966 оны энэхүү Гэрээ нь БНМАУ, ЗСБНХУ нь улс төр-цэрэг батлан хамгаалах, худалдаа-эдийн засаг, соёл шинжлэх ухаан зэрэг нийгмийн амьдралын олон салбарт идэвхтэй хамтран ажиллах үндсэн чиглэлийг тодорхойлж байлаа. Энэхүү Гэрээ нь үзэл суртлын шинж чанартай, БНМАУ ба ЗХУ-ын харилцаа нь цэрэг улс төрийн холбоотны агуулгатай байсныг маш тодорхой гэрчилдэг баримт бичиг билээ. Тус Гэрээнд БНМАУ-ын нутаг дэвсгэрт Зөвлөлтийн цэргийг байрлуулах заалт тусгагдсан ба тэр нь ЗХУ-ын өмнөт хилийг БНМАУ-аас хамгаалах зорилготой гэжээ. Хэрэв гадны халдлага үйлдэгдвэл ЗСБНХУ нь БНМАУ-ыг хамгаалах үүрэгтэй гэж тус Гэрээнд заасан. Үүнийг “Москвагаас Монгол, Оросын цэрэг-улс төрийн хамтын ажиллагаа нь Варшавын Гэрээний гишүүн орнуудтай тогтоосон харилцаатай нэгэн адил түвшинд авч үзсэн явдал”<sup>47</sup> гэж орос, монголын судлаачид үздэг.

“Хүйтэн дайн” Монгол оронд сөрөг нөлөө үзүүлсэн ба ЗХУ-тай цэрэг-улс төрийн холбоотны харилцаатай байсны хувьд БНМАУ нь батлан хамгаалах салбарт ихээхэн хөрөнгө зарцуулж байв. Үүнд: цэрэгт алба хаах хугацаа 3 жил байсан ба энэ нь улсын төсөвт том дарамт учруулж байлаа. 1988 он гэхэд сая орчим хүн амтай Монгол Улс нь 24500 цэрэг, 200 мянган бэлтгэл цэрэг, офицертой<sup>48</sup> байсан ба энэ нь хөдөлмөрийн чадвартай олон мянган хүнийг бүтээн байгуулалтаас хөндийрүүлж байв. Ингэснээр эдийн засаг, нийгмийн салбар, хөдөлмөр эрхлэлтэд зохих бэрхшээлийг авчирсан.

1960-аад оноос Зөвлөлт-Хятадын харилцаа таагүй болсон ба түүний тусгалаар монгол-хятадын харилцанд ч ан цав гарав. Зөвлөлт-Хятадын харилцааны төлөв байдал нь Монгол-Зөвлөлтийн харилцаанд нөлөөлж ирсэнийг

---

<sup>47</sup>“Современные российско-монгольские отношения модели и сценарии” .БГУ, Улан-Удэ, 2013,с.60

<sup>48</sup> “Монголын улс төрийн гадаад харилцааны түүх (1911-1999)”. Ер.ред. проф. Л.Хайсандай. ШУА, ОУСХ, Улаанбаатар, 2012, 242 дахь тал

Зөвлөлт, Монголын харилцаан дахь “Хятадын хүчин зүйл”<sup>49</sup> гэж судлаачид нэрлэдэг. Урд ба хойд хоёр хөршийн хоорондын харилцаа хүйтэрсэн цаг үед Монгол орон хэнийг нь дагах вэ гэсэн сорилттой тулгарсан. Тухайн үед Монголын удирдагчид улс орны тусгаар тогтнол, нийгэм-эдийн засгийн хөгжлийн ирээдүйг хойд хөрштэй холбож ЗХУ-ыг сонгосон. Зөвлөлт-монголын цэрэг-улс төрийн холбооны мөн чанар, Монгол, ЗХУ-ын нэгдмэл эрх ашгийн талаархи Оросын эрдэмтэдийн байр сууринаас энд иш татвал: доктор С.Г.Лузянин “Монгол улс нь ЗСБНХУ-тай тогтоосон цэрэг-улс төрийн холбоог төр улсынхаа бүрэн эрхт байдлын баталгаа, монголын нийгмийн нийгэм-соёлын шинэчлэлийн хүчин зүйл”<sup>50</sup>тэй холбон үзсэн гэж бичсэн бол доктор Г.С.Яскина “олон улсын тавцанд тухайн улс орнуудын үндэсний эрх ашиг нийцэж байсан тохиолдолд нэг улсынх нь гадаад бодлого нь нөгөө улсаас бүрэн хамааралтай байсан гэж ярих нь хир зохимжтой вэ?”<sup>51</sup> гэсэн сонирхолтой саналыг дэвшүүлжээ. Тухайн цаг үед хоёр том гүрний дунд хавчуулагдсан жижиг Монгол орны хувьд бие даасан, төвийг сахисан гадаад бодлого явуулах боломж хязгаарлагдмал байлаа. Тиймээс ч тусгаар тогтнолын эрх ашиг, ард түмний хүсэл хэрэгцээ зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр дээрхи сонголтыг монголын төр, засгийн удирдлага хийсэн болов уу.

БНМАУ-ын нутаг дэвсгэрээс Зөвлөлтийн цэргийг гаргаж БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгох асуудал 1980-аад оны эхэн үеэс Монгол, Зөвлөлтийн удирдагчдын уулзалт ярианы гол сэдэв байлаа. 1985 онд хоёр орны удирдагчид болох Ж.Батмөнх, М.С.Горбачёв нар хоёр удаа, 1986 онд 3 удаа уулзсан ба энэ нь тухайн цаг үеийн Орос-Монголын харилцаа улс төрийн дээд түвшинд ойр дотно байсныг гэрчилдэг. Ж.Батмөнх 1986 онд МАХН-ын их хуралд үг хэлэхдээ “БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгох”-ыг гадаад бодлогын чухал зорилт гэсэн бол ЗСБНХУ-ын удирдагч М.С.Горбачёв Монголын нутгаас зөвлөлтийн цэргийг гаргана гэж удаа дараа мэдэгдэж, монголын талын эрх ашгийг бодолцож “гуравдах талын эрх ашгийг хохироохгүй” байхыг тэмдэглэж байв.

1989 оны 3 дугаар сарын 16-ны өдөр ТАСС агентлаг ЗХУ-ын БНМАУ-аас цэргээ гаргах тухай шийдвэрийг анх мэдээлжээ. Зөвлөлтийн цэрэг ба

---

<sup>49</sup> Ц.Батбаяр “Монголо-советские отношения в период соперничества между Москвой и Пекином (начало 1950-х годов – 1966 г.) В кн. “Россия и Монголия новый взгляд на историю взаимоотношений в XX веке”. Москва, ИВ РАН, 2001, с.162

<sup>50</sup> “Современные российско-монгольские отношения модели и сценарии”. БГУ, Улан-Удэ, 2013, с.32

<sup>51</sup> Г.С.Яскина “Монголия и внешний мир”. Москва, ИВ РАН, 2002, с. 12

офицеруудын гэр бүлийн хүмүүсийг оролцуулан 100 мянга орчим цэргийн албан хаагчид 1989-1992 онд Монголын нутаг дэвсгэрийг орхин гарсан билээ. 1989 оны 5 дугаар сарын ЗХУ, БНХАУ-ын Хамтарсан мэдэгдэлд Монголоос Оросын цэргийг гаргасан ба Хятадаас Монголыг хамгаалах Зөвлөлтийн “үүргийг” хүчингүй болгов гэжээ. ЗХУ болон БНХАУ нь гуравдагч орны газар нутгийг ашиглан бие биедээ заналхийлэхгүй гэж уг Мэдэгдэлд тохиролцжээ. Энэ нь Монгол орны тусгаар тогтнол, хил хязгаарын бүрэн бүтэн байдлын баталгаа болж, хожим монголын гадаад орчинд эерэг нөлөө үзүүлсэн. Орос, Хятад хоёр орны харилцаа хэвийн болоход саад учруулж байсан асуудал ийнхүү шийдэгдэж, Монгол Улс Зөвлөлтийн цэрэг улс төрийн холбоотны хувиар өөрийн газар нутагт хойд хөршийн цэргийг байлгах “хүйтэн дайны” сөргөлдөөний нөхцөл арилав. Мөн БНМАУ, БНХАУ-ын хоорондын харилцаа хэвийн болж, сайжран хөгжих эхлэл тавигджээ. Энэ нь БНМАУ-аар “жийргэвч” холбоотон улсын үүргийг гүйцэтгүүлж ирсэн ЗХУ-ын цэрэг улс төрийн ашиг сонирхолд гарсан бодитой өөрчлөлт байлаа. Харин ЗХУ ба БНХАУ-ын хоорондын харилцаа хэвийн болж хожим Ази Номхон далайн бүс нутаг, дэлхий дахины олон улсын аюулгүй байдалд тааламжтай нөлөө үзүүлсэн билээ. Горбачёвын улс төрийн шинэ сэтгэлгээ олон улсын харилцаа, бүс нутгийн аюулгүй байдалд эерэг нөлөө үзүүлсэний нэгэн жишээ болов.

Монголын талаархи ЗХУ-ын байр суурь, ашиг сонирхолд гарсан бас нэг өөрчлөлт нь БНМАУ-аас АНУ-тай дипломат харилцаа тогтоох асуудлаар тодорхой илэрсэн бөлгөө. Энэ асуудалд Москва олон жил түдгэлзсэн хариу өгч тусгаар тогтносон БНМАУ-ын хүсэл эрмэлзэлд дарамт үзүүлж байв. Харин 1987 онд М.С.Горбачёв БНМАУ-ыг АНУ-тай дипломат харилцаа тогтоохыг зөвшөөрсөн юм. БНМАУ нь 1961 онд НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсноор олон улсын тавцан дээр Монгол орны нэр хүнд өсөн нэмэгдсэн ба 1950-иад оноос Ази, Европын олон оронтой дипломат харилцаатай болж идэвхтэй гадаад бодлого явуулж байлаа. 1960-аад оны эхээр БНМАУ ИБУИНВУ-тай дипломат харилцаа тогтоосон ба энэ цагаас АНУ-тай дипломат харилцаа тогтоох яриа хэлэлцээг эхлүүлсэн. Гагцхүү ЗХУ-ын нам, төр засгийн удирдлагын зүгээс энэ асуудлыг удаа дараа хойшлуулж байв. Энэ нь Зөвлөлтийн удирдлага Монголын дотоод хэрэгт оролцдог, зааварчилгаа өгдөг, Монголын удирдагчид ч аливаа шийдвэр гаргахдаа Москвагийн “амыг” хардаг байсны илрэл байлаа. ЗХУ нь АНУ-тай сөргөлдөж “хүйтэн дайны” бодлого явуулж байсан тул цэрэг-улс төрийн холбоотон Монгол Улсыг өөрийн “хараа хяналт”-аас гадуур байлгаж, өрсөлдөгчтэйгээ хэвийн

харилцаатай байлгахыг хүсэхгүй байлаа. ЗХУ-ын энэ үеийн шийдвэр гаргагчид, дипломатчид, хувь хүмүүс Монголын АНУ-тай дипломат харилцаа тогтоох гэсэн хүсэл эрмэлзэлд татгалзангуй хариу өгч байсан. Үүнийг гэрчилсэн баримт эдүгээ ил тод болсон. 1990 оноос хойш нээлттэй болсон Монгол Улсын ГХЯ-ны архивын баримтууд, тухайн үед ажиллаж байсан нам төрийн зүтгэлтэн, дипломатчидын дурьдатгал номонд тодорхой тэмдэглэн бичжээ. Монгол Улсын ГХЯ-ны архивын баримт бичгүүдэд ч тодорхой тусгагдсан байдаг. ЗХУ нь Монголыг зөвхөн өөрийн нөлөөнд байлгах ашиг сонирхолд хөтлөгдөн бусад хөгжилтэй барууны орнуудтай Монгол Улсын харилцах явдлыг хааж боох, хязгаарлах бодлогоос ийнхүү Горбачёвын шинэ сэтгэлгээний үр ачаар татгалзсан билээ. Ийнхүү БНМАУ нь 1987 онд АНУ-тай дипломат харилцаа тогтоосон нь Монгол Улсын гадаад бодлого олон чиглэлд өргөжин хөгжихөд чухал түлхэц үзүүлэв.

#### БНМАУ-ын эдийн засгийн талаархи ЗХУ-ын ашиг сонирхол

Монгол орон 1921-1980-аад оны дунд үе хүртэл Зөвлөлт маягийн хөгжлийн загвараар замнан ЗХУ-ын тусламжийн ачаар феодалын үеийн хоцрогдсон ахуй байдлаас орчин цагийн суурин соёл иргэншилд шилжиж, аж үйлдвэр, хот суурин газруудыг байгуулж, шинэ цагийн соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсролын салбарыг үүсгэн хөгжүүлж чадсан юм. Ингэснээр хүн ард эрүүлжиж, соёл боловсролын түвшин ахиж, нийгэм–эдийн засгийн хөгжилд томоохон ахиц гарав. Хөгжлийн энэхүү загвар нь Монгол орныг дэлхийн соёл иргэншилтэй хөл нийлүүлэн алхах үндэс суурь болсноороо чухал ач холбогдолтой байв. ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд нь олон улсын социалист хөдөлмөрийн хуваарь, хожим нь социалист интеграцийн зарчмын үндсэн дээр бие биетэйгээ харилцаж байв. Хөгжлөөр сул дорой орнууд (тухайлбал, Монгол, Вьетнам, Куба Улс)-ын хувьд дотоодын эдийн засгаа төлөвлөн хөгжүүлэх бие даасан бодлого шийдвэр гаргах эрхээ хязгаарлуулсан юм. Монгол нь дотооддоо хөдөө аж ахуй, уул уурхайн чиглэлд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх үүргийг ЭЗХТЗ-ийн гишүүн орны хувьд хүлээж, бусад гишүүн орнуудыг тухайн салбарын бүтээгдэхүүнээр хангах, өөрийн бүтээгдэхүүнээ хямд үнээр тэдэнд нийлүүлдэг байлаа. ЭЗХТЗ-д голлох үүрэгтэй ЗХУ нь Монголын ашигт малтмалд дулдуйдан манай орны үндэсний эрх ашиг, сонирхлыг үл харгалзсан бодлогыг явуулж эхлэв. Социализмын материал техникийн бааз байгуулах зорилтоор халхавчлан өөрийн улсад ашигтай эдийн засгийн бүтээн байгуулалтыг Монголд өрнүүлэв. Үүнд Монгол-Зөвлөлтийн хамтарсан үйлдвэр болох зэс-молибдений “Эрдэнэт” үйлдвэр, Бор-Өндөрийн

хайлуур жоншны үйлдвэр, Дорнодын Мардайн уран олборлолтын үйлдвэр зэргийг нэрлэж болно. Тэдгээрийг барьж байгуулахад хөрөнгө оруулалт хийж, өр зээлэнд нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн доод үнээр худалдан авч байлаа. Энэ нь хожмоо хоёр орны худалдаа-эдийн засгийн харилцаанд тэгш бус байдлыг бий болгосон. Монгол-Зөвлөлтийн цэрэг улс төрийн холбоо нь Зөвлөлтийн ашиг сонирхолд нийцсэн худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг өргөн агуулгаар тэтгэж байлаа. Өөрчлөн байгуулалтын үед Монголын талаархи ашиг сонирхолд өөрчлөлт ажиглагдмагц хоёр орны хооронд байгуулсан Гэрээ, хэлэлцээрийг Зөвлөлтийн талаас биелүүлэхгүй явдал гарч эхлэв. Хэдийгээр улс төрийн хүрээнд хоёр орны удирдагчид 1984-1990 онд ойр ойрхон уулзалдаж хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байсан хэдий ч ам ажил хоёр зөрөх явдал гарч байсан. Зөвлөлтийн тал Монголын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг бараг 100 хувь хангаж байсан атлаа 1987-1988 онд түүний нийлүүлэлтийг цаг хугацаанаас нь хоцроох, экспортын бараа таваар үүнд, хүнс болон хүн амын өргөн хэрэгцээний бараа, аж үйлдвэрийн салбарт шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, түүхий эдийг Монголд нийлүүлэх амлалт үүргээ хэрэгжүүлэхгүй тасалдуулж байв. Түүнчлэн хоёр талын Засгийн газрын хэлэлцээрээр тохиролцсон хивс, нэхмэл, арьс, үслэг эдлэлийн бүтээгдэхүүн, мал аж ахуйн бараа таваарыг Монголоос худалдан авахаа зогсоов. Монголын экспорт Зөвлөлтийн зах зээлд голчлон чиглэгдэж байсан тул энэ нь монголын эдийн засагт хүнд цохилт болсон. Энэ үеийн Монгол-Зөвлөлтийн худалдаа-эдийн засгийн харилцааны мөн чанарыг авч үзвэл: монголын түүхий эдийг дэлхийн зах зээлийн үнээс 40-50 хувиар<sup>52</sup> бага үнээр ЗХУ-д гаргаж байв. 1988 оны байдлаар манай улсын худалдааны эргэлтэд социалист орнууд 96,6 хувь, түүний дотор ЗХУ 81.8 хувь, харин хөгжингүй капиталист орнууд дөнгөж 3,3<sup>53</sup> хувийг эзэлж байв. Энэ үед ЗХУ-аас БНМАУ-ын авч ашигласан зээл нь хожим 1990-ээд оны дунд үеэс Монгол, Орос хоёр орны харилцааг шинэ зарчмаар хөгжүүлэхэд “их өрийн” тухай эмзэг асуудал болон хувирсан билээр. 1990 оны байдлаар Зөвлөлтөд төлөх өрийн хэмжээ манай нэг хүн тутамд 5000 гаруй шилжих

<sup>52</sup> "Монголын улс төрийн гадаад харилцааны түүх (1911-1999 он)." Ер. ред. Проф.Л.Хайсандай.ШУА, ОУСХ, Улаанбаатар, 2012, 242 дэх тал

<sup>53</sup> "Монгол Улсын түүх. Тавдугаар боть (XX зуун)".ред проф.Ж.Болдбаатар, проф,М.Санждорж, акад. Б.Ширэндэв. Улаанбаатар, 2003, 326 дахь тал

рубль<sup>54</sup> оногдохоор тооцоо гарчээ.1949-1990 онд ЗХУ-аас Монгол Улсад олгосон нийт зээлийн 80 гаруй хувь<sup>55</sup> нь 1975-1990 онуудад ногдож байлаа. Зээл нь хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн бүтцийг сайжруулахад зарцуулагдсангүй, харин түүний 1/3 орчим хувь нь гадаад худалдааны бараа гүйлгээнд зориулагдсан. БНМАУ-ын улс ардын аж ахуйг салбарын болон нутаг дэвсгэрийн оновчтой бүтцийг бүрдүүлэх, дотоод нөөц боломжийг дайчлах зорилт орхигдсоны улмаас өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийг үндэсний чадавхиар дэмжин явуулах боломжгүй болсон байв. Улс ардын аж ахуйн бүтэц, түүнээс улбаатай мөнгө, санхүү зээлийн тэнцвэрт бус харьцаа, өртэйгээр хөгжих үзэл баримтлал, монголчуудын дунд дэлгэрсэн “бэлэнчлэх сэтгэлгээ” энэ бүгд нь монголын эдийн засгийн үр ашиг буурах, улмаар хямрал, зогсонги байдалд ороход нөлөөлсөн. 1984 оны 8 дугаар сард Монголын нам төрийн удирдах албан тушаалд 40 гаруй жил ажилласан Ю.Цэдэнбалыг Москва, ЗХУКН-ын Улс Төрийн Товчооны оролцоотойгоор эрүүл мэндийн шалтгаанаар бүх албан тушаалаас нь өөрчилж, Ж.Батмөнхийг түүний оронд сонгосон. Ж.Батмөнхийн засаглалын үед БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн даргаар ажиллаж байсан Д.Содном Улс төрийн Товчоонд хандан Монгол-Зөвлөлтийн хамтарсан уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн үр ашиг, түүний бүтээгдэхүүнийг ЗХУ-д хямд үнээр нийлүүлж байгаа асуудлыг тусгайлан хэлэлцэх хүсэлт гаргаж байсан. Энэ байдлыг Ж.Батмөнх, Д.Моломжамц зэргийн Улс Төрийн Товчооны гишүүд дэмжиж байсан боловч Д.Майдар зэрэг бусад гишүүд нь Монгол-Зөвлөлтийн найрамдалд сэв суулгах эмзэг сэдэв гэж үзэн хэлэлцэхээс цааргалж байв. Монгол-Оросын худалдааны тэгш бус байдал, Орост төлөх “их өр” зэрэг асуудал улс төрийн шинэ сэтгэлгээний нөлөөгөөр 80-д оны сүүлчээр ил тод яригдаж эхэлсэн ч “их өрийн” асуудал олон жилийн дараа буюу 2002 онд шийдвэрлэгдэж, Монголоос Орост төлөх их өрийн 97,5 хувийг хүчингүй болгосон билээ.

Монгол-Оросын харилцааны нийгэм-соёлын бүрэлдэхүүний асуудлыг авч үзвэл 1980-д оны эхээс Монголд зөвлөлтийг даган дууриах бодлого эрчимтэй хэрэгжсэн нь тодорхой харагддаг. Энэ нь нэг талаас Монголын удирдагчдын хүсэл

---

<sup>54</sup> М.Дүгэрсүрэн, Ц.Гомбосүрэн “Монгол Улсын XX зууны гадаад бодлогын түүхэн тойм.” УБ, 2004, 116 дахь тал

<sup>55</sup> Д.Дамба “Үндэсний аюулгүй байдал” Монгол Улс Оросын төрийн бодлогын толинд...” “Монголын нийгмийн хувь заяаны тулгамдсан асуудлууд” номонд. УБ, 1998 он, цуврал №3, 141-159 дэх тал

эрмэлзэл, нөгөөтэйгүүр ЗХУ-ын Монгол дахь ашиг сонирхлын бодит тусгал байлаа. 1976 онд МАХН-ын XIX их хурлаас дэвшүүлсэн "...БНМАУ-ыг эдийн засаг, улс төр, соёл, үзэл суртлын талаар ах дүү социалист орнуудтай, юуны түрүүнд ЗХУ-тай ойртуулан нягтруулах явдлыг хүчтэй болгох"<sup>56</sup> зорилтын дагуу Зөвлөлтийг даган дууриах бодлого хэрэгжсэн юм. ЗХУ-тай ойртон нягтрах ажил нь ЗХУ-ын яам, газар, үйлдвэр, хөдөө аж ахуйн байгууллагуудтай Монголын талын байгууллага, газрууд шууд харилцаа холбоо тогтоох замаар, зөвлөлтийн туршлагыг судлах зэрэг олон хэлбэрээр явагдаж байв. 1984 онд Монголын 20, Зөвлөлтийн 30 яам, хэлтэс, газрууд<sup>57</sup> хоорондоо шууд харилцаа тогтоосон явдал үүнийг тодорхой гэрчилнэ. Яам, үйлдвэр аж ахуйн газар, их, дээд сургууль тэр ч бүү хэл олон нийтийн байгууллагад өндөр цалин хангамжтай зөвлөлтийн мэргэжилтнүүд ажиллаж, тэдний заавар зөвлөлгөөг монголчууд дагадаг байв. Их дээд сургуулийн хичээлийг орос хэлээр заах туршилт ч хийгдсэн. Орос хэлний мэдлэг нь боловсон хүчний боловсрол, чадварын нэгэн шалгуурт тооцогдож байв. Зөвлөлт нийгмийн амьдралын туршлагыг судлах кампанит ажил зохиогдож, олон зуун монголчууд ЗХУ-д очиж туршлага судлан, эх орондоо ирээд түүнийгээ нэвтрүүлдэг байлаа. Энэ нь хоёр орны ард түмэн бие биенээ сайн таньж мэдэх, харилцан ойлголцох, орос хэлийг монголчууд сурахад түлхэц үзүүлсэн нь мэдээж боловч Зөвлөлтийг даган дууриах бодлого ямар өргөн хүрээтэй байсныг харуулж байлаа.

Горбачёвын засаглалын үеэс Зөвлөлтийг хэт даган дууриах хандлагад өөрчлөлт гарч эхлэв. Улс төрийн шинэ сэтгэлгээний нөлөөгөөр монголын сэхээтний давхарга үзэл суртал, үндэстэн-улс төрийн хүлээснээс ангижирч, 70 жилийн түүхэн замналын зарим хаалттай сэдвүүдийг (жнь: улс төрийн хэлмэгдүүлэлт, Коминтерний нөлөө) ярьж хэлэлцэх болов. Монголын сэхээтний төлөөлөл бүр 1960-аад оны эхээр өөрийн бие даасан үзэл бодлоо илэрхийлж байсныг тухайн үеийн нам төрийн удирдагчид "намын эсрэг бүлэглэл" нэрээр халхавчлан Ю.Цэдэнбал тэргүүтэй удирдлага тэднийг улс төрөөс хөндийрүүлж байлаа.

Ж.Батмөнх тэргүүтэй нам-төрийн удирдлага 1984-1990 онд өөрчлөн байгуулалтын үзэл санааг олон нийтэд сурталчлах, Монгол, Оросын хооронд эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны талаар урьд тохирсон

<sup>56</sup> "МАХН-ын түүхэн замнал". МАХН-ын Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээллийн төв, Улаанбаатар, 1995

<sup>57</sup> "Монголын улс төрийн гадаад харилцааны түүх (1911-1999)". ШУА., ОУСХ., Улаанбаатар, 2013, 241 дэх тал



хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэхэд голчлон анхаарч ирэв. Энэхүү үзэл санааг монголын олон нийт, ялангуяа сэхээтний хэсэг, залуучууд талархан дэмжсэн бол МАХН-ын удирдлага ЗХУ-ад өрнөсөн үйл явцыг анхааралтай ажигласан байдалтай байв.

Горбачёвын улс төрийн шинэ сэтгэлгээний нөлөөгөөр 1989-1990 оны зааг үед Монгол оронд ардчилсан хөдөлгөөн өрнөж, улс төрийн шинэ намууд байгуулагдсан билээ. Тэд өөрчлөн байгуулалтыг түргэтгэж засаг төрийг өөрчлөх хэрэгтэй гэж үзэн, БНМАУ-ын Ардын Их Хурал (цаашид АИХ), МАХН-ын ТХ-нд хандан өргөн барих бичиг гаргасан бөгөөд Сайд нарын Зөвлөлийг огцруулж, АИХ-ыг тараах, өөрчлөн байгуулалтыг хазаарлан барьж байгаа намын Улс төрийн Товчоог огцруулж, түүний хэмжээгүй эрх мэдлийг халахыг шаардаж байв. Энэ зорилгоор улс төрийн өлсгөлөн зарласан ба ээдрээтэй улс төрийн нөхцөлд 1990 оны 3 дугаар сард МАХН, төрийн төлөөлөгчид ба ардчилсан хүчнийхний хооронд хэлэлцээр болж, монголын ард түмний сонорт хүргэх улс төрийн Тунхаглал гаргав. МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал болж, Улс төрийн Товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, намын удирдан чиглүүлэх үүргийн тухай Үндсэн хуулийн заалтаас татгалзах шийдвэрийг гаргасан билээ. Харин 1990 оны 5 дугаар сард болсон АИХ-ын IX чуулганаас төрийн эрх барих дээд байгууллагын бүтцийг өөрчлөн шинэчлэх асуудлыг хэлэлцэж, бүх нийтийн ардчилсан сонгууль явуулах, Ерөнхийлөгчийн албан тушаалыг бий болгох, “Улс төрийн намуудын тухай” хуулийг баталж, намууд шинэ нөхцөлд үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх шийдвэрийг гаргажээ. Ийнхүү Монгол Улс харьцангуй богино хугацаанд тайван замаар ардчилалд шилжсэн нь Монголын гадаад орчинд гарсан томоохон өөрчлөлтийн нөлөө, тусгал байлаа.

### **Дүгнэлт**

**Нэг.** Өөрчлөн байгуулалтын үзэл санаа, улс төрийн шинэ сэтгэлгээ гүнзгийрэн хөгжиснөөр зөвлөлт нийгмийг хямралд хүргэсэн үндсэн шалтгаанууд ил болсон юм. Зөвлөлт нийгмийн удирдан чиглүүлэгч хүч болж байсан ЗХУКНам нь социализмын бодит агуулгыг амьдрал дээр гажуудуулж, Коминтерн, сталинизмаас үр хөврөлөө авсан хатуу төвлөн удирдах ёс, хэт зүүний чиг баримжаа бүхий гажуудсан “социалист” нийгмийг Зөвлөлт оронд байгуулжээ. Энэ нь хожим нийгмийн зөрчлийг гүнзгийрүүлэх үндсэн шалтгаан болсон. Хэдийгээр коммунист үзэл суртлаа шинэ нөхцөлд нийцүүлэн боловсронгуй болгох оролдлого хийж

“хөгжингүй социализм”-ын үзэл санааг дэвшүүлсэн авч нийгмийн дотоод зөрчлийг гэтлэн давах бус, харин ч лавшруулах, ам ажил хоёр зөрөх, бодит байдал болон дэвшүүлж буй зорилтын хооронд ихээхэн ялгаа гарсны илэрхийлэл болсон. Улс төр - үзэл суртлын хатуу чанд баримтлал, хөгжингүй орнуудын хөгжлийн ололт амжилтыг үл тоомсорлох, дэлхий ертөнцөөс тусгаарлагдсан байдал нь зөвлөлт хүний чадавхийг нээн хөгжүүлэх, шинэ санаа, санаачлагыг дэвшүүлэхэд саад тотгор болсон. Хүний хүчин зүйлийг үл тоомсорлон, социализмыг бүтээн байгуулагч хүн нь улс төрийн бодлого, шийдвэрийг үг дуугүй биелүүлэгч гэж үзэх хандлага хэвшсэн байлаа. Капиталист, социалист хоёр ертөнц эвлэршгүй гэсэн үзэл сурталд ЗХУ хөтлөгдөн капиталист орнуудыг гүйцэд түрүүлэх утопи зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж, энэ нь чанар, үр ашигт анхаарлаа хандуулах бус, харин нийгэм-эдийн засгийн хөгжлийн тооны үзүүлэлтийг илүүд үзэх хандлагыг бий болгосон. Энэ нь аажмаар эдийн засгийн өсөлтийг сааруулж, зогсонги байдлыг төрүүлэн, улмаар хямралд хүргэв. Өөрийгөө дэлхийн социалист аугаа хүчирхэг гүрэн гэж үзэн, бусад орны хөгжлийн түүхэн сонголтыг үл таашааж, зөвхөн өөрийн замналыг зөвтгөж байсан нь ЗХУ-ын гадаад бодлогыг явцууруулж, сөрөг үр дагаврыг бий болгосон. ЗСБНХУ-улс нь дэлхий дээр хамгийн олон үндэстэн, ястныг нэгтгэсэн хүчирхэг социалист улс байсан хэдий ч энэ давуу тал, онцлогоо ухаалгаар ашиглаж чадалгүй, өөрийнхөө ашиг сонирхолд хэт хөтлөгдөн зарим талаар дураараа аашлах явдал гаргаж байсан нь дотооддоо БНУ-ын хувьд төдийгүй, дэлхийн социалист хамтын нөхөрлөлийн орнуудын дунд ч нэр хүндээ сэвтээхэд хүргэсэн.

Энэ бүх зөрчил даамжирсаар ЗХУКНам нь нийгмээ удирдан залуурдах чадвараа алдан, үйл явцын өрнөлтийн урсгалд хөтлөгдөн аугаа их социалист гүрэн гэгдэж байсан ЗХУ бутран унахад хүргэв.

**Хоёр.** ЗСБНХУ бутран унаснаар социалист системийн гол түшиц орон үгүй болж, социалист лагерь задран устав. Дорнод Европын хуучин социалист орнуудад ардчилалын төлөө хөдөлгөөн, хувьсгал ээлж дараалан өрнөж, улс орондоо өөрчлөлт шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, улс төрийн ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих түүхэн үйл явц өрнөв. XX зууны сүүлийн арван жилд дэлхий дахины хөгжлийн түүхэнд нэгэн шинэ үе эхэлж, олон улсын харилцаа дэлхийн дэг журамд тогтож байсан хоёр туйлт ертөнцийн хуваагдмал байдал арилах урьдач нөхцөл аажмаар бий болов.

**Гурав.** ЗХУ нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг олон улсын тавцанд хүлээн зөвшөөрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн улс гэдгийг монголчууд бид зүй ёсоор үнэлэн хүлээн зөвшөөрдөг. Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлд ЗХУ, түүний дотор Зөвлөлтийн нам, төрийн зүтгэлтэн И.В.Сталины уйгагүй хүчин чармайлт, хатуу байр суурийн ачаар 1945 оны нэгдүгээр сард Ялтад болсон ЗХУ, АНУ, Их Британи гурван улсын төрийн тэргүүнүүдийн уулзалтаар БНМАУ-ын статус-квог одоогийн байгаа газар нутгийн хүрээнд эдгээр орнуудаар хүлээн зөвшөөрүүлсэн чадсан. Энэ нь хожмоо БНМАУ-ыг өмнөт хөрш Хятад аажмаар хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн.

Хэдийгээр Монгол улсын тусгаар тогтнолыг бэхжүүлэн тогтооход ЗХУ үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэсэн боловч, жижиг боловч бие даасан, тусгаар Монгол улсын эрх ашгийг үл хүндэтгэх явдал гаргаж байсныг энд дурьдах хэрэгтэй. Тухайлбал, Монголыг өөрийн хараа хяналтанд байлгах хүсэл эрмэлзэлд хөтлөгдөн зарим улс төрийн шийдвэр гаргахад хүчтэй нөлөөлж байлаа. Цэрэг улс төрийн холбоотны харилцаанд дулдуйдан бие даасан улсын газар нутагт цэрэг зэвсгээ байрлуулах, энэ орны уул уурхайн баялаг, ашигт малтмал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн үнээс бага өртгөөр худалдан авах зэргээр цэрэг-улс төрийн болон эдийн засгийн ашиг сонирхлоо хэрэгжүүлж байсан нь түүхэн үнэн юм. Гэхдээ энэ байдал нь 1921-1990 онуудад манай орны улс ардын аж ахуй, эдийн засаг, нийгэм соёлын хөгжилд ЗХУ-ын үзүүлсэн бүх талын тусламжийг дутуу үнэлэх, үгүйсгэх шалтаг шалтгаан огтхон ч биш бөгөөд, харин ч монголын ард түмэн Оросын ард түмэнд гүн талархалтай хандаж ирсэн уламжлалтай. БНМАУ нь 60 жилд (1921-1980) боловсрол, эрүүл мэнд, соёл, шинжлэх ухаан зэрэг нийгмийн олон салбарт ихээхэн амжилтанд хүрч, зарим үзүүлэлтээр хөгжингүй орнуудын түвшинд хүрсэнийг Өрнөдийн судлаачид хүлээн зөвшөөрөн өөрийн ном зохиолдоо тэмдэглэн бичсэн байдаг.

**Дөрөв.** Горбачёвын өөрчлөн байгуулалт, улс төрийн шинэ сэтгэлгээний нөлөөгөөр ЗХУ-д өрнөсөн үйл явц нь ЗХУ ба БНМАУ-ын харилцаа, хамтын ажиллагаанд өөрчлөлт гарах шинэ нөхцлийг бий болгосон. Учир нь шинээр бий болсон бодит нөхцөл байдал нь хоёр талын аль алинд нь харилцаагаа хуучин байдлаар үргэлжлүүлэх боломжгүй болсныг мэдрүүлэв. ЗХУ-ын цэрэг-улс төр, аюулгүй байдлын ашиг сонирхолд томоохон өөрчлөлтүүд гарч эхлэв. Үүний нэг жишээ нь Монголын нутаг дэвсгэрээс Зөвлөлтийн цэргийг гаргасан үйл явдал байлаа. Түүнчлэн ЗХУ өөрийн улс төр-цэргийн холбоотон болох /судлаачдын

нэрлэдгээр “жийргэвч” орны нэгд тооцогдож байсан/ Монгол Улстай харилцах зарчмаа эргэн харах зайлшгүй шаардлага бий болсон. Тиймээс ч Монголыг өөрийн хараа хяналтанд байлгах хатуу бодлогоо өөрчлөх, тусгаар улсын бие даасан бодлогод хөндлөнгөөс шууд нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэх явдлаас татгалзахаас өөр аргагүй болсон. Үүний нэг жишээ нь БНМАУ-ыг АНУ-тай 1987 онд дипломат харилцаа тогтоохыг дэмжсэн байр сууринаас тодорхой харагддаг.

**Тав.** БНМАУ-ын тухайд ЗХУ нь эдийн засгийн ашиг сонирхлоо урьдын байдлаар цаашид хэрэгжүүлэх боломж аажмаар хумигдаж, үүнд дотоод, гадаад хүчин зүйлүүд ч нөлөөлсөн. ЗХУ бутран унаж, зөвлөлт нийгмийн дотоодод өрнөсөн ээдрээтэй үйл явц, эдийн засгийн шинэчлэлийн бодлогын бүтэлгүйтэл зэрэг нь БНМАУ-тай урьд өмнө тохиролцсон гэрээ, хэлэлцээрийг тасалдуулахад хүргэсэн. Монгол Улстай тохиролцсоны дагуу 1988 оноос түүнд зарим бараа бүтээгдэхүүн нийлүүлэх явдал саатаж байлаа. Үүнд Оросын дотоод эдийн засгийн хүндрэл бэрхшээл нөлөөлсөнийг ч үгүйсгэх аргагүй. 1990-ээд оноос дэлхийн хөгжлийн голдролын дагуу хөрш хоёр орон нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт, чөлөөт өрсөлдөөний зарчимд шилжих, шилжилтийн үйл явцын түгээмэл сорилт бэрхшээлтэй тулгарах ижил төстэй замналыг туулж өнгөрүүлсэн. Хөрш орнууд нь том бага гэлтгүй тусгаар улс, ард түмний үндэсний эрх ашгаа дээдлэн, харилцан бие биенээ хүндэтгэн, харилцан ашигтай, тэгш, найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэх шинэ шаардлагыг түүх ийнхүү дэвшүүлэн тавив.

## **Ашигласан ном зүй**

### Монгол хэлээр:

1. М.С.Горбачёв “ Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг”. УБ,1986
2. М.С.Горбачёв “Октябрь өөрчлөн байгуулалт: хувьсгал үргэлжилж байна”.1987 оны 11 дүгээр сарын 2. УХГ, УБ, 1987
3. М.С.Горбачёв “Өөрчлөн байгуулалт шинэ сэтгэлгээ манай оронд болон дэлхий дахинд”. УХГ, УБ, 1988
4. “МАХН-ын түүхэн замнал”. МАХН-ын Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээллийн төв. УБ, 1995
5. “ХХ зууны дэлхийн түүх”. Улсын Багшийн Их Сургууль, Улаанбаатар, 2001
6. “МАХН-ын түүхэн товчоон”.МАХН-ын Сургалт судалгааны “Прогноз” төв. УБ, 2001
7. Монгол Улсын түүх.Тавдугаар боть (ХХ зуун).УБ, 2003
8. “Монгол-Оросын харилцаа Бүсчилсэн хөгжлийн бодлого, хамтын ажиллагаа”. ШУА, УБ., 2005

9. "Монголын улс төрийн гадаад харилцааны түүх.(1911-1999)" ШУА,ОУСХ, УБ, 2013
  10. Б.Лхамсүрэн "Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол" Акад.Б.Лхамсүрэн "Эрдмийн бүтээл -1", УБ,2013
  11. "Монголын нийгмийн хувь заяаны тулгамдсан асуудлууд" Цуврал №1,УБ,1997, Цуврал №3,УБ, 1998, Цуврал №4, УБ,1998, Цуврал №5,УБ, 1999
- Орос хэлээр:
1. Страницы истории КПСС Факты. Проблемы. Уроки. Москва, Высшая школа,1989
  2. А.В.Кива "Российские реформы в контексте мирового опыта".Вопросы теории и политической практики. Москва, ИВ РАН, 2006
  3. В.В.Грайворонский "Реформы в социальной сфере современной Монголии".Москва, ИВ РАН, 2007
  4. "Россия и Монголия новый взгляд на историю взаимоотношений в XX веке". Москва, ИВ РАН, 2001
  5. "Россия и Монголия на пути стратегического партнерства" Москва – Улан-Батор, 2011
  6. "Современные российско-монгольские отношения модели и сценарии". БГУ, Улан-Удэ, 2013

## МОНГОЛ, ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА НОГООН ХӨГЖИЛ\*

Н.Төмөр

ШУА-ийн ОУХХ, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,

Доктор профессор

**Хураангуй:** Монгол, Хятад хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд ногоон хөгжил чухал ач холбогдолтой. Байгаль экологийн цэвэр орчин, агаар болон усны цэвэр байдал, эрүүл хүнс зэрэг олон хүчин зүйл нь хүний эрүүл мэндэд шууд нөлөөлнө. Байгаль экологийн орчныг хамгаалах болон агаарын бохирдолыг бууруулахад сэргээгдэх эрчим хүч чухал үүрэг гүйцэтгэнэ. Эрүүл хүнсийг үйлдвэрлэхэд цэвэр хөрс, цэвэр ус зайлшгүй шаардлагатай. Монгол, Хятад хоёр улс дээр дурдсан салбарт хамтран ажиллах бүрэн боломжтой. БНХАУ нь ус, нар, салхины эрчим хүчийг ашиглах болон ойжуулах салбарт дэлхийн хамгийн их хөрөнгө оруулж, ихээхэн туршлага хуримтлуулсан улс орнуудын нэг юм. Байгаль экологийн орчноо хамгаалж, ногоон хөгжлийн төлөө хамтран ажиллах нь Монгол, Хятад хоёр улсын ард иргэдийн эрүүл мэндэд ашиг тусаа үзүүлэх нь дамжиггүй. Монгол, Хятад хоёр улсын аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаа хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд зохих хувь нэмрээ оруулна. Байгаль экологийн орчноо хамгаалж, ногоон хөгжлөөр хамтран ажиллах нь Монгол, Хятад хоёр улсын эдийн засгийн хөгжилд ашиг тустай.

**Түлхүүр үг:** Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа, ногоон хөгжил, экологийн орчин, сэргээгдэх эрчим хүч, аялал жуулчлал.

Монгол Улс, БНХАУ найрсаг харилцаатай хөрш орон бөгөөд худалдаа эдийн засгийн харилцаа өргөжин хөгжиж, олон салбарт хамтын ажиллагаагаа гүзгийрүүлэн хөгжүүлж байна. Тухайлбал, байгаль экологийн орчныг хамгаалах, сэргээгдэх эрчим хүчнийг ашиглах болон аялал жуулчлалын зэрэг олон салбарт хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНХАУ-ын дарга Ши Жиньпиний урилгаар 2019 оны дөрөвдүгээр сарын 24-25-нд БНХАУ-д Төрийн айлчлал хийж, 26-28-нд Бээжин хотод болсон “Бүс ба зам” олон улсын хамтын ажиллагааны дээд

---

\* МУИС-ийн ОУХНУС-ийн “Олон улсын харилцаа” сэтгүүл, Улаанбаатар, 2019.

түвшний хоёр дахь удаагийн уулзалтад оролцов. Айлчлалын хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, БНХАУ-ын дарга Ши Жиньпин нар албан ёсны хэлэлцээ хийж, хоёр орны худалдаа эдийн засаг, соёл боловсрол, олон улс, бүс нутгийн зэрэг өргөн сэдвээр ярилцлаа. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын дэвшүүлсэн “Зүүн хойд Азийн цахилгаан эрчим хүчний нэгдсэн супер сүлжээ”, энэхүү сүлжээний бүс нутгийн байгууллагыг бий болгох санаачилгыг БНХАУ дэмжиж байгаа хэмээн байр сууриа илэрхийлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат 2017 онд БНХАУ-д айлчлав. Айлчлалын хугацаанд “Бүс ба зам” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний чуулга уулзалтад оролцож, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кецянтай албан ёсны хэлэлцээ хийсэн. Албан ёсны хэлэлцээ хийх үедээ, Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Монгол Улс БНХАУ-тай экологийн орчныг хамгаалах болон сэргээгдэх эрчим хүчний салбарт хамтран ажиллана гэдгээ илэрхийлсэн байна.

Монгол Улс, БНХАУ-тай 4700 гаруй км хиллэж, уул усаар холбогдсон хөрш орон. БНХАУ-ын хойд, баруун хойд болон зүүн хойд нутгийн цаг агаар, уур амьсгал, геологийн бүтэц, газар зүйн нөхцөл байдал болон газар хөрсний найрлага зэрэг байгаль экологийн орчин нь Монгол Улсын зарим аймгуудтай ижил төстэй байдаг.

Хүний эрүүл мэнд нь байгаль экологийн цэвэр орчин, цэвэр агаар болон ус, эрүүл хүнс зэрэг олон хүчин зүйлээс шууд шалтгаална. Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг нь байгаль экологийн орчныг хамгаалах болон экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэх явдал юм. Цөлжилтийн эсрэг тэмцэх, шар шороон шуургыг зогсоох, агаарын бохирдлыг бууруулах, ногоон хэрэм байгуулах, химийн бордоо үл хэрэглэх газар тариалангийн аж ахуйг хөгжүүлэх, цэвэр, өндөр технологийн үйлдвэр аж ахуйн газруудыг байгуулах, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн ашиглах зэрэг олон салбарт Монгол, Хятад хоёр улс хамтран ажиллах үндэс суурь, боломж бололцоо их байна. Хятад улс нь нар, салхины эрчим хүчийг ашиглах, ойжуулах салбарт дэлхийн хамгийн их хөрөнгө оруулж, ихээхэн туршлага хуримтлуулсан орон. Байгаль экологийн орчноо хамгаалж, ногоон хөгжлийн төлөө хамтран ажиллах нь Монгол, Хятад хоёр улсад ашиг тустай.

Улаанбаатар хот цаг агаарын хувьд дэлхийн хамгийн хүйтэн нийслэлд тооцогддог бөгөөд агаарын бохирдлын хувьд ч мөн тэргүүлж байна. Агаарыг бохирдуулагч олон бодисын агууламж Монгол Улсын болон олон улсын байх ёстой

норм хэмжээнээсээ хэтэрсэн үзүүлэлттэй. Улаанбаатар нь эрс тэс уур амьсгал, хүйтний улирал 7 сар үргэлжилдэг, газар зүйн хувьд дөрвөн уулаар хүрээлэгдсэн, эрчим хүчний үүсвэртээ түүхий нүүрсийг дагнан хэрэглэдэг зэрэг нь өнөөгийн агаарын бохирдолын үндэс нь билээ. Бээжин хотын агаарын бохирдол их байсан боловч сүүлийн жилүүдэд агаарын бохирдлын эсрэг доривтой арга хэмжээ авсны үр дүнд байдал мэдэгдэхүйц сайжирсан. Ялангуяа 2008 онд Бээжинд болсон дэлхийн олимпийн наадмын үеэр нэлээд арга хэмжээ авсан. Тухайлбал, Бээжингийн агаарыг нэлээд бохирдуулж байсан Шижиншань хэмээх томоохон хар төмөрлөгийн үйлдвэрийг өөр хотод нүүлгэн шилжүүлсэн нь тус хотын агаарын бохирдлыг бууруулахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Агаарын бохирдлыг бууруулах талаар манай хоёр улсын нийслэлийн хооронд хамтран ажиллаж, энэ талаар Бээжингийн хуримтлуулсан сайхан туршлагаудыг Улаанбаатар судлан хэрэгжүүлэх хэрэгтэй. Хятад улсын Зүүн хойд нутагт орших Хар мөрөн, Гирин, Ляонин зэрэг муж нь тус улсын аж үйлдвэрийн томоохон мужууд ба агаарын бохирдлын үзүүлэлтээр нэлээд дээгүүр байдаг. Энэ нь хөрш зэргэлдээ орших Монгол Улсын Дорнод, Сүхбаатар зэрэг аймгийн агаарт ямар нэгэн хэмжээгээр сөргөөр нөлөөлөх нь зайлшгүй. Иймд агаарын бохирдлыг бууруулах нь ганц нэг улсын асуудал бус, улс орнууын хамтран шийдвэрлэх асуудал болоод байна.

Агаарын бохирдолыг бууруулах асуудлыг шийдвэрлэх арга замуудын нэг нь сэргээгдэх эрчим хүчийг ашиглах явдал билээ. Монгол Улс сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн ашиглах талаар ямагт анхаарал тавьж, 2007 онд УИХ сэргээгдэх эрчим хүчний хуулийг батлан, 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Сэргээгдэх эрчим хүчийг ашиглан цахилгаан эрчим хүчийг гаргаж байна. Одоогийн байдлаар Төв аймгийн “Салхит” салхин цахилгаан станц, Дарханы нарны цахилгаан станц, Тайшир, Дөргөний усан цахилгаан станцууд ажиллаж байгаа бөгөөд Хөшигтийн хөндийн 15 МВт-ын нарны цахилгаан станцын төсөл амжилттай хэрэгжиж байна. Төв аймгийн Хөшигтийн хөндийд байрлах энэхүү нарны цахилгаан станц нь Улаанбаатар болон шинэ олон улсын нисэх онгоцны буудлыг цахилгаан эрчим хүчээр хангах юм. Дээрх төсөл хэрэгжсэнээр жилд 22.3 сая КВт/цаг цэвэр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх аж. 2019 оны 3-р сард энэхүү нарны цахилгаан станц барих, ажиллуулахад шаардагдах 18.7 сая ам.долларын зээлийн гэрээ байгууллаа. Монгол Улс нь нар салхины арвин нөөцтэй. Тухайлбал, говийн бүсийн нар, салхины нөөц гэхэд л 2.6 ихнаяд ватт гэсэн тооцоо судалгаа байна. Төв аймгийн “Салхит” салхин станц 2013 онд ашиглалтанд орсон. Энэхүү салхин цахилгаан



станц жилд 140-170 сая КВт.ц ногоон эрчим хүчийг нүүрс, ус хэрэглэхгүйгээр салхиар үйлдвэрлэх бөгөөд энэ нь Төвийн бүсийн эрчим хүчний 4 орчим хувийг хангаж, ойролцоогоор Улаанбаатар хотын айл өрхийн жилийн цахилгааны хэрэглээний дөрөвний нэгийг ханган, жил бүр 122 мянган тонн нүүрс шатаахаас сэргийлж агаарын бохирдлыг буруулж, 1.6 сая тонн цэвэр ус хэмнэж, 178 мянган тонн CO<sub>2</sub> буюу нүүрс төрөгчийн давхар исэлийг агаарт ялгарахаас сэргийлж уур амьсгалын өөрчлөлтийг саармагжуулж байна. Дарханы нарны цахилгаан станц 2017 оны нэгдүгээр сард ашиглалтанд орж, Монгол Улсын төвийн бүсийн эрчим хүчний системд цахилгаан эрчим хүч нийлүүлж байна. 10 МВт-ын хүчин чадалтай энэхүү нарны цахилгаан станц жилд 15.2 КВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн, 14.7 тонн хүлэмжийн хий ялгаруулахаас сэргийлэх урьдчилсан тооцоо гарчээ. Монгол Улс нарны эрчим хүчний асар их нөөцтэй. Энэ нөөц баялаг дээр тулгуурлан нарны цахилгаан станц олноор байгуулах боломжтой.

Дөргөний усан цахилгаан станц 2009 онд ашиглалтанд орсон. Монгол Улсын Ховд аймгийн Дөргөн сумын нутагт орших энэхүү 12 МВт хүчин чадалтай усан цахилгаан станцыг БНХАУ-ын Гадаад эдийн засаг, технологийн хамтын ажиллагааны Шанхай корпораци барьж байгуулсан. Дөргөний усан цахилгаан станцын төслийн техник эдийн засгийн үндэслэлийг ОХУ-ын “Гидропроект” институт боловсруулж, урьдчилсан судалгааны дүнд Дөргөний УЦС-ыг байгуулах нь техникийн хувьд зөв шийдэлтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчны талаас онцын сөрөг нөлөөгүй учир барьж байгуулах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргасан. Дөргөний усан цахилгаан станцын суурилагдсан хүчин чадал 12 МВт, жилд 38.0 сая КВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх чадалтай. Нүүрсний ордыг түшиглэн дулааны цахилгаан станц байгуулах нь байгаль экологийн орчинг хамгаалахад чухал ач холбогдолтой. Монгол, Хятад хоёр улс нүүрсний ордыг түшиглэн дулааны цахилгаан станц байгуулахад хамтран ажиллаж болох юм. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНХАУ-ын дарга Ши Жиньпиний урилгаар 2019 оны дөрөвдүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд БНХАУ-д Төрийн айлчлал хийж, албан ёсны хэлэлцээний дараа хоёр улсын Ерөнхийлөгч нарыг байлцуулан зарим баримт бичигт гарын үсэг зурав. Тухалбал, “Бөөрөлжүүтийн нүүрсний уурхай болон цахилгаан станц байгуулах төслийн барилга угсралтын ажил гүйцэтгэх тухай Монгол Улсын “Цэцэнс Майнинг энд Энержи” ХХК болон БНХАУ-ын Синостийл Экүйпмэнт энд Инженерийн (SINOSTEEL) ХК хоорондын гэрээ”-г дурдаж болно.

Монгол Улсын Засгийн газраас эрчим хүчний салбарын хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлсон “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, “Буман нарны гэрэл хөтөлбөр” зэрэг хөтөлбөрүүдэд сэргээгдэх эрчим хүчний салбарын хөгжлийн ойрын болон урт хугацааны стратегийг тодорхой тусгасан байдаг. Жилийн 300-аад өдөр нь нартай, байнгын салхитай, уудам нутаг дэвсгэртэй, хүн ам сийрэг, нүүдэлчин удамтай манай орны хувьд нар, салхины сэргээгдэх эрчим хүч бол эрчим хүчний хөгжлийн нэг арга зам юм. Манай улсын нийт нутаг дэвсгэрийн 10 хувийг салхины эрчим хүчний нөөц сайтай бүс нутаг эзэлдэг. Энэ бүс нутагт ердөө нэг хавтгай дөрвөлжин км талбайгаас гэхэд л багаар тооцооход 7 мегаватт /МВт/ эрчим хүч үйлдвэрлэх боломжтой. Монголын говьд 20 хавтгай дөрвөлжин км талбайд суурилуулсан нарны парк манай улсын эрчим хүчний өнөөгийн хэрэгцээг хангана гэсэн тооцоо ч бий. Монгол Улсын Засгийн газар “Буман нарны гэрэл” үндэсний хөтөлбөр дэвшүүлж, амжилттай хэрэгжүүлсний үр дүнд Монголын хөдөөд хуучин хэрэглэж байсан лаа, дэнлүүг түүх болгож, нарны гэрлээр сольсон туршлага бидэнд байна. Өнөөдөр Улаанбаатар хот болон бусад хот суурин газарт “Буман нарны дээвэр” хөтөлбөр дэвшүүлж, зам, талбайн гэрэлтүүлэг, байрны халуун усыг нарны зай, коллектороор шийдвэрлэвэл, асар их эрчим хүч хэмнэхээс гадна агаарын бохирдол буурч, ард түмний эрүүл ахуйд дэвшил гарах нь ойлгомжтой .

Салхи болон нарны эрчим хүчний хөгжлөөр БНХАУ дэлхийн тэргүүлэгч орнуудын нэг бөгөөд 2016 оны байдлаар Хятад улсад салхин турбины багтаамж нь 149 Квт хүрч, 241 тэрбум Квт/цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн нь бүх цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 4%-ийг эзэлсэн. БНХАУ-ын Засгийн газар сэргээгдэх эрчим хүчийг ашиглах талаар анхаарал тавьж, 13-р таван жилийн төлөвлөгөөнд салхины эрчим хүчний үйлдвэрлэлийг онцгойлон хөгжүүлнэ гэж заажээ. Нарны эрчим хүчийг ашиглах талаар Хятад улс дэлхийд тэргүүлж, энэхүү нарны эрчим хүчний үйлдвэрлэлийг цаашид хөгжүүлэх нөөц бололцоотой. Хятад улсад үйлдвэрлэсэн фотоэлементийн хураагуурын 90%-ийг экспортоор гаргадаг, энэ салбар дахь дэлхийн худалдааны 50-иас дээш хувийг эзэлдэг байна.

Дээр дурдснаас үзэхэд Монгол, Хятад хоёр улс аль аль нь нар болон салхины эрчим хүчийг ашиглан хөгжүүлэх байгалийн нөөц бололцоо ихтэй байхаас гадна, хоёр улсын Засгийн газар эдгээр эрчим хүчийг ашиглан хөгжүүлэх талаар анхаарал тавьж хамтран ажиллах нь манай хоёр улсын байгаль экологийн цэвэр

байдлыг хамгаалж, агаарын бохирдлыг буруулахад ашиг тустай, улмаар хоёр орны ард иргэдийн эрүүл мэндэд ч ашиг тустай байх нь дамжиггүй.

Цөлжилт гэдэг нь цаг агаарын хувиралт, хүн төрөлхтний буруутай ажиллагаа хоёроос хамаарч байгаль экологийн тэнцвэр алдагдаж хөрс эвдэгдэж гандаж хуурайших явцыг хэлнэ. Цөлжилт нь Монгол, Хятад хоёр улсад нүүрлэсэн нийтлэг хүндрэлтэй асуудлын нэг төдийгүй дэлхийн хүн төрөлхтөнд заналхийлсэн том сүйрэл юм. Эдүгээ дэлхийн 100 гаруй улс орон цөлжилтөнд шууд өртөж байгаа бөгөөд салхи, усны элэгдлээс болж дэлхий дээр жилд 75 тэрбум тонн хөрс устаж байна гэсэн тооцоо байна. Монгол Улсын нийт газар нутгийн 45 % нь цөл газар, 90% нь цөлжилтөнд өртөх магадлал өндөртэй, газрын 78% нь доройтолд орж, хөрсний үржил шим нь алдагдсан хэмээн эрдэмтэн судaalчдын хийсэн тооцоо бий. Хятад улсын цөлжсөн бүс нутгийн талбай бүх нутаг дэвсгэрийн 27.4%-ийг эзэлж, 400 сая хүн ам үүний хор хохиролд өртөөд байна. Хятад улсын хойд, зүүн хойд болон баруун хойд нутгийн байгаль экологи ноцтой эвдэгджээ.

Цөлжилттэй тэмцэх талаар Монгол Улсын Засгийн газар тууштай арга хэмжээ авсаар ирлээ. 2010 онд Монгол Улсын Засгийн газраас “Цөлжилттэй тэмцэх Үндэсний хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан. Цөлжилттэй тэмцэх зорилгоор 2005 оноос “Ногоон хэрэм” хөтөлбөр амжилттай хэрэгжиж, манай улсын говь, хээрийн бүсийн заагийг хамарсан ойн зурвас байгуулах ажлыг өөрийн болон олон улсын дэмжлэг туслалцаатайгаар өрнүүлж, экотрассын дагуу зүүн хязгаараас өмнөд нутгаар баруун хил хүртэл 3700 гаруй км зурваст 200 мянган га талбайд мод бут суулгажээ. “Ногоон хэрэм” хөтөлбөрийн дагуу 13 аймгийн нутагт 307 га талбайд мод, бут, сөөг суулгаж, 140 мянган суулгац тарьсан. Цөлжилттэй тэмцэх ажилд манай улсын аймаг, сумын засаг захиргаа мөн нэгэн адил идэвхитэй оролцож байна. Тухайлбал, “Цөлжилттэй тэмцэх Ховд аймгийн дэд хөтөлбөр”-ийг боловсруулж, 2011 оны нэгдүгээр сард Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулсан. Энэхүү дэд хөтөлбөрт заахдаа, “Хөтөлбөрийн зорилго нь Ховд аймгийн хэмжээнд цөлжилт, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх, сааруулах, тэмцэх замаар аймгийн нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын тогтвортой хөгжил, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж, ард иргэдийн амжиргааг дээшлүүлэх явдал юм” гэжээ.

Хятад улс нь цөлжилтийн байдлаар дэлхийн хүнд ноцтой улс орнуудын нэг бөгөөд тус улсын цөлжилтийн байдлаар хамгийн хэцүү нутаг нь Хятадын зүүн хойд, хойд, баруун хойд нутаг юм. Энд Хятадын дөрвөн том элсэрхэг газар, элсэн манхан

хийгээд хязгааргүй үргэлжилсэн говь нутаг бий. Түүний нийт талбай Хятад улсын бүх цөлжсөн талбайн 85%-ийг эзэлж, Хар мөрөн муж, СУӨЗО хоёрыг холбосон 1 сая 480 мянган хавтгай дөрвөлжин км талбай бүхий асар том хэмжээний газар юм. БНХАУ-ын Засгийн газар шар шороон шуурга болон цөлжилтөөс сэргийлэхийн тулд Хятадын хойд, зүүн хойд болон баруун хойд нутагт “Хамгаалалтын ойн байгууламж” төслийг 1978 оноос хэрэгжүүлж байна. Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд нийт 73 жил зарцуулж, 2050 онд дуусгах бөгөөд Хятад улсын 13 муж, өөртөө засах орны 4.069 сая хавтгай дөрвөлжин км талбайг хамруулж байна. 2050 он гэхэд дээр дурдсан газар нутгийн 5.05% нь ой модоор бүрхэгдсэн байсныг 14.95% болгон өсгөх зорилт тавин ажиллаж байна.

Монгол, Хятад хоёр улс хөрш орон учраас байгаль экологийн нөхцөл, цаг агаар, хөрсний бүтэц зэрэг нь ижил төстэй. Иймд шар шороон шуурга болон цөлжилттэй тэмцэх талаар манай хоёр улс хамтран ажиллахад давуу нөхцөл бололцоо их байгаа юм. Энэ салбарт манай хоёр улсын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай бөгөөд түүнийг эрчимжүүлэх нь хоёр талын эрх ашигт ч нийцнэ. БНХАУ-ын элсний нүүлт, цөлжилтээс хамгаалах, ногоон зурвас байгуулж байгаа арга туршлагыг судлан хамтран ажиллах шаардлагатай. Шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэхэд зөвхөн манай хоёр улсын хамтын ажиллагаагаар зогсохгүй, ОХУ болон Зүүн хойд Азийн бүс нутгийн бусад улс орнуудтай ч хамтран ажиллах нь зүйтэй. Учир нь шар шороон шуурга зөвхөн Монгол, Хятад хоёр улсад бус, Зүүн хойд Азийн бусад орнуудад ч хор уршиг учруулах болсон тухай гадаад, дотоодын хэвлэл мэдээлэл, эрдэмтэн судлаачид мэдээлдэг болжээ.

Монгол, Хятад хоёр улс аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах бүрэн боломжтой бөгөөд сүүлийн жилүүдэд манай хоёр улсын харилцан аялан жуулчлах иргэдийн тоо эрс нэмэгдсэн. Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Аялал жуулчлалын сайд нарын III хуралдаан 2018 оны 7-р сард Улаанбаатар хотноо болж, аялал жуулчлалын төрийн захиргааны байгууллагууд болон аж ахуйн нэгжүүд хоорондын хамтын ажиллагааг өндрөөр үнэлж, гурван улсын хил орчмын аялал жуулчлалын хамтын ажиллагааны ололт амжилтыг бататган протоколд гарын үсэг зурав. Монгол, Хятад, гурван улс аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах бололцоотой байгаагийн нэгэн чухал хүчин зүйл нь гурван улсын нийт хүн амын тоо 1.5 тэрбум гаруйд хүрч, аялал жуулчлалд явах хүсэлтэй хүний тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаагаас гадна, хил дамнасан аялал жуулчлалын чиглэлийн тоо ч сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж буй явдал бөгөөд аялал жуулчлалыг хөгжүүлэх асар их том

зах зээл байна. Тухайлбал, Монгол Улсаас эхлүүлээд ОХУ-ын Алс дорнод, БНХАУ-ын Зүүн хойд нутгаар дайран өнгөрч Япон, Солонгос руу усан онгоцоор аялах цогц чиглэлийг дурдаж болно. Монгол, Орос, Хятадын энэхүү аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаа нь гурван улсын эдийн засгийн хөгжилд ашиг тустай байх нь дамжиггүй.

Ашигласан материал:

1. “Новости Монголия”, сонин, 2 мая 2019 года, №17(1197)
2. “UB POST”, сонин, March 22, 2019, №032(2000)
3. “Mongolian Economy”, сэтгүүл, 2017, №6
4. “Солонго” сэтгүүл, 2017, №5
5. Polars Wind Power Network, 2017.03.09
6. Политика Китая в сфере энергетики, Пекин, 2012